

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО

ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

/“Халзан бүрэгтэй” орд газрын ашиглалт байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл
эрсдэлийг нарийвчлан судлах/

2025 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

Та сонсголын тэмдэглэлийн цахим хувьтай дараах QR кодыг уншуулан
танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРОО, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНООС
2025 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/ ЗОХИОН
БАЙГУУЛСАН ““ХАЛЗАН БҮРЭГТЭЙ” ОРД ГАЗРЫН АШИГЛАЛТ, БАЙГАЛЬ
ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ЭРСДЭЛИЙГ НАРИЙВЧЛАН СУДЛАХ”
ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Ерөнхий хяналтын сонсголыг 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 10.30 цагт Төрийн ордны “Их Эзэн Чингис хаан” танхимд зохион байгуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар даргалав.

Ерөнхий хяналтын сонсгол явуулсан сэдэв:

““Халзан бүрэгтэй” орд газрын ашиглалт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах”

Сонсголд оролцогчид:

Сонсголын үйл ажиллагаанд Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хорооны гишүүн нарын гишүүд оролцсон.

Сонсголд тухайн сэдвээр мэдээлэл өгөх эрх бүхий төрийн байгууллагын удирдах албан тушаалтныг сонсголд дуудсан бөгөөд Хүний эрхийн Үндэсний комисс, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Аж үйлдвэр, эрдэс баялагийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Эрүүл мэндийн яам, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Үндэсний геологийн алба, Ашигт малтмал, газрын тосны газар, Цагдаагийн ерөнхий газар, Цөмийн энергийн комисс, Ховд аймгийн ЗДТГ, ИТХ-ын холбогдох албан тушаалтнууд зэрэг төрийн 17 байгууллагын удирдах албан тушаалтнууд болон төсөл хэрэгжүүлэгч “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага болон албаны бусад төлөөлөл, Ховд аймаг, Ховд аймгийн Мянгад сумаас нийт 65, “Үндэсний баялгийн сан” ТББ, “Хөшөөтийн ахмад уурхайчдын холбоо” ТББ, “Монголын Байгаль Эхийн Аврал сан” ТББ, “Ил тод байдал сан” ТББ, “Ангир нүдэн мөндөөхэй хөдөлгөөн” ТББ, Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн ТББ, Захиргааны Шинэ Санаачлага Нийгэмд үйлчилдэг ТББ, Босоо хөх Монгол ТББ, Иргэний нийгмийн байгууллага ТББ, Мянган шүгэл хөдөлгөөн ТББ-уудын төлөөлөл болон 9 шинжээч сонсголд оролцсон.

Сонсголын үйл ажиллагаанд Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүн Н.Алтаншагай, О.Амгаланбаатар, Ж.Батжаргал, П.Батчимэг, Б.Бат-Эрдэнэ, М.Ганхүлэг, С.Замира, Ж.Золжаргал, Ц.Идэрбат, С.Лүндэг, М.Мандхай, Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан, З.Мэндсайхан, Ц.Туваан, А.Ундраа, Б.Уянга, Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж, тус байнгын хорооны гишүүн М.Бадамсүрэн, Р.Батболд, О.Батнайрамдал, Ж.Бат-Эрдэнэ, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу, Г.Лувсанжамц, Э.Одбаяр, Г.Очирбат, Б.Пунсалмаа, Л.Соронзонболд, Д.Үүрийнтуяа нарын нийт 30 гишүүн хүрэлцэн ирж, 53,7 хувийн ирцтэйгээр сонсгол 10 цаг 30 минутад Төрийн ордны “Их Эзэн Чингис хаан” танхимд эхлэж, 19 цаг 30 минутад дуусав.

Ерөнхий хяналтын сонсгол эхлэхээс өмнө сонсголын дэг, сонсголын зохион байгуулалттай холбоотойгоор сонсголд оролцогчдыг саналаа хэлэхийг сонсгол даргалагч зөвшөөрсөн тул сонсголд оролцогч Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, Б.Пүрэвдож, Л.Мөнхбаясгалан нар сонсголын хөтөлбөртэй холбогдуулан санал хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ө.Шижир, Б.Уянга, С.Замира, Э.Болормаа, Ж.Золжаргал, З.Мэндсайхан, Ч.Лодойсамбуу, М.Бадамсүрэн, О.Амгаланбаатар, Б.Заяабал, Дав.Цогтбаатар нар асуулт асууж, санал, үг хэлэв.

Сонсголд оролцож санал хэлэхээр хүсэлт гарган бүртгүүлсэн Ховд аймгийн 24 иргэн, цахим хуудсаар D-parliament.mn саналаа ирүүлсэн 17 иргэн, заалнаас 19 нийт 60 иргэн санал, үг хэлэв.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Та бүхэндээ өглөөний мэнд хүргэе. Хурлын ирц 50,9 хувьтай болсон тул Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооноос зохион байгуулж байгаа “Халзан бүрэгтэй” орд газрын ашиглалт байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл эрсдэлийг нарийвчлан судлах асуудлаарх Ерөнхий хяналтын сонсгол эхлэхэд бэлэн боллоо. Өнөөдрийн сонсголд оролцохоор Улсын Их Хурлын гишүүд, төрийн байгууллагын төлөөлөл, Ховд аймгийн төрийн байгууллагын төлөөлөл, Ховд аймгийн Мянгад сумын иргэдийн төлөөлөл ирсэн байна. Өнөөдрийн сонсголыг нээснийг мэдэгдье.

Та бүхэндээ хөтөлбөр танилцуулья. Сонсгол 1 цаг 30 минут хоцорч эхэлсэн тул Улсын Их Хурлын гишүүдээс бас саналууд гарлаа. Батлагдсан хөтөлбөр та бүхэнд тараагдсан байгаа. Зарим Улсын Их Хурлын гишүүдээс гарсан санал нь өнөөдөр 14:00 цагаас Улсын Их Хурлын нэгдсэн чуулган хуралдаж улсын нэгдсэн төсөв хэлэлцэхтэй холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүд ирцээ бүртгүүлээд орчихсон байна. Мөн Байнгын хороонд хамаарахгүй зарим Улсын Их Хурлын гишүүд орж ирээд сууж байгаа энэ цаг үед мянга гаруй километрийн цаанаас туулж ирсэн иргэдийнхээ мэдээлэл, санал, үзэл бодлыг нь одоо бид нар сонсох хүсэлтэй байна гэсэн юм.

Иймд хөтөлбөрийн өөрчлөлтийг горимын саналын дагуу гаргасан байгаа. Үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүд санал хураагаад явчих уу эсвэл би өөрөө шууд дангаараа шийдвэр гаргаад явах уу? Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1-д заасны дагуу сонсгол даргалагч шийдвэрийг өөрөө биечлэн гаргах эрхтэй байгаа. Тийм учраас өнөөдөр би танхимд цугласан иргэдээсээ дахин хүлцэл өчөөд ажлын алдаа гарсан байна. Ямар нэгэн байдлаар Улсын Их Хурлын гишүүд хүндэрч хойшоо суусан зүйл байхгүй гэдгийг хэлээд, хөтөлбөрт өөрчлөлт оруулаад өнөөдөр шууд Мянгад сумын иргэдийн төлөөллөөс 2 мэдээлэл сонсоод ардаас нь 25 Мянгад сумын иргэд үг хэлэхээр нэрсээ ирүүлсэн байгаа. Ингээд үгээ хэлээд дараа нь шинжээч нарын мэдээллийг танилцуулья гэдэг хөтөлбөрийг өөрчилж, хөтөлбөр батлагдлаа. Хурлын хөтөлбөртэй холбоотой Б.Пүрэвдорж гишүүн горимын санал гаргачих уу.

УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж: Энд хүрэлцэн ирсэн Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Ховд аймгийн оролцогч Г.Нямдаваа гавьяат энэ батлагдсан хөтөлбөрөөр 11:00 цагт мэдээлэл хийхээр байгаа тул энэ асуудлыг урагшлуулж оруулж өгөөч гэдэг хүсэлтийн дагуу сая хөтөлбөрт өөрчлөлт орж байна. Хоёрдугаарт, би энэ 2 Байнгын хорооны гишүүн биш л дээ. Тэгэхээр яаж асуулт асуух вэ? Хамгийн сүүлд асуух болчихоод байна. Энийг яаж зохицуулах вэ? Гуравдугаарт нь иргэдийн төлөөлөл болон төрийн төлөөлөл хоёулаа мэтгэлцэх зарчим байхгүй юм уу? Өөрөөр хэлбэл асуулт асуух, асуулт асуусныхаа үр дүнд тодорхой мэдээллийг олж авах, нийтэд хүргэх асуудал чинь байхгүй байх шиг байгаа тул энэ 3 асуултыг асууж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Сүүлийн асуултаас нь эхлээд хариулчихъя. Энэ сонсгол нь Халзан бүрэгтэй ордын газар ашиглалттай холбоотой Ерөнхий хяналтын сонсгол юм. Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу өнөөдрийн энэ сонсгол зохион байгуулагдана. Энд ямар нэгэн сонсгол даргалагчаас олгогдсон эрх, үүрэг бол байхгүй. Тухайн хуулиудад заасан чиг үүргийн дагуу Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, санал хэлж, хариулт авч болно. Оролцож байгаа иргэд үзэл бодлоо илэрхийлж үгээ хэлэх эрхээр нь Парламент өөрөө энэ хяналтын сонсгол дээр хангаж байгаа. Хоёрдугаарт, Улсын Их Хурлын гишүүн аль ч Байнгын хороонд байгаагаас үл хамаарч тухайн хэлэлцэж байгаа асуудалд асуулт асууж, үг хэлэх эрх нь хуулиар нээлттэй байгаа учраас та Байнгын хорооны гишүүд асуулт асууж, үг хэлсний дараа холбогдох асуултаа асууж, саналаа хэлэх эрхийг танд нээлттэй олгоно гэсэн байр суурьтай байна. Одоо Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан үг хэлнэ.

УИХ-ын гишүүн З.Мэндсайхан: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Хурал даргалагчаас хүсэлт байна. Энэ Халзан бүрэгтэйн асуудлаар манай сумаас 50 гаруй хүн ирсэн байна. Энэ иргэд хараат бусаар томилогдсон шинжээч нарын дүгнэлттэй холбоотойгоор асууж, таньж мэдэх, өөрсдийнхөө үзэл бодлоо илэрхийлэх хүсэлттэй байгаа. Тэгэхээр шинжээчийн дүгнэлтийн дараа иргэдийн маань үгээ хэлэх, асуух боломжийг нь хангаж өгөөч гэж хүсэж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Өнөөдрийн батлагдсан хөтөлбөр таны хэлж байгаа дарааллаар байгаа. Хурлын ирц бүрдүүлэх гээд хүлээгдэж байх хооронд Ховд аймгийн иргэд болон Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан хүсэлтийг би аль аль талыг нь үзэж байгаад хөтөлбөрт өөрчлөлтийг оруулсан. Хэрвээ ингэж үзэж байгаа бол хэдүүлээ горимын саналаараа санал хураалт явуулчихъя. Санал хураалтаар Улсын Их Хурлын гишүүд шийдээд явах нь байна. Одоо Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан үг хэлнэ.

УИХ-ын гишүүн Л.Мөнхбаясгалан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хурал даргалагчийн зүгээс сая хурлын дэгийг өөрчилж иргэдийн үгийг эхэлж сонсох шийдвэр гаргасан. Миний хувьд энэ Байнгын хорооны гишүүний хувиар горимын санал гаргаж байна. Хуралдааны дэгийг хуучин дэгээр нь явуулъя, хөтөлбөрт заасан дэгээр нь санал хурааж өгнө үү.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За тэгвэл санал хураалтад бэлтгэе. Л.Мөнхбаясгалан гишүүний гаргасан горимын санал, З.Мэндсайхан гишүүний гаргасан горимын саналаар дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 29 гишүүн оролцож, 17 гишүүн зөвшөөрч, 58,6 хувиар горимын санал дэмжигдлээ. Ингээд хуучин хөтөлбөрөөр явахаар боллоо.

Халзан бүрэгтэйн орд газрын ашиглалт байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрсдэлийг нарийвчлан судлах гэсэн ерөнхий хяналтын сонсголыг 2025 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж байна. Өнөөдрийн сонсголд Улсын Их Хурлын гишүүдээс гадна ажиглагчаар оролцохоор 2, Төрийн бус байгууллагын төлөөлөл 14, төрийн байгууллагын төлөөлөл 31, иргэдийн төлөөлөл 100, нийтдээ 152 оролцогч бүртгүүлснээс өнөөдөр танхимд хүрэлцэн ирсэн 126 төлөөлөл энэ танхимд хүрэлцэн иржээ. Мөн өнөөдрийн сонсголд Ховд аймгийн Мянгад сумын нутгийн иргэдийн төлөөлөл бүхий 50 оролцогч, Ховд аймгийн холбогдох төрийн байгууллага, иргэдийн төлөөлөл бүхий 15 оролцогч нийт Ховд аймгаас 65 иргэн оролцож байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.4-д “Улсын Их Хурлын хяналтын сонсголыг нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулах бөгөөд хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдал хангахтай холбоотойгоос бусад асуудлаар сонсголыг хаалттай явуулахыг хориглоно.” гэж заасны дагуу хэвлэл мэдээллийн төлөөллийн оролцох эрх нээлттэй байгаа. Мөн Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз болон Парламентын шууд дамжуулах суваг ажиллаж байгааг та бүхэнд мэдэгдье. Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу хэл яриа сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах, тэдний сонсголд оролцох, ажиглах боломжийг нь хангах зорилгоор өнөөдрийн сонсголыг Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз дохионы хэлмэрчтэйгээр шууд дамжуулан хүргэж байна. Улсын Их Хурлаас зохион байгуулж байгаа хяналтын сонсгол зөвхөн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмаар явагддаг болохыг сонсгол эхлэхийн өмнө Та бүхэнд онцгойлон анхааруулъя. Өнөөдрийн сонсголд оролцож байгаа та бүхэн зөвхөн хуульд заасан дэг, журмыг сахин оролцохыг хүсэж байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.3-т заасны дагуу “хуульд өөрөөр заагаагүй бол оролцогч сонсголын үеэр сонсгол даргалагч гишүүн бусад оролцогчоос асуулт асуухгүй” гэж заасан бөгөөд мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасны дагуу сонсголд оролцогчийн эрх, үүргийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Сонсголд оролцогч дараах эрхийг эдэлнэ. 124.1.1-д хуульд заасан үндэслэл журмын дагуу асуултад хариулах тайлбар санал хэлэх, 124.1.2 Сонсголын тэмдэглэл гарсан шийдвэртэй танилцах, өөрийн хэлсэн санал тайлбарлах, 124.1.3 Сонсгол зохион байгуулагч болон даргалагчаас тэнцвэртэй хүндэтгэлтэй хандахыг шаардах, 124.2-т сонсголд оролцогч дараах үүргийг хүлээнэ. 124.2.1 Сонсгол зохион байгуулагчийн дуудсанаар сонсголд хүрэлцэн ирэх, 124.2.2 сонсголын дэг сахих, 124.2.3 сонсгол зохион байгуулагч болон сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх, 124.2.4 сонсголд үнэн зөв мэдүүлэх, бодитой дүгнэлт өгөх, 124.2.5 холбогдох, бусад хууль тогтоомжид заасан үүрэг хүлээх гэж тус тус заасан.

Мөн тус хуулийн 125 дугаар зүйлд заасны дагуу Сонсгол даргалагч нь сонсголын асуулт, хариулт, тайлбар, санал, мэдээлэл нь сонсголын сэдэвт хамааралгүй, ялгаварлан гадуурхсан, доромжилсон үг хэллэг хэрэглэсэн бол таслан зогсоох, сонсголын дэг зөрчсөн, сонсгол даргалагчийн зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хүч хэрэглэх зэрэг зохисгүй үйлдэл гаргасан оролцогчид сануулах, зайлшгүй шаардлагатай бол үг хэлэх эрхийг нь хасах, сонсголын тогтсон сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сануулга өгөх, сонсголын үйл ажиллагаанд саад учруулсан этгээдийг танхимаас гаргах хүртэл арга хэмжээ авах эрхтэй болохыг та бүхэнд сануулъя.

Монгол Улсын Их Хурлаас зохион байгуулж байгаа өнөөдрийн сонсголын гол ач холбогдол нь мэдээлэл сонсох, цуглуулах төрийн болон төрийн бус байгууллага иргэдийн мэдэх эрхийг хангаж, саналыг сонсож шийдвэр гаргах түвшиндээ нэгтгэн нэг ойлголттой болох, төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар засгийн газар болон холбогдох бусад байгууллагад чиглэл өгөхөд чиглэгдэх болно.

Ингээд Та бүхэнд сонсголын хөтөлбөр, дэг дарааллыг танилцуулъя. “Халзан бүрэгтэй” орд газрын өнөөгийн ашиглалт сэдвийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас нэгдүгээрт мэдээлэл хийнэ. Дараа нь “Халзан бүрэгтэй” ордын талаар өнөөгийн нөхцөл байдал тусгай зөвшөөрөл олгосон талаарх шинжээчийн

дүгнэлтийг шинжээч Х.Лхагвабаатар танилцуулна. Гуравдугаарт “Газрын ховор элемент, хүдэр, баяжмалыг боловсруулах хими технологи”-ийн талаарх шинжээчийн дүгнэлтийг шинжээч Т.Аззаяа танилцуулна. “Халзан бүрэгтэйн” орд ашиглалтаас үүдэх байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаарх шинжээчийн дүгнэлтийг шинжээч Н.Наранцэцэг танилцуулна.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.4-т заасны дагуу сонсголд оролцогч санал мэдээллээ 3 минутад багтаан танилцуулна. Мөн хуулийн дагуу холбогдолтой асуудалтай холбогдуулан бичгээр ирүүлсэн санал, мэдээллийн агуулгыг сонсгол даргалагчид танилцуулна. Дараа нь Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариултаа авна. Ингээд мэдээлэл дууссаны дараа цайны завсарлага болоод орж ирээд 2 цаг 30 минутын хугацаанд 25 иргэдийнхээ үзэл бодол болон 2 мэдээлэлтэйгээ сонсоод та бүхэнд тараагдсан хөтөлбөрийн дагуу явна.

Хөтөлбөрийн дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны мэдээллийг сонсоно. Индэрт урьж байна. Бусдадаа их хүндэтгэлтэй хандана. Мэдээллийн дундуур таслан зогсоох бүдүүлэг үг хэрэглэсэн тохиолдолд танхимыг чөлөөлөх арга хэмжээ авахыг би та бүхэнд хатуу сануулъя.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын Бодлого, төлөвлөлт, судалгааны хэлтсийн дарга М.Мэндбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Юуны түрүүнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд гадаадад албан томилолттой учраас яамнаас бэлтгэгдсэн мэдээллийг миний бие танилцуулахаар боллоо. Эхлээд газрын ховор элементийн тухай ерөнхий ойлголтыг өгөх нь зүйтэй байх. Газрын ховор элемент лантанойд бүлгийн 15 элемент, дээрээс нь скандий, иттри гэсэн 2 элементэд нийлээд 17 элемент газрын ховор элементийн ангилалд багтаж байгаа. Газрын ховор элементийн лантанойд бүлэг дотроо 57-64 хүртэлх элементүүд “хөнгөн”, 65-71 хүртэлх нь “хүнд” гэсэн ангилал дотроо хуваагддаг юм байна. Газрын ховор элемент маань өнөөдөр бидний мэдэхээр нарны зай хураагуур, салхин сэнсний хөдөлгүүр, батерей, шилэн кабель, хайбрид машины бүрэлдэхүүн, ухаалаг тоног төхөөрөмж, дэлгэц хийхэд гол түүхий эд болж өгдөг.

Бид дэлхийн хэмжээнд газрын ховор элементийн нөөц ямар байдлаар тогтоогдсон, ямар байдлаар тархаж хуваарилагдсан байдаг юм бэ гэдгийг харуулахыг хичээлээ. Энэ дэлгэцийн зүүн гар талд та бүхний харж байгаагаар өнөөдөр дэлхийн хэмжээнд тогтоогоод байгаа нөөцийг улс орнуудаар нь харууллаа. Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид “БНХАУ” гэх) хамгийн их хэмжээний нөөцтэй, дараа нь Вьетнам, Бразил, Оросын Холбооны Улс (цаашид “ОХУ” гэх), Энэтхэг гээд явж байгаа. Тэгвэл олборлолтын хувьд дэлхийн хэмжээнд мөн олборлолтоор БНХАУ тэргүүлж байна. 2022 оны байдлаар 240 мянган тонн гэсэн үзүүлэлттэй байгаа бол, Америкийн Нэгдсэн Улс 43 мянган тонн, Мьянмар, Австрали, Тайланд гээд эрэмбэлэгдсэн байна.

Газрын ховор элемент өөрөө түгээмэл тархацтай биш, элбэг тохиолддоггүй, мөн төвлөрч тогтсон орд дээрээ ч гэсэн бас нэлээн сарнимал байдаг учраас ховор гэж нэрлэгдсэн. Олдоц нь ховор байдаг учраас бас тэрэнтэйгээ холбоотой байх. Хэрэглээний хувьд дангаараа хэрэглэгдэхээс гадна маш олон төрлийн элементүүд хэрэглэгдэх салбарууддаа ангилагдаж хамт хэрэглэгддэг. Дэлгэцийн баруун доод буланд байгаа инфографикийг харахад бидний түгээмэл хэрэглэж заншсан зэс, никель, цайр гэх мэт элементүүд бол саяын үйлдвэрлэлүүдэд маш бага хэрэглэгддэг, нөгөө талаасаа олдоц элбэгтэй байдаг. Дараагаар нь литидтэй нь, бал, чулуу, кобальт гээд явж байгаа бол хамгийн их эрэлттэй байгаа нийлүүлэлтийн эрсдэл үүсэж

байгаа элемент нь газрын ховор элементүүд буюу түрүүчийн ярьсан 17 элемент байгаад байгаа юм.

Бид нар тэгвэл хамгийн том тоглогч болох БНХАУ-ын үйлдвэрлэлийг энд харуулахыг хичээлээ. БНХАУ үндсэндээ түрүүчийн ярьсан газрын ховор элементийн 83% нь хөнгөн, 17% нь хүнд элементүүдийг хэрэглэдэг. Нийт нөөцийн 40 гаруй хувь байна гээд түрүүн ярьсан. Тэгвэл дэлхийн нийт нийлүүлэлтийн 70 орчим хувийг дангаараа хангадаг үйлдвэрлэлийнхээ 60 хувийг БНХАУ дотооддоо үйлдвэрлэдэг. Хамгийн сүүлийн бидэнд байгаа мэдээллээр 2021 онд 168 мянган тонн газрын ховор элементийн исэл үйлдвэрлэсэн гол 3 томоохон орд оршиж байгаа мужуудыг шар өнгөөр тэмдэглэсэн байгаа. Хэрвээ та бүхэн анзаарч харах юм бол Өвөр Монгол Өөртөө засах оронд нийтдээ 68,3% хэмжээний нөөц нь ногдож байна. Өөрөөр хэлбэл манай хил залгаа бүс нутагт их хэмжээний нөөц нь байна гэсэн үг. Дараагийн ээлжид бид нар хойд хөршөө сонирхож үзэхэд түрүүн та бүхэн харсан байх нөөцийн хувьд бол ОХУ эхний эрэмбэд нэлээн дээгүүр байгаа боловч олборлолтын хувьд эхний 5 дотор байхгүй бусад гэсэн ангилал дотор багтаж байгаа. Эргээд харах юм бол ОХУ ерөнхийдөө гарааны хөрөнгө оруулалтын 1,5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгээд байгаа ойрын зорилт буюу 2030 он гэхэд БНХАУ-ын дараа хоёрдугаарт эрэмбэлэгдэх зорилтыг тавиад ач холбогдол өгөөд ажиллаж байна.

Хамгийн томоохонд тооцогдох орд гэхэд л жишээлбэл 45 тэрбум рублийн хөрөнгө оруулалтыг Засгийн газраас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Төрийн бодлогоор төрийн санхүүжилттэй хэрэгжих гэж байгаа төсөл гэж харж болох юм. 2021 онд 2700 тонн газрын ховор элементийн эслэл үйлдвэрлэсэн ийм статистиктай байгаа юм байна. Монгол Улсын хувьд газрын ховор элементтэй төрийн ямар бодлого баримталж байгаа гэвэл бид нарын хамгийн сүүлд гаргасан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого эдийн засгийн тэргүүлэх салбаруудын хувьд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж боловсруулалтын түвшин нэмэгдсэн байна гэсэн ерөнхий томъёолол байгаа.

Гэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт газрын ховор элементийг боловсруулах үйлдвэрлэлийн төслүүдийг бодлогоор дэмжинэ гэсэн ерөнхий нэг зорилт байгаа. Газрын ховор элементийн судалгаа аль эрт эхэлсэн байдаг. Хуучин 1990 оноос өмнө төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед ОХУ-ын дэмжлэгтэйгээр маш өргөн хүрээний судалгаанууд хийгдсэн. Тэр дотор газрын ховор элементийн судалгаа хийгдсэн байдаг. Энэ газрын зураг дээр зэсийн болон газрын ховор элементийн тархалтыг ерөнхийд нь харуулсан байгаа. Бид 1990 оноос хойш хийгдсэн судалгаан дээр тулгуурлаад шинэ ашигт малтмалын эрх зүйн харилцаанд орсноос хойш хувийн хэвшлүүд тодорхой хэмжээний хайгуул судалгааны ажлуудыг үргэлжлүүлэн хийсэн байдаг.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын газрын ховор элементийн нөөц бүхий ордуудын мэдээллийг товч хураангуйлан энэ хүснэгтэд харуулахыг хичээлээ. Нийт дүнгээр нь харахад 1 тэрбум гаран хүдрийн нөөцтэй ислээрээ бодох юм бол 3,1 сая тонн ислийн нөөцтэй юм байна гээд ерөнхийд нь дүгнээд хэлж болох байх. Энэ хүснэгтийг та бүхэн тогтоод харах юм бол үндсэндээ Дорноговийн Хатанбулаг, Өмнөговийн Цогт-Овоо, Мандал-Овоо, Ховдын Мянгад сум, Хэнтийн Биндэр, Өмнөдэлгэр сумдууд, Увс аймгийн Завхан сумдуудад ерөнхийдөө нөөц бүхий ордууд тогтоогдоод байгаа.

Нэг бүрчлэн товчхон мэдээлэл өгвөл “Лугийн голын орд” гэж байгаа. Энэ Дорноговь аймгийн Хатанбулаг сум гээд түрүүн дурдагдсан, нийтдээ 13 мянган тонн ислийн нөөцтэй гэж үзэж байгаа. Энэ дээр Икту, Рио гээд 2 тусгай зөвшөөрөл

эзэмшигч үйл ажиллагаа явуулж байгаа. За ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүдийн хувьд бол газрын ховор элемент өөрөө маш хүнд баяжигдах боловсруулагдах технологитой, маш олон шатлал бүхий олон шатын боловсруулалт шаардагддаг нэлээн өртөг зардалтай байдаг болохлоор ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид өнөөдөр ашиглалтад шилжиж амжихгүй.

Өнөөдөр яг технологийн тухайн хүдэртэй таарсан тухайн ялгаж авах гэж байгаа элементтэй тохирсон технологийн хувилбар сонголтуудаа хийгээд маш олон тооны туршилт хагас үйлдвэрлэлийн туршилтууд явуулдаг байгаа. Тэгэхлээр өнөөдөр тэр хагас үйлдвэрлэлийн туршилтууд эцэслэгдээгүй хийгдэх шатдаа үргэлжилсээр яваа гэдэг мэдээллийг өгчих нь зүйтэй байх гэж бодож байна. Дараагийн ээлжид Хотгорын орд байгаа юм. Хотгор Минералс компанийн эзэмшдэг Виржиниа арлуудын хөрөнгө оруулалттай нийт нөөцийн хэмжээ 486 мянган тонн.

Дараагийнх нь Мушгиа худгийн орд. Рэмет ХХК эзэмшиж байгаа хөрөнгө оруулалт нь Монголын хөрөнгө оруулалттай нийтдээ 82 мянган тонн исэл, хил залгаа тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа Жи Эс Би Майнинг ХХК мөн Монголын хөрөнгө оруулалттай Ц зэрэглэлээр 50 мянган тонн ислийн нөөцтэй гэж бүртгэгдсэн байна. Халзан бүрэгтэйн орд дээр Монголиан Нешнл рийр ийрт корпораци гээд сонсголын үндсэн сэдэвт хамаарч байгаа тусгай зөвшөөрлийн хувьд та бүхэнд ерөнхий мэдээлэл нь байгаа байх гэж бодож байна. 1,2 сая тонн ислийн нөөцтэй тусгай зөвшөөрөлтэй талбай дээр 811 мянган тонн ислийн нөөцтэй байгаа. Мөн ялгаагүй хүдэр баяжуулах туршилтын судалгаа хийгдэж байгаа. Дараа нь хагас үйлдвэрлэлийн туршилт, технологийн туршилт гээд олон туршилтын ажлууд хийгдэхээр хүлээгдэж байгаа. Ашиглалтад яг өнөөдөртөө шилжихэд аль аль ашиглалтын тусгай зөвшөөрлүүд бэлэн биш байна гээд ерөнхийд нь дүгнэж болно.

Хайгуулын 2 тусгай зөвшөөрөл байгаа. Түрүүчийн хүснэгтийн сүүлийн 2 тусгай зөвшөөрөл НАБД компанийн Хэнтий аймгийн Биндэр, Өмнөдэлгэр сумдын нутгийг дамнан оршиж байгаа урьдчилсан таамаг нөөцөөр 274 мянган тонн маноцитийн нөөцтэй гэж тогтоосон байдаг. Нэмэлт хайгуулын ажил хийх судалгааны ажил үргэлжлэх шаардлагатай. Мөн Улаан дэлийн орд Увс аймгийн Завхан сумд байрлаж байгаа Монголын хөрөнгө оруулалттай Ц зэргээр 398,5 мянган тонн ислэлийн нөөц урьдчилан үнэлсэн ийм ордууд байна. Тусгай зөвшөөрлийн хувьд өнөөдөр хүчин төгөлдөр байгаа 6 тусгай зөвшөөрлийн мэдээллийг хүргэлээ. Газрын ховор элементтэй холбоотойгоор газрын ховор элемент дангаараа биш нэлээн олон элементүүдтэй оршиж оршдог. Дээрээс нь бусад ашигт малтмалуудтай хамтаар үйлдвэрлэлд хэрэглэгддэг гэдэг байдлаараа дэлхийн улс орон бүс нутаг бүр өөрсдөдөө нэг чухал амин шаардлагатай элементүүд, металлуудыг чухал ашигт малтмал гэж бид нар одоохондоо мэргэжлийн хүрээнд ярьж, нэрлээд байгаа.

Олон улсын нэршил нь критикал минерал гэдэг нэршил ангилалд хамруулж явж байгаа юм. Хэрвээ зэс кобальт гээд бусад критикал элементүүдийн минералуудыг хамруулаад харах юм бол нийт үйлдвэрлэл ба нөөцийн хэмжээгээрээ БНХАУ мөн ялгаагүй нэгдүгээрт байна. Дараагийн ээлжинд Бразил, Орос, Энэтхэг, Австрали. Гэтэл Америкийн Нэгдсэн Улс 1,8 сая тонны нөөцтэй. Монгол Улс бидний ярьснаар 3,1 сая тонны нөөцтэйгөөр олон улсын түвшинд иймэрхүү хэмжээний нөөцтэй байна гэж харьцуулж харуулахыг зорьсон юм. Ер нь бол Грек критикал минерал гэдэг ерөнхий нэр томьёонд агуулагдаж байгаа газрын ховор элемент гэдэг ойлголт одоо бүс нутгийн төдийгүй олон улсын хэмжээнд анхаарал татсан томоохон асуудал үүсгэсэн сэдэв болоод байгаа. Ер нь бүс нутгийн зэвсэгт мөргөлдөөн, Америк, Хятадын эдийн засгийн стратегийн өрсөлдөөн гэх мэтчилэн олон зүйлсүүд

тодорхой хэмжээгээр критикал минерал буюу газрын ховор элементийн нөөц түүний ашиглалт баялгийн өрсөлдөөн цаанаа давхар дагуулсаар байгаа.

Өөрөөр хэлбэл, бид нарын өдөр тутамд хэрэглэж байгаа гар утас, энэ асаалттай байгаа дэлгэцүүд эд нар бүгдээрээ тэр газрын ховор элементийн түүхий эдийн хэрэгцээ өндөр байгаад байгааг харуулж байгаа юм. Гэхдээ энэ технологи хөгжих тусам нано технологиуд өндөр технологийн үйлдвэрлэл хөгжих тусам эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдээд байдаг. Гэтэл дэлхий дээр байгаа нөөц эрэлтийг гүйцэхгүй түвшинд өнөөдөр байгаад байна. Хамгийн сүүлийн бодит тооцооллоор харахад 2035 он гэхэд өнөөдрийн байгаа хэрэгцээ 400 хувь хүртэл өсөх нь гэсэн олон улсын эдийн засагчдын таамаглал байгаа. Ер нь олборлолт боловсруулалтаар критикал минералын улс орнуудын харьцуулалтыг дэлгэцийн зүүн талд харуулж байна. Боловсруулалт дээр ч, олборлолт дээр ч тэр БНХАУ ноёлж байгаа статистикийг харж болно. Та бүхэн доод талаасаа 2-т газрын ховор элементийг нь харвал үндсэндээ БНХАУ дангаараа давамгайлж байгаа гэдгийг энд харж болно. Нэмж хэлэхэд ер нь бараг бүх критикал минералын боловсруулалтад БНХАУ ойрын хэдэн жилдээ дангаараа ноёлно гэдгийг дүгнээд хэлчихэж болох байх. Критикал минералын өрсөлдөөн нөөцийн төлөө нөөцийг нэмэгдүүлэх ашиг сонирхол бол ер нь улс орнуудын эдийн засгийн хувьд далд хэлбэрийн үүдэн дайны гэж хэлж бараг болохоор түвшинд анхаарал татаж байгаа юм.

Бид цаашдаа Монгол Улс ямар бодлоготой, төлөвлөгөөтэй байна вэ гэдгийг өнөөдөр товчхон дурдах юм бол хайгуулын ажлыг бусад улс орнуудтай уралдан эрчимжүүлэх шаардлагатай байна. Мөн хүн ашиглагдаж байгаа ордуудын баяжмалын хаягдлыг шинжилж үзэж, дахин боловсруулах технологиудыг нарийвчлан судлах шаардлагатай байна. Яагаад гэвэл нэгж ашигт малтмалын маань өөрийн үнэ асар өндөр байгаад байгаа болохлоор бид аль болохоор ширхгийг ч хаяхгүй байхыг эрмэлзэх шаардлага байгаа гэж ойлгож байгаа. Энгийн үгээр хэлбэл хил залгаа газрын ховор элементүүдийн ордуудын үргэлжлэл. Өөрөөр хэлбэл түрүүн гаргасан зураг дээр Өвөр Монголын өөртөө засах орны хил манай улсын хилийн цаана байгаа томоохон ордуудын үргэлжлэл геологийн тогтоцын хувьд Монголын хил залгаа бүс нутгуудад байх боломжтой гэж үзээд тэр хил орчмынхоо бүсийн судалгааг эрчимжүүлэх шаардлага байна гэж харж байна. Ерөнхийдөө хэлсэн 6 ордын хувьд технологийн шийдэл, хөрөнгө оруулалт эцэслэн шийдэгдээгүй байгаа болохлоор энэ дээр дэмжлэг үзүүлэх тодорхой хэмжээгээр төрийн бодлого шаардлагатай.

Нөгөө талаасаа олон улсын туршлага судлах технологийг Монголд нутагшуулах боломжуудыг эрэлхийлэх шаардлага байна. Ер нь хамгийн эхний ээлжид бид салбарын хэмжээнд Солонгос Улстай хамтран ховор металлын судалгааны төвийг байгуулах ажлыг 2023 онд эхлүүлсэн. Улаанбаатар хотод дэд бүтцийг шийдвэрлэх нутаг дэвсгэрийн хэмжээнд суурь судалгааг идэвхжүүлэх боловсон хүчнийг бэлтгэх гэсэн 3 зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Тоног төхөөрөмж, байрны асуудлыг шийдээд, хамгийн сүүлийн тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдээд дууссан. Энэ оны 11 дүгээр сард ашиглалтад ороход бэлэн болсон байгаа гэсэн мэдээлэлтэй байна. Миний илтгэл дууслаа баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Танд баярлалаа. Дараагийн мэдээлэл Халзан бүрэгтэй ордын талаар өнөөгийн нөхцөл байдал, тусгай зөвшөөрөл олгосон талаарх дүгнэлт, танилцуулга сэдвээр илтгэгч шинжээч Х.Лхагвабаатар 10 минутад танилцуулна.

Шинжээч Х.Лхагвабаатар: Сонсголд оролцож байгаа та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Миний танилцуулга Халзан бүрэгтэй орд дээрх тусгай зөвшөөрөл олголт

ямар байсан талаар, ямар бичиг баримтууд одоогоор бүрдүүлчихээд байгаа талаар та бүхэндээ мэдээлэл өгнө. Тусгай зөвшөөрлүүдийн байршлыг нь тоймлоод харуулсан байна. 5 аймгийн нутагт энэ 6 орд газрууд байгаагаас нэг нь шороон ордынх үлдсэн 5 нь үндсэн ордууд байна. Газрын ховор элемент өөрөө “хүнд” болон “хөнгөн” гэсэн 2 ангиллаар ангилагдаж байна. Зургаас харахад Халзан бүрэгтэй ордоос бусад ордууд нь хөнгөн төрлийн ордууд байгаа бөгөөд Халзан бүрэгтэй ордын хувьд хүнд болон хөнгөн 2 элементийг хоёулаа агуулсан ийм онцлог орд байж таарч байна. Одоогоор 5 аймгийн нутагт 7 нэгж талбар дээр хайгуулын ажлууд их, бага хэмжээгээр хийгдэж байна.

Тусгай зөвшөөрлийг насжилтаар нь үзвэл 2-3 жилийн настай тусгай хайгуул хийгдэж байгаа 3 орд байна. 9-өөс дээштэй үлдсэн 4 нэгж талбар дээр газрын тосны хайгуул идэвхтэй хийгдэж байна. Халзан бүрэгтэй ордын судалгаа нь хэр хийгдсэн юм бэ? Яаж хийгдэж байсан юм бэ гэвэл 1987 оноос эхлээд судалгааны ажил нь эхэлж байсан байна.

Эхлээд Коваленко В.И. нарын удирдсан Зөвлөлт-Монголын эрдэм шинжилгээний хамтарсан экспедицийн хээрийн судалгааны ажлаар газрын ховор шороон элементүүд (ГХШЭ)-үүдийн хүдэржилт байгааг олж илрүүлсэн. Дараа нь Гаврилов. Ю.М нарын удирдсан 1:50000 масштабтай аэрогеофизикийн зураглалын анги интрузив бүрдлийн хэмжээнд радио-геохимийн, аэрогамма-спектрометрийн өндөр гажил бүхий талбай ялгасан.

Сүүлд нь 1989-1990 онуудад Минин А.Д нарын удирдсан М-46-100-В,Г; М-46-112-А,Б,В,Г; М-46-113-А,Б; М-46-124-А,Б,В,Г листүүдэд хийсэн 1:50000 масштабтай геологийн зураглалын Баяннуурын анги хээрийн ажлаар уг илрэл дээр хээрийн маршрут, сорьцлолтын ажил гүйцэтгэсэн.

2011 оноос тусгай зөвшөөрөл авснаараа өрөмдлөгийн ажил буюу газрын гүндээ судалгааны ажлууд хийгдсэн байна. 2011-2013 он, 2022-2023 онуудад үндсэндээ 2 өрөмдлөгийн ажлууд хийгдсэн байна. Монголиан Нешнл рийр ийрт корпораци компанийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Канад Улсын 90 хувь байна. Супрем 17 Холдинг Лимитед гэдэг компани эзэмшдэг юм байна. 10 хувийг нь Сингапур Улсын Билэг Индастриал гэдэг компани эзэмшиж байна.

Өнөөдрийн байдлаар энэ компани өөрөө 4 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. 691112335 гэсэн газрын 2 элементээс гадна 2072078320784 гэсэн 2 талбай дээр барилгын чулуу болон шохойн чулууны ашигт малтмалын нөөцтэйгөөр 4 тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна. Энэ компани өөрөө мөн 51 хувийг нь эзэмшдэг Монголиан нэшнл рийр ийрт корпораци 51 хувийн хувьцааг нь эзэмшдэг юм байна. Үлдсэн 49 хувийг иргэн Өлзийбаяр гэдэг хүн эзэмшиж байна. Энэ компани өөрөө бас Увс аймгийн Завхан сумын нутагт байдаг 11933 гээд газрын элементийн тусгай зөвшөөрлийг эзэмшдэг байна.

Тусгай зөвшөөрөл олгогдсон байдлын хувьд хамгийн анх 2000 онд иргэн Б.Зулд XV-002797 хайгуулын тусгай зөвшөөрлийг 2,439.72 га талбайд анх олгосон байна. 2001 онд иргэн Б.Зулаас “Монтем” ХХК-д хайгуулын тусгай зөвшөөрөл 100% шилжсэн. 2001 онд энэ хайгуулын тусгай зөвшөөрлөөс 3.7% нь буюу 91.39 га талбайд “Монтем” ХХК-д MV-004003 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл болсон байна.

2004 онд “Монтем” ХХК-д хайгуулын тусгай зөвшөөрлөөс 7.2% нь буюу 175.24 га талбайтай MV-006911 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон бол

2007 онд MV-004003 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн гэрчилгээг гээгдүүлсэн тул Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын 210 дугаартай шийдвэрээр MV-012335 дугаартай гэрчилгээ хавсралт нөхөн олгосон. Сүүлд энэ 012335 шинэ дугаартай явж байгаа. Хойшид энэ дугаараар нэрлэгдээд явж байгаа.

“Монтем” ХХК болон “Бошго-Уул” ХХК хоорондоо хөрөнгө оруулалтын чиглэлээр маргаан үүсээд 2009 онд “Монтем” ХХК дээр байсан MV-006911, MV-012335 дугаартай 2 ашиглалтын тусгай зөвшөөрөл “Бошго-Уул” ХХК руу шилжсэн байна.

“Монтем” компаниасаа мөн дахиж хариу шүүхийн маргаан үүсгээд Дээд шүүхийн хяналтын Иргэний шүүхийн шийдвэрээр буцаагаад 2011 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр буцаад “Монтем” ХХК дээрээ 2 тусгай зөвшөөрөл нь буцаад шилжсэн байна. Ингээд 2011 оны 3 дугаар сарын 22-нд “Монтем” ХХК-аас “Монголиан нэшнл рийр ийрт корпораци” ХХК руу энэ 2 тусгай зөвшөөрөл шилжсэн байна. Мэдээллийг зурган хэлбэрээр та бүхэнд бас харуулъя. Анх 2797 гэсэн ашиглалтын тусгай зөвшөөрөл олгож байгаад “Монтем” ХХК-руу шилжсэн байна. 2001 онд хамгийн анхны ашиглалтын тусгай зөвшөөрөл 91.39 га талбайтай анхны тусгай зөвшөөрөл олгогдсон байна. За дараагийнх дээр нь MV-006911 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 175.24 га талбайтай тусгай зөвшөөрөл олгогдоод, 2005 онд хайгуулын тусгай зөвшөөрөл маань цуцлагдсан байна. Дараа нь 2005 онд нөгөө хайгуулын тусгай зөвшөөрөл дээр 9819 гэсэн хайгуулын тусгай зөвшөөрлийг Монголиан нэшнл рийр ийрт корпораци авсан байна. Үндсэн том тусгай зөвшөөрөл 2014 ондоо цуцлагдаад дараагийн хайгуул нь шилжээд, саяын 10 794 гэсэн хайгуулын тусгай зөвшөөрөл 19 329 гэсэн тусгай зөвшөөрөл болсон. 9819 гэдэг тусгай зөвшөөрөл тэр 20783 гэсэн Монголиан нэшнл рийр ийрт корпораци дээр энэ барилгын чулууны ашиглалтын тусгай зөвшөөрөл байж байна.

Одоогийн нөхцөл байдал бичиг баримтын байдал дээр 2012-2013 онуудад анхны хайгуулуудыг хийж эхэлсэн. Тухайн үедээ 2011 онд тусгай зөвшөөрөл шилжигдээд 2012 оноос уг компани 41 цооног бүхий 1100 тууш метр өрөмдлөгийн ажил хийсэн байна. Энэ ажил дээрээ үндэслээд 2015 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр уг нөөцөө хэлэлцүүлээд бүртгүүлсэн байна. Тэгээд 2 талбайд ирээд тус тусдаа нөөц бодуулсан ордын нөөцийн хувьд нийт нөөц хүдрээрээ 278, тэгээд ислээрээ 1,2 сая тонн бүртгүүлсэн байна. Уг нөөцдөө үндэслээд 2018 онд техник эдийн засгийн үндэслэл (цаашид “ТЭЗҮ” гэх)-ээ боловсруулаад Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна. Уг ТЭЗҮ-ээс товчхон хэлэхэд хүчин чадал 5 саяар, ашиглалтын хугацаа 39 жилээр ашиглалтын технологи ил уурхай баяжуулалтын технологийн хувьд гарвитац хлотацын хосолсон. Уг төслийн нийт төслийнхөө хэмжээнд олборлох болон баяжуулах хүдрийн хэмжээ 194 сая нийт хугацаандаа 21 сая тонн баяжмал гаргахаар төлөвлөсөн байна.

2023 онд дахиад энэ ТЭЗҮ-ээ тодотгож, ашиглалтын жилүүдийг 48 жилээр авсан боловч тооцоогоо 15 жилээр хийсэн ба ашиглалтын технологи, баяжуулалтын технологийн хувьд бол ижилхэн байна. Ил уурхай гарвитац хлотацын хосолсон технологиороо олборлох хүдэр 15 жил дээрээ 74 саяар, нийт гарах баяжмалын хэмжээ 7 саяар хийхээр байсан байна. 2022-2023 онуудад хайгуул хийгдэж байгаа ба 93 цооног бүхий 19 мянган тууш өрөмдлөгийн ажил хийсэн байна. Олборлолтын технологийн хувьд бусад уурхайнуудтай мөн адил хэрвээ одоо үйл ажиллагаа яваад л ирэх юм бол олборлолтын технологийн хувьд бол ил уурхай аргыг сонгосон байна.

Сүүлийн 2023 оны ТЭЗҮ-ээр 74 сая тонн хүдэр олборлоно. Тээвэрлэлтэд 19,2 мянган метр сая м³ хөрс хуулахаар төлөвлөсөн байна. Уурхай өөрөө одоо Монгол Улсын нөгөө Эрдэнэтийн овоо, Цайрт минералын, Шивээ Овоо гэсэн ийм ил уурхайнуудтай адилхан ийм ил уурхай бол үүснэ.

Баяжуулалтын технологийн хувьд 2014-2025 онуудад 3 үндсэн том судалгаа хийгдсэн байна. 2014 онд тухайн үеийн хуучин нэрээр Геологийн Төв Лаборатори-Финляндын Геологийн албаны лабораториудын хамтарсан туршилтаар гравитац-флотацийн хосолсон технологи боловсруулан ГХЭ ислийн нийлбэрийн (TR2O3)-3.68% агуулгатай, 73.35% металлын авалттай баяжмал гарган авсан.

2016-2019 онд Германы Аахены их сургуулийн Rheinisch-Westfälische Technische Hochschule (RWTH) лабораторид баяжуулах технологийн туршилтуудыг хийлгэсэн нь ГТЛ-ийн туршилттай ойролцоо үр дүнд хүрсэн.

Сүүлд шинжилснээр 2025 онд Канадын SGS Lakefield (SGS) лабораторид баяжуулах үйлдвэрийн хагас үйлдвэрлэлийн туршилтаар хэт нунтаг жижиг эрдсүүдийг өндөр эрчимт нойтон соронзон ангилагч(WHIMS)-аар баяжуулан гарсан баяжмалыг флотацийн аргаар гүйцээн баяжуулах туршилтууд амжилттай болж 18.5% гарцтай, 3,90 % хүнд ГХШЭ буюу TREO-ийн агуулгатай, 75.3 %-ийн металл авалттай баяжмал гарахаар судалгаа шинжилгээний үр дүнгүүд гарсан байна. За баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа. Цагаа барьцгаана шүү. Дараагийн мэдээлэл Газрын ховор элемент, хүдэр, баяжмалын боловсруулах химийн технологийн талаарх дүгнэлт, танилцуулгыг шинжээч Т.Аззаяа илтгэнэ.

Шинжээч Т.Аззаяа: Эрхэм та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Миний бие газрын ховор элемент гэж юу болох, хүдэр, баяжмалыг химийн технологийн аргаар хэрхэн боловсруулдаг талаарх товч мэдээллийг хүргэнэ. Өмнөх илтгэгч нарын илтгэлд гарсан. Ер нь газрын ховор элемент гэж Менделеевийн үелэх системийн Лантаноидын группын 15 элемент, үүнээс гадна тэдгээртэй химийн шинж чанараараа төстэй итрий, скандий гэсэн 2 элементийг нэмээд нийт 17 элементийг нэрлэдэг. Энэ бүлгийн элементийг дотор нь церийн бүлгийн буюу хөнгөн, мөн итрийн бүлгийн буюу хүнд газрын ховор элемент гэж бүлэглэн ангилдаг. Ерөнхийдөө газрын ховор элемент нь “ховор” гэсэн нэртэй хэдий ч гэсэн дэлхийн царцдаст харьцангуй өргөн тархсан байдаг. Эдгээр элементүүд өөр хоорондоо химийн шинж чанараараа маш төстэй, тиймээс баяжуулалтын болон боловсруулалтын маш нарийн арга технологийг шаарддаг онцлогтой.

Хэрэглээний хувьд сүүлийн үед өндөр технологийн түүхий эдээр өргөн ашиглагдаж байгаа. Ер нь батлан хамгаалахын салбарт, анагаахын салбарт, сансрын технологи, мөн бид бүхний хамгийн өргөн хэрэглээнд байдаг хайбрид системийн автомашины эд ангийн түүхий эдээр нэлээн ашиглагдаж байна. Амьдралд хамгийн ойр жишээг авч үзвэл, хайбрид системийн автомашины эд ангиудыг үйлдвэрлэхэд эдгээр элементүүд ихээр орж байна. Жишээлбэл, цахилгаан моторын үүсгэвэр хэсэгт неодим, празеодиум, диспрозий, тербий ордог.

Эдгээр элементүүдийн дэлхийн нөөцийн хувьд 2024 оны байдлаар Америкийн Нэгдсэн Улсын Геологийн албаны судалгаагаар 115.4 сая тонн нөөцтэй гэж тогтоосон байдаг. Энэ слайдад дэлхийд ГХЭ-ийн нөөцөөрөө тэргүүлэх байр эзэлж буй улс орнуудыг жагсааж харуулсан байна. БНХАУ-ын хувьд дэлхийн нөөцийн 38 хувийг эзэлдэг бол цаашлаад Бразил, Вьетам, Энэтхэг, Австрали зэрэг улс орнууд удаах

байруудыг эзэлж байна. Монгол Улсын хувьд 2.7-иар ГХЭ-ийн нөөц бүхий улс орнуудын жагсаалтад ордог байгаа.

Энэ слайдад газрын ховор элементийг агуулж буй эрдэс хүдрийн шинж чанарын талаар яригдана. Судлаачдын үзэж байгаагаар өнөөгийн байдлаар ГХЭ-ийн агуулагч 250 гаруй эрдэс мэдэгдээд байна. Эдгээр эрдсийг 5 бүлэгт ангилан авч үздэг ба тэдгээр нь карбонат, фосфат, оксид, галид, силикатын ангилал болно. Карбонат, фосфатын ангиллын бастнезит, монацит, ксинотим зэрэг эрдсүүд нь газрын ховор элементүүдийн үндсэн эрдсүүд юм. Харин оксид, галид, силикатын ангиллын эрдсүүд нь газрын ховор элементийг тээгч байдлаар агуулдаг эрдсүүд.

Ер нь бол газрын ховор элементүүдийг агуулагч эдгээр эрдсүүд цацраг идэвхт уран, торийг тодорхой хэмжээгээр дагалдан агуулдаг онцлогтой, үүгээрээ бусад төрлийн ашигт малтмалууд болох алт, зэсийн эрдсүүдээс ялгардаг. Энэ шинж төлөв нь дэлхий дээрх газрын ховор элементийн бүхий л эрдэст ажиглагддаг төлөв байдал юм.

Газрын ховор элементийн олборлолтын хувьд ил болон далд уурхайн аргаар олборлодог. Дэлхийн ихэнх газрын ховор элементийн ордуудыг ил аргаар олборлож байна. Слайдын баруун хэсэгт харагдаж байгаа зурагт дэлхийн газрын ховрын тэргүүлэх 3 том ордыг жишээ болгож харуулсан. Хятадын Баян-Овоо, Австралийн Маунт Велт, Америкийн Нэгдсэн Улсын Маунтэйн Пасс зэрэг ордуудыг ил уурхайн аргаар олборлож байна. Харин далд уурхайн аргыг маш цөөхөн, маш ховор уурхайд ашигладаг ба нэг жишээ нь ОХУ-ын Мурманск мужид орших Ловозерогийн Лопаритийн орд юм.

Газрын ховор элементийн хүдрийг боловсруулах ерөнхий схемийг энд харуулсан байна. Схемийн дагуу газрын ховор элементийн хүдэр олборлолт, бутлалт, нунтаглалт, баяжуулах процесс явагдаж баяжмал гаргаж авна. Баяжмалыг цааш нь химийн аргаар гүн боловсруулснаар газрын ховор элементийн нийлбэр исэл, нийлбэр ислээс дан исэл гаргадаг байгаа.

Газрын ховор элементийн хүдрийг дэлхийн улс орнуудад ямар технологиор хэрхэн баяжуулдаг талаарх ерөнхий тоймыг энэ хүснэгтэд нэгтгэн харуулсан. Ерөнхийдөө олон аргууд байдаг л даа. Тэдгээрээс хамгийн өргөн хэрэглэгддэг гравитацийн арга, соронзон баяжуулалтын арга, цахилгаан дамжуулах чанарт үндэслэсэн арга, мөн флотацын арга гэсэн 4 аргыг энд харуулжээ. Хүдэр баяжуулах процесст эдгээр аргуудыг дангаар нь ашиглаж болно, гэхдээ тухайн хүдрийн эрдсийн шинж чанараас нь хамааруулаад ихэнхдээ эдгээр аргуудыг хосолсон байдлаар буюу гравитаци-флотаци, соронзон баяжуулалт-флотаци гэх мэтээр ашигладаг. Энэ нь ч илүү үр дүнд хүргэдэг. Баяжуулалтын технологийг тухайн хүдэрт агуулагдах эрдсийн шинж чанар, химийн найрлагаас нь хамааруулж сонгодог байгаа.

Гаргаж авсан баяжмалыг цаашлаад химийн аргаар гүн боловсруулдаг аргуудыг энэ хүснэгтэд харуулсан ба Хүчлийн, Шүлтийн, Аммонийн сульфатын давсны уусмалаар уусгах гэсэн эдгээр 3 аргыг дэлхийд өргөнөөр ашиглаж байна. Өөр бусад аргууд байгаа хэдий ч одоогийн байдлаар судалгааны түвшинд байна.

Тухайлбал Bio-leaching буюу био уусгалтын арга гэх мэтчилэн байгаль орчинд ээлтэй арга технологийг нэвтрүүлэхээр судлаачид ажиллаж байна. Эхний хүчлийн арга нь баснецит манацит гэх мэт эрдэс агуулсан баяжмалыг, өөрөөр хэлбэл тухайн эрдэс нь фосфор, фтор агуулсан бол азотын хүчил, давсны хүчил, хүхрийн хүчил гэх мэт эрдэс хүчлүүдээр 200-500 градусын температурт уусгах технологи юм. Энэ технологи нь одоо Баян-Овоогийн уурхайд ашиглагдаж байна.

Дараагийн арга нь шүлтийн арга нь мөн л нөгөө фтор, карбонат агуулсан эрдсүүдийг харьцангуй нам буюу 140-150 градусын температурт шүлтийн урвалжаар уусгах технологи байдаг. Энэ аргыг АНУ-ын Маунтэйн Пасс ордод ашиглаж байсан. Гуравдугаар арга нь аммонийн сульфатын давсны уусмалаар уусгах арга. Энэхүү аргаар ион шингээсэн шаврын ордын шаварт агуулагдах хүнд газрын ховор элементийг уусгадаг ба Хятадын өмнөд нутаг дахь ордуудад ашиглаж байна.

Монгол орны хувьд одоогоор нөөц нь тогтоогдсон газрын ховор элементийн 6 орд байдаг ба нийтдээ 3.1 сая газрын ховрын ислийн нөөцтэй гэж үздэг. Тухайлбал, говийн бүсэд Мушгиа худаг, Хотгор, Лугийн гол гэсэн 3 орд орших ба эдгээр ордуудад хөнгөн газрын ховор элементүүд давамгайл байдлаар оршдог. Энд хөнгөн газрын ховор элементүүдийг цэнхэрээр, хүнд газрын ховор элементүүдийг улбар шар өнгөөр дүрслэн харуулсан байгаа. Харин баруун бүсэд Халзанбүрэгтэй, Улаан дэлийн ордууд байна. Халзан бүрэгтэй ордын хувьд хүнд болон хөнгөн газрын ховор элементийг аль алиныг нь агуулдаг, дээрээс нь үйлдвэрлэлийн чухал ач холбогдол бүхий 3 өөр одоо металл илэрсэн нь ниобий, тантал, цирконий юм. Эдгээр металлууд газрын ховор элементүүдээсээ илүү хэмжээгээр агуулагддаг онцлогтой, орчин үеийн үйлдвэрлэлд илүү ашиглагддаг элементүүд байгаа.

Байршлын хувьд тус орд нь Ховд аймгийн Мянгад сумын нутагт оршдог, газрын ховор элементийн геологийн нөөц нь 1.2 сая тонн гэж тогтоосон бөгөөд цирконий-ниобий-газрын ховор элементийн орд юм. Энэ ордын хүдрийн эрдсийн болон химийн найрлагын урьдчилсан судалгааг Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэн, Геологийн төв лаборатори, Финляндын геологийн алба, Германы Аахены их сургууль гэсэн судалгааны байгууллагуудад хийсэн байдаг. Гэхдээ тэдгээр судалгаанууд нь он цагийн хувьд өөр өөр он дараалалтай хийгдсэн. Хими, химийн технологийн хүрээлэнд 1990-ээд оны дундуур хийгдсэн судалгааны үр дүнгээр энэ ордын хүдэрт ойролцоогоор 37 эрдэс агуулагдаж байна.

Тодруулбал, газрын ховор элементүүд нь фторкарбонатын эрдэст, цирконий нь элпидид, гитингсит-циркон, ниобий нь пирохлорт агуулагдаж байна. Геологийн төв лабораторид хийсэн 2014 оны судалгаагаар хүнд газрын ховор элементүүд нь циркон, элпидит, колумбит, пирохлорт агуулагдаж байгаа бол хөнгөн нь бастнезит, паризит, синхезитэд агуулагдаж байна тогтоосон. Харин Германы Аахены их сургуульд энэ ордын хүдэрт фторкарбонат, бастнезит, синхезит, паризит агуулагдаж байна гэсэн өмнөх судлаачдын дүнтэй нийцсэн үр дүнг гаргасан байгаа юм.

Химийн найрлагын хувьд Химийн хүрээлэнд хийсэн судалгаагаар газрын ховор элементийн исэл нь 1.28-2.44% агуулагдаж байсан бол цирконий исэл 1.5-2.4%, ниобийн исэл 0.5-0.6%-иар хувь тус тус агуулагдаж байв. Газрын ховор элементийн эрдэс, хүдэр нь цацраг идэвт элементүүд болох уран, торийг бага хэмжээгээр дагалддаг гэсэн үүднээс уран, торийг зайлшгүй тодорхойлох ёстой. Шинжилгээгээр хүдэр дэх ураны агуулга 0.009%, торий 0.028% хувь байна гэсэн үр дүнг гаргасан. Германы Аахены их сургууль дээр хийсэн судалгаагаар уран нь Гитингсит, элпидит, пирохлорт агуулагдаж байгааг тогтоосон байна. Тэдний судалгаагаар энэ ордын хүдрийн төв хэсэгтээ циркон гэх эрдэс агуулагдаж байсан бөгөөд энэ эрдэст цирконий, иттрийгээс гадна гафни гэх өөр нэгэн үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий элемент байгааг илрүүлсэн. Геологийн төв лабораторийн судалгаагаар хүдэр нь 0.41%-ийн газрын ховор элементийн исэл агуулагдаж байгааг тогтоосон байна.

Уран, торий газрын ховор элементийн эрдэст агуулагддаг гэдэг үүднээс ураны орд гэж юу вэ, газрын ховор элементийн орд гэж юу вэ гэсэн үндсэн ялгааг ойлгуулах нь зүйтэй гэж үзэж байна. Энэ хүснэгт дээр Монгол орны газрын ховор элементийн

болон ураны 2 том ордыг жишээ болгож авсан. Учир нь сүүлийн үед олон нийтийн анхаарлыг ихээхэн татаж байгаа ордууд юм. Харьцуулаад үзэхэд газрын ховор элементийн болон ураны ордууд нь гарал үүсэл, геологийн бүтэц тогтоц, агуулж байгаа эрдэс минералынхаа хувьд тэс ондоо ордууд. Халзанбүрэгтэй ордын хувьд үндсэн эрдэс нь бастнезит, паризит, синхезит-иттрий, пирохлор, циркон гэх газрын ховор элементийг агуулагч эрдсүүд байсан. Энэ ордын ашигт элемент нь циркон, ниобий, газрын ховор элементүүд бол дагалдах элемент нь уран, торий бөгөөд бага хэмжээгээр агуулагдаж байна.

Харин Зөөвч-Овоогийн ураны ордын гарал үүсэл нь элсэн чулууны орд бөгөөд үндсэн эрдэс нь уранинит, пиролизит, карнотит гэсэн ураны эрдсүүд байдаг. Уранинит эрдэст агуулагдах ураны дундаж агуулга нь 0.02% байна. Дагалдах элемент нь ванадий, молибден, селен, торий юм. Тэгэхлээр тухайн эрдсийн шинж чанар, геологийн тогтоц зэргээс хамааруулаад энэ 2 ордын хүдрийг олборлох, химийн аргаар боловсруулах процесс өөр өөр байдаг. Халзанбүрэгтэй ордыг ил аргаар олборлоод, хүдрийг нь баяжуулаад, баяжмалыг нь химийн аргаар боловсруулдаг бол, Зөөвч-Овоогийн ордын хувьд газрын доор уусган олборлох технологи буюу хүхрийн хүчлийн сулруулсан уусмалаар боловсруулдаг байгаа. Эрдсийн найрлага, ашигт болон дагалдах элементийн найрлага, боловсруулах технологи нь өөр өөр учраас Халзанбүрэгтэй орд бол циркон-ниобий-газрын ховор элементийн орд, Зөөвч-Овоогийн орд бол ураны орд юм.

Монгол орны газрын ховор элементийн ордуудын хүдэрт уран, торий агуулагддаг гэдэг утгаар тэдгээрийн агууламжийг харьцуулан харуулсан дүнг энэ хүснэгтэд нэгтгэсэн. Судалгааг Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэн, Геологийн төв лаборатори, Германы Аахены их сургуулиудад хийсэн. Хүснэгтэд харуулснаар дэлхийн царцдас чулуулаг дахь уран, торийн дэвсгэр агууламжийг харуулсан бөгөөд ураны хувьд 0.0002%, торийн хувьд 0.001% байдаг. Судалгаагаар Лугийн гол, Мушгиа худаг зэрэг говийн бүсэд орших ордуудад уран, торий байгалийнхаа тогтоц, шинж чанараасаа хамаараад дэвсгэр түвшнээс өндөр хувьтай байна. Харин Хотгор ордын хувьд байгалийн дэвсгэр түвшнийхээ ойролцоо байсан бол Халзанбүрэгтэй ордын хувьд мөн л дэвсгэр түвшний ойролцоо утгатай байна гэсэн урьдчилсан судалгаануудыг гаргажээ.

Халзан бүрэгтэй ордын хүдрийн баяжуулалтын талаар миний өмнөх илтгэгчийн илтгэлд гравитац-флотацын хосолсон аргаар баяжуулах боломжтой юм байна гэж яригдсан. Тэгэхээр Геологийн төв лабораторид хийгдсэн судалгаагаар 0.41%-ийн газрын ховрын исэл агуулсан анхдагч хүдрийг гравитац-флотацын аргаар баяжуулж 3.68%-ийн агууламжтай баяжмал гаргаж авсан. Металл авалт нь 73.32%, цирконы агууламж 98660мг/кг байсан. Эндээс харахад Халзанбүрэгтэй ордын эрдэс хүдэр нь өөрөө маш хүнд баяжигддаг, цирконий, ниобий, газрын ховрын нарийн нийлмэл бүтэцтэй эрдсүүдийг агуулдаг учраас баяжуулалтын судалгааг нарийвчлан явуулах, өөр тохирсон баяжуулалтын аргаар баяжуулж, 3.68%-ийн агууламжийг нэмэгдүүлэх боломжит нарийвчилсан судалгааг хийх шаардлагатай. Цаашлаад баяжуулалтаас гарах хаягдал болон баяжмалд агуулагдах уран, торийн хэмжээг хянаж явах шаардлагатай гэж үзэж байгаа.

Ордын хүдрээс гаргаж авсан баяжмалыг цаашид гүн боловсруулах технологиор боловсруулдаг. Гэхдээ баяжмалд яг ямар эрдэс агуулагдаж байна вэ гэдгээс шалтгаалаад баяжмалыг боловсруулах химийн технологи тодорхойлогдоно. Халзанбүрэгтэй ордын баяжмалыг гүн боловсруулах Канадуудын урьдчилсан судалгаанаас харахад энэ ордын баяжмалыг шүлтийн аргаар гүн боловсруулж болох юм гэсэн технологийн схемийг гаргасан байсан. Тэгэхээр шүлтийн боловсруулалт

хэрхэн явдаг юм бэ гэхээр газрын ховор элементийн баяжмалыг натрийн гидроксидоор уусгаж, газрын ховор элементийг гидроксид хэлбэрт шилжүүлнэ.

Үүссэн гидроксидыг давсны хүчлээр уусгаж хлорид хэлбэрт шилжүүлээд, дараа нь тэр шингэн хэсэгт байгаа хлоридоо шавелийн хүчил буюу хурган чихний хүчлээр тунадасжуулж оксалат хэлбэрт шилжүүлэсний дараа өндөр температурт шатааж газрын ховор элементийн ислийг гаргаж авах технологи юм. Ерөнхийдөө ямар зорилгоор ямар агууламжтай баяжмал гаргаж авах, тэрхүү баяжмалаа хэрхэн яаж боловсруулах вэ, химийн технологи нь яаж явагдах вэ гэдэг бол өөрөө маш нарийн технологи байдаг тул нарийвчилсан судалгааны үр дүнд л технологи шийдэгдэнэ. Үүнээс гадна баяжмалд уран, торий дагалддаг тул боловсруулалтын процессын үед ч уран, торийн агууламжийг үе шат бүрт нарийн хянаж байх ёстой. Тиймээс тал бүрээс нь судалсан илүү их судалгаа шаардлагатай.

Халзанбүрэгтэй ордын хувьд хүдэр, баяжмалыг боловсруулах туршилт судалгааны ажил хомс, бараг хийгдээгүй байгаа тул та бүхэнд ер нь боловсруулалтын явцад уран, торий хаана, хэрхэн яаж тархан хуваарилагддаг юм бэ гэдгийг Хими, химийн технологийн хүрээлэн дээр хийгдсэн Хотгор ордын хүдэр, баяжмалыг боловсруулах технологийн судалгааны үр дүн дээр жишээлэн тайлбарлах гэж байна. Хүснэгтээс харахад Хотгор ордын анхдагч хүдэрт уран 0.01% агуулагдаж байсан бол баяжуулах процессын үед энэ нь 7 дахин баяжигдаад 0.07% болсон байна. Өөрөөр хэлбэл хүдэр баяжуулах процессын үед уран нь баяжмал дотроо баяжигдаад ороод ирж байна. Баяжуулалтын процессын үед хаягдал гарнаа, тэрхүү хаягдалд ураны агууламж багасч байна. Хүснэгт дээр ногоон дэвсгэртэй хэсэг нь хүдрийн баяжуулалтын процессын хэсэг, харин цагаан дэвсгэрээр боловсруулалтын процессыг харуулсан. Баяжмалыг боловсруулахад уран нь баяжуулалтын хатуу, шингэн хаягдалд хэдэн хувьтай агуулагдаж байгааг эндээс харж болно. Тэгэхээр боловсруулалтын үед ураны агууламж багасах шинж төлөв ажиглагдаж байна.

Ер нь бол газрын ховор элементийн хүдэр, баяжмалыг боловсруулах процессын үед, түүнчлэн бусад уур уурхайтай холбоотой үйл ажиллагааны үеэр байгаль орчинд үүсгэж болзошгүй сөрөг нөлөөллийг маш нарийн авч үзэх хэрэгтэй. Яг ямар процессын үед эрсдэл үүсгэж болох вэ гэвэл нэгд хүдэр олборлолтын үед үүсэх хаягдал чулуулгийн овоолго байдаг. Энд хүнд металл, уран, торий агуулагдах боломжтой бөгөөд эдгээр нь борооны усаар угаагдан хөрсөнд нэвчиж гүний усанд орох магадлалтай. Гэхдээ овоолго чулуулгийн ширхэглэлийн хэмжээ том байдаг тул тэрхүү чулуулаг дахь хүнд металл, уран, торий нь борооны усаар угаагдан усах процесс маш удаан явагддаг. Тэгэхээр эрсдэл бага байх боломжтой. Дараагийн өөр нэгэн процесс бол баяжуулалтын үед үүсэх хаягдал юм. Тэрхүү хаягдлыг тусгайлан бэлтгэсэн хаягдлын санд агуулна. Хаягдалд хүнд металлууд, фторидууд, уран, торий агуулагдах боломжтой.

Баяжуулалтын процессын үед тодорхой хэмжээний чийг буюу 12% орчимтой, зутан хэлбэрийн хаягдал гардаг. Тэгэхээр тэрхүү хаягдлын далан буюу сан нь байгалийн давагдашгүй хүчин зүйлд л нэрвэгдчихгүй бол хаягдлаас үүсэх эрсдэл харьцангуй бага байх боломжтой. Гэхдээ нарийн хяналт шаардлагатай. За үүнтэй холбоотой асуудлыг дараагийн илтгэгч ярих бхаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Дараагийн илтгэл, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны мэдээллийг Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын дарга Э.Энхмөнх танилцуулна. Э.Энхмөнх даргыг индэрт урьж байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын дарга Э.Энхмөнх: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Илтгэлийн агуулгын хувьд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, нарийвчилсан үнэлгээ, хайгуулын ажлын үеийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй холбоотой процесс, явц ямар түвшинд байгаа талаар товч мэдээлэл өгнө.

Тухайн төслийн буюу газрын ховор элементийг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт 2022 оны 02 дугаар сарын 5-ны өдөр гарсан. Ерөнхий үнэлгээний дүгнэлтээр нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай гэх дүгнэлт гарсан. Байгаль орчинд нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд онцгойлон анхаарах шаардлагатай зүйлүүдийг тусгаж өгсөн. Үүн дээр ямар асуудлыг тусгаж өгсөн гэвэл

1/төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчин, ус, хөрс, агаар, амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүний хамрах хүрээ, учруулах хохирлын хэмжээг тооцож, экологи, эдийн засгийн хувьд үр ашигтай хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар нэгдсэн дүгнэлт;

2/тухайн орд газрын газрын доорх болон гадаргын усны хамаарлыг тогтоох;

3/ордыг ашиглахтай холбоотой технологитой уялдуулан нарийвчлан судлах, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулах;

4/тухайн ордын үйл ажиллагаа явагдсантай холбоотойгоор тусгай зам ашиглах журмын дагуу замыг бий болгохтой холбоотой асуудлыг нарийвчилсан үнэлгээний тайланд тусгаж өгөх;

5/тухайн уулын ажил болоод баяжуулалтын үйл ажиллагаатай холбоотойгоор уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн урьдчилсан төлөвлөлтийг хийх;

6/тухайн тайланг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.4.8-д заасны дагуу иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх, олон нийтийн оролцоог хангах асуудлуудыг онцгойлон анхаарах шаардлагатайг ерөнхий үнэлгээн дээр тавьж өгсөн байна.

Төсөл хэрэгжүүлэгч болоод мэргэжлийн байгууллагаас тайланг 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн Байгаль орчны төсөл хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн байгаа. Ингээд мэргэжлийн зөвлөлөөс тухайн тайланг сонсоод ургамлын суурь судалгаа зураглал буруу хийгдсэн, усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг нарийвчлан тодорхойлох, усны чанарын судалгаа мэдээлэл зөрүүтэй, мөн мониторингийн цэгүүд тодорхойгүй, судалгаа хангалтгүй гэх үндэслэлүүдээр тайланг буцааж шийдвэрлэсэн байгаа.

Одоогийн байдлаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд тухайн тайланг ирүүлээгүй, хянагдаагүй байна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй холбоотой асуудал энд харагдаж байна. Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 2023 онд хайгуулын ажлын үеийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг баталсан. Ингээд тухайн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Ховд аймгийн Байгаль орчны газраас дүгнээд 2024 оны 3 сарын 22-ны өдөр тухайн төлөвлөгөөний хэрэгжилт 90%-ийн гүйцэтгэлтэй байна гэсэн албан бичиг, холбогдох ажлын хэсгийн дүгнэлтийг ирүүлсэн. Уг дүгнэлтийг үндэслэн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдсан байдаг.

Энэ слайд дээр 2024, 2025 онд үйл ажиллагаа явагдаагүй, менежментийн батлагдсан төлөвлөгөө болоод тухайн сумын Засаг даргын үйл ажиллагааг зогсоосон тухай албан бичиг харагдаж байна. Орон нутгаас тусгай зөвшөөрлийг цуцлахтай холбоотой 5 албан бичиг ирсэн байдаг. Тухайн 5 албан бичгүүдийг нэг бүрчлэн оруулж өгсөн байна. Эхний албан бичиг 2024 оны 02 дугаар сарын 15-нд ирсэн, тухайн албан бичигт тусгай зөвшөөрлийг цуцлуулахтай холбоотой асуудлыг хөндсөн. Улмаар хуучнаар Аж үйлдвэрийн яамнаас 03 дугаар сарын 07-ны өдөр Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.5 мөн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын баталсан 2020 оны журмаар Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл цуцлахтай холбоотой БОАЖЯ-ны гаргах дүгнэлтийн хүрээнд тавигдах шаардлагууд байгаа. Энэ шаардлагыг хангаж ирүүлээч гэх албан бичгийг хүргүүлсэн. Үүнтэй холбоотойгоор 06 дугаар сарын 05-ны мөн хариу ирүүлсэн. Тухайн албан бичгээр “Журмын шаардлага бүрэн хангагдаагүй учраас дахин хангаж ирүүлнэ үү” гэх хариуг явуулсан.

Ингээд тухайн 5 албан бичгийн агуулгын хүрээг хараад үзвэл, 2020 оны БОАЖ-ын сайдын баталсан журмаар тавигдсан шаардлага, үндэслэл бүрэн хангагдаагүйгээс болоод Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас тухайн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах дүгнэлт гаргах ийм эрх зүйн орчин бүрдэх нөхцөл байдал үүссэн.

Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д тусгай зөвшөөрлийг цуцлахтай холбоотой 11 заалт байна. Үүний нэг заалт нь л Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай хамааралтай буюу 56.1.5-д тусгай зөвшөөрлийг цуцлуулах дүгнэлтийг холбогдох төрийн захиргааны байгууллага буюу Ашигт малтмалын газарт хүргүүлэхтэй холбоотой зохицуулалт байгаа юм.

Ямар үндэслэлүүд байна вэ гэвэл дүгнэлт гаргах үндэслэл байж байгаа. Байгаль орчинд хортой нөлөө үзүүлж байгаа, эсхүл нөхөн сэргээлт хийх менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаагүй гэж байгаа. 2023 онд үйл ажиллагаа явуулж үүнийг нь орон нутгаас 90%-тай дүгнэчихсэн. Үүнээс харахад 2023 оны явуулсан үйл ажиллагаан дээр менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлт үүргээ гүйцэд хэрэгжүүлээгүй байна гэдэг асуудал гаргаж ирдэг. Гэтэл орон нутгаас 90%-тай үнэлчихсэн. Үнэхээр үүнийг менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлээгүй бол нотлох баримтаа ирүүлээч гэдэг л шаардлага тавьж байгаа юм.

Хоёрдугаарт, байгаль орчинд хортой нөлөө үзүүлж байгаа бол 2020 оны БОАЖ-ын сайдын баталсан журмын дагуу хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар байгаль орчин хордож байгаа эсэх асуудлаар холбогдох баримт бичиг, нотолгоо дүгнэлтийг ирүүлэх гэдэг л шаардлага байгаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Дараагийн шинжээч “Халзан бүрэгтэй” ордын ашиглалтаас үүдэх байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлт танилцуулга.

Шинжээч Н.Наранцэцэг: Сайн байцгаана уу. Байгаль орчин, цаг уурын өөрчлөлтийн яамаар танилцуулсны дагуу одоогоор төслийн талбайд дараах байгаль орчны ажлууд хийгдсэн байна. Сая баталгаажсан ажлуудыг танилцууллаа.

2013 онд байгаль орчны археологи, палеонтологийн судалгаа хийгдсэн бол 2022 онд байгаль орчны төлөв байдлын судалгаа хийгдсэн байна. 2022, 2023, 2024, 2025 онуудад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын менежментийн

төлөвлөгөөг баталгаажуулсан. 2022, 2023 онуудад тус төлөвлөгөөний биелэлтийн тайлангуудыг мөн баталгаажуулсан байна. 2023 онд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулсан боловч баталгаажаагүй. 2024 онд байгаль орчин нийгмийн нөлөөллийн судалгааны тайланг боловсруулсан. Төсөл маань яг хаана явж байгаа юм бэ гэвэл одоогоор уг төсөл геологийн нарийвчилсан хайгуулын шатандаа явж байгаа ба одоогоор хайгуулын ажил зогсчихсон байгаа. Энэ цаг үедээ бол олборлолтод бэлтгэх ажлуудыг хийж эхлээд явж байгаа. Тэгэхээр төсөл маань яг нарийвчилсан хайгуулын үе шатандаа олборлолтод бэлтгэх үе шатад явж байгаа учраас байгаль орчны сөрөг нөлөөллийг нарийвчлан дүгнэх боломжгүй цаг үе дээр явж байгаа гэдгийг хэлмээр байна.

2022, 2023 онуудад дараах байгууллагуудаас Мянгад сумын Иргэдийн хурал, сумын Засаг дарга, ҮАБЗ, Уул уурхайн яам, Ховд аймгийн Байгаль орчны газар гэх 6 байгууллагаас нийт 8 удаагийн хяналт, шалгалт орсон байгаа. Цаашид байгаль орчны эрсдэлийг яаж, ямар байдлаар төсөл хэрэгжүүлэгч хариуцаж ажиллах юм бэ гэвэл, байгаль орчны орд ашиглахын өмнө хуульд нийцүүлэн холбогдох аргачлал, журмын дагуу боловсруулсан төслийн мэдээлэл, техникийн тодорхойлолт, талбайн байгаль орчны төлөв байдлын судалгаа, нийгэм эдийн засгийн үнэлгээ, болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ, дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөө, хог хаягдлын менежмент, нөхөн сэргээлт, хаалтын төлөвлөгөө, төслийн экологи, эдийн засгийн үнэлгээн дээр үндэслэн сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний хөтөлбөр, хяналт шинжилгээний хөтөлбөрүүдийг боловсруулсан байх ёстой.

Эдгээрээс байгаль орчны болзошгүй нөлөөллийг агаар, хөрс, газрын гадарга, гүний ус, ургамал, амьтан, нийгэм эдийн засгийн хүчин зүйлүүдээр тодорхойлдог. Халзан бүрэгтэй төслийн хувьд агаар, хөрс, ус, цацрагийн хэмжилтүүд илүү түлхүү хийгдсэн байна. Энэ нь 2022 оны төлөв байдлын биелэлтийн тайлангууд, 2023 оны байгаль орчны нарийвчилсан үнэлгээний судалгаа, 2024 оны олон улсын байгууллагын хийсэн судалгаан дээр илүү дэлгэрүүлж судалсан судалгааны үр дүнгүүдийг авч үзэж байна.

Үүнээс харвал агаарын чанарын хяналтын шинжилгээг хяналт мониторингийн цэгүүд болон төслийн талбайн ойролцоо байрлах өвөлжөө, хаваржааны байршлууд дээр хэмжилтийг хийсэн. Зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан үзүүлэлт гараагүй. Дуу чимээний хяналт шинжилгээ мөн эдгээр цэгүүд дээр давтан хийсэн. Усны шинжилгээг гол, гадаргын ус болон малчдын худгуудаас хийсэн байна. Үүний чанарын үзүүлэлтүүд нь стандартаас давсан үзүүлэлт байхгүй.

Хоёр үзүүлэлт бага зэргийн өөрчлөлттэй гарсан байсан. Усны шинжилгээг дараах стандартуудтай харьцуулж үзсэн. Төслийн талбай дахь хөрсний шинжилгээг мөн мониторингийн цэгүүдэд давтан авсан. Шинжилгээний үр дүнгээс хүнд металлын бохирдол илрээгүй дүгнэлтүүдийг гаргасан. Цацрагийн хяналтын хувьд эхний зураг дээр төслийн талбайгаас алслагдсан зайд, бүс нутгийн хэмжээнд цацрагийн хяналтын цэгүүдийг төслийн талбайн усан дахь цацрагийн хяналт мөн төслийн талбайг бүхэлд нь торлох байдлаар хяналтын цэгүүдийг эдгээр дээжүүдийг хяналтын зорилгоор цаашид төлөв байдал болгох зорилгоор хийгдсэн.

Цацрагийн чиглэлээр Төрийн байгууллагын хяналт, шалгалтын мэдээ тайлан, улсын байцаагчийн гаргасан дүгнэлт болон олон улсын зөвлөх үйлчилгээний байгууллага, итгэмжлэгдсэн лаборатори, төсөл хэрэгжүүлэгч байгууллагын 2012 оноос 2025 онуудад хийгдсэн шинжилгээний дүн, судалгаа, тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж ажиллалаа. Тооцоолол дүн шинжилгээг хөрс, ус, радоны хуримтлалын дүн болон гамма цацрагийн тунгийн чадлын хэмжилтээр бүлэглэн авч

үзсэн. Тус үр дүнгүүдийг нэгтгэн дүн шинжилгээ хийхэд хөрсний дээжид агуулагдах кали, уран, торийн агуулга Цацрагийн аюулгүйн нормд заасан чөлөөлөгдөх түвшний утгаас 1.06-2.41 дахин их, гамма цацрагийн тунгийн чадлын хэмжилтийн утга 4-8 дахин их, радоны хуримтлал -хэмжилтийн 1 цэгт 1.2 дахин их, усан дах цацраг идэвхт изотопуудын үзүүлэлт Цацрагийн аюулгүйн норм, MNS09005:2018- стандарт заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй гэсэн дүгнэлтүүд гарч байсан байна. Хэмжилт шинжилгээний дүнгээс харахад өндөр гарсан цэгүүд нь Халзан бүрэгтэй ГХЭ-ийн төслийн талбайд байрлаж байгаа бөгөөд Тус талбайн ойролцоо суурьшин амьдардаг малчин иргэд, мянгад сум, ховд аймгийн төвүүдэд хийгдсэн гамма цацрагийн тунгийн чадлын хэмжилтүүд монгол орны дэвсгэр түвшнээс хэтэрсэн үзүүлэлт ажиглагдсангүй.

Халзан бүрэгтэй газрын ховор элементийн төслийн талбайд хамгийн өндөр хэмжигдсэн 1.67 микроЗивер.цаг буюу монгол орны дэвсгэр түвшнээс 8 дахин өндөр гарсан утгыг монгол орны болон олон улсын зарим цэгүүдтэй харьцуулсан байдлаар диаграмм дээр харуулсан байна. Үүнээс харахад цацрагийн тун өндөр байдаг нүүрс, алт, жоншны уурхайнуудын зарим цэг болон газрын хөрсийг хөндөөгүй байгалиараа оршиж байгаа уул, тал, рашаануудын зарим цэгийг жишээ болгон татаж харьцуулсан байгаа. Тухайлбал Бразил улсын Гуарапари гэх газар нь Атлантын далай эрэг дагуух аялал жуулчлалын бүс нутаг, 100 гаруй мянган хүн амьдарч, хэдэн сая жуулчин зорчдог бөгөөд далайн эргийн элс нь цацраг идэвхт элемент ихээр агуулдаг учир байгалийн цацрагийн тун нь 10 микрозивер.цаг хүртэл заадаг юм байна. Энэ нь 1.67 микрозивер.цаг гэж тэмдэглэгдсэн цэгийн цацрагийн тунгаас 6 дахин их, Мянгад сумын цацрагийн фоноос 91 дахин их гэсэн үг. Мөн иргэд Дорнод аймгийн Мардайн орхигдсон уурхай болон Дорноговийн зөөвч овоон зарим цэгүүдтэй адилтгаж ойлгоод байдаг. Эдгээр газруудын өндөр хэмжигдсэн цэгүүдээс даруй 3-5 дахин бага байхнээ.

Ер нь дэлхий дээр оршин байгаа амьтай амьгүй бүхий л биет, хүрээлэн буй орчин, хоол хүнс, агаар, хөрс, чулуулаг, сансар огторгуй өөрийн гэсэн тодорхой хэмжээний цацрагийг цацаргаж байдаг. Жишээлбэл: хүн жилд хоол хүнс, хөрс, агаар, сансрын туяа, хүний хүчин зүйлээр бүтээгдсэн зарим нөлөөллөөс хамааран ойролцоогоор 2700 микрозивер тунг авдаг гэж олон улсын баримт бичигт дурдагдсан байдаг. Тэгвэл бид Халзан бүрэгтэй ГХЭ-ийн төслийн талбайд хамгийн өндөр хэмжигдсэн 1.67 микрозивер.цаг заадаг цэгийн утгыг эрүүл мэндийн салбарын бидний амьдралд хамгийн ойр хэрэглэгддэг шүдний рентгенд 0.1секундийн хугацаанд буюу 1 удаа зураг даруулах утгатай харьцуулахад 3 дахин бага, онгоцоор нэг удаа нисэхэд сансрын туяанд өртөх тунгаас 150 дахин бага байгааг дараах хүснэгтээс харж болно.

Нийгмийн нөлөөллийг авч үзэхдээ хүн амын амьжиргааны хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн, боловсролын, дэд бүтэц, малын эрүүл мэндийн үнэлгээ, орон нутгийн иргэдийн оролцоо, нийгмийн нөлөөлөл гэсэн бүлгүүдийг багтаан авч үздэг. Ховд аймгийн Мянгад сумын хүн амын байдал нь 2024 оны байдлаар 3733 хүн амтай, 2012 онд 3400 байсан бол 9,8%-аар нэмэгдсэн. Сумын төв Баянхошуу баг 911 хүнтэй, Баянцагаан, Гахайт, Баянбулаг, Чацарганат багуудад төсөл хэрэгжиж байгаа. Гахайт баг маань хамгийн бага буюу 308 хүнтэй байна. Өрхийн тоо нь 950, үүнээс сумын төвд 232, хөдөө 722 айл амьдардаг. Хүйсийн харьцаа эрэгтэй 50,7%, эмэгтэй 49,3% байна. Эдгээрээс хөдөлмөрийн насны 15- 64 насны хүмүүс 61,3%-ийг эзэлдэг. Ховд аймгийн Мянгад сумын эрүүл мэндийн байдлыг улсын хэмжээнд халдварт бус өвчлөлтэй харьцуулбал аймгийн хэмжээнд ийнхүү өссөн төлөвтэй байгаа, дундаж улсын дундаж хэмжээтэй харьцуулаад үзвэл харьцангуй бага гэсэн судалгаа байна. Ховд аймгийн 17 сумыг халдварт бус өвчнөөр нь ангилаад үзвэл Мянгад сум 4 дүгээрт явж байгаа. Хүн амын эрүүл мэндийн байдлаар халдварт бус өвчний тэргүүлэх шалтгаан нь улсын хэмжээнд нийтдээ амьсгалын тогтолцооны

өвчин байгаа бол баруун бүс Ховд аймаг, Мянгад сумын хувьд хоол боловсруулах тогтолцооны өвчин тэргүүлэх байр суурьтай байна. Улсын хэмжээнд мал эмнэлгийн халдваргүй өвчлөлийг аваад үзэх юм бол мал эмнэлгийн эрүүл мэндийн газраас гаргасан тоон мэдээлэлд улсын хэмжээнд малын халдваргүй өвчлөлийн тоо 2024 оны байдлаар Архангай, Өмнөговь, Дорнод аймгуудад хамгийн их буюу 4396-8436, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Сүхбаатар аймагт хамгийн бага буюу 53-348 гэж бүртгэгдсэн байна.

2025 оны хаврын мал төллөлтийн үеэр Мянгад сумын Цагаанбулаг, Гахайт, Баянбулаг багуудад гарсан ургийн гажигтай төллөлт мал эмнэлгийн ариун цэврийн станцын төв лабораторид гаргасан дүгнэлтийг танилцуулъя. Цагаанбулаг суманд баруун урд хөл нь бугалганы үеэрээ дээшээ нурууны хэсэг рүү эргэсэн байрлалтай толгой буюу чамархай хэсэг нь ивэрхий, толгой усархаг хавантай нэг хурга төрсний Улсын мал эмнэлгийн ариун цэврийн станцын лабораторийн шинжилгээний үр дүн нь хар тугалга, зэс, төмөр хэвийн хэмжээнд, цайр хэвийн хэмжээнээс бага илэрсэн. Элэг бөөрөнд Ц3137, тори 232, ради 226, кали 40 зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна гэсэн дүгнэлт гарсан байна.

Мөн Гахайт баг дээр гарсан баруун урд мөчний хөгжил дутуу, далны урд үеэс урагш хөгжилтэй 3 хөлтэй ишиг төрсөн гэсэн. Шинжилгээний хариу бол Цз 137, тори 232, ради 202, зөвшөөрөгдөх хэмжээнээс бага, байгаль дээр оршдог цацраг идэвхт изотоп, кали 28,9 бикрил килограмм буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс бага гэсэн дүгнэлт гарчээ. Мөн цээж, хэвлийн хэсгээр бүдүүрч, цүлхийсэн хэвлийн хэвийн бус бүтэцтэй, анусын амсар битүү хурганы хувьд шинжилгээний хариу ирээгүй байна. Дараагийн нэг толгойтой, нэг биетэй, 6 ширхэг хөлтэй, анх татаж гаргахад 8 хөлтэй байсан, толгойн хэсэг нь 2 чихнээс урагш байхгүй гэсэн 2 ишиг, хурга мал эмнэлгийн лабораторид хадгалагдаж байгаа гэсэн мэдээлэл ирсэн байна. За саяын өвчлөлийн талаарх шинжлүүлэх болон шинжилгээний үр дүнгүүдийн албажуулсан байдал нь Монгол орны хэмжээнд халдваргүй өвчний нөлөөллийн бусад хүчин зүйл буюу аймгуудын халдваргүй өвчнүүдийг ийнхүү бүртгэсэн байдалтай байна.

Ховд аймгийн хувьд малд илрэх бодисын солилцооны эмгэг өвчний шалтгаан нь эрдсийн дутагдал, иодын дутагдал гэж бүртгэгдсэн. Ургамлын хордлогын талаар зургаас харахад Ховд аймгийн Буянт, Ховд гол дагуу хорт ургамлын тархалт элбэг болохыг харуулж байна. Манай эрдэмтдийн судалгаанаас үзэхэд Монгол орны байгаль, цаг уурын өөрчлөлт, экологийн сөрөг хүчин зүйлүүдээс шалтгаалан ургамлын зүйлийн бүрдэл өөрчлөгдөж улмаар хорт үйлчилгээтэй бодис агуулагдаж байна гэсэн. Энэ нь тэсвэртэй ургамал ихээр тархан ургаснаас мал бөөнөөр болон гэнэт хордох, нээлттэй мал идэх, идсэн тохиолдолд ургийн гажиг үүсэх магадлалтай гэсэн зүйлүүд байдаг гэсэн байна. Хариуцлагатай уул уурхай, зөвшилцлийн талаарх олон улсын сайн туршлагуудыг Монгол оронд хэрэгжүүлээд явж байгаа. Үүний талаар дурдаж өгөх юм бол үүнд олон талт оролцооны, олон талт оролцогчдын зөвшилцлийн механизм иргэдийн оролцоотой хяналт шинжилгээ хариуцлагатай уул уурхайн кодекс, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын загвар, соёлын өв хамгаалах тусгай бүсийг тогтоох зэрэг ажлууд хийгдэж байгаа юм байна.

Үүнийг бас манай Монгол оронд хэрэгжүүлээд хийгээд эхлээд явж байгаа. Эдийн засгийн зах зээлийн хандлагын хувьд болохоор өмнө танилцуулсан, манай нөөц нь Монгол Улс дэлхийд эхний 10-т багтдаг юм байна. Олборлолтоор 5 саяыг олборлоно гэвэл манай улс тэргүүлэгч улсуудын тоонд орохоор байна. 2023 онд батлагдсан техник эдийн засгийн үндэслэлээр 5 сая тонноор гэж 15 жилийн хугацаатай баталсан. Үүнийгээ гравитац, флотацын аргаар баяжуулна гэсэн байгаа. Энэ аргаар баяжуулах технологийн эдийн засгийн үр дүнгүүдийг харуулсан байна.

Нарийвчилсан судалгааны үр дүн нэмүү өртөг шингэсэн гүн боловсруулалт хийх, газрын ховор элементийн элсэлт гарган авах нь.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа. Шинжээч нар мэдээллээ хийгээд дууслаа. Нарийвчилсан мэдээллүүд байгаа учраас та бүхэн танилцуулгыг нь аваад танилцаж болно. Ер нь өнгөрсөн 2 сарын хугацаанд би амралтгүйгээр олон талт уулзалтуудыг хийж, судалгаан дээрээ сууж ажиллалаа.

Ер нь энэ малын гоц халдварт өвчин гэж бид нар илүү ярьдагаас илүүтэйгээр халдваргүй өвчний асуудал ер нь Монгол Улсад хүндэрчихсэн юм байна лээ шүү. Халдварт өвчин гэж яриад баахан вакцин урдаас оруулж ирж шахдаг болчихсон ийм бүлэглэл өнөөдөр Монголд амьдраад байдаг. Тэгтэл өнөөдөр зүүн аймгаас баруун аймаг руу адуу зөөж байхдаа битүү туйраагаар нь хөрсний бохирдлыг зөөн авчирч малын эрдэс бодис хүрэхгүй энэ мэт хортой ургамлыг орон нутагтаа ургуулах ийм нөхцөлийг бүрдүүлж байгаа судалгааг бид нар хийдэггүй. Тэгээд судалгааг хийхэд зайлшгүй тодорхой төсвийн хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа. Энийг би дараа ярина. Үүнийг хийж байж өнөөдөр бид мал яг ямар өвс идээд байгааг, 20 жилийн өмнө бид нарыг бараг давах гээд ургадаг байсан өвс өнөөдөр ургаж байна уу, ургахгүй байна уу, энэ ургаад байгаа өвс өнөөдөр зэрлэг юм уу, эсхүл эрдэс бодис нь бүрэн ханачихсан юм уу гэдэг асуудал дээр судалгаа хийх ёстой.

Аливаа асуудалд цаашид 7 хэмжиж нэг огтлох буюу шинжлэх ухаанч байр сууринаас хандаж байх ёстой. Бид өнөөдөр малын махаа өөрсдөө идэж байгаа шүү дээ. Тэгээд энэ мал өнөөдөр юу идэж байна, юу ууж байна? Энийгээ бид нар шинжлэхээ байчихсан. Энэ өвсийг бид нар шинжилж байгаа юм уу, өвчнүүд гарахаар л нэг баахан хилийн гаднаас вакцин оруулж ирж шахдаг. Малыг гоц халдварт өвчин гэж баахан хөл хорио тогтоодог. Өнгөрсөн хугацаанд нэг ийм л нөхцөл байдал үүсчихээд байгаа шүү. За мэдээлэл хийгээд дууслаа. Ингээд цайны завсарлага 30 минут болно. Сонсгол түр завсарлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Ховд аймгийн Мянгад сумыг төлөөлөн 2 хүн, 5 минутаар мэдээлэл хийнэ. Үүний дараа Ховд аймгийн Мянгад сумын иргэдийн төлөөлөл 25 хүн тус бүр 3 минутаар үг хэлнэ. Үүний дараа сонсголд оролцож үг хэлэхээ илэрхийлсэн, цахимаар санал ирүүлсэн 17 хүн үг хэлнэ. Үүний дараа Тамгын газрын ажилтнууд бичгээр үг хэлэх иргэдийн нэрсийг танхимд цаасаар аваад явж байгаа. Үүнээс мөн хүмүүсийн тоо гарч ирнэ. Ингээд бид нар 15:00 цаг хүртэл үргэлжилнэ. Дараагийн мэдээлэл Халзан бүрэгтэйн асуудлууд сэдвээр танилцуулгыг Г.Төрмөнх хийнэ. 6 номерын микрофоныг өгье.

Мянгад сумыг төлөөлж, оролцогч иргэн Г.Төрмөнх: Сайн байцгаана уу? Оролцогчдын амгаланг айлтгая. Халзан бүрэгтэйг тойрсон асуудлууд дээр олон нийтийн мэдэх эрхийн өмгөөлөл хийсэн байгууллагыг төлөөлж байгаа, уг асуудлаараа та бүхэнд мэдээлэл хийе.

Халзан бүрэгтэйг тойрсон асуудал дээр хэд хэдэн ноцтой асуудал байгаа. Нэгдүгээрт, нөлөөллийн бүсийн болон бүс нутгийн иргэд тэрчлэн нийтийн эрх ашиг зөрчигдөж байгаа асуудал, дээрээс нь хууль захиргааны зөрчлийн асуудлууд бодитой байгаад байгаа. Яагаад нийтийн эрх ашгийн зөрчил гараад байгаа юм гэвэл нэгдүгээрт нь, Монголиан нэйшнл рийр ийр корп компани нь Халзан бүрэгтэйн ордын тусгай зөвшөөрлийг хууль бусаар авсан. Үүнд 2 үндэслэл байгаа нэгдүгээрт, тухайн компани цацраг идэвхит ашигт малтмалын лицензийг авсан болж таарч байна. Цөмийн энергийн тухай хуулийн 3.1.5-д заасны дагуу мөн 3.16-д заасны дагуу нотлогдоно. Гэтэл Цөмийн энергийн тухай хуулийн дагуу тухайн компани 2009 оны 11

дүгээр сарын 15-наас өмнө энэ лицензийг цацраг идэвхит энгийн ашигт малтмалын лицензийн шугамаар авчсан. Цацраг идэвхит ашигт малтмалын лиценз болгож шилжүүлж, шинэчлэх ёстой байсан боловч шилжүүлэхгүй байгаа. За энэ нь Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх тухай хуулийн 1 болон 4 дүгээр зүйл заалтын дагуу цуцлагдах ёстой байгаа.

Хоёрдугаарт, Ашигт малтмалын болон Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан заалтуудаа анхнаасаа огт биелүүлэхгүй явж ирсэн. Тухайлбал, байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хууль бусаар батлуулсан нь 2017 онд улсын байцаагчийн дүгнэлтээр тогтоогдоод хүчингүй болсон. Мөн тэр дороо Байгаль орчны яаман дээр татаж аваад дахиад баталж өгсөн. Байгаль орчны яам баталж өгөхдөө мөн хууль бусаар баталсан. Энэ нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлах тайлагнах журмын 1.6, 2.9, 3.1, 3.3, 3.5-д заасан заалтуудыг нууцаар зөрчиж байгаа гэх мэтчилэн. Энэ асуудлуудаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд Мянгад сумын ИТХ, Засаг дарга түүнчлэн төрийн бус байгууллагуудаас Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 түүнчлэн тухайн хуулийн 40 дүгээр зүйлд заасанг зөрчсөн талаар хамтарсан өргөдөл гаргасан. Гэсэн хэдий боловч энэ материал одоог хүртэл шийдэгдэхгүй явж байна.

Сая яамны газрын даргын тавьсан мэдээлэлтэй нэг талаараа би санал нийлэхгүй байгаа. Энэ материал журмын тухайн асуудлыг хэлэлцэж шийдэх сайдын тушаалаар батлагдсан журмыг бүрэн хангаад бүх материал нь хүргэгдчихсэн байгаа.

Гуравдугаар асуудал нийтийн эрх ашгийн зөрчил гэдэг дээр тухайн компани ард иргэдийн эрхийг ноцтойгоор зөрчих асуудлууд байнга давтагдаж байгаа. Тухайлбал тухайн бүс нутгийн иргэдэд байгаль орчны үнэлгээний тайланг зөвшөөрүүлэх дүгнэлт гаргуулахын тулд янз бүрийн эд зүйл тараадаг гэх мэт. Тэрчлэн Ашигт малтмалын тухай хуулийн дагуу орон нутагтай хамтрах ажиллах гэрээ байгуулаагүй, нийгмийн лиценз аваагүй, олон нийтээс хүлээн зөвшөөрөгдөөгүй буюу бүс нутгийн, нөлөөллийн бүсийн иргэдээс хүлээн зөвшөөрөгдөөгүй хэрнээ тэнд хөрөнгө оруулалт хийх нэрийдлээр элдэв хүмүүсийг татах гэсэн элдвийн арга явуулдаг гэх мэтчилэн асуудлууд байгаад байгаа.

Эдгээрийг тодорхой нотлох баримтууд дээр харуулж болно. Тухайлбал энэ цацрагийн шинжилгээний дүнгийн тухай сая шинжээчид танилцуулсан 2022 онд ҮАБЗ-өөс хийгдсэн шалгалтын дүгнэлтэд Цөмийн энергийн комиссоос гарсан дүгнэлт энд байж байна. Ялангуяа лабораторийн шинжилгээний дүнгүүд дээр бол тодорхой магадлан шинжилгээ хийгдсэн байдаг. Мөн үүнтэй холбоотой Халзан бүрэгтэй төслийн хувь заяа яах вэ гэдгийг урьдчилан судалж үзээд Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд Цөмийн энергийн комиссоос хүргүүлсэн албан бичиг гаргаж байна. Тэгэхээр Халзан бүрэгтэй орд нь эдийн засгийн хувьд үр ашигтай гэж үзэх боломжгүй сөрөг нөлөөлөл нь давамгайлж байна. Ялангуяа эндээс гарах хаягдал тэр тусмаа цацраг хаягдлыг зайлуулах булшлах гэх мэтчилэн нарийн асуудлууд байна.

Олон нийтийн эрх ашиг зөрчигдөж байгаа, лабораторийн шинжилгээний дүн энд харагдаж байна. Ард иргэдийн эрх ашиг нөлөөллийн бүсийн малчдын асуудал байгаа. Малын ургийн гажигтай төлийн бүртгэлийг бол сая цухас танилцуулж байна.

Харьцуулсан судалгааны дүн байгаа. Ховд аймгийн Мал эмнэлгийн газраас гаргаж өгсөн. Тэгэхээр сүүлийн 10 жилийн байдлаар Ховд аймгийн 17 сумаас бусад ямар ч суманд ийм ургийн гажигтай тохиолдол илрээгүй байгаа. Гагцхүү 2022 оноос хойш Мянгат суманд 8 тохиолдол илэрсэн байгаа. Бичлэг байж байгаа, бодитой байгаль орчны ноцтой асуудал байгаа.

Байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэсэн тухай сая танилцуулж байна. Байгаль орчны ерөнхий үнэлгээний зааврын дагуу археологийн судалгаа заавал хийлгэх ёстой байдаг. Археологийн судалгааг хийлгэхдээ тухайлбал ШУА-ийн тодорхой судлаачдаар дүгнэлт гаргуулаад хавсаргасан байсан. Тэр судалгаа нь археологийн ямар ч дурсгал байхгүй гэж дүгнэсэн байсан. Гэтэл 2022 онд Ховд аймгийн соёлын өвийн судлаач Бямбасүрэнгээр ахлуулсан судлаачид энэ дээр яг лицензтэй талбайтай давхцуулаад соёлын өвийн үл хөдлөх үнэт дурсгалууд илрүүлсэн. За тэгээд улсын цахим бүртгэлд бүртгүүлсэн баримт нь энд харагдаж байна. Ашигт малтмалын тухай хуулийн 40 дүгээр зүйл Соёлын өвийн тухай хуулийн 38.1.2 3-ыг ноцтой зөрчиж байгаа асуудал байгаа.

Усны асуудал байгаа. Тухайлбал эрх бүхий төрийн байгууллагууд тухайн компанийн ус ашиглах дүгнэлт зөвшөөрлийг олгохдоо хууль журмуудыг зөрчиж олгосон гэдэг асуудлаар олон удаа гомдол гарч шалгагдаад усны газраас нэг удаа хүчингүй болгож байсан боловч дахиж баталж өгсөн. Энэ ноцтой асуудал баримтаар харагдаж байна. Компанийн нөлөөллөөс болоод малын үс ноос нь хавсарч унаад бөөн өвчин, янз бүрийн өвчин тууралт болоод гомдол гаргаад гомдлыг аймгийн ИТХ-ын шийдвэрийн дагуу ажлын хэсэг шалгаад, лабораторийн шинжилгээ тогтоогоод дүгнэлт гаргасан. Энэ асуудал гарцаагүй компанийн үйл ажиллагааны нөлөөллөөс болсон учир танай компани энэ малчны хохирлыг барагдуулж өг гэдэг. Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын албан бичиг компанид хүргэгдсэн ийм асуудал байна тэр баримтууд нь харагдаж байна. Тэгэхээр иймэрхүү ноцтой асуудлууд байгаад байгаа.

Тэгэхээр энэ зөрчлүүдийг шалган шийдвэрлэх асуудал хуулийн дагуу явагдахгүй байгаа гэдэг асуудал дахиад цааш үргэлжилнэ. Энэ асуудлуудыг сая манай төрийн захиргааны төв байгууллагын нөхдүүд яг энэ зөрчилтэй холбоотой тухайн нөхцөл дээр яг ямар асуудал болоод байгаа юм бэ гэдэг тал дээр огт ярихгүй байна. Энэ асуудлын талаар цаашдаа Улсын Их Хурлын гишүүд маань анхаараад яг энэ асуудалд төвлөрч далайцтай судалгаа шинжилгээ хийлгэх, бүх талын оролцоог хангасан хяналт шалгалтын баг бүрдүүлж шалгуулж асуудлыг тогтоох ёстой гэсэн байр суурьтай байна. За баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Г.Төрмөнх танд баярлалаа. За дараагийн мэдээллийг манай Ховд аймгийн Засаг дарга асан Г.Нямдаваа дарга Халзан бүрэгтэйн уул орчмын байгаль орчны асуудал сэдвээр 5 минутын хугацаанд танилцуулга хийнэ. Г.Нямдаваа даргын микрофоныг өгье.

Мянгад сумыг төлөөлж, оролцогч иргэн Г.Нямдаваа: За баярлалаа. Өнөөдрийн мэдээлэл дээр нэлээд зүйлийг сонслоо, ихэвчлэн хуучин мэдээллүүдийг голдуу сонслоо. Хоёрдугаарт та бүхэн мэдээллүүдээс харсан байх гэж бодож байна. Байгаль орчинтой холбоотой Байгаль орчны яамны газрын даргаас өөр ер нь юу ч сонсогдсонгүй гэж хэлж болно. Тэгэхлээр энэнтэй холбогдуулаад зарим нэг зүйлийг би товчхон мэдээлэл хийе.

Бид нар ямар газрын байршил дээр, ямар байгалийн тухай яриад байгаа юм бэ? Энэ зургийг сайн харах хэрэгтэй байгаа юм. Эргэн тойрон нуур, гол, Алтан Хөхийн уулын наад талаар Ховд голын өргөн хөндий тэгээд урд талд нь конвенцод орчихсон дэлхийн ЮНЕСКО-ийн тусгай жагсаалтад орсон нүүдлийн шувуудын гол их нутаг болсон Хар ус нуур тэгээд цаашаагаа Тээлийн голоороо дамжаад Завхан гол руугаа нийлчихдэг Завхан голоосоо хойшоо Айраг нуурлуугаа цутгадаг Айраг нуураасаа хойшоо Хяргас нуур луугаа цутгадаг. Өөрөөр хэлэх юм бол манай Монгол

орны усны сангийн 40% асар их баялагтай ийм нутаг. Тэгтэл Халзан бүрэгтэй маань бол би нөгөө заавар байхгүй учраас энийг заах боломжгүй байна. Тэр наад талын хошуун дээр байгаа хүрэн уул, хойд талд нь төрийн тахилгатай Алтан Хөхийн уул Монгол Улсын нөөц газар гэдэг ангиллаар улсын тусгай хамгаалалтад авчихсан нутаг. Урд талынх нь Хар Ус нуур болохоор байгалийн цогцолбор газар, 2 дархан цаазат тусгай хамгаалалттай газар нутгийн дунд нь байж байгаа юм.

Бүс нутгийн маань өөрийнх нь эко систем бол маш их эмзэг. Салхи гэхэд бараг байнгын 7-10 метр секундийн салхи өдөр тутам дээд тал нь 35 метр секундийн хурдтай салхилдаг. Тэнд олборлолт явлаа гэхэд 75 сая.куб.метр газар шороог ухаж ил гаргах юм. Та бүхэн илтгэл дээрээс харсан байх. 19 сая.куб.метрийг нь зөөх нь байна. Энэ хугацаанд хэчнээн дэлбэлэлт, тэсэлгээ үндсэндээ энэ уулыг орвонгоор нь эргүүлээд овоолсон шороо болгоно. Тэр орчмын нутаг бол бүхэлдээ овоолсон шороо л болно. Их олон байгалийн экологи яаж сүйрэхийг дараагийнх нь зураг дээрээс харуулъя. Энэ бол Халзан бүрэгтэй, Мянгад сумын нутагт хоёрхон шүтлэгтэй сайхан хайрхан байгаа юм. Нэг нь Халзан бүрэгтэй хайрхан цаад талд оргилоор нь харагдаж байгаа нь төрийн тахилгатай Алтан Хөхий уул. За тэгэхээр энэ 2 хайрханы наад талынх нь бол нэг ёсны овоолсон шороо болгох тал руугаа орох гээд байгаа юм. Дараагийнх нь, миний хэлсэн ийм сайхан цэнгэг устай Ховд гол, Хар ус нуур, яг хойд тал дээр нь Зээрэн нуур гээд уулын нуур байгаа. Эдгээр нууруудын дунд нь байж байгаа тэнд болсон тоосжилт мөдхөн л ерөөсөө тэр бүгдийг хамрах ийм бүрэн бололцоотой.

Амьтнаас дандаа бидний бахархал болсон аргаль, янгир, ирвэс, улаан номд орчихсон зэгсний улаан гахай гэх мэтчилэнгээр амьтны зүгээр жишээ болгоод харуулж байна. Шувууд гэхэд л хотон, хун, алтан гургуул гээд ерөөсөө л манай Монголын нүдний гэм болсон ховор энэ голууд нь, уснууд, нь шувууд маань нүүдлийн хамгийн гол цэг болсон эндээ ирж нутагладаг. Бид Японоос судлаачтай хамтраад 3 газраас шувуунд бөгж зүүхэд бидний Ховд аймгаас буусан тогоруу Гималайн нуруун дээгүүр 9 метрийн дээгүүр асар хүчтэй шуургыг туулж байж Энэтхэгийн далайд очиж бууж байгаа юм. Тэгэхээр шувуу судлаачдын хамгийн гол сонирхол болсон цэг учраас Хар ус нуур нь конвенцод орчихсон байхгүй юу. Тэгэхээр ямар нэгэн байдлаар хортой нөлөөлөл үзвэл экологи өөрчлөгдлөө гэхэд л ийм их хэмжээний сүйрэл учрах ийм бүс нутаг юм.

Олборлолтын нөлөөлөлтэй холбогдуулаад Ховд голоос гэхэд л 8-12-хон километрийн зайтай тэгсэн мөртлөө Халзан бүрэгтэй уул маань далайн түвшнээс дээш 1800 гаруй метр өндөртэй, Ховд гол маань 1100 гаруйхан метр өндөртэй дээрээсээ шууд урсаад доошоо гулгаад хөрсний гулгалт ийм шилжилтүүд зөвхөн салхиар биш усны урсгалаар орж ирэх ийм бүрэн бололцоотой, ийм бүс нутаг юм.

Үүнтэй холбогдуулаад хэлэхэд сая танилцуулсан мэдээллүүд дээр судлаачид ураны юм байдаггүй, цацраг байхгүй гэсэн. Гэхдээ энэ нь маш аюултай. Экологийн эсрэг дандаа худал мэдээлэл ард түмний дотор явуулж байгаа юм. Жишээлбэл Оросын Коваленко тэргүүтэй эрдэмтэд 1987 онд судалгаа хийсэн гээд түрүүн ярилаа шүү дээ. Циркон газрын ховор элемент, ялангуяа нитри, уран, тори гээд заачихсан. Ингээд Оросын эрдэмтэд дүгнэлт гаргасан байгаа юм. Тэгтэл манай нөхдүүд юу гэж хэлж байна гэвэл цацраг бодис байхгүй гэдэг. Цөмийн энергийн комиссын ажлын хэсгийн дүгнэлтийг хүртэл худлаа яриад явж байгаа юм. Жишээлбэл, ар талд нь 113 эрдсийг тодорхойлсон байна.

Үүний 64 дээр нь торигийн өндөр хэмжээнд байгааг нь 2004 онд хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллэгт байгааг би та бүхэнд толилуулж байна. Мөн ялгаа

байхгүй та бүхэн ерөөсөө кларк гээд газрын энгийн түвшинд байдаг хэмжээнээс хэд нь 100 дахин илүү өндөр хэмжээ байгааг танилцуулга дээрээс харж болно. Үүнд 4-т хар тугалга, 5-д уран гээд биччихсэн байгаа. Тэрүүгээр доош тоог нь харахад дээд тал нь 1419 хүртэл тоо байж байгаа. Тэгвэл энгийн түвшиндээ 3,4-өөс хамгийн ихдээ 7 хүрдэг. Тэгэхээр энэ хэмжээний байна гээд тэр үеийн судалгаагаар маш нарийн анализ хийгээд гаргачихсан байх жишээтэй.

Байгаль орчны чиглэлийн хууль тогтоомжууд хэрхэн зөрчигдөж байгаа талаар сая эхний мэдээлэл дээр орлоо. Зарим нь давтагдаж байгаа байх. Ерөөсөө хуулийн дагуу явдаггүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө батлуулдаггүй, батлуулалгүй олон жил болчихоод дараа нь хуулиа зөрчөөд дахиад батлуулдаг ийм байдал ажиглагдаж байгаа юм. Жишээлбэл, түрүүнд Э.Энхмөнх даргын мэдээлэлд ерөнхий үнэлгээний дүгнэлтийг нь 2002 онд яамнаас өгчихсөн. Ингэхдээ 2002 оны 4 дүгээр улиралд багтааж нарийвчилсан үнэлгээгээ танилцуул гээд хугацаа заагаад өгдөг. Э.Энхмөнх дарга аа энэ чинь хүчингүй болох хугацаа нь болчихсон шүү. Монголын судлаачдын зүйлийг хүртэл байж байна. Та бүхэн энийг уншаад үзээрэй. “Халзан бүрэгтэй газрын ховор элементийн ордын хувьд ойролцоогоор хагас сая.тонн газрын ховор элементийн ислийн нөөцтэй боловч хүдрийн металлын агуулга маш бага байдаг. Гарган авах баяжилтын металлын агуулга маш бага учраас баяжмалаа гидрометаллургийн аргаар боловсруулах туршилтууд хийгдээгүй гэх мэт шалтгаанаас болж эдийн засгийн эргэлтэд оруулахад хүндрэлтэй.” гээд дүгнэлт гаргачихсан. Энэ ерөөсөө 2 жилийн өмнө хурал дээр тавигдсан хэд хэдэн Мушгиа худаг хооронд нь харьцуулсан... (минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: 5 номерын микрофоныг 2 минут сунгачих.

Оролцогч Г.Нямдаваа: За баярлалаа. Ингээд дахиад нөгөө тори, уран зэрэгтэй маш сайн илэрсэн эерэг хандлагатай бөгөөд тэр нь ихсэхэд агуулга нь жигд ихсэж байна гээд дүгнэчихсэн байгаа юм. Эрдэмтэд, ШУТИС-ийн профессор, Германы профессоровын хамтарсан илтгэл байж байгаа юм. За ингээд худлаа хэлээд байхаар нь компанид Цөмийн энергийн комиссынхон “та нар ингээд буруу худлаа хэлсэн контент бичээд байна, энийгээ боль, залруул гээд” шаардлага хүргүүлж байгаа шүү дээ. Та бүхэн энэ дээрээс харж болно. Нөгөө энгийн цацрагийн дээд түвшний дундаж утгаас 7-8 дахин өндөр байна гээд тодорхойлчихсон юмыг байхгүй ээ гээд ард түмний дотор Ховдын бүх сумын хүмүүст худлаа хэлээд сурталчилгаа хийж байгаа байхгүй юу. Ингэж худлаа хэлээд байгаа хүмүүс ард түмэн биднийг яаж ч хуурахаас буцахгүй.

Ер нь ард түмэн дотор энэ компанийн нэр хүнд цаад эздээс нь хамаараад хүртэл дандаа л хулхидаж явдаг. Нөгөө л Эрдэнэбилиг бүүр нэр хүнд нь хүртэл навс уначихсан байж байгаа шүү дээ. Тэгсэн хэр нь дахин дахин ичихгүй нэмж худлаа хэлээд яваад байх юм. Тийм учраас миний энэ дээр онцгой хэлэх нэг юм яг үнэн бодитой мэдээллээр ард түмнийг зөв хангаж байж дараа нь учраа ойлгуулах тал дээр явна шүү. Иймэрхүү байдлаар яваад ерөөсөө хол явахгүй гэдгийг онцгой анхааруулах хэрэгтэй. За жишээлбэл Цөмийн энергийн тухай хууль, цөмийн бодис гэж цөмийн материал болон цөмийн технологид хэрэглэгдэх уран торын бүлийн цацраг идэвхт изотоп газрын ховор элемент агуулсан бодисыг, энэ дотор нөгөө газрын ховор элемент гээд бүр хуульчлаад оруулчихсан байгаа шүү дээ.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Г.Нямдаваа дарга болчихсон уу? За нэг минут сунгачихъя.

Оролцогч Г.Нямдаваа: Б.Уянга гишүүн ерөөсөө газрын ховор элемент байдаггүй гэж илт худал мэдээлэл өгөөд зогсож байна шүү дээ. Байдаггүй юм бол яагаад хуульд заачихсан юм бэ? эсхүл зүгээр мэргэжлийн бус хүмүүс хийсэн байх. Монгол Улс цацрагийн тухай хуулийг гаргахдаа мэргэжлийн хүмүүс сонсохгүй л энд хуйвалдаад хууль гаргав гэж дээ. Тэгэхээр иймэрхүү байдлаар цаашаа явахгүй. Би Улсын Их Хурлын гишүүн байхдаа энэ Улсын Их Хурлын шийдвэрүүдийг үнэн бодитой гаргахын тулд энэ хүрээлэнг чинь 2003 оны тогтоол боловсруулаад өргөн бариад батлуулаад, эрдэм шинжилгээ судалгааны төв байгуулж байсан. Улсын Их хурлын дэргэд Парламентын судалгааны төв гэж байна уу? Тэгэхээр иймэрхүү байдлаар эрдэм шинжилгээний үндэслэлтэй судалгаа... (минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Г.Нямдаваа даргад баярлалаа. Оролцогч иргэд 5, 6 дугаар микрофон дээр ээлжилж суугаад үг хэлнэ. Танхимд Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, З.Мэндсайхан, Л.Соронзонбол, Э.Болормаа, Б.Уянга, Г.Очирбат, Л.Мөнхбаясгалан, П.Сайнзориг, Б.Бат-Эрдэнэ нарын гишүүд байна. Бусад Байнгын хорооны гишүүд танхимдаа орж ирнэ үү. Иргэдийн үгийг сонсох ёстой. Эхний үг хэлэх хүн бол Д.Батсуурь, дараа нь Д.Оюунчулуун 6 номерийн микрофон дээр суугаарай. Оролцогч иргэд 3 минутаар үг хэлнэ. Өнөөдрийн сонсголд бараг 50-аад оролцогч үг хэлэхээр байгаа.

Оролцогч Д.Батсуурь: Мянгад сумын ард иргэд бол критикал минералтай холбоотой буюу энэ чухал ашигт малтмалыг ямар нэгэн байдлаар сохроор эсэргүүцээд байгаа юм огт биш ээ. Энэ компанийн явуулж байгаа үйл ажиллагаа нь Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль, Усны тухай хууль, Цөмийн энергийн тухай хуулиудыг бүгдийг нь ямар нэгэн хэмжээгээр зөрчиж үйл ажиллагаагаа явуулж байгаа. Өнөөдөр байгаль орчны үнэлгээний тухай асуудал, байгаль орчны нөхөн сэргээх асуудал энэ бүх зүйлүүд нь орхигдоод явж байна гэж үзэж байгаа юм.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл авмагц дараа нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэнэ гээд 2022 оноос өнөөдрийг хүртэл хийгдэхгүй байгаа талаар сая харин энэ мэдээлэл дээр ярьж байна. Яг нарийндаа байгаль орчны нарийвчилсан төлөвлөгөө хийх юм бол 4 хувь үйлдээд орон нутгийн засаг захиргаанд 1 хувийг өгөх ёстой. Энэ байгаль орчны нарийвчилсан үнэлгээ гэж яагаад байгаль орчны ерөнхий үнэлгээ буюу байгаль орчны нарийвчилсан үнэлгээ гэж хэлээд байгаа юм бэ гэвэл энэ байгаль орчинд хохирол багатай явуулах агаар мандал болон усны бохирдол, хүн ам, ургамалд сөргөөр нөлөөлж болох бүх зүйлүүдийг цогцоор нь нарийвчилсан үнэлгээнд тусгах ёстой гээд заачихсан байдаг.

Тэгвэл өнөөдөр энэ нарийвчилсан үнэлгээг хийснээрээ мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах ёстой. Гэтэл уг менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөө үзүүлэх хортой байж болох хүн, амьтан бүх зүйлүүдийг нь цогцоор нь тусгасан байгаа учраас үүний сөрөг нөлөөлөл, хорыг хэрхэн, яаж багасгах тухай асуудлыг тусгах ёстой. Тэгтэл өнөөдөр ямар замаар явж байгаа вэ гэвэл энэ компанийн байгаль орчны нэг мэргэжилтэн нь менежментийн төлөвлөгөөг боловсруулаад Байгаль орчны яамны ямар нэгэн газрын дарга юм уу, нэг улсын байцаагч батлаад байгаа юм. Тэгэхээр энэ нь ямар маягтай байна вэ гэвэл түрүүнд хэллээ. Тэр байгаль орчин орчны менежментийн төлөвлөгөөг 90 хэдэн хувиар биелүүлж байна гэж. Энэ ямар хэмжээтэй юм байна гэвэл бараг л худал хэлсэн хүнд нөгөө машиныхаа тос асахгүй... (минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За нэг минут өгье.

Оролцогч Д.Батсуурь: Аюулгүй орчинд амьдрах эрх хангах байгаль орчны чадавхын хэм хэмжээг тогтоосон байх ёстой. Стандартын дагуу тогтооно гэж хуульд заачихсан. Тэгвэл энэ хуульд чинь стандартаараа мөрдөгдөж байгаа юм огт байхгүй байна. Тэр нь юу гэсэн үг вэ гэвэл би хувиараа шинжилгээ хийлгэж үзэхэд манай Ховдын малчдын ууж ашиглаж байгаа худгуудад хар тугалга, бисмут, бас уран илэрч байгаа. Тэгэхээр үүнийг нэгжээр тодорхойлоод үзэхээр ямар хэмжээтэй байна вэ гэвэл өнөөдөр нэгж нь өөр стандартын хуульд милограмм, литрээр тодорхойлно гээд, ... (минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Цагаа барьж ярихгүй бол болохгүй байна. Олон хүн байгаа учраас би сая танд нэг минутаар сунгаж өглөө дараагийнхаа хүний минутаас авах юм уу. Зарчим бол тийм шүү дээ. Дараагийн чинь хүмүүсийн минутаас хорогдоно гэж л ойлгоорой. Нэг минут өгье.

Оролцогч Д.Батсуурь: Өнөөдөр бека литр гэдэг юмаар гаргаж тодорхойлж байгаа юм. Бека литр гэдгээр нь өнөөдөр стандартад байхгүй. Гэтэл хаягдал усны стандарт байхгүй зүйлээр тодорхойлоод гаргаад ирэхээр тэр Цөмийн энергийн газрын нормоор 1 нэгжээр тодорхойлохоор заачихсан байна. Тэгвэл өнөөдөр бека литрээр тодорхойлохоор энийг чинь мэддэг мэргэжилтэн алга. Тэгвэл өнөөдөр Монгол Улсад зүгээр Норов гэдэг энэ нэг доктор, профессор байна. Энэ профессор сайн байх, энэ компанийн төслийн зөвлөх гээд 2022, 2023 онд уран энэ газрын ховор элемент чинь хоргүй ээ гээд явж байсан. Тэгвэл Говь компанийн ажлын хэсгийн ахлагч Баялаг Ундрах компани

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Д.Батсуурь гуай хоёулаа дараа нь уулзъя. Би таны мэдээллийг үргэлжлүүлээд би өөрөө сонсьё. За баярлалаа, дараагийн хүн Д.Оюунчулуун. 6 номерын микрофоныг нээе.

Оролцогч Д.Оюунчулуун: Сайн байцгаана уу? Энэ арга хэмжээнд оролцож байгаа нийт хүмүүст энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

За би ерөөсөө маш товчхон ярина аа. Монгол Улсын Үндсэн хуульд заасан Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхээ Мянгадын ард түмэн бид эдэлмээр байна. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт газрын ховор элементийн салбарыг төрийн бодлогоор дэмжинэ гээд орсон. Гэтэл ард иргэд эсэргүүцэж байгаа. УИХ-ын гишүүд, төрийн түшээд очихоороо “та нарыг зөвшөөрөхгүй бол ухуулахгүй, нэг ч хүрз шороо ч ухуулахгүй” гэдэг. Гэтэл 500 метрийн цаана эргээд сурвалжлагчдын асуултанд хариулт өгөхдөө “газрын ховор элементийн салбараар дэлхийд тоглогч орон болмоор байна.” гэж ард иргэдэд илт худал мэдээлэл өгдгөө болимоор байна. Дээр нь Монгол Улсын Засгийн газар түүний чиг үүргийн яам, хяналт шалгалтын ажлаа хангалттай хийхгүй байна. Байгаль орчны яамны хяналтын ажлыг Мянгадын ард иргэд хийж байна. Өөрсдөө хийж байна шүү Иргэд юу хүсээд байгаа юм бэ? Бид эрүүл аюулгүй орчинд амьдрах ёстой, бид нар энэ уурхайг хүсэхгүй байхад төр анхааралдаа аваач. Төрийн бодлогоороо Мянгад сумын 3725 иргэн, 900 өрхийн асуудлыг эрүүл аюулгүй орчинд амьдрах энэ баталгааг гаргаж өгч чадах юм уу? Монгол Улсад хариуцлагатай уул уурхай гэж байна уу? Хариуцлагатай уул уурхай байхгүй учраас ард иргэд чинь үүнийг эсэргүүцээд байгаа юм аа гэдгийг л би хэлэх гэсэн юм аа. Маш товчхон энэ асуудлуудыг тавья гэж бодлоо. За баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа дараагийн хүн С.Бат-Орших, дараа нь Д.Шаравсамбуу 6 номер дээр суугаарай. 5 номерын микрофоныг өгье.

Оролцогч С.Бат-Орших: Би Ховд аймгийн Мянгад сумын Цагаан булан багийн малчин Сандаг овогтой Бат-Орших гэдэг хүн байна. Би насаараа 3 үеэрээ энэ нутагт мал маллаж амьдарч байгаа малчин хүн байна.

Илтгэлүүдийг харж байхад энэ компани чихэж байх шиг байна. Намайг хүүхэд байхаасаа өдий болтол ургаж байгаа ургамал, их идвэл үхдэггүй, их идэхгүй бол идээд л явж байдаг ийм л ургамал. Энэ ургамал руу муу нэрээ өгч байна. Энэ байдлаар энэ компанийг би шүүмжлэх гээд байгаа юм. Би өөр дээрээ жишээ аваад ярьчихъя. Хаврын жагсаал цуглаан эхэлж байх үед бид нар бичиг өгсөн. Тэгээд А.Цолмон гэдэг дарга намайг за хөгшин та больчихоорой энэ жагсаал цуглаанд битгий яваад байгаарай гэж хэлж байсан. 2-т нь та хохиролтой байвал хохирлоо гаргаад ир мөнгө өгье гэж ярьсан. Тийм учраас энэ компанийг ард түмэн эсэргүүцээд байгаа юм. Үүнийг үндэслээд би юу гэж хэлэх гэж байна гэвэл “та боль” гэдэг чинь хүний эрх хааж байна шүү дээ. Ард иргэдийнхээ эрхийг хаагаад байгаа юм.

Хоёрдугаарт, энэ мөнгө яриад мөнгөөр хахуульдаад байгаа юм. Би энийг хахууль гэж үзээд байгаа юм.

Гуравдугаарт, ёс зүй гэдэг юм байхгүй. Дандаа худал хэлдэг нь батлагдаад олон хүн нотолж хэлж байна шүү дээ. Энэ бүгдийг би биш энэ ард иргэд намайг хэл гэж 200 хүний төлөөлөл болж би ирсэн юм. Улсын Их Хурлын гишүүд болон тэр компанийн ноёд хатагтай нарт зориулаад ийм бусармаг муухай юм хийж байгаа болиод үнэн зөв мэдээлэл өгөөд, үнэн зөв ярьж суръя аа гэдгийг уриалаад, дахиад энэ компанийг ийм байдалтай очих юм бол тэр Халзан бүрэгтэйн орчинд бид нар нэг ч цаг минут зогсоолгохгүй хөөнө. Энэ залуучуудын хэлдгээр алалцаад байна. Ийм л юм ярья өөр юм алга аа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа. Ер нь манай иргэд үнэн зөв мэдээлэл өгөөд сайн ойлголцох хэрэгтэй байна гэдэг зүйлийг хэлж байна шүү. За Д.Шаравсамбуу 6 номер, дараа нь Д.Цэен-Ойдов бэлдэж байгаарай.

Оролцогч Д.Шаравсамбуу: За, өнөөдөр цөмийн энерги ярьж байгаа учраас Цөмийн энергийн комисс, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон энэ хэлэлцүүлэгт оролцож байгаа эрхэм та бүгдийнхээ амар амгаланг айлтгая.

Цөмийн энергийн комиссын дүгнэлтээр манай суманд газар дээр нь очоод 7-8 хувь өндөр байгаа гэдэг шийдвэр гарсан. Тэрэнд хөдөөгийн ард түмэн болон ХАА-н салбарт ажиллаж байгаа малчин 35-аас доош насны залуучууд ирээдүй болсон хүмүүс маань ажил амьдралаа төлөвлөж, магадгүй тэнд оршин тогтнох үндэс нь алга байна. 35-аас нааш доош насны залуу ямарваа малчин ч бай, бизнесмен ч хүмүүс 5 жилийн хугацаанд өөрийнхөө ажил амьдралыг төлөвлөж амьдрал ахуйгаа дээшлүүлж, нийгэмд байр сууриа эзлэх ёстой. Тэгтэл тэнд амьдрах орчин хязгаарлагдмал болсон. Ер нь баруун монголчууд айдаст автаж байгаа. Энэ мэдээлэл бүх юмнаас хараад уран, цөмийн энерги бол бид нарт аюултай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн гэдгийг хүмүүс ойлгож байна. Үндсэн хуулиар олгогдсон амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй байтал өнөөдөр амьд явах эрхээ эдэлмээр байна. Тийм учраас малчин бид нар мянга гаруй км-ээс хөдөөгийн малчдын төлөөлөл болоод ирсэн. Миний ард өч төчнөөн төлөөлөл болсон хүмүүс байгаа. Цаг хугацааны хувьд ийм болсон.

Хоёрдугаарт, Хөдөө аж ахуйн яам яагаад бодлого барьж Монгол орны эдийн засгийн хэдэн хувийг бүрдүүлж байгаа малаас гарч байгаа бүтээгдэхүүн, малчин иргэдийн ажил амьдралыг ая тухтай амьдрах орчныг нь бүрдүүлж өгөхгүй байгаа юм бэ.

Ганцхан компанийн уул уурхайгаас болж амьдармааргүй байна гэж ҮАБЗ-ийн эрхэм 3 гишүүдэд анхааруулмаар байна. Хамгийн гол нь үндэсний аюулгүй байдалд бид нар эрүүл аюулгүй орчинд амьдарч, ХАА-н салбарт ажиллаж байгаа 35-аас дооших насны 1990 оноос хойших хүмүүс боловсролтой, боловсролгүй хүмүүс байгаа. Тэд нар ажил амьдралаа яах вэ? Нийгмийн асуудлыг нь яаж шийдэх вэ гэдэг дээр л өнөөдөр хэлэлцүүлэгт орж байгаа энэ агентлагуудын хүмүүс маань анхаарч шийдвэрээ ард түмний талд гаргаж өгөөч. Энэ Халзан бүрэгтэй компанийн үйл ажиллагааг зогсоож өгөөч. Энэ хууль тогтоомж Халзан бүрэгтэйг тойрсон 24 зөвшөөрөл байгаа, энэ 24 зөвшөөрлийг цуцалж өгөөч. Ганцхан өнөөдрийн энэ Монголиан нэйшнл рийр ийрт корп компани биш бусад энэ нэр дээр салаавчлаад авчихсан өөр өөр нэрэн дээр авсан ашигт малтмалын лицензууд зөндөө байж байгаа. Энийг та бүхэн маань бас анхаарал тавьж судалж асуудлыг нь шийдэж өгөөч. Өнөөдрийн статистик тоонуудыг бид шинжээчдийн дүгнэлтээс харлаа. Тэгэхэд бол үнэндээ хийсвэр байна. Саяын манай эрдэмтэн мэргэд докторууд бүгд ярьж байна л даа. Тэр бол үнэндээ хийсвэр байна. Юу гэсэн үг вэ?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: 5 номерын микрофон Д.Цэен-Ойдов, дараа нь Л.Төмөрбаатар бэлдэж байгаарай.

Оролцогч Д.Цэен-Ойдов: Эрхэм Улсын Их Хурлын гишүүд, энд хуран цугласан орон нутгийн иргэд ээ! Та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтган мэндчилье. Би Ховд аймгийн Мянгад сумын Баянбулаг багаас оролцож байгаа иргэн Д.Цэен-Ойдов гэж хүн байна.

Халзан бүрэгтэй хайрхан маань Алтай таван Богдоос эх авч урсдаг Ховд голоос 12 км, Хар ус нуурын тусгай хамгаалалттай газар нутгийн хилээс 8 км, Мянгад сумын төвөөс 16 км, Буянт сумын төвөөс 29 км, Ховд аймгийн төвөөс 56 км зайд орших бөгөөд Их нууруудын хотгорын цэвэр усны ай сав, эко системд шууд нөлөөлөх газар байрлаж байгааг юуны өмнө хэлэхийг хүсэж байна. Их нууруудын хотгор нь Монгол орны баруун хэсэгт хамаарагдах Ховд, Говь-Алтай, Увс, Завхан аймгуудын нутаг дэвсгэрт хамаарагдаж Увс, Хяргас, Дөргөн, Хар ус, Айргийн нуурууд гэх мэт давст болон цэнгэг уст нууруудыг бий болгодог олон нуур, цөөрөм бүхий хотгор газар юм аа. Энэ нь баруун талаараа Алтайн нуруу зүүн талаараа Хангайн нуруу хойд талаараа Тагны нуруугаар хүрээлэгдэж далайн түвшнээс дээш мянгаас 3500 метр өндөрт 100 мянган квадрат метр талбай бүхий ийм газар оршдог юм аа. Энэ бүс нутаг нь цэнгэг усны томоохон ай сав газар бөгөөд Төв Азийн маш чухал ус намгархаг газруудыг өөртөө агуулдаг. Зэгс шагшуурга ихтэй хоорондоо нүдэнд үзэгдэх болон далд хүйн холбоотой эдгээр нуурууд нь энэ бүс нутгийн ус намгархаг орчныг бүрдүүлдэг. Монгол Улсын төр засаг болон гадаад дотоодын төсөл хөтөлбөрүүд гэх мэт байгууллагууд нь нэг талаараа хүрээлэн буй байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа явуулж байгаа мэт боловч нөгөө талаараа Монгол орны байгалийн биологийн олон янз байдлыг устгах үйлийг зориуд санаатайгаар ч юм шиг эсвэл мэдлэг ойлголтын дутуугаас санамсаргүйгээр явуулсаар байна.

Биологийн олон янз байдлыг тэтгэж байдаг Ховд, Завхан, Тэс голуудын эх ундарга урсац голдирлыг хайрлаж хамгаалах бодлого явуулах арга хэмжээ авахын оронд тэдгээрийнх нь тэтгэх ойр ундаргынх нь ойролцоо усны эхийг ширгээж амийг нь таслах зорилготой ч юм шиг уул уурхайн лиценз олгох хамгийн их устай

үзэсгэлэнтэй хүн, амьтан нутагшиж байрладаг хэсэгт нь уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг санаархах гэх мэт хорлонтой үйл ажиллагаа явуулж байгаад харамсалтай байна. Их нууруудын хотгор амьдарч байсан болон байгаа уугуул, суугуул иргэд нь сүүлийн жилүүдэд дэлхий даяар явагдаж буй уур амьсгалын өөрчлөлт, экологи, хүрээлэн буй орчин, тэнцвэр... (минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа. Та надад бичсэн зүйлээ бичгээр өгчих. Л.Төмөрбаатар гуай 6 номер дээр дараа нь Ч.Алтангадас бэлдэж байгаарай.

Оролцогч Л.Төмөрбаатар: Би Ховд аймгийн Мянгад сумаас ирсэн малчин Л.Төмөрбаатар байна. Бид нар 2012 оноос хойш энэ уул уурхайн компанитай тэмцэж яваа. Бид нар эрүүл, аюулгүй орчинд амьдармаар байдаг. Энэ уул уурхай чинь бид нарыг амьдрах боломжоор хангахгүй байна. Тэгэхээр бид нар энэ компанийн лицензийг цуцалтал тэмцлээ үргэлжлүүлэх болно.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Ч.Алтангадас гуай сууж байгаа микрофоныг нээе. Дараа нь Ц.Мягмарсүрэн 6 дээр бэлдэж байгаарай.

Оролцогч Ч.Алтангадас: Баярлалаа эрхэм хүндэт төрийн түшээд ээ! Энэ сонгогдон оролцож байгаа төрийн албан хаагчид аа! Сонсголд оролцож буй эрхэм нөхөд өө! Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Миний бие Ховд аймгийн Мянгад сумын Гахайт багийн иргэн Чулуунбатын Алтангадас гэдэг хүн байна. Гахайт багийн бид нутагтаа жарныг дамнан нутаглаж ирсэн. Бидний өвөг дээдсийн цагаас ургийн гажигтай мал, хүнд гаж нөлөөтэй зүйлс байгалийн ган, зуд тохиолдож байгаагүй ээ.

Халзан бүрэгтэй уулыг оролдсоноос хойш дээр дурдсан ургийн гажиг нөлөөтэй холбоотой зүйлс илэрч бас тэр нутагт, тэр ууланд байдаг аргаль, янгир шувуу, хойлог, ятуу, улаан хошуут хэрээ, дайжин алга болсон. Хулгана, зурам, оготно, могой, туулай үгүй болсон. Ургийн гажигтай гарсан төлийг холбогдох байгууллагад нь хүргүүлэн өгсөн. Хариу нь уран болон газрын ховор элементийн хор уршгийг Монголд нотлох лаборатори байхгүй гэж мал эмнэлгийн хэлтсийн дарга нь тайлбар өгсөн. Тийм учраас Халзан бүрэгтэй ууланд газрын ховор элементийн лицензийг цуцалж өгнө үү.

Бид эзэн болсон уул ус, газар шороо, шороондоо энх тунх амьдарч баймаар байна аа. Үр хойчдоо бүтнээр нь үлдээж Их нууруудынхаа хотгор, цэнгэг усны ай сав болсон газраа Баруун 5 аймаг цацрагийн хорт хөнөөнд автаж байгаа тулд Халзан Бүрэгтэй энэ лицензийг цуцалж өгнө үү хэмээн үзэж байна аа. Эс цуцалбаас ард түмэн хурц хэлбэрт шилжинэ ээ. Төр та нарт армийн чинь цэрэг, төрийн чинь цагдаа байдаг байх. Голд нь амьсгаатай гол нь ард түмний хүүхэд байгаа гэдгийг төр минь мартаж болохгүй шүү Төр минь төвшин байг. Түмэн олон минь амгалан байг Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа танд. Дараагийн үг хэлэх хүн бол Ц.Мягмарсүрэн 6 номер дээр, дараа нь Н.Золбаяр 5 номер дээр бэлдэж байгаарай.

Оролцогч Ц.Мягмарсүрэн: Ховд аймгийн Мянгад сумын иргэн Ц.Мягмарсүрэн гэж хүн байна. Энэ ургийн гажиг гэдэг чинь 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр манай хотонд гарч байсан юм. Урьд нь бол ийм юм гардаггүй байсан. Үе үеэрээ малладаг өвөлжөө хаваржаандаа хаваржиж байдаггүй байсан хүн байгаа юм. Миний хэлэх зүйл бол ерөнхийдөө энэ лицензийг цуцалж өгөөч ээ. Ард түмнийг тайван

амьдруулмаар байна гэж хэлмээр байна. Энэ компанийг явахгүй бол манай Мянгадчууд, Ховдчууд тайван амьдрахгүй шүү гэж хэлмээр байна. За өөр юм алгадаа. За баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: 5 номер дээр Н.Золбаяр дараа нь А.Амаржаргал 6 номер дээр бэлдэж байгаарай.

Оролцогч Н.Золбаяр: Гахайт багийн иргэн Н.Золбаяр байна. Өнөөдөр Монгол Улсад газрын ховор элементээ ашиглах тийм нэн даруй хэрэгцээ байгаа юу? Тэгээд тэр хэрэгцээнийхээ дагуу та нар хөгжсөн юм уу, эрдэмтдээ бэлдсэн юм уу? Өнөөдөр аюулгүй олборлох бэлтгэлээ хангасан юм уу? Бэлдээгүй байж яагаад ингээд лиценз олгож байгаа юм бэ? Энэ компанид яагаад ингээд лиценз олгож байгаа юм бэ? Газрын ховор элементийг олборлохын тулд нэг тухайн бүс нутгийг золигт гаргаж байж золиосолж байж ингээд ухдаг олборлодог ийм юм аюултай эд юм байна аа.

Эргээд тэр газрынхаа олборлосон юмныхаа хаягдлыг булшлахад сая сая жил тэр миний газар нутаг дээр байх юм байна. Энэ ингээд баруун монголчуудыг ганцхан Ховд аймгийн Мянгад сумын асуудал биш болоод байна. Энэ бол бүх нийт монголчуудын асуудал болоод байна шүү дээ. Бид нар төрдөө итгэх итгэл байхгүй. Хулгайч шүү дээ та нар. Өчнөөн Монголыг тэжээх ордуудаа та нар зараад идчихсэн биз дээ? Одоо төрөөгүй хүүхэд нь хүртэл өртэй байж байгаа биз дээ. Тэгээд дахиад баруун монголчуудыг золиод, үхлийн хэмжээнд хүргээд ингээд ахиад нэг ордыг олборлоно гээд байгаа юм бэ? Энийг гайхаад байх юм. Тэгээд тэрнийхээ дагуу аюулгүй ажиллах юмаа ч бэлдээгүй. Одоо тэр эрдэмтдээ ч бэлдээгүй, ийм луйварчин өртэй, ийм хөгжөөгүй шинжлэх ухаантай байж энэ аюултай зүйлээр оролдож баруун монголчуудыг тэр чигээр нь хүйс тэмтрэх гэж байгаа хоморголон устгаж байгаа энэ асуудал чинь бүүр үндэсний аюулгүй байдлын хэмжээнд байна шүү дээ.

Одоо бүүр энэ үнэхээр ингээд энийгээ явуулна аа гэдэг юм бол бид нар цаашдаа тэмцлийнхээ хурц хэлбэрт шилжинэ. Бид бол компанитай тохиролцёе гээгүй. Наадуул чинь угаасаа тохиролцёе гээд айл айлд нь очоод мөнгө санал болгоод, бэлэг тараагаад явдаг юм байна лээ. Авсан айл ч бас байж л байгаа байх. Гэхдээ нөгөө хор хөнөөлийг нь таниулахгүй гээд. Энэ чинь хоргүй шүү дээ 1,8 тэгээд 8 дахин өндөр цацрагийн идэвх нь гарчихсан байхад яагаад энийг ингээд ойлгохгүй байгаа юм бэ? Бид нараас тэнэг хүмүүс энэ дотор суудаг юм уу? Тэр шинжээчид одоо юу яриад байгаа юм бэ? Рашаан гэдэг ургамал чинь намайг нялх байхаас эхлээд байж байдаг байсан.

Одоо нөгөө үхэж байгаа мал ахуйг маань ургамал идээд хордоод үхчихсэн юм байна шүү дээ ухааны юм яриад байх юм. Нийтэд ийм сонсгол хийж байж бүх газраар дамжуулж байхад ийм буруу ойлголт төрүүлж байна шүү дээ. Одоо ингээд магадгүй бид нарыг харлуулах гээд нэг хэдэн шантаачин ингээд компани шантаажлаад ажил явуулахгүй төр уяад байна аа, уул нь бол энэ нь хоргүй шүү дээ гээд ингээд зарлаж байна. Төр нь ч гэсэн тэгээд зарлаж байна. За хортой гэдгийг чинь манай нутгийн иргэд биеэрээ, малаараа, бүх юмаараа мэдрээд хэлээд та бүхэнд танилцуулаад байна шүү дээ. Та нар өнөөдөр бөхийн шээсээ шинжилж чаддаггүй бөхийнхөө шээсийг шинжилж чаддаггүй байж ураны хор хохирлыг шинжилж чадах уу? Одоо тэр гарах үр дагаврыг та нар дааж чадах юм уу энэ дээр анхаараач ээ. Бид нар бол лицензийг цуцлах хүртэл явна. Ирээдүйдээ хадгалъя. Манай ирээдүйн хүүхдүүд өсөж том болоод дараагийн үедээ хадгалъя. Тэд нар хүнээ бэлтгэ эрдэмтдээ бэлтгэ, тийм ээ улс төрчид нь та нар шиг хулгайч биш байг. Луйварчид биш байг тэр үедээ ухуулъя. Тэр үедээ тэд нар авах юмаа аваад хэрэглээд ирээдүйдээ илүү сайжруулалт хийг ээ.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Дараагийнх нь 6 номер А.Амаржаргал дараа нь Ч.Оюунчимэг бэлдэж байгаарай.

Оролцогч А.Амаржаргал: Чацарганат багийн малчин А.Амаржаргал гэдэг хүн байна. Одоо ингээд би ерөөсөө төрийнхөө тэргүүн Ерөнхийлөгч У.Хүрэлсүх гуайгаас ганцхан л юм зүйлийг гуймаар байна. Та бид нар өөрөө Ерөнхийлөгч гарахдаа би ард түмнээрээ хүрээлүүлээд хамгаалуулаад гарна, ард түмэн намайг хамгаална аа гэж хэлж байсан. Одоо бид нар ганцхан л юм тэр Ерөнхийлөгчөөс гуймаар байна. Ард түмэн бид нар үнэхээр туйлдаа хүрч байна аа.

Энэ Халзан бүрэгтэйн төлөө тэмцээд, энэ төслийн төлөө тэмцээд бид нарын төлөө одоо л нэг дуугараад өгөөч ээ. Бид үр хүүхдүүд бид нарын төлөө би ингээд эмэгтэй хүн 1500 км-ийн цаанаас ингээд үнэхээр ядраад энд ирээд буудалд яах нь мэдэхгүй 2,3 хоног ингэж амьтанд хардагдаад ч байгаа юм шиг байж байна. Эх хүн үрийнхээ төлөө зүтгэж чаддаг юм. Тийм болохоор Ерөнхийлөгч та бол энэ Монголын аав нь гэсэн үг. Ерөөсөө тийм болохоор бид нар таны үр хүүхдүүд, та үр хүүхдүүдээ эргээд нэг хараач дээ л гэдэг үгийг би Ерөнхийлөгчид ерөөсөө хандаж нэр цохож хэлмээр байна. Би У.Хүрэлсүх Ерөнхийлөгч миний аав байна. Энийг бид үр хүүхэд бид нарыг хараад өгөөч дээ. Эргээд бид нар үр хүүхэдтэй ач зээтэй. Тийм болохоор энийг би Ерөнхийлөгч У.Хүрэлсүх гуайд л би хандаж хэлж байгаа юм. Энийг та зогсоох эрх танд байгаа байх.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: 5 номер дээр Ч.Оюунчимэг дараа нь Г.Нямдаваа 6 дээр бэлдэж байгаарай.

Оролцогч Ч.Оюунчимэг: Ховд аймгийн Мянгат сумын Чацарганат багийн малчин Ч.Оюунчимэг байна. Тэгээд би малчин бидний амьжиргааны гол эх үүсвэр болсон МАА-н салбар нь уул уурхайтай зэрэгцэн орших ямар ч боломжгүй гэж ойлгож байна. Ийм учир төрсөн нутагтаа эрдэнэт мал сүргээ маллаж амар тайван амьдрах үр хүүхдээ эрүүл саруул өсгөн хүмүүжүүлэх эх орныхоо ирээдүйд итгэл төгс амьдармаар байна. Иймд лицензээ цуцалж өгнө үү гэж хүсэж байна.

Малчин бид эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байна. Бид нутаг усаа хамгаалах үүрэгтэй малчид эцсээ хүртэл тэмцэх болно. Ард иргэдийнхээ төлөө та нарыг хэн чинь санаа тавьж байна. Хатуухан хэлэхэд та нарын нүдэнд мөнгө харагддаг бол бидний нүдэнд эрүүл аюулгүй орчин, үр хүүхэд, ирээдүй минь харагддаг юм шүү. Өвөг дээдэс минь үр хүүхдүүд минь харагддаг юм шүү гэдгийг л хэлэх гэсэн юм. Бид ургуулдаг хөрстэй, ундаалдаг рашаантай, сүү өргөж цэцэглэдэг хайрхантай эрүүл аюулгүй орчинд тайван амьдармаар байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа Г.Нямдаваа 6 номер дээр суучих. 5 дээр дараа нь Б.Гантөмөр бэлдэж байгаарай.

Оролцогч Г.Нямдаваа: Би өмнө хэлж амжаагүй зүйлээ дүгнэлт байдлаар хэлье гэж бодож байна. Ер нь миний түрүүнд ярьдаг байгаль орчны асуудал ер нь их хоцрогдоод байна. Ялангуяа төрийн бодлого тодорхойлдог манай эрхэм гишүүд маань та бүхэн ямар нэгэн асуудлыг авч үзэхдээ маш нарийн хандах хэрэгтэй байна. Бид юу гэж хараад байна гэвэл, сүүлийн үед мөнгө л олох юм бол хамаагүй гэдэг байдал руу л бүх бодлого явчих шиг болоод байна. Мөнгийг олох олон арга бий шүү дээ. Байгалийг сэргээх тийм олон арга байхгүй. Энэ байгалийн төлбөр бид нарт гарч ирэхгүй. Магадгүй 10 жилийн дараа 20 жилийн дараа устаж үгүй болсон биологийн төрөл зүйл бусад зүйлээр илэрч гарна. Тэр үеийн төлбөр бол одоогийн бидний хайж олох гээд байгаа мөнгөнөөс хэдэн 100 дахин илүү төлбөр төлөөд ч боломжгүй байх

ийм аюул байгаа юм. Биднийг УИХ-ын гишүүн байхад одоо 20 гаруй жилийн өмнө жил тутам УИХ-аар бүүр нэгдсэн чуулганаар Монгол Улсын төлөв байдлын тайланг хэлэлцдэг байсан. Монгол орны уур амьсгал бусад асуудлууд нь яаж байна? хаана гол нь яаж бохирдож байна гэдгээ онцгой анхаардаг байсан.

Дараа нь арваад жилийн өмнөөс Байнгын хороогоор 2 жил тутам оруулдаг болсон. Гэтэл дэгийн тухай хуульд өөрчлөлт ороод ерөөсөө авч хэлэлцэхгүй болчихсон байна. Бодлого тодорхойлдог УИХ-ын эрхэм гишүүддээ! Монгол орны байгаль орчны зүй тогтол яаж өөрчлөгдөж байгаа нарийн чанд мэдээлэл өгөхгүйгээр бүх бодлого жигд явна гэж байхгүй. Ийм учраас энийг бол та бүхэн маань анхааралдаа аваач гэж хэлэх гэсэн юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа. Г.Нямдаваа гуай бас өмнө нь УИХ-ын гишүүнээр МАН-аас сонгогдож ажиллаж байсан аймгийн Засаг дарга байсан хүний хувьд байгаль орчинд ер нь Монгол Улсын хэмжээндээ судалгаа хийж үнэлгээ гаргах нь зүйтэй гэдэг дээр санал нэг байна гэдгийг хэлье. Б.Гантөмөр гуай 5 номер, дараа нь Я.Хундаганай гэж хүн бэлдэж байгаарай.

Оролцогч Б.Гантөмөр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхлээр энэ сонсголын ер нь гол ач холбогдол зорилго юу вэ гэдэг асуудал байна л даа. Ер нь бол эндээс аль аль талдаа үнэн бодит зөв мэдээлэлтэй гарах гэдэг одоо энэ үндсэн гол зорилго байх ёстой гэж би ойлгож байгаа. Гэтэл бид эндээс нэг ерөнхий мессеж авч байна шүү дээ. 1 дүгээрт лиценз нь бол хуулийн дагуу олгогдсон. Шинжээчдийн үр дүнд тайланд 2 дугаарт ураны агуулга байхгүй, хоргүй гэсэн, 3 дугаар газрын ховор элемент эдийн засгийн хувьд бол ач холбогдолтой гэсэн нэг ийм л мессеж ард түмэнд өгөх гээд байх шиг байна.

Гэтэл бодит байдал дээрээ бол энэ мессеж маань худлаа, санал нийлэхгүй байгаа гэдгийг ард түмэн мэдээд байна шүү дээ. Ялангуяа энэ газар, орд, уран тойрсон агуулгын талаарх мэдээллүүдийг бол. Олон улсын эрдэмтэд тодорхой түвшинд судлаад хэвлэл мэдээлэлд нийтлэл болгоод хэвлүүлчихсэн. Ийм мэдээлэл зөндөө байна. Хамгийн сүүлд Г.Нямдаваа дарга эшилсэн Коваленкогийн өгүүлэлд Халзан бүрэгтэйн орд дахь хүнд газрын элемент ховор элементүүд нь уран, торийн агуулагатайгаа шууд хамааралтай байна гээд дүгнэчихсэн байна.

Өөрөөр хэлбэл, энэ элементүүдийн агуулга өсөх тохиолдолд уран, тори агуулга дагаад өсөж байна гэдэг. Ийм дүгнэлтийг хийгээд гаргачихсан байх жишээтэй. Гэтэл ингээд уран, тори бол ердийн юм шиг байна гэж дүгнээд одоо ард түмэнд мессеж өгч байгаа нь зөв үү буруу юу? Эндээс одоо бид ерөнхийдөө бол энэ шинжээчдийн тавьсанг одоо үнэн гэж ойлгох юм уу аль эсвэл тэр олон улсын түвшинд хэвлэгдчихсэн бүтээлүүдийг үнэн гэж ойлгох юм уу? Ийм байгаа учраас энэ ард түмэн чинь тэмцээд байна шүү дээ.

Мэдээллийн зөрүүтэй байдал. Тэгээд мэдээллээ зөв болгоод ирье гэхээр дахиад худлаа мэдээллээрээ ингээд дарамтлаад шахаад байгаа нь өөрөө бол энэ төслийг явуулахгүй энэ процесс цаашаа явах ямар ч үндэсгүй ийм байдалд хүргэж байна. Тийм учраас нэгэнт ийм байдалд хүрсэн учраас энийгээ үнэн зөв болгодог мэдээлдэг тэр цагтаа төслөө хөдөлгөө. Тэрнээс өмнө энийг хөдөлгөх ямар ч шаардлага алга. Хоёрдугаарт, энэ төслийн чинь нөлөө байгаль орчинд тодорхой түвшинд сөрөг нөлөөлж байна гэдгийг энэ малчид маань ахуйгаараа мэдэрчихээд тэмцээд байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: 6 номер дээр Я.Хундаганай дараа нь Б.Долгор бэлдэж байгаарай.

Оролцогч Я.Хундаганай: Ёстой нэг өнөөдөр энэ хааны нэртэй танхимд шинийн 2-ны билигт өдөр давхацсан энэ сайн өдөр их бэлгэшээж ирсэн юм. Гэтэл төрийн эрх байгууллагын энэ эрхэм гишүүд иргэдээ хүндэлдэггүй юм байна. 1 цаг 30 минут хоцорлоо. Мөн иргэдээ сонсдоггүй юм байна. Сая иргэд ярина гэхэд танхимд байж байгаа хүмүүс чинь 10 хүрэхгүй байна шүү дээ. За энэ бол иргэдээ сонсохгүй энэ төрийн эрх дээд байгууллага бол дампуурч байгаагийн нэг шинж байна.

Хоёрдугаарт, энэ саяын хурал дээр хэлсэн дүгнэлт хийсэн хүмүүс бол үнэхээр хариуцлагагүй мэдээлэл хийж байна. Ер нь бол энэ ураны талаар дандаа худал мэдээлэл хийдэг, худлаа шинжээчид оруулдаг, бүүр тийм үл бүтэх хүмүүсийг оруулж худалдагдсан луйварчин ийм хүмүүсийг оруулж мэдээлэл хийдэг. Би Халзан бүрэгтэй энэ ховор элементийн ордыг эсэргүүцэж байгаа хүн. Яагаад эсэргүүцэж байгаа вэ гэвэл, энэ чинь хуулиудаа зөрчиж байгаа юм.

1 дүгээрт бол тэр 2009 оны 7 сарын 16-ны өдөр 2 хууль батлагдсан юм. Улсын Их Хурлаар гол мөрний урсац бүрэлдэх усан сан бүхий газар ашигт малтмал хайх олборлохыг хориглоно гэж, нөгөө хууль нь мөн энэ өдөр анхны хэлэлцүүлгээр Цөмийн энергийн хууль баталсан юм. Цөмийн энергийн хуулийн 3.1.5-д ховор элементийг чинь цөмийн бодис гээд тодорхойлчихсон. Мөн хуулийн 3.1.15 дээр нь бүүр цөмийн эх үүсвэр, материал гээд тодорхойлчихсон байж байгаа. Тийм учраас Цөмийн энергийн хуулийн дагуу яагаад ч ашиглагдаж болохгүй. Дээр нь Цөмийн энергийн хууль бол гаднын захиалгаар хийгдсэн гэдгийг тодорхой хэлье. Монголчуудад хэрэгтэй сүүлийн 3 заалт нь энэ гуравхан хуудсанд байж байгаа. Хяналт тавих, хүлээлгэх хариуцлага нь ерөөсөө байхгүй. Ялангуяа олон нийтийн хяналт иргэний хяналт энд огт тусаагүй. Тийм учраас энэ хуулийг бид эсэргүүцээд Үндсэн хуулийн цэцэд хүчингүй болгуулах гэж өгөөд дийлэхгүй байна.

Өчигдөр надад хариу ирсэн тэр магадлангаар одоо хүчингүй болгохгүй гэнэ. Улсын Их Хурал бол бүрэн эрхийг нь хууль баталсан юм л гэсэн тайлбар өгч байна. Өнөөдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт 100 мянган хүний гарын үсгийн хариуд маш инээдэмтэй мэдээлэл өгч байна. Ер нь бол төр засаг ингэж иргэдээ доромжлоод байж болох юм уу? Бодит байдал дээр энийг л одоо асуумаар байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Сэдвийнхээ хүрээнд ярья. Дорноговийн асуудлыг энд ерөөсөө яриагүй сэдвийнхээ хүрээнд асуудалаа ярья. За дараагийн хүн Б.Долгор тэрний дараа нь М.Баянзул бэлдэж байгаарай.

Оролцогч Б.Долгор: Өнөөдрийн сонсголд оролцож байгаа та бүхний амар амгаланг айлтгая. Би Мянгад сумын Цагаанбулан багаас оролцож байгаа Б.Долгор гэдэг хүн байна. Би Мянгад сумд 18 настайгаасаа эхлээд малчин, малын эмч, ХАА-н газрын түшмэл зэрэг ажлуудыг хасаж байсан. Энэ хугацаанд бол мал эмнэлэгт ийм гажиг хөгжилтэй төл ерөөсөө гарч байгаагүй. Сүүлийн жил 2025 онд 8 тийм төл гарлаа. Төлийн шинжилгээг мал эмнэлгийн лабораторид явуулахад үнэн зөв хариу ирсэнгүй.

Манай мал эмнэлгийн улсын байгууллага бол үүнийг зөв шинжилгээ хийх хэмжээнд хөгжиж чадсан мал эмнэлгийн байгууллага гэж би өөрөө дүгнэж байсан. Гэсэн хэдий ч энэ хариу бол сэтгэлд нийцсэн хариу ирээгүйд сэтгэл дундуур байна. Энийг би жаахан буруу дүгнэчихэв үү, буруу шинжлэсэн үү гэсэн хардах сэтгэл надад

байна. Хоёрдугаарт, 2024 оны 11 дүгээр сард ахмад настнууд Халзан бригадыгаа хамгаалахаар бид жагсаал цуглаан хийсэн. Жагсаал цуглааны үеэр бараг одоо онц хэрцгий мөргөлдөөн үүсэх дөхсөн. Компани бид хэд ингээд хоорондоо усны машин оруулахгүйгаас болоод хувцас хунараа ураад би тэр бичлэгийг хийж тавьсан байгаа.

Тэгээд ард түмэн болон компани 2-ын дунд одоо байдал хүндэрчихсэн, цаашид асуудал гарах магадлалтай байгаа гэдгийг та бүхэнд хүргэе. Гуравдугаарт энэ замын асуудлаар Улсын Их Хурлын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нар манай Ховд аймагт улсын чиглэлийн замын тавих асуудлаар ярихад бид Халзан бүрэгтэйхээ асуудлыг танилцуулахад та бүхэн 50 хүнээ сонгоод ирээрэй гэсэн. Тэр 50 хүний сонголтод бид ороод ард түмнийхээ төлөөлөл болоод ирсэн. Бидний тавьж байгаа санал, хүсэлтийг бас лицензийг цуцлуулах асуудлыг хүргээд мэдээллээр нь хангаад буцаад ирнэ гэж бидний ард түмэн хүлээж байгаа. Тийм учраас та бүхэн минь бидний хүсэлтийг хүлээж аваарай. Бас сайхан сэтгэлээр хандсан учраас манай ард түмэн итгэл үнэмшилтэйгээр лицензээ цуцлуулна. Энэ сонсгол бол бидний төлөө хүртээмжтэй нааштай сонсгол болно гэж хүлээж байгаа гэдгийг та бүхэндээ хэлье. Ингээд та бүхэндээ баярлалаа. Бидний сэтгэлийг хүлээж авч байгаа та бүхэнд баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа. Одоо М.Баянзул дараа нь Г.Дуламсүрэн 5 номер дээр бэлдэж байгаарай.

Оролцогч М.Баянзул: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Мянгад сумын Гахайт багийн харьяат Мянгадын мянган морьтон ТББ-ын удирдах зөвлөлийн дарга Мягмаржавын Баянзул гэж залуу байна. Би бас товчхон хэлье. Миний хэлэх санаанууд давхцаад байгаа учраас Монголын төрд хандаж хэлэх хэдэн үг байна. Би Монголын төрийн 30 жилийн гажуудлын хар гайгаар халуун залуу насаа БНСУ-д аж үйлдвэрийн салбарт 2006-2012 оны үед ажилласан.

Аж үйлдвэрийн салбарт Солонгос орныг хөгжүүлж яваад ирсэн нэгэн иргэн байна. Надтай адилхан залуучууд одоо ч гадаадад Солонгос, Япон дэлхийгээр тарчихсан байгаа. Яагаад үүнийг онцолж хэлээд байна вэ гэвэл, бид газрын ховор элементээр юу үйлдвэрлэдгийг бүгд мэдэж байгаа. Захын малчид мэддэг болсон. Бүгд гар утсандаа газрын ховор орж байгааг мэдэж байгаа. Бид нарын унаж байгаа приус-30, приус-20 батареид газрын ховор орж байгааг мэдэж байгаа. Сансрын хөлөгт газрын ховор элемент орж байгааг захын малчид мэддэг болчихсон. Бид энийг мэдэж байгаа худалдаж аваад хэрэглэж чадаж байна. Харин миний санаа бол газрын ховроо Монгол Улсдаа боловсруулъя.

Монгол Улсдаа тэр батарейтай машиныг үйлдвэрлэе Монгол Улс чинь Монгол залуучууд яагаад эх орондоо гар утас үйлдвэрлэж болдоггүй юм бэ? Энийг би Засгийн газар, УИХ-ын гишүүдэд хэлж байгаа юм. Өнөөдөр авч явах гээд байгаа зүйл бол энэ газрын ховор элементийг гадаадын компанитай нийлээд гадаад руу гаргаж явах гээд байна. Зарим нэгэн улс төрчдийн увайгүй үйлдлүүд бүгд Монголын тагнуул шалгах байх. Би Монгол хүний саруул ухаанд итгэж явдаг хүн байгаа юм. Ерөөсөө миний санаа тэр. Монголдоо үйлдвэрлэе. Халзан бүрэгтэй төслийг үүцэндээ хадгалъя. 2040-2050 онд технологи нь хөгжөөд гараад, Монгол залуучуудаа бэлдье, эрдэмтдээ бэлдье. 2050 онд монголчууд Азийн бар улс болъё, дэлхийн нэг номерын улс болъё.

XIII дугаар зуунд ялсан шигээ 2050 онд монголчууд дэлхийд нэгээр гарч ирье гэж би уриалж байна. Дахин давтаж хэлэхэд Монголын төрийн нэрийг доромжилсон төрийн албан хаагч нарыг цэвэрлэх цаг болсон. Дахин давтаж хэлэхэд Монгол Улсаас урвасан УИХ-ын гишүүдийг бид дахиж сонгохгүй байх боломж ирсэн. 2028 онд бид

дүнг нь тавина шүү. Дахин давтаж хэлэхэд Монголын ШУА гэсэн энэ гоё нэрийг бузарласан хуурамч эрдэмтдийг хөөж гаргах цаг нь болсон.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Та санаагаа ер нь бүрэн илэрхийлчихлээ. Дараагийнхаа хүндээ боломж олгосон нь дээр байх. М.Баянзулд баярлалаа. Монгол Улсаа хөгжүүлэх, Монголдоо үйлдвэрлэх талаар зөв саналуудыг хэлсэнд таатай хүлээж авч байна. Г.Дуламсүрэн гуай үг хэлнэ. Дараа нь Д.Мөнхсүх 6 номер дээр бэлдэж байгаарай.

Оролцогч Г.Дуламсүрэн: Танхимд хуран цугласан та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Би Мянгад сумын Гахайт багийн өндөр настан Г.Дуламсүрэн гэж хүн байгаа юм. Сая энэ шинжээчдийн дүгнэлттэй холбоотой ганцхан л асуудал дээр ярья. Хүн амын эрүүл мэндэд ямар ч хохирол хор нөлөө байхгүй ч гэсэн үзүүлэлт гаргачихлаа. Гэтэл би зүгээр иргэнийхээ шугамаар өөрийнхөө аймгийн хэмжээн дээр аймгийн эрүүл мэндийн газрын дүн бүртгэлээс авсан. 2014 онд манай Мянгат сумын амбулаторийн өвчлөл 306 байсан бол 2022 онд 679, 2023 онд 449 гэж 1,5-аас 2 дахин байсан. Гэтэл сая энэ ямар ч хүн амд эрүүл мэндэд нөлөөгүй гэж хэлж байна. Ийм л дүгнэлт. Шинжээчдийн дүгнэлт дээр та бүгд одоо дүгнэлтээ гаргах гэж байгаа юм байна шүү. 2 дугаарт зүрх судасны өвчлөл гээд байна. Энэ чинь дотроо зургаа хуваагддаг юм байна. Энэ өвчлөл 2014 онд 34 байсан бол 2022 онд 108 байна 3 дахин нэмэгдсэн. Энэ одоо би эсвэл буруу тоо бичсэн байж магадгүй.

Та бүхэн энэ яам холбогдох байгууллагаас авч үзээрэй. Та нар намайг бодоход нүдтэй, хараатай, оюунтай, ухаантай улсууд. Манай Мянгад суманд 2019-2024 оны хооронд 5 ургийн гажигтай хүүхэд гарчихаад байгаа юм. Дөрөвхөн жилийн дотор зүрх нь цоорхой төрөлхийн зүрхний гажигтай. Тэгээд энийг ямар нүүрээрээ ямар юм харж уншаад, судлаад хүн амд сөрөг нөлөөгүй гэдэг дүгнэлт гаргаж байгаад би үнэндээ гайхаж байна. Хоёрдугаарт би энд сууж байгаа гишүүддээ баярлалаа. Эхлэхдээ жаахан бариа муутай эхлэх шиг боллоо. Цаг гаруй хүлээчихсэн. Өнөөдөр ард түмнээ сонсож байгаа нь би тоондоо муу 57 хүнээс 32 нь 56%-тай гээд байх юм. Энд 10-аадхан гишүүн сууж байна. Манай Улсын Их Хурлын нүүр царай ийм л байна шүү дээ ард түмнээ ингэж сонсож байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа. Би та бүхэндээ мэдээлэл болгоод хэлэхэд УИХ-ын нэгдсэн чуулган энэ цагт эхэлж байна. Тэнд нэгдсэн төсвийн хэлэлцүүлгүүд өрнөж байгаа гэдгийг та бүхэн маань ойлгоорой. Хэлэлцүүлэгт хэдий цөөхөн УИХ-ын гишүүд сууж байгаа ч гэсэн улс төрийн нам болгоны төлөөллүүд та бүхний үгийг сонсож байгаа гэдгийг хэлье. Д.Мөнхсүх дараа нь Г.Даваасүрэн бэлдэж байгаарай.

Оролцогч Д.Мөнхсүх: Сайн байна уу? Та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа. Би Ховд аймгийн Мянгад сумын Цагаанбулан багийн иргэн Д.Мөнхсүх гэж хүн байна. Би алим, жимс, жимсгэнийн мод тариалдаг. Олон жил Ховд аймагт тарвас тариалсан газар тариалан эрхлэгч, малчин, уяач иймэрхүү ажил хийж явдаг хүн байгаа юм. Хүмүүс янз бүрийн юм ярьж байна. Би бол үндсэндээ Ховд аймгийн 3500 гаруй тариаланч өрхүүдийг төлөөлж үг хэлье гэж бодож байна. Үнэхээр Монгол орны зөвхөн Ховдыг бол тарвасгүйгээр төсөөлөх арга байхгүй. Тэр их тарвасыг тариалахын тулд Халзан бүрэгтэй уулаас ерөөсөө 10 хэдхэн километр газар л тэр хамаг тарвас нь тарьчихдаг юм. Тэгтэл баруун бүсийн усны хагалбарын тийм ойрхон газар ингээд ийм цацраг идэвхтэй цөмийн эрсдэлтэй үйлдвэр байгуулна. Тэгээд тэр нь бүүр ил задгай гэж байгаа юм. Ил задгай яаж байгаа юм бэ? Тэгээд бид нарыг тэгээд яах гэсэн юм бэ? Яаж амьдар гэж байгаа юм бэ? Ямар ч байсан энэ Халзан бүрэгтэй ордыг

Ховдын ногоочид лав шийдвэртэй эцсийнхээ арга хэмжээг дуустал тэмцэнэ гэдгийг та бүхэнд дамжуулж өгөөрэй гэж хэлсэн шүү.

Ямар ч байсан энэ Халзан бүрэгтэй төсөл бол яах вэ? Саяын хүмүүсийн хэлдгээр улс орны эдийн засагт ашигтай ч юм уу? одоо янз бүрийн юмнууд хэрэгтэй гэдэг байх. Тэгтэл тэр хэдэн сая жил, хэдэн мянган жил, хэдэн 100 жил амьдрах бид нарын орчныг үгүй хийчихээр бид яаж амьдрах юм бэ? Дараа нь тэр чинь дуусчихна дараа нь үлдсэн хүмүүс нь яах юм бэ? 5 жилийн дотор 2 жилийн дотор аваад явчихвал яах юм? Ард нь үлдсэн хүмүүс нь яах юм бэ? тэр цацрагийн хог хаягдлыг чинь хаашаа хийх юм бэ? Бид бол шийдвэртэй эсэргүүцэж байна гэдгээ хэлмээр байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа. Манай танхимд УИХ-ын гишүүд сууж байна. Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар улсын нэгдсэн төсөв хэлэлцэж байгаа гэдгийг бас та бүхэндээ хэлье. Гишүүдээс манай Б.Бат-Эрдэнэ гишүүн байна. Байгаль орчны сайдаар ажиллаж байсныг та бүхэн сайн мэдэж байгаа, Ж.Батжаргал гишүүн ХАА-н чиглэлээр мэргэшсэн Төв аймгийн Засаг даргаар ажиллаж байсан. М.Мандхай манай ХХАА-н дэд хорооны дарга сууж байна. С.Золжаргал гишүүн, Б.Уянга гишүүн 2 бол уул уурхайн чиглэлээр мэргэшсэн 2 хүн байна. Манай Л.Мөнхбаясгалан гишүүн байна. Ч.Лодойсамбуу гишүүдийг та бүхэн таньж байгаа. Сэтгүүл зүйн чиглэлээр ард иргэдийнхээ үгийг олон нийтэд зөв зүйтэй талаас нь үнэн шударга байдлаар хүргэдэг. Манай Л.Соронзонболд гишүүн, Б.Заяабал гишүүн гээд эдийн засаг талаасаа сууж байна. За хамгийн гол нь тэр Э.Болормаа гишүүн тэр доор сууж байна. Тойргоос чинь сонгогдсон одоо УИХ-ын гишүүн бүтэн та бүгдийнхээ яриаг сонсоод сууж байгаа. Тэгэхээр бид нар цөөхөн гэлтгүй парламентын төлөөлөл бүгд байж байна. Мөн Г.Очирбат, Р.Батболд залуу гишүүдээ төлөөлөөд сууж байгаа учраас та бүгд чамлахаар чанга атга гэж бид хэддээ үгээ сайн хэл дээр нь МҮОНРТ шууд дамжуулж байгаа гэдгийг би хэлсэн. Г.Даваасүрэн хэлнэ дараа нь М.Чагнаадорж бэлдэж байгаарай.

Оролцогч Г.Даваасүрэн: Сонсголд оролцож байгаа та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Би газрын ховор элементийн ордын онцлогийн талаар жаахан тодотгож хэлье гэж бодож байна. Би зүгээр мэргэжлийн хүн биш. Гэхдээ өөрийн олж мэдсэн мэдлэгийн хүрээнд товчхон мэдээлэл хийе. Халзан бүрэгтэй газрын ховор элементийн гол онцлог нь диспрози, циркон давамгайлсан цацраг идэвхт агуулсан бодис ихтэй онцлог орд байгаа юм. Дээр нь ураны агууламж зохих хэмжээгээр байдаг онцлогтой. Энэ ордод ураны хэмжээ 13мг/кг гэж байгаа. Түрүүн илтгэгчид маань тодорхойгүй л өнгөрөөд байна. Тэгэхээр энэ 13мг/кг ураны хэмжээ байна гэдэг маань өнөөдрийн газрын ховор элементийн ашиг олборлох гэж байгаа компанийн хэлж байгаагаар бол жилдээ 3 сая тонн хүдэр олборлоно гээд байгаа энэ нөхцөлд 40-50 тонн уран энэ үйлдвэрлэлд орох нь гэсэн ийм тооцоолол гарч ирж байна.

Энэ циркон гэдэг маань цацраг идэвхт бодис. Одоо изотопын хувьд бол 91-96 гэсэн цацраг идэвхт бодис байж байгаа. Ингээд диспрози циркон ураны нийлэмжтэй, цацраг идэвхт бодис нь давамгайлсан орд байгаа юм байна гэдгийг би тодруулж хэлэхийг зорьсон юм. Энэ дээр батлаад хэлсэн зарим хүмүүс байж байгаа. Энэ Шинжлэх ухаан техникийн их сургуулийн доктор багш Ж.Оюун гуай бол Халзан бүрэгтэй ураны хэмжээ 13мг/кг байна. Энэ бол аюултай хэмжигдэхүүн гэдгийг онцолж тэмдэглэсэн байж байгаа. Өнгөрсөн 2024 онд үндэсний эрдэм шинжилгээний хурал болсон. Энэ хурал дээр мөн Шинжлэх ухаан техникийн их сургуулийн багш Энхбат доктор бас энэ ордын талаар тодруулж хэлсэн байгаа... (минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Цаг дуусчихлаа. Б.Заяабал гишүүн орж ирсэн байна. Мөн О.Номинчимэг гишүүн Өргөдлийн байнгын хорооны дарга орж ирээд та бүхний саналыг сонсож байна. За одоо М.Чагнаадорж.

Оролцогч М.Чагнаадорж: Та бүхэнд намрын дунд сарын шинийн 02-ны мэнд дэвшүүлье. Миний хувьд Ховд аймгийн Дөргөн сум бадамлянхуа цэцэгтэй, өвлийн хун шувууд өвөлждөг 260 гаруй нэр төрлийн шувууд нүүдэллэдэг, Далай нуур, Хар усан нуурыг Монгол Улсын иргэний үүргээ биелүүлээд нуурын бохирдлыг сайн дураараа цэвэрлээд явдаг иргэн хүн байгаа юм. Одоо 4 жил цэвэрлэж байна. Гэхдээ 7 хоногт 3-4 удаа тэр дунд тэгж явж байхдаа нууран дунд 8 мянган цагийг өнгөрсөн байна. Нуурандаа их хайртай. Мэдээж Халзан бүрэгтэй төслийг төрийн хийх ёстой ажил мөн эсэх тэр мэдээ мэдээллийг би сайн мэдэхгүй. Гэхдээ Мянгад сумын иргэдийн тэмцэж байгаа тэмцэлд нэгдээд төрийн та бүхний санаа оноог сонсож жоохон ч гэсэн мэдээлэл авъя гэж зорьж ирсэн байгаа.

Ер нь манай Дөргөн сум Хар усан нуур дэлхийд зайлшгүй хамгаалах ёстой цэнгэг усны 200 нууруудын нэг юм. Энэ нуурыг хамгаалахын тулд төрийн хийх ёстой чиг үүргийг Үндсэн хуульд заасныхаа дагуу ганц эрэгтэй хүн 4 жилийн хугацаанд хавар, намар, зунгүй цэвэрлээд ирсэн. Халуунд нь халлаа, хүйтэнд нь хөрлөө даарлаа. Гэхдээ энд би юуг мэдсэн юм бэ гэвэл тэр олон мянган цагийг нууран дунд ажиллахад нуурын тодорхой хэмжээний мөн чанар тэр нууртаа хайртай байх. Нууран дунд ямар их сайхан зүйлүүд байдаг вэ гэдгийг би ойлгосны хувьд энэ Мянгад сумынхаа ард түмнийг дэмжээд ойлголт авъя гэж ирсэн. Ер нь Дөргөн сум бол 3 мянга гаруй иргэдтэй, зоопарк гэмээр 260 гаруй нэр төрлийн шувууд нүүдэллэн ирж байна. Хун, хотон шувууд нь байна. Зэгсний зэрлэг гахай нь байна. Монгол орны ард түмэн бадамлянхуа цэцэг үзэх гэж зорьдог ийм нуурыг одоо иргэнийхээ хувьд чадан ядан хамгаалахыг хичээгээд явж байгаа. Дөргөний ард түмэн бол мэдээж л энд их эмзэг хандаж байгаа. Тийм болохоор санаа давхцаж байгаа болохоор тодорхой хэмжээний мэдээлэл өгөөд ер нь иргэдийгээ мэдээллээр хангаач ээ гэж хэлэх гэсэн юм.

Түүнчлэн Баруун бүсэд сонгогдсон бидний төлөөллийн гишүүд маань иргэдтэйгээ уулзаач ээ. Тэнд айдастай маш олон ард түмэн байна. Тэнд уялдаа холбоотой ажиллаач. Та бүхнийг бид нар сонгосон. Бид нарт эрх байдаг бол та нарт бас үүрэг байдаг юм аа гэдгийг сануулахыг зорилоо. Ер нь Монгол орныхоо хатан далайн нуур тэнд ай саваар амьдарч байгаа хүн зон ирээдүй болсон хүүхдүүдийнхээ өмнөөс Монголын төр минь жоохон уян хатан ард түмнийх мэдэхгүй хүмүүсээ мэдээллээр хангаж, бодит мэдээллийг өгч ажиллах байх гэж бодож байна. Сонгогдсон 20 гишүүд маань эргэх холбоотой байгаач гэдгийг хэлье.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа одоо Н.Сэр-Од дараа нь Б.Энхтайван бэлдэж байгаарай.

Оролцогч Н.Сэр-Од: Та бүхэнд энэ өдрийн мэнд дэвшүүлье. Халзан бүрэгтэй уулын энэ асуудал өнөөдөр Монгол Улсын маань төрийн хойморт хүрч Монгол Улсын Их Хурал анхааралдаа авч, бүс нутгийн ард иргэдийг өнөөдөр Улсын Их Хурлын энэ их танхимд авчирч, иргэдийн санал бодлыг солилцож төрийн шийдвэртэй ажлын хэсгийн дүгнэлтүүд эрдэм шинжилгээний мэргэжилтнүүдийн дүн шинжилгээг танилцуулсан сонсгол хийж, иргэдийн санал бодлыг хүлээж авсанд талархаж байна.

Нөгөө талаараа би Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Хар ус багийн иргэн Нямдаваа овогтой Сэр-Од Мянгад сумын зэргэлдээ сум буюу Халзан бүрэгтэй уулын нөлөөллийн бүсийн иргэн. Ховд аймгийн мянга мянган залуучууд нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд өвөг дээдсийн цагаас эхлэн бид бүхэн зүтгэж ирсэн. Өнөөдөр

хэрвээ энэ уул уурхайн олборлолт явах юм бол юун Монгол Улсын эдийн засгийг дээш нь өргөх гэж байгаа Эрдэнэбүрэнгийн УЦС руу хүн очиж ажиллаж амьдрах, юун бүс нутгийн эдийн засаг хөгжих, бид ирээдүйгээ химийн хүнд металлын хортой нөхцөлд үр хүүхэд, ургамал ногоо, ан амьтан, цэвэр ус энэ үндэсний аюулгүй байдлын хэмжээний асуудлыг бид ярьж, мэдэж, судалж чадаагүй ч гэсэн иргэн хүний ухамсраараа тэнд амьдарч чадахгүй.

Бүх иргэд төвийн бүсийн суурьшил руу шилжинэ. Олон мянган ийм үзэл бодолтой залуучууд байгаа. Өнөөдөр зөвхөн Мянгад сумын төлөөлөл болсон 60 малчин иргэн ирээгүй. Энэ асуудал бол Ховд аймгийн хэмжээний 16 сум, олон үндэстэн ястны нүүдэлчин өв соёлыг хадгалсан тусгай ондоошилтой бүхэл бүтэн баруун бүс нутгийн үндэсний аюулгүй байдлын асуудал. Тэгээд өнөөдрийн нийгэмд бид үгээ хэлсэн нь гэмтэн болдог, үнэнээр явсан нь ядуурч үлддэг, цөвүүн цагийн, худал хуурмагийг харж байна. Бид эх орондоо эрх чөлөөтэй, чөлөөгөө хамгаалуулсан, өвчингүй, өвчлөлгүй, үр удмаа гэсэн цусаа мэдэх төрөл садантай, үндэс ногоо, ан амьтан, жигүүртнээ хамгаалсан үндэсний үзэл бодолтой өвөг дээдсийн цагаас захисан Монгол гэсэн ийм малчин ард иргэд авч үлдэх хэрэгтэй байна. Юун Ховд нутгийн газар тариалан баруун бүсийн хэмжээний тэр олон улсын эдийн засгийн хэмжээний тэр ХАА-н том том төсөл. Өнгөрсөн жил бид нар Чингис хааны мэндэлсэн өдөр буюу 11 сарын 02-нд өвлийн тэргүүн сарын шинийн нэгэнд Халзан бүрэгтэй уулыг эсэргүүцсэн тайван жагсаал Ховд аймгийнхаа төвд болоод морьтой жагсаал хийсэн.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа. Өнөөдөр хяналтын сонсгол зохион байгуулагдана гэдэг бол Монголд УИХ парламентын хяналтын чиг үүргийг бид 2018 оноос хойш хуульчилсан. Сүүлийн үед нийгэмд тулгамдаад байгаа асуудлуудаар хяналтын болон хянан шалгах түр хороо байгуулж, УИХ-ын хяналтыг чиг үүргүүдийг хэрэгжүүлээд явж байгаа. Үүний эхний үр дүн гэхэд жишээлбэл яг тухайн бүс нутгийн иргэдийн үг хэлэх бололцоог нь хангаж, үзэл бодлыг нь олон нийтэд түгээх гээд ийм зүйлүүд явж байгаа юм. Тэгэхээр би бас Мянгад сумын иргэддээ өнөөдөр сонсголд хүрэлцэн ирж, оролцож үг хэлж үзэл бодлоо илэрхийлж байгаад талархаж байна.

Нөгөө талаараа бид энэ сонсголоор хэн нэгнийг бас буруутгах эрх байхгүй. Би түрүүнээс хойш хэд хэдэн хүний амнаас энэ талаар сонслоо. Ялангуяа олон жил төрд алба хашаад, төрийн албыг төрийн нэрийн өмнөөс та бүхэнд мэдээлэл, танилцуулга хийж байгаа шинжээч нар, ажлаа хийж байгаа төрийн албан хаагчидыг шүүмжилж буруутгах эрх байхгүй. Тийм учраас аль альдаа хүндэтгэлтэй хандаж, зөвхөн өөрийнхөө үзэл бодлыг илэрхийлэх нь зохистой гэдгийг та бүхэнд хэлье. Б.Энхтайван дараа нь Б.Гурвандаваа бэлдэж байгаарай.

Оролцогч Б.Энхтайван: Сайн байцгаана уу? Би Ховд аймгийн Буянт сумын иргэн Батцэндийн Энхтайван гэж хүн байна. Халзан бүрэгтэй уулын хайгуул явагдсанаас хойш манай Буянчууд, Мянгачууд, Дөргөнчүүд, Чандманьчууд бүгд л маш их айдаг боллоо. Маш их айдастай болсон. Энэ уулыг ухаад төнхөрчихөөд эхлэх юм бол бид хаана очиж амьдарна гэдэг ийм зүйлтэй тулгараад байна. Бид нар хаашаа ч явахгүй. Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэн хүнийхээ хувьд нутаг орноо амар амгалан тайван байдлыг хамгаалж, цааш цаашдаа үр хүүхдийнхээ эх нутгийг хамгаалж, тэмцэж, Халзан бүрэгтэй уулын төслийг бүрэн зогстол нь бид бүхэн тэмцэнэ.

Би баруун бүсээс сонгогдсон 10 гишүүндээ хандаж хэлье. Энэ ганцхан Мянгад сум, Буянт сум, Эрдэнэбүрэнгийн асуудал биш ээ. Баруун 5 аймаг баруун Монголын

асуудал. Энэ баруун 5 аймгаас сонгогдсон 10 гишүүн маань бид бүхэнд уул нь анх амлахдаа нутаг орныхоо амгалан тайван байдлыг хамгаалах, эх нутгаа та бүгдийнхээ өмнө бид нар өөрийн биеэр чөмгөө дундартал нь хамгаална гэж ам өчиг өгч байж бидний өмнө санал аваад гарсан 10 гишүүн байгаа. Тэгээд энэ 10 гишүүн маань бид бүхнийхээ өмнө ажиллаж өгөөч гэдгийг хүсмээр байна.

За баярлалаа. Компанийн үйл ажиллагаанд нэг зүйлийг хэлчихье. Энэ үйл ажиллагаа явуулж байгаа компани бол ард иргэдийг тагнадаг, чагнадаг, янз бүрийн байдлаар гарын үзүүрээр юм өгдөг, ээж аав нь мэдээгүй байхад оюутан хүүхэдэд тэтгэлэг олгосон байна. Ээж аав нь мэдээгүй байна. Одоо ийм юмаа болиоч ээ. Янз бүрийн асуудал дээр ард иргэдийг шүүхэд өгдөг, дууддаг. Манай нэг найз өнөөдөр би шүүх дээр очоод торгуулчихаад ирлээ. Маргааш манай эхнэр явна, нөгөөдөр манай найз явах байх гэж байна. Энэ чинь одоо юу гэсэн үг юм бэ? Ийм дарангуйлал байж болох уу?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа. Б.Гурвандаваа дараа нь 3.Энхбаяр бэлдэж байгаарай.

Оролцогч Б.Гурвандаваа: Сайн байцгаана уу? Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Намайг Мянгат сумын Цагаан булан багийн иргэн Б.Гурвандаваа гэдэг. Өнөөдөр шинжээч нарынхаа ярьсан, хэлснийг сонсоод сууж байна. Эндээс нэг зүйлийг ажиглалаа. Энэ хүмүүст итгэх итгэл алга. Жишээлбэл, төр нь өөрсдөө Мянгадад хүрч ирээд цацрагийн хэмжээ байх ёстой хэмжээнээс 8 дахин их гэдгийг Мянгатын ард түмэнд итгүүлсэн. Тэгсэн өнөөдөр яасан бэ гэсэн чинь хоргүй гээд сууж байна.

Уран, торийг нөгөөдөх нь хүлцэх хэмжээнээс их юм аа гэдгийг А.Цолмон захирал надад өөрөө хэлж байсан. Хяналтын хэмжээнээс жишээлбэл торыг нь бол илүү яг гараад байгаа юм, манайх тэрэн дээр одоо цацрагийн хяналт хийж байгаа гэж хавар хэлсэн. Тэгсэн чинь одоо шинжээчид нь үгүй ээ гээд сууж байна. Төр нь өөрсдөө нэг бол байх ёстой хэмжээнээс их байна гэхихээд одоо бага байна гэж тайлбарлаад байхаар яаж итгэх юм бэ? Нэг арьсан дотор хүн таргалж, турж болно. Өнгө нь хувирч болдог юм уу?

Жишээлбэл манайхан биет болоод гарч байгаа нь машинтай нүүрсээ тоолж чадахгүй байгаа шүү дээ. Тэгчихээд хүний нүдэнд харагдахгүй, гарт баригдахгүй цацрагаа яаж хянах гээд байгаа юм бэ? Тийм мэргэжилтэн байгаа юм уу? Монгол Улсад энэ гишүүдэд мэдээлэл өгч байгаа төрийн байгууллагуудаас илүү магадгүй манай Мянгадын ард түмэн мэдээлэлтэй байгаа байх шүү. Би хатуухан хэлчихье, манай Ховдын Байгаль орчны газар, Хар ус нуурын тусгай хамгаалалттай газар, Ховд гол сав газар, Ховд голын сав газрын захиргаа зэрэг байгууллагаас илүү манай Мянгадын ард түмэн, Ховд голыг, Хар усан нуурыг нутаг орноо хамгаалаад явж байгаа. Тиймдээ ч өөрсдөө ажил, амьдралаа хаяад цаг заваа гаргаад энд ирээд сууж байгаа. Одоо тийм учраас ховор элементийн талаар нэгэндээ үнэнээ хэлдэг болсон цагтаа, нэг нэгэндээ итгэдэг болсон цагтаа ашиглая тэгэх үү? Тэгэхгүй бол энэ чинь дандаа л худлаа ярьж байна шүү дээ. За баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа. 3.Энхбаяр дараа нь Т.Пүрэвжав бэлдэж байгаарай.

Оролцогч 3.Энхбаяр: Юуны өмнө та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе! Ховд аймгийн Мянгад сумын Баянхошуугийн иргэн 3.Энхбаяр байна. Би саналаа хэлэхээсээ өмнө энэхүү сонсголын үйл ажиллагаа маань өмнөх утаа түлшний сонсгол

шигээ бүү замхарчихаасай гэдгийг хүсмээр байна. Тэрэн шиг үр дүнгүй болох юм бол үнэхээр бид бүгдийн ирдэг, хойноо итгэл хүлээж суугаа ард иргэд маань тэд нарынхаа итгэлийг алдах хөсөрдүүлэх зүйл болно.

Хоёдугаарт Мянгад сумын Ховд аймгийн ер нь бараг л Монгол Улсын ард иргэд төрдөө итгэх итгэл жилээс жилд, өдрөөс өдөрт буурч байна. Итгэх итгэлгүй болж байна. Үнэхээр ард түмнийхээ эрхийг хангадаг төр байх уу? ашиг сонирхлыг дэмждэг төр байх уу? гэдгийг өнөөдөр Монгол Улсын иргэд харж суугаа байх гэж бодож байна.

Тэгээд Монгол Улсын үндсэн хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсад газар, түүний хэвлий ой, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл төрийн хамгаалалтад байна гэж заасан байгаа. Мөн хууль дээр Монгол Улсын иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй байгаа. Энэ маань бид нарын яг өнөөгийн нөхцөл байдал дээр бол маш ноцтойгоор зөрчигдөж байна. Манай өмнөх хүмүүс маань бас хэллээ. Үнэхээр өнөөдөр Монгол Улс ургийн гажигтай малыг шинжилж чадахгүй байж бусадыг нь шинжилж чадах уу? Газрын ховор элементтэй холбоотой судалгаа шинжилгээгээ нарийн хийгээд хоорондох судалгааны дүн нь яг таг тохирохгүй, мэдээллийн зөрөөтэй, газрын ховор элементийн талаар мэргэшсэн мэргэжилтэнгүй. Наад зах нь Ховд аймгийн Байгаль орчны газар цацрагийн мэргэжилтэнгүй, цацраг хэмжих багажгүй ийм байж энэ газрын ховор элементээр тоглох нь цаг хугацааны хувьд арай эрт байна гэж иргэн хүнийхээ хувьд бодож байна.

Үнэхээр энэ газрын ховор элементийн талаар боловсон хүчнээ бэлдээд, судалгаа шинжилгээ хийдэг лабораторио байгуулчихаад түүнийхээ дараа магадгүй 2050-2060 онд ашиглаж болох байх. Энэ ойрын 20 жилдээ бол бид бүхэн зөвшөөрөхгүй. Эцэст нь хэлэхэд үнэхээр Ховд аймаг баруун Монголын ард иргэдийнхээ амьдрах эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангаж, энэхүү дүгнэлтэд ач холбогдол өгч, уян хатан шийдэхийг та бүгдээсээ хүсье. За баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Утааны сонсгол үр дүнгүй боллоо гэж дүгнэж болохгүй. Би тэр сонсголын нэг хэлэлцүүлгийг нь өөрөө ахлаад явуулсан хүний хувьд жишээлбэл 286 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлээд өнөөдөр хууль хяналтын байгууллагад шалгагдаж байна. Нөгөө хортой гэж яриад байгаа түлшийг чинь өнөөдөр үйлдвэрлэлийг нь зогсоосон, 96 тэрбумаар өнгөрсөн жил бүх айлуудад зуух тараах гэж байсныг 100 хувь зогсоосон. Энэ үр дүн мөн байх тийм ээ. Тэгэхээр хэдүүлээ бас ярьж хэлэхдээ нэгнийхээ хийсэн ажлыг үгүйсгэж болохгүй байх аа гэж бодож байна. Надад 2 хүсэлт ирсэн байгаа. Тэгээд хүсэлтийн оролцогч Т.Пүрэвжав, дараа нь Н.Дарханбаяр бэлдэж байгаарай.

Оролцогч Т.Пүрэвжав: Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе! Миний хувьд Ховд аймгийн Мянгад сумын мал эмнэлгийн тасагт төрийн чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг хүний хувьд миний чиний гэхгүйгээр бодит байдлыг та бүхэнд хүргэе гэж бодож байгаа юм. 2020 оноос хойш Ховд аймгийн Мянгад сумд ургийн гажигтай төл мал мэндэлсэн 8 удаагийн тохиолдол Ховд аймгийн Мянгад сумын Мал эмнэлгийн газар бүртгэгдсэн. Тэгээд дээр мэдээлэлд дурдсан анх 2020 онд нэг унага байсан. Энэ асуудал улам бүүр явсаар 2025 оны мал төллөлтийн үеэр 5 тохиолдол болж бүртгэгдсэн.

Бид харъяалалын дагуу аймгийн мал эмнэлгийн лабораториор дамжуулаад Улсын мал эмнэлгийн ариун цэврийн лабораторид шинжлүүлдэг. Мал эмнэлгийн лаборатори нь тоног төхөөрөмж хүрэлцээ хангамж муу, чадахгүй байна гээд эцсийн хариуг өгч чадахгүй ард түмэн их төөрөгдөлд өртөөд байна. Ер нь МАА-н салбар бол

ард иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр, хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн гэдгийг та бүгд мэдэж байгаа. Ийм учраас хөдөө, орон нутагт амьдарч байгаа малчин ард иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр болсон МАА-н салбар өнөөгийн яриад байгаа энэ нөхцөл байдал, Монголын маргааш бол төвөгтэй байдал руу шилжихийг үгүйсгэхгүй байгаа юм. Тийм учраас дараах 3 саналыг тавья гэж бодож байна. Мэдээж тойргоос сонгогдсон гишүүд энийг бол юуны өмнө ажил хэрэг болгож, арга хэмжээ авч ажиллах байх гэж харж байна.

Нэгдүгээрт нь аймгийн Мал эмнэлгийн лабораторид нэг толгойгүй шиг байна. Анх гарахдаа 8 хөлтэй одоо 6 хөлтэй болчихсон байгаа гээд мэдээлэлд гарч ирсэ. Хөлдөөгөөд хөргөгчинд хадгалчихсан байна. Үүнийг шинжлэх судлах газар өнөөдөр Монголд байхгүй учраас олон улсын лавлагаа лабораториудад цацрагийн хүнд металлын химийн хордлогын зэрэг шинжилгээнүүдийг хийлгэж ард иргэдэд үнэн бодит хариултыг өгөөч гэдэг саналыг тавимаар байна. Ховд аймгийн Мянгад сумын Халзан бүрэгтэй төсөл хэрэгжиж байгаа. Нөлөөллийн буюу орчны бүсэд хүрээлэн буй орчны шинжилгээг зайлшгүй хийлгэх шаардлага байна. Үнэхээр цацрагийн идэвх нөлөөнд өртөөд байна уу, үгүй юу? тэнд идэвхжилттэй байна уу, үгүй юу? гэдгийг шинжлэх ухааны үндэстэйгээр олж мэдэх зайлшгүй шаардлага байна. Дараа нь цацрагийн идэвхээ хянадаг багаж байхгүй гээд хүмүүс яриад байгаа. Цацрагийн идэвхийн хяналтыг олон удаагийн давтамжтайгаар ашиг сонирхол, тал талын оролцоог хангасан байдлаар... (минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа. Саналууд хэллээ. Та бичгээр саяын ярьсан зүйлээ бичгээр өгвөл сайн байна. Н.Дарханбаяр дараа нь Л.Галбадрах бэлдэж байгаарай.

Оролцогч Н.Дарханбаяр: Сайн байцгаана уу? Би Ховд аймгийн Мянгад сумын Гахайт багийн иргэн Насанжаргалын Дарханбаяр гэдэг залуу байна. Миний ярих гэж байгаа зүйл Халзан бүрэгтэй уулын талаар үг үзэл бодлоо илэрхийлсэн ард иргэдийг маш их дарамталж байгаа. Цагдаагаас олон удаа дуудах торгох арга хэмжээ авч байна. Намайг энд ирсний дараа хүртэл буудалд цагдаа нар ирж лавлагаа мэдээлэл авна гэсэн журмаар байцаалт авсан.

Би зүгээр уул усныхаа төлөө, нутаг усныхаа төлөө явж байна. Янз бүрийн ашиг сонирхол надад байхгүй. Тийм байхад яагаад ингэж дарамталж байгаа юм бэ? Энэ бол цаанаасаа явуулж байгаа дарамт гэж би ойлгож байгаа. Түүнээс Ховд аймгаас ганцхан намайг онцгойлон шалгахгүй байх гэж би бодож байна. 2 дугаарт Халзан бүрэгтэй уулыг хамгаалахын тулд манай баруун Монголын ард түмэн тэр чигтээ тэмцэх шаардлагатай болчихоод байгаа. За ингээд орхиё доо.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа. Л.Галбадрах үг хэлье.

Оролцогч Л.Галбадрах: Та бүхний амар мэндийг мэндчилье. Би энэ Ховд аймгийн Засаг даргаар 1996-2000 онд ажиллаж байсан хүн л дээ. Халзан бүрэгтэй ордыг анх сонирхож, судалж байсан тэр хүмүүсээс эхлээд одоог хүртэлх энэ үйл явцыг нь мэдэх юм. Би саналуудаа их товчхон хэлчихье гэж бодож байна.

1 дүгээрт нь төрийн бодлого гаргах хэрэгтэй байна. Газрын ховор элементээ, ураны одоо юунаас ялгаж гаргах юм уу? Энэ хүрээнд УИХ-аас газрын ховор элементийн талаар төрийн бодлогоо тодорхой болгоод хэдэн үеэсээ эхэлж олборлож эхлэх юм. Олборлосон ашигт малтмалаа хэдэн хувийг нь экспортод гаргах юм, хэдэн хувийг нь дотооддоо үйлдвэрлэлээ хөгжүүлэх вэ гэдэг талаар саяын залуу хэлж

байна. Ирээдүйдээ бид итгэх ёстой. Ирээдүйд энэ технологийн дэвшлийг гартаа атгах ёстой гэдэг үүднээсээ өөрсдийнхөө үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд ашиглах ёстой юм уу гэсэн ийм бодол байгаа юм.

2 дугаарт лиценз эзэмшиж байгаа компани, ард иргэдтэй маш их зөв ойлголцох ёстой юм. Анхнаасаа нэлээн түрэмгийдүү байдлаар хандсанаас болж нутгийн иргэдийн дургүйцлийг хүргэсэн. Ийм хандлага улайм цайм ажиглагдаж байдаг. Энэ бодлого нь цаашдаа нэлээн хүчтэй яваад төр засгийн анхааралд орж, энэ УИХ-ын сонголт болгож байгаа. Сонголт болж байгаа дээр их баяртай байна. Үүнийг цааш нь ахиж нэлээн гүнзгий авч үзэх хэрэгтэй байх гэж бодож байна.

3 дугаарт нь бид эдийн засаг хүндэрч байна гэж үзээд байгаа. Халзан бүрэгтэй ордыг яаралтай ашиглаад төсвийн цоорхой нөхнө гэвэл энэ зөв бодлого биш. Төсвийн цоорхойг нөхөх маш их бололцоонууд байгаа. Нүүрсээ зах зээл дээр гаргаж зарах хэрэгтэй байна, хулгайгаа багасгах хэрэгтэй байна, төрийн данхар бүтцээ багасгах хэрэгтэй байна, үр ашиггүй хөрөнгө оруулалтаа багасгах хэрэгтэй байна. Магад ч үгүй ард иргэдийг залхуу болгоод байгаа нь халамжийн тогтолцоогоо эргэж харах ч хэрэгтэй байгаагүйсгэх боломжгүй юм. Түүнээс биш төсвийн цоорхойг нөхөх чиглэлээр, яаралтай мөнгө олж хүнд байдлаас гаръя гэвэл энэ буруу бодлого гэж би хувьдаа үздэг хүн. Өөрөө ч эдийн засагч хүн байгаа.

Тэгээд ирээдүйд ашиглах талаас их анхаарах хэрэгтэй байх. Хайгуул судалгааны ажил дээрээ манай орон нутгийнхан зөв ойлголцох юм бол нэг их тээг тавиад заавал лицензийг цуцлал гэдэг нэг талын хатуу байр суурь баримтлах шаардлагагүй байх гэж би бодож байна. Харилцан орон нутгийнхныгаа оролцуулж хяналт тавиад, тайлан мэдээллээ зөв өгөөд, зөв мэдээллээр хангахгүй бол нэг талыг барьсан нэг хэсэг сэтгүүлчдийг оролцуулсан мэдээлэлд нь ард иргэдийн хардлага сэрдлэгт хүргэх байдалд хүргээд байгаа юм. Тэгээд хамгийн сүүлд нэг үг хэлье. Ховд аймгийн ард иргэд бол олон үндэстэн ястан ард иргэдтэй юмыг ойлгодог, сайн ойлгуулж чадах юм бол ... (минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонголт даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа. Ингээд нийтдээ 27 хүн үг хэлсэн байна. Одоо сонголт бүртгүүлэхдээ үг хэлэхээр хүсэлт ирүүлсэн оролцогч байгаа. Түүний дараа заалнаас авсан нэрсийн дагуу 20 гаруй оролцогч байна. “Хөшөөтийн ахмад уурхайчдын холбоо” ТББ-аас нэг хүн үг хэлэх ёстой. Д.Цэдэнбал та үгээ хэлнэ үү. Дараа нь “Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн” ТББ-аас нэг хүн үг хэлнэ.

Оролцогч Д.Цэдэнбал: Энэхүү танхимд хуран цугларсан нийт хүмүүст энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Өнөөдөр энэхүү сонголт оролцсон шалтгаан бол би Ховд аймгийн Манхан сумын иргэн хүн байна. Би Ховд аймгийн Хатан Хар усан нуурын уснаас 9 үеэрээ ууж ундаалж өссөн ийм хүн байгаа юм. Ийм учраас энэ усны асуудал бол манай Хар усан нуур, Хар усан нуурыг дагасан 5 том нуур бий. Монгол Алтайн нуруу Хангайн нуруу 2-ын завсарт орших 6 том нуурын 5-ыг нь тэжээдэг ийм их мундаг нуур байгаа юм.

Тэгэхлээр би энэ дээр хамгийн гол чухал акц өгч орж ирээд байгаа юм. Би сая төрийн албан хаагчдын мэдээллийг нэлээн сонсож хооронд нь дүгнэлт хийлээ. Манай төрийн бодлого ерөөсөө л ганцхан юм ярьдаг нь эдийн засаг л сайжруулах гэж байна. Өөр бодлого ерөөсөө гаргаж ирэхгүй байна. 1990 оноос эхлээд эдийн засгийнхаа бодлогыг бид ярьсаар ирсэн. Тухайлбал, Тавантолгой, бүх алт хөтөлбөр гээд бид эдийн засаггүй байна, үүнийг л ухчихвал олчихно гэдэг.

Нөгөө талаараа Оюутолгойг ухаад Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлчихнэ гээд амлаад байсан Ерөнхий сайд би хар толгойгоороо үүрнээ гэсэн. Ерөнхий сайд өнөөдөр хаана байна, тэрэнтэй хариуцлага тооцсон хэн байна. Гэтэл өнөөдөр яг миний өөдөөс хараад сууж байгаа О.Батнайрамдал гишүүн яг тооцоо хийгээд Оюутолгой дахиад 30 жил өрөнд байх юм байна, ямар ч үр өөжгүй байгаа гэж хэлж байсан. Ингэхлээр бид төрийн бодлого, төрийн түшээд буруу байна гэдгийг дамжуулаад байна шүү дээ. Төрийн бодлого худлаа бйсан нь сая энэ тайлан дээрээ хэлж байна. Зөвхөн эдийн засаг ярьчихдаг. Уг нь төрийн бодлого бол ард түмний эрх ашгийн төлөө байх ёстой. Хэрвээ эрсдэл гарах юм бол эрсдэлийг төр ингэж хамгаална, хэрвээ агаар, усаар хордоод ирэх юм бол ингээд зогсоочихно гэсэн ийм бодлого гаргаж ирж чаддаггүй. Нөгөө хар толгойгоороо үүрнэ гэсэн хариуцлагатай хүмүүст тооцоо хийж чаддаггүй нь төрийн дутагдал байна. Дээрээс нь бусад хүмүүс бол экологийн асуудлыг бүгдийг нь ярилаа. Би нэг орхигдож байгаа зүйлийг ярьа. Компанийн ТЭЗҮ-ээс үзэхэд нэг секундэд 300 литр ус зарцуулна гэсэн тооцоо байгаа юм. Бид ашигт малтмалыг яадаг вэ гэвэл, алтыг ч тэр, мөнгийг ч тэр, зэсийг ч тэр бүгд усаар угааж цэвэрлэж ... (минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Цаг дууссан байна. Таны саналыг ойлголоо. Одоо “Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн” ТББ-ын төлөөлөл 6 номер дээрээс үгээ хэлээрэй. Дараа нь “Хүний эрхийн хөгжил” ТББ Г.Уранцоож 5 дээр бэлдэж байгаарай.

Оролцогч Б.Батсайхан: Би “Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн”-ийг төлөөлөөд үг хэлж байна. Би өөрөө Ховд аймгийн уугуул хүн байгаа юм. Байгаль орчны асуудлаар сүүлийн 20-иод жил ажиллаж байгаагийн хувьд хэд хэдэн зүйлийг зайлшгүй хэлэх шаардлагатай байна.

Нэгд, бид яг энэ цаг доор цацраг малтмал буюу мөн газрын ховор элементийг л ухчихвал баяжчих юм шиг үлгэрийг орхих хэрэгтэй. 1992 онд анхны Ерөнхийлөгч маань бид газрын тосоо ухвал бар болно гээд эхэлсэн үеэс хойш бид юутай үлдсэн бэ? Байгаль орчны хувьд Монголын говь, тал хээрийн хувьд эко систем байхгүй болсон. Хангайн нуруунаас урагшаа урсдаг бүх голын эхэн дээр бид ухаад Хангайн нурууны урдах голууд байхгүй болсон. Эг Тааз, Онги, Байдраг цутгадаг нуурууд нь үгүй болсон. Хангайн нуруунаас хойшоо эх авдаг ихэнх голууд гадагшаа гараад явдаг. Гэтэл бидний усны нөөц болсон Их нууруудын хотгор яг үлдсэн газрыг ухчихвал болох юм гэнэ дээ. Энэ бол Монголын бодлого биш шүү.

Өнөөдөр хууль тогтоогч сууж байгаа учраас би зайлшгүй хэлж байгаа юм. Энэ бол Монголын бодлого биш. Өөрөөр хэлбэл газрын ховор элемент, уран энэ торий чинь төлөө дэлхий дайтаж байгаа юм. Дайн үүний төлөө болж байгаа юм. Энийг эзэмшсэн нь өнөөдөр дэлхий дээр хүчтэй байгаа юм. Хамгийн их хохирогч нь яг манай Монгол шиг төр засаг нь замбараагүй, авлигад идэгдсэн, ядуу буурай орон хохирогч болж үлдэж байгаа юм. Тийм учраас Монголын төр энэ дээр маш хариуцлагатай байх ёстой. Яагаад гэвэл манай хууль тогтоох байгууллага нь өөрсдөө маш аюултай хууль батлаад бид яг энийг эхлүүлээд нэг л алхах юм бол асар том ангал руу орох хуулийг хийчихсэн. Энэ чинь өөрөө зүгээр газрын ховор элемент гээд байгаа болохоос биш гол асуудал нь энэ бол цацраг идэвхт ашигт малтмал.

Үүнийг бид олборлож, тээвэрлэх юм бол хуулиараа буцаад яг энэ нутагт булшлах зүйлийг бид олон улсын конвенцоороо хүлээгээд авчихсан шүү дарга нар аа. Яг энэ конвенцыг 2016 онд зүтгүүлэхэд нь бид тогтоон барьж байсан юм. Харамсалтай нь авчихсан. Эрх зүй нь бүх юм нээлттэй. Тийм учраас бид ухуулаад, ашиглуулаад, бүр сүүлдээ цөмийн хог хаягдал булшлуулах сав болохыг эрх зүйгээрээ

авчихсан. Бүр цөмийн байгууламж барина гээд авчихсан шүү гэдгийг Улсын Их Хурлын гишүүдэд анхааруулъя гэж бодож байгаа юм. Энийг сайн судлаарай, энэ дээр ажиллаарай.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Цаг дууслаа баярлалаа. Зөөвч-Овоогийн гэрээтэй холбоотой асуудлыг ингэж хаа хамаагүй хольж ярьж иргэдэд буруу мэдээлэл өгч болохгүй. Тэр Зөөвч-Овоогийн асуудал бол тусдаа асуудал явж байгаа гэдгийг анхаарна биз. Одоо Г.Уранцоож 5 номер дээр дараа нь Далхжав, Гомбодаш бэлдэж байгаарай.

Оролцогч Г.Уранцоож: Сайн байцгаана уу? Манай байгууллага “Хүний эрх хөгжил төв” бөгөөд “Төлсөн авснаа нийтэл” гээд 30 гаруй гишүүн, ТББ-аас бүрдсэн иргэний нийгмийн эвслийн гишүүн байгууллага юм. Тийм учраас бид ТАН эвслийн байр суурийг ерөнхий танилцуулж, тусгай асуудлууд дээр байр суурийг илтгэх үүрэг хүлээж энд сууж байна.

Энэхүү танилцуулах байр суурийг боловсруулахдаа ТАН эвслийн гишүүн байгууллагуудаас ажлын хэсэг гарч, орон нутгийн иргэдээс авсан мэдээлэл дээр үндэслэн, ялангуяа үндэснийхээ хууль тогтоомж, олон улсын хүний эрхийн хэм хэмжээний үндсэн дээр боловсруулж гаргасан байр суурийг та бүхэнд танилцуулах гэж байна. Гэхдээ энэ бол нэлээд урт учраас бүгдийг нь 3 минутад уншиж багтахгүй.

Бодлогын баримт бичгүүд хууль, эрх зүйн хэм хэмжээнүүдийн баримт бичиг, зарим гарсан шийдвэр баримт гэх мэтчилэн бусад нотлох баримтын эмхэтгэлтэй хамт 2 Байнгын хорооны гишүүдэд илгээсэн байгаа. Тийм учраас та бүхнийг бас гишүүдийг уншиж танилцаасай гэж хүсэж байна. Бидний байр суурийн үндсэн гол нэг дүгнэлт бол энэ үйл явцад маш олон хуулийг зөрчсөн юм байна.

Энэ сонсгол дээр хуулийн зөрчлийн тал дээр нэлээн ярьсан учраас би зүгээр дурдаад явчихъя гэж бодож байна. Тусгай зөвшөөрөл нь хууль бус болох талаар бид нэлээд хэдэн чухал үндэслэлүүдийг гаргасан байгаа. Тэгэхдээ энэ дээр юуг анхаарсан бэ гэвэл манайд хуулийн процесс нь хэрэгждэггүй юм байна гэдэг асуудлыг гаргасан байгаа. Хууль бусаар шилжүүлсэн, хууль бусаар авсан юм байна гэсэн байгаа. Мөн Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг ч гэсэн зөрчиж байгаа гэсэн энэ мэдээллүүд бол тодорхой байж байгаа. Тийм учраас энэ асуудлыг би ингээд өнгөрөөе гэж бодож байна.

Цөмийн энергийн тухай хуулийг ч гэсэн зөрчиж байгаа талаар түрүүнд хүмүүс ярьсан байгаа. Гэхдээ энэ дээр хамгийн онцлох хэлэх ёстой зүйл нь их хэмжээний хаягдал үүсэхээр байгаа бөгөөд үүнтэй холбогдуулаад Цөмийн энергийн тухай хуулийн 17.1.1-д заасан техникийн болон аюулгүй ажиллагаа нь шаардлагыг бүрэн хангасан байх ёстой байсанг хангаж чадаагүй байна шүү гэсэн ийм дүгнэлтийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс байгуулагдсан ажлын хэсгээс гаргасан байдаг.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа. ТАН (Төлсөн авснаа нийтэл) эвслийн байр суурийг илэрхийлсэн бичгийг авсан. Та сая товч илэрхийллээ, таны саналыг сонслоо. Гомбодаш гуай санал давхацсан гээд үгээ татсан. Дараагийн хүн Даваадорж 6 дугаар микрофонд ирж сууна уу? Хүрэлмөнх дараа нь бэлдэж байгаарай 5 номерт. Даваадорж байна уу? Хүрэлмөнх байна уу? Байхгүй байна. О.Пүрэвсүрэн бэлдэж байгаарай.

Оролцогч О.Пүрэвсүрэн: Сайн байцгаана уу? Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Би Ховд аймгийн Мянгад сумын Баянбулаг багийн иргэн, “Алтай бидний

шүтээн" ТББ-ын зохицуулагчийн ажилтай хүн байна. Бид Халзан бүрэгтэйн орд газрын асуудлаар би бас нутагтаа багийн даргын ажил хариуцаж байхдаа сая танилцуулж байгаагаар бол 2000 онд анх лиценз олгосон гээд л явж байна. Тэгтэл энэ лиценз чинь 1997 онд олгогдож эхэлсэн байдаг юм. Энэ лицензийг авахдаа компани хууль бусаар авсан, ашиглалтын лиценз, хайгуулын лиценз хоёрыг хамтад нь зэрэг авчихсан байдаг. Уг нь бол зүй нь хайгуул хийж дуусаад, нөөцийг нь тогтоогоод ашиглалтын лицензийг авах ёстой байдаг. Гэтэл хууль зөрчиж авсан байгаа нь бидэнд тодорхой, нотлогдсон асуудал байгаа.

Тэгээд 2012 оноос хойш бид иргэний нийгмийн байгууллага байгуулаад, Халзан бүрэгтэйн орд газрын асуудлаар тодорхой хэмжээнд судалж ирсэн. Энэ судалгаа ТББ-ын зүгээс ч юм уу, Ховд аймгийн холбогдох мэргэжлийн хүмүүстэй хамтарч ажиллаад, судалгаа явуулаад, ерөөсөө ашиглах боломжгүй, асар эрсдэлтэй ийм төсөл юм байна гэдгийг ойлгосны үндсэн дээр ард иргэдийнхээ дуу хоолой болоод тэмцэлд нэгдээд өдий хүртэл явж байгаа юм. Энэ дээр сая төрийн байгууллагуудын шинжээчид маш хариуцлагагүй дүгнэлтүүдийг хэлж байна. Бүгд хуурамч, худлаа гэдэг нь нотлогдож байгаа юм. Тэгэхээр одоо манай төр яаж байна вэ? Ард иргэдийнхээ эсрэг ажилладаг болж байна.

Ер нь монголчууд 30 жил замбараагүй уул уурхайн лиценз гэдэг нэг алга дарам цаасаар улс орныхоо газар нутгийг худалдаад дууслаа. Сая Халзан бүрэгтэй, энэ "Монголиан нэшнл рийр ийрт корп" гэдэг компани бол 100% Монголын эзэмшилд байгаа компани гэж яриад байдаг байсан. Тэгсэн сая танилцуулга дээр 96% нь Канадын компани гээд гараад ирж байна шүү дээ. Энэ чинь тодорхой болж байна ш дээ. Ийм байдлаар ард иргэдээ хуурч, энд төрийн алба хашиж сууж байгаа нөхдүүд энэ компаниудтай хуйвалдсан, худалдагдсан шинжлэх ухааны зүтгэлтнүүд бүгдээрээ ичих хэрэгтэй. Ард иргэд бүгд та нарын болохгүй бүгдийг мэдээд сууж байгаа. Энгийн иргэдийг хуурч байгаа юм шиг, ямар ч мэдээлэлгүй хөдөөгийнхөн болохоор тэр химийн томьёо ч мэдэхгүй гээд ярьж байдаг юм байна. Тийм юм байхгүй. Одоо бид нар шинжлэх ухааны түвшинд эрдэм мэдлэгтэй, боловсролтой хүмүүс манай Мянгадын ард түмэн дотор ч өчнөөн олноороо байгаа. Тийм учраас энэ асуудлыг төрийн хэмжээнд ... (минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа, Та хэд маань үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлж байгаа. Бид тэрэнд хүндэтгэлтэй хандах үүрэгтэй учраас сонсоно. Пүрэвсүрэн байхгүй юу? Дараагийн хүн Аварзэд овогтой Оюунчимэг байна уу? Алга байна. За, Ганболдын Эрдэнэтуяа? Цэрэндоржийн Эрдэнэцогт? За, Г. Эрдэнэтуяа 5 дугаарт микрофон дээр суучих. Дараа нь Ц.Эрдэнэцогт бэлдэж байгаарай.

Оролцогч Г.Эрдэнэтуяа: Өдрийн мэнд хүргэе. Өнөөдрийн нээлттэй хэлэлцүүлэг болж байгаад талархалтай хандаж байна. Миний нэр Г.Эрдэнэтуяа, Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн гүйцэтгэх захирал. Олон талын байр суурийг сонслоо. Судлаачдын байр суурийг сонслоо. Өнгөрсөн хугацаанд хийсэн судалгааны ажлын үр дүнг бас сонслоо. Тэгэхээр аливаа асуудал дээр гарч буй эргэлзээтэй зүйлүүдэд бид нар хариулт авч чадаж байна. Нөгөө талдаа оролцогч талууд нэгдсэн нэг ойлголттой болоод энэ хэлэлцүүлгээс гарна гэж хүлээлттэй байна.

Бидний зүгээс өнөөдөр манай салбарт тулгамдаж байгаа том сорилтыг энд харж байна. Төр маань нэг талдаа хөрөнгө оруулагчдыг урьж ирээд зөвшөөрөл өгдөг. Нөгөө талдаа үйл ажиллагаа явуулах гэхээр төрийн албан хаагчид, ялангуяа хууль тогтоох байгууллагад ажилладаг УИХ-ын гишүүд маань өөрсдөө иргэддээ буруу

ташаа мэдээлэл өгдөг. "Та нар дэмжихгүй бол энэ төсөл явахгүй" гэдэг. Сая иргэд маань ч үүнийг дурдсан. Энэ бол үнэн.

Нөгөө талдаа бас нэг ажиглагдаж байгаа зүйл нь, бид нарын үйл ажиллагааг нийт газар нутгийн хэмжээтэй харьцуулахад өнөөдөр уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нийт газар нутгийн 0,25%-д л үйл ажиллагаа явуулж байна.

Усны хэрэглээ гэхэд нийт усны хэрэглээний 18%-д хүрч байгаа. Ус дахин ашиглалт бол эрдэс баялгийн салбарт технологийн хөгжлийг дагаад нэлээн өндөр түвшинд хүрсэн. Тэгэхээр бидний хувьд нийт усны хэрэглээний 18%-ийг ашиглаад, газар нутгийн 0,25%-д үйл ажиллагаа явуулж, эдийн засгийн өнөөдрийн энэ үр өгөөжийг авчирч, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна гэж итгэж байгаа. Цаашдаа оролцогч талуудын гаргаж ирж байгаа үр дүнг харахад мэдээллийн зөрүүтэй байдал, шинжилгээний байгууллагуудын болон төрийн байгууллагуудаас өгч байгаа дүгнэлтүүдийн зөрүү энэ үл ойлголцлыг улам хүндрүүлж байна гэж харж байна.

Тэгэхээр ажил хэрэгч санал байна. Энэ нээлттэй сонсголд оролцсон талуудаас бүрдсэн ажлын хэсэг байгуулж, холбогдох байгаль орчны нөлөөллийн хөндлөнгийн судалгааг хийлгэх. Түүнийг нэг лабораториор биш, хэд хэдэн лабораториор хийлгээд, ажлын хэсэг сонгож байгаад үр дүн дээр нь дүгнэлт гаргуулах ийм санал байна. Нөгөө талдаа, Халзан бүрэгтэйн төслийн хувьд хариуцлагатай уул уурхайн кодекст нэгдсэн, хуулийн хэрэгжилтийг хангахын зэрэгцээ нэмэлт шаардлагуудыг биелүүлэх үүрэгтэй. Энэ стандартын хүрээнд хамтын оролцоотой мониторингийг орон нутгийн иргэдтэй хамтраад хийвэл өнөөдрийн яригдаж буй эргэлзээ, нэг нэгнийхээ шинжилгээний үр дүнд итгэхгүй байгаа байдал тодорхой хэмжээнд арилна гэсэн хүлээлт байна.

Бидний хувьд Монгол Улс хууль засагладаг орон гэдэгт итгэдэг. Хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг ялгалгүйгээр үйл ажиллагаа явуулах боломжийг хангаж өгөх ёстой гэж байр сууриа илэрхийлмээр байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа, таны цаг дууссан байна. Манай төрийн бус байгууллагуудын төлөөллүүдээс үг хэлээд явж байна. Ер нь ТББ, иргэний нийгмийн байгууллагууд чиг үүргийнхээ дагуу аливаа асуудалд хариуцлагатай мэдэгдэл хийдэг байх ёстой гэж би хувь хүнийхээ хувьд боддог. Сая хоёр ТББ-ын тэргүүн хууль зөрчсөн үйлдлийг зарлаж байгаа мэтээр ярилаа. Монгол Улсад өнөөдөр зөвхөн шүүх л хууль зөрчсөн эсэхийг тогтоодог. Гэтэл оролцогч Г.Уранцоож маш олон хуулийг зөрчсөнийг албан ёсоор зарлаж байгаа юм шиг ярих нь хариуцлагагүй мэдэгдэл. Дараагийн ТББ-ын тэргүүн та хардах эрхтэй, харин хүн гүтгэх, гүжирдэх эрх Монгол Улсын иргэн хэнд ч байхгүй. Тиймээс төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд нэрээ өндөрт өргөж, илүү иргэдийн төлөөлөл болж, аливаа асуудалд ул суурьтай хандах нь өөрөө илүү үнэ цэнтэй юм болов уу гэж бодож байна. Энэ бодлоо та бүхэнд илэрхийлье. Одоо Ц.Эрдэнэцогт, дараа нь Далхжавын Цолмон, бэлдэж байгаарай.

Оролцогч Ц.Эрдэнэцогт: Байна уу? Та нөхдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Миний бие Ховд аймгийн Мянгад сумын уугуул, Буянт сумын суугуул, Мянгад сумандаа есөн үеэрээ амьдарсан иргэн байна. Энд оролцож байгаа миний гол зорилго бол Үндсэн хуульд заасан хүний эрх, тухайлбал эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байгааг хэлэх гэсэн юм. Сая ч хүмүүс маань энэ талаар дурдсан. Нөгөө талдаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн гаргасан хүнсний аюулгүй байдлын тухай хөтөлбөр ч мөн зөрчигдөж байна. Үүнийг ярих үндэс нь юу вэ гэхээр,

би Ховд аймгийн Ховд гол, Буянт сумын сав дагуу тариачид, ногоочдын дунд ажиллаж амьдардаг. Хэрэв цацраг идэвхт алдагдал гарах юм бол бидний тариа ногооны ургалт удааширч, ургац алдагдана. Тийм учраас энэ санаа зовнилоо тариачид маань дамжуулж хэлж өгөөч гэж намайг явуулсан.

Мөн Ховдын тарвас бол бидний брэнд. Монгол Улсад намар ирсэн хүн бүр Ховдын тарвасыг амсаж, намрын сайхан цагийг мэдэрдэг. Харин цацраг идэвхт алдагдал гарч, ус, агаараар дамжин хүнсний ногоонд нөлөөлөх юм бол энэ нь зөвхөн Ховд аймгийн иргэдийн төдийгүй Монгол Улсын нийт ард иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байна гэсэн үг. Энэ талаар төр засаг маань бидний үгийг сонсох цаг болсон.

Та нар 35 жил ухаж, бидний амьдралыг дээшлүүлэх гэж оролдсон санаа чинь сайхан байсан ч ажил хэрэг дээрээ болохгүй байна. Тиймээс одоо ухаж биш, ухаарч, ухаан зарж амьдрах цаг болсон. Юмыг дандаа мөнгөний талаас нь битгий хараач, ирээдүйн хүүхдүүдийнхээ, эх орныхоо төлөө бодооч гэж хэлэх гэсэн юм. Биднийг тайван амьдруулаач ээ. Миний гол зорилго бол зөвхөн Ховд аймгийн ард иргэдийн бус, баруун бүсийн, цаашлаад Монгол Улсын ард иргэдийн дуу хоолойг дамжуулахад оршиж байна. Анхаарах цаг болсон, сэрэх цаг болсон гэж хэлэх гэсэн юм. Анхаарал тавьсанд баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа. Далхжавын Цолмон байна уу? За байхгүй байна. Халхын Эрхэмбаяр байна уу? алга байна. Баярмагнай, Мөнгөн байна уу? Дараа нь Галданжамцын Бат-Эрдэнэ бэлдэж байгаарай.

Оролцогч Б.Мөнгөн: Баярлалаа. Энэ сайхан хэлэлцүүлгийг зохион байгуулж байгаа бүх хүмүүстээ, оролцож байгаа бүх хүмүүстээ энэ өдрийн мэндийг хүргэе. Миний бие гадаадад сурч, ажиллаж амьдарч байгаа хүмүүсийн төлөөлөл болж энэ хэлэлцүүлэгт оролцож байна. Зарим мэдээллийн чанартай зүйлсийг хэлэх хэрэгтэй байна.

Манайхан заримыг нь мэдэхгүй байх шиг байна. Ялангуяа энд сууж байгаа шинжлэх ухаанчид, доктор, профессоруудаа. Яг одоогийн байдлаар шинжлэх ухаан хөгжөөд хөгжөөд ураны аюулыг бүрэн дарах, бүрмөсөн арилгах технологи хараахан гарч ирээгүй. Үүнийг бүгд мэдэж байгаа. Гэтэл зарим эрдэмтэд үүнийг гуйвуулж, янз янзаар ярьдаг. Нөгөө талдаа, 60 жилийн өмнө уран олборлолт эхэлсэн олон улс оронд уугуул нутгийнхан нь сүйрчихсэн байгаа. Би дэлхийн туршлагыг ярьж байна. Үүнийг та бүхэн давтах гэж байгаа юм биш биз? Үүнийгээ дотроо маш сайн бодоорой.

Ялангуяа Улсын Их Хурлын гишүүд ямар мэдээллээр хангагдаж, юу уншиж судалдаг юм, тэрийгээ маш сайн бодоорой. Халзан бүрэгтэйн төлөөлөл болж Ховдоос ирсэн хүмүүстээ баярлалаа. Та бүхэн ямар сайхан нэгдэж, нийлж чаддаг юм бэ. Баруун Монголынхны жинхэнэ нэгдмэл байдлыг харуулж байна. Энэ хэлэлцүүлгийг зөвхөн орон даяар Монголчууд ч биш, гадаадад байгаа Монголчууд ч үзэж байна. Тэгэхээр та бүхэнтэйгээ бүх тал дээр хамтарч ажиллахаа илэрхийлье. Бүү зогсоорой, бүү зогсоорой.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа. Хүсэлт ирүүлсэн хүмүүс үгээ хэлж дууслаа. За, одоо заалнаас авсан нэрийг уншина. Одоо цаг 14:45 болсон байна. 15:00 цагаас хоолны завсарлага болно. Манай оролцогчдод зориулж үүдэнд хоол бэлдсэн байгаа. Тэгээд буцаад 16:00 цагаас орж ирээд, үлдсэн хүмүүс нь үгээ хэлж дуусаад, ард нь УИХ-ын гишүүд асуулт асууж, үг хэлнэ.

Цэдэндоржийн Нарантуяа, дараа нь Цэвээн-Ойдов бэлдэж байгаарай. Нарантуяа та 5 номерт сууна уу. Цэвээн-Ойдов дараа нь 6 дугаарт сууна.

Оролцогч Нарантуяа: Юуны өмнө энд байгаа бүх иргэд, бүх талын оролцогчдод энэ өдрийн мэнд хүргэе. Нэлээд их зүйл яримаар байна, гэхдээ би нэгэн түүхийг, үг хэлэх завсраа хэлье гэж бодлоо. 35 жилийн өмнө мал малчдад шилжсэн, дараа нь Ховд аймагт Дөргөний УЦС, дараа нь Хөшөөтийн уурхай, дараа нь Эрдэнэбүрэний УЦС, түүнийгээ дагаад Халзан бүрэгтэйн төсөл эхэлсэн. Ингэж ажиглаад харахад нэг л тактик, нэг л сонин арга барил давтагдаад байгаа юм. Үүнд харамсаж байна. Нөгөө талдаа би талархаж байна. Яагаад гэвэл ардчилсан Үндсэн хууль батлагдаад, нээлттэй парламентын 35 жилийн ой тохиож, хууль сайжирч, амьдрал ахуйгаа дагуулж байх энэ цаг үед 1500 км-ын цаанаас манай Ховд аймгийн малчин иргэдийн төлөөлөл энд сууж байна. Би өөрөө Ховд аймгийн иргэн. Ховдод 65 нас хүртлээ сургууль соёл төгсөж, ажиллаж амьдарсан хүний хувьд тэндхийн хүмүүсийг, Ховдын бүтээн байгуулалтыг маш сайн мэднэ. Хэн юу хийснийг ч сайн мэднэ. Гэвч нэг зүйл дээр харамсахад, 35 жилийн өмнө иргэний нийгмийн байгууллага, ТББ, хувийн хэвшил гэж яригдаж байхад шал өөр байжээ. Бид аймаг, орон нутгийн удирдлагуудыг ширээний ард суулгаад, мэдээлэл солилцоод, бичиг баримт өгөөд, тэр үеийн жудаг, соёл гэж байсан. Одоо бол нийгэм өөр болсон.

Сүүлийн үед дэндүү ардчилсан нийгмийг зориуд анархист болгох гэж байгаа мэт харагдаж байна. Би ч гэсэн төрийн ажилтнуудыг харддаг байсан үе бий. Ховд аймгийн иргэдийн эрх ашиг, хүний эрхийн төлөө би Хөшөөтийн уурхайд очиж, хэвлэл мэдээллийн сувгаар дуу хоолойгоо хүргэж явсан. Тэр үед яг өнөөдрийн адил, орон нутгаас малын хохирол, амьтдын үхэл зэрэг асуудал яригдаж байсан. Миний өмнө нүүр тулан сууж байгаа Г.Нямдаваа дарга тухайн үед Засаг дарга байсан. Чөлөөт зах зээл, хувийн хэвшлийн талаар ярьж байхад тэр үеийн 17 сумын нэгдлийн дарга бид нарыг яг өнөөдрийн адил зарим хүмүүсийн нэрийг хэлж, дор нь чимээгүй болгож байсан... (минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За, таны цаг дууссан байна. Цэвээн-Ойдов 6 дугаарын микрофоноор ярина уу. Таны саналыг сонслоо. Нарантуяа гуайн саналыг сонслоо. Цагаа барья. 6 дугаар номерын микрофоны цагийг дахин эхнээс нь өгье. Дараа нь Мэндбаярын Саранцэцэг бэлдэж байгаарай.

Оролцогч Д.Цэвээн-Ойдов: За сайн байцгаана уу? Би Ховд аймгийн төвөөс ирсэн иргэний төлөөлөл, олон нийтийн байгууллагын төлөөлөгч. Энэ хэлэлцүүлэгт хүрэлцэн ирсэн бид нар эндээс үнэн зөв мэдээлэл сонсох гэж ирсэн. Гэтэл иргэдийн зүгээс юу шаардаж байна вэ гэхээр: “Мал хүнд хор учруулж байна, ургийн гажиг гараад байна” гэж байна. Ургийн гажиг юунаас болж гарч байгаа вэ гэдэгт хариуцах мэргэжлийн байгууллага алга байна. Энэ дээр хариу өгөх хүн байна уу? Мөнгө төлөөд бөхчүүдийг “допинг хэрэглэсэн, хэрэглээгүй” гэж шинжилж чаддаг атлаа, малчин, ураг үхэж байхад юунаас болж байгааг шинжлэхгүй байна. Энэ нь Хятадын эмээс болж байгаа юм уу, малчид эмийг замбараагүй хэрэглэж байгаагаас болж байгаа юм уу, эсвэл Халзан бүрэгтэйтэй холбоотой юу? Ургийн гажиг зөвхөн Мянгадад гарч байгаа юм уу, өөр аймагт гарч байгаа юм уу? Жишээ баримт алга байна. Энэ бүхнээс харахад Монголын төр ажлаа хийж чадахгүй байна, ард түмнээсээ тасарчихсан байна.

Ард түмнийхээ үгийг сонсохгүй байна, үнэн зөв мэдээллээр хангахгүй байна. Хэзээ үнэн зөв мэдээллээр хангадаг болох юм бэ? Түрүүн Хөшөөтийг ашиглалтад оруулахад бас л мал үхэж байсан, ан амьтан үхэж, хүүрийг нь овоолж байсан. “Өрөмдлөг тавьснаас боллоо, уурхай ухсанаас боллоо” гээд бөөн эсэргүүцэл өрнөж байсан. Дарвийнхан, Цэцгийнхэн бүгд эсэргүүцэж байсан. Дараа нь Дөргөний УЦС

ашиглалтад ороход “Хар ус нүүрс хөвөрлөө, загас жараахайгүй боллоо, Чонохарайхын гол үгүй боллоо” гээд эсэргүүцэл өрнөж байсан. Дандаа ийм эсэргүүцэлтэй тулж байгаа нь төр ажлаа сайн хийж чадахгүй байгаагийн шинж. Ард түмэндээ ойлгуулж, үнэн зөв мэдээллээр хангах ёстой. Өмнө нь ч өөрсдөө шуналаар газрын баялаг руу дайрч байсны нэг хэлбэр. Одоо энэ эрдэмтдэд итгэх үү? Эсвэл физик, хими судалгаа хийсэн эрдэмтдэд итгэх үү? Эсвэл ард түмэндээ, малчдад итгэх үү? Мянгадынхан төлөөлж ирсэн хүмүүс бүгд л өөрсдөө эрдэмтэд мэт хариулж байна шүү дээ: “Энэ үүнээс болж байна, тэрнээс болж байна” гэж... (минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За, Баярлалаа танд. 5 дугаарт Мэндбаярын Саранцэцэг. Дараа нь Энхболдын Алтан-Од 6 дугаарт бэлдээрэй.

Оролцогч М.Саранцэцэг: Байна уу? За өнөөдөр та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая. Миний бие Мэндбаяр овогтой Саранцэцэг гэдэг. Би МУИС-ийн Газар зүй, геологийн сургуулийг 2011 онд цаг уурч, физикч мэргэжлээр төгссөн. Төгсөөд 10 жил болж байна. УИХ-ын гишүүн асан Л.Гантөмөр ах намайг танина, МУИС-ийн 70 жилийн рекордыг эвдэж байсан оюутан, 5 хэлээр чөлөөтэй ярьдаг физикч мэргэжилтэй хүн байна. Өнөөдрийн хувьд миний зорилго бол ураны эсрэг үгээ хэлэх. Маш богинохон, гурван минутын үг байгаа учраас товч тодорхой ганцхан зүйлийг хэлье. Би байгаа цагт Монгол Улсад уран ухуулахгүй гэж амлаж байна.

Хэрэв уран ухуулах юм бол би У.Хүрэлсүх болоод Н.Учрал гишүүн, түүнтэй холбоотой ураныг оруулж ирсэн бүх хүмүүстэй амьдаар нь хариуцлага тооцно гэдгээ хатуу тангараглаж байна, Ард түмнийхээ өмнөөс. Н.Учрал гишүүнийг би мэднэ. Тэр хүн өмнө нь Тимон нэртэй хип хоп дуучин байсан, Их Засаг сургуульд сурсан. Ямар мэдлэг боловсролтойг нь мэдэхгүй. Би Чингэлтэй дүүргийн 23-р хороонд сонгуулиар түүний мөрийн хөтөлбөр дээр нь, штаб дээр нь ажиллаж байсан. Гэвч тэр хүн мөрийн хөтөлбөрөөсөө шал өөр зүйл хийсэн. Тухайн үед 12 мянган айлын орон сууцыг Чингэлтэйд барина гэж байсан, “20 минутын хот” гэж байсан. Гэтэл “Улаанбаатар хотыг 14 хуваана гээд юу ярьж байгаа юм бэ, 1-р ангийн хүүхдээс ч доогуур зүйл яриад байгаа юм. Өнөөдөр “уран ямар ч хоргүй” гэж тэр хүн яриад байгаа нь үнэндээ инээдтэй. Би тэр хүнийг татан буулгах эрхтэй гэж бодож байна. Яагаад 76 байсан УИХ-ын гишүүдийг 126 болгосон бэ? Ард түмнээсээ санал асуулга аваагүй. Яагаад бид нар баяр наадам тэмдэглэж байх хооронд дандаа хууль баталдаг юм бэ? Яагаад улс эх орноо ломбардад тавьчихдаг юм бэ? Та нарын хүүхэд алт, бид нарын хүүхэд цус уу? Үгүй. Бид бүгд адилхан, бүгд эх хүн, бүгд Монголын ард түмэн. Төр гэдэг нь ард түмэн байгаа цагт л оршдог. Та нар бид нарыг байхгүй бол та нар оршихгүй. Та нар мянга насална гэж бодож байна уу? Үгүй шүү, хэдхэн жилийн дараа та нар ч үхнэ. Харин бид нар өсөж яваа залуу Монгол хүмүүс, бидний үр хойч Монгол Улс хөгжих ёстой. Чингис хаан газар нутгаа шилжүүлэлгүй, бидэнд бүрэн бүтэн үлдээсэн. Монгол Улс мөнгөгүй байх хамаагүй, хөгжихгүй байсан ч газар нутгаа бүрэн бүтэн авч үлдэх эрхтэй. Хэрэв уран ухах юм бол энэ бол чимээгүй тахал.

Өнөөдөр Номтойбаярын Тэгшбаяр юу яриад байна? Физикийн мэдлэг нь 5-р ангийн мэдлэгээс доогуур зүйл яриад сууж байна. Монголын ирээдүй маш гэрэлтэй байхад ийм тэнэглэл хэрэггүй. Би Монгол Улсыг АНУ шиг хөгжүүлнэ. Та нар ажлаа хийж чадахгүй бол би хийе. Та нар зүгээр суудал бөглөж байгаа бол би ажлыг чинь хийе. Би угаасаа баян эмэгтэй, надад мөнгө сонин биш, мөнгө бол зүгээр цаас. Гэхдээ тэр цаасыг үйлдвэрлэх гэж мод сүйдэж, ус ширгэж байна. Ус байхгүй бол амьдрал байхгүй. Харин усанд уран орвол яах юм бэ? Номтойбаярын Тэгшбаяр, Монатомын захирал Далайжаргал нар “усан дотор хүхэр орохоор цэвэр тунгалаг болдог” гэж

сэтгүүлчид ярьж байна. Тэгвэл тэр урантай усыг өөрсдийнх нь нүдэнд цутгаад үзэх үү? Нүдэндээ цутгуулахгүй л биз дээ.

Тэгвэл яагаад бид тэр усыг уух ёстой гэж ард түмнээ доромжилж байгаа юм бэ? Та нар бид нарыг тэнэг гэж бодоогүй биз? Та нар бид нарыг байхгүй бол та нар ч байхгүй. Та нар үхнэ, бид нар өснө. Та нар ажлаа хийж чадахгүй бол залуус хийе. Гэтэл та нар 20, 30, 40 жил гишүүн боллоо, юу ч хийсэнгүй. Очирбат газрын тосыг Монголд үйлдвэржүүлнэ гэж байсан ч өнөөдөр юу ч болоогүй.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За, таны цаг дууслаа. М.Саранцэцэг ээ, таны гурван минутын үгийг бүрэн сонслоо. Гэхдээ бусад руу “үхнэ, ална” гэх мэтээр заналхийлэхгүйгээр, хүндэтгэлтэйгээр үзэл бодлоо илэрхийлэх хэрэгтэй. Монгол Улс тусгаар тогтносон, бүрэн эрхт улс. Төр нь ард түмэнтэйгээ хамтдаа бодлогоо нэгтгэж, асуудалдаа хандах ёстой. Бид бүгд бие биенийхээ үгэнд хүндэтгэлтэй хандах учиртай. За, Энхболдын Алтан-Од, дараа нь Ядамбаатарын Цэрэнханд бэлдээрэй.

Оролцогч Э.Алтан-Од: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ хэлэлцүүлэг, сонсгол орон нутагт зохион байгуулагдах болов уу гэж олон жил хүлээсэн. Одоо Ховдын иргэдийн төлөөлөл болж энд сууна. Бид ерөнхийдөө мэдээллээр хангагдах зорилгоор хүрч ирсэн. Эсэргүүцэж байгаа нь зөвхөн Мянгад сумынхан биш. Олон иргэд ажиглаж, эцсийн үр дүнг хүлээж байгаа. Би Ховд аймгийн Инженерүүдийн холбооны тэргүүн Э.Алтан-Од, архитектор, хот төлөвлөгч мэргэжилтэй. Манай Ховд амьдрах орон зай багатай, уулархаг, нүцгэн газар нутагтай. Тиймээс үлдсэн амьдрах боломжтой газар нь маш үнэ цэнтэй. Товчхондоо, оршихуйн үзэл баримтлал уул уурхайтай зөрчилдөж байгаа учраас иргэд эмзэг хандаж байна.

Үндсэн асуудал нь мэдээлэл хангалтгүй, мэдээллийн зөрүүтэй байдлаас болж иргэдийн ойлгомжгүй байдал нэмэгдэж байна. Төрийн талаас өгч буй мэдээлэл, ТББ-аас тавьж буй мэдээлэл зөрүүтэй байгаа нь өнөөдрийн нөхцөл байдлыг хүндрүүлж байна. Ховд аймагт энэ хэлэлцүүлгийг нээлттэй зохион байгуулж, ил тод мэдээлэл өгөхийг олон жил хүлээсэн. Гэвч сүүлийн дөрвөн жил эрчимтэй үйл явдлууд өрнөчихөөд өнгөрсөн. Ц.Туваан сайдын үед орон нутагт нь мэдээлэл хийх, сайд газар дээр нь очиж ажиллая гэсэн санал иргэдэд өгөгдсөн ч өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй, хамгийн том хүндрэлтэй асуудал нь энэ байх шиг байна.

Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийг сануулан, саналаа хэлье: “газрын хэвлийн баялаг төрийн хамгаалалтад, ард түмний мэдэлд байна” гэж заасан. Харин өнөөдөр Халзан Бүрэгдэй төсөл дээр эсрэг дүр зураг харагдаж байна. Орон нутгийн иргэд хамгаалъя гээд явж байхад төр нь хэлэлцэх шат алгасаад шууд ашиглана гэж байгаа нь маргааныг улам дагуулж байна. Мэдээллээс харахад лиценз олон дамжсан, зарим оролцогч дундаас нь ашгаа аваад гарчихсан байж магадгүй гэх хардлага төрүүлж байна. Эцсийн дүгнэлт гэвэл зөв үү, буруу юу гэдгийг л мэдэх шаардлагатай. Энэ бол хамгийн түрүүнд бид мэдэх ёстой үнэн.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа. Я.Цэрэнханд саналаа хэлээд, завсарлага.

Оролцогч Я.Цэрэнханд: Сайн байцгаана уу? Юуны өмнө энд, УИХ дээр сонсгол хийлгэх хэмжээнд тэмцэл өрнүүлсэн Ховд аймгийн ард түмэндээ талархлаа илэрхийлье. Та бүхэн зөвхөн тухайн бүс нутгийн төдийгүй Монгол Улсын цэвэр усны нөөцийг хамгаалахад чухал ач холбогдол өгч, асар их хүч гарган ажиллаж байгаагийн илрэл энэ тэмцэл юм. Энэ бол Монголын ард түмний хичээл зүтгэл, тэмцлийн нэг

жишээ. Монголын нутаг болгонд гол, усаа хамгаалах, оршихуйгаа хамгаалах тэмцэл өрнөж байна. Түүний нэг тод илрэл нь Ховд аймгийн нутгийн иргэдийн тэмцэл юм.

Яагаад ингэж хэлж байна вэ гэхээр, манай улсад байгаль орчны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх асуудал үнэхээр орхигдоод байна. Монгол Улсын хамгийн чухал, тогтвортой бодлого бол нутгийн уугуул иргэдийн эрх ашгийг хамгаалах, гол усаа хамгаалах асуудал юм. Энэ бол хамгийн амин чухал цаг үе. Тиймээс Их Хурлын Гишүүд маань энэ асуудалд онцгой соргог хандаж, чухал хуулийнхаа зүйл заалтыг хамгаалж, хичээнгүйгээр ажиллаасай гэж хүсэж байна. Одоо “цацраг” гэдэг дээр үгээ хэлье. Энэ орд газар нь анхнаасаа цацраг идэвхт орд гэж Цөмийн энергийн газраас тодорхойлогдсон байдаг.

Гэтэл яагаад үүнийг энгийн ашигт малтмал, “ховор элемент” гэж нэрлэж, цацраг идэвхт орд биш болгож байна вэ? Тиймээс нутгийн иргэдийн саналыг хүлээж аваад энэ сонсголоор тусгай зөвшөөрлийг нь цуцалж өгөөч ээ. **Нэгдүгээрт**, тусгай зөвшөөрлийг нь цуцлах, **хоёрдугаарт**, энэ ордыг Монголын төр өөрийн мэдэлд авч, дахин ийм газар дээр тусгай зөвшөөрөл битгий олгооч ээ. Яагаад гэвэл энэ газар нь Монгол Улсын ундны цэвэр усны хагалбар нутаг. Түүгээр ч зогсохгүй дэлхийн цэвэр усны хагалбар газарт багтдаг нутаг. Ирээдүйн дайн юун дээр тогтох вэ? Одоогийн эрх баригчид шүтээд байгаа “цөмийн ховор элемент” дээр биш, зөвхөн усан дээр тогтоно.

Тиймээс усаа хамгаалаач ээ. Усны эх үүсвэрээ хамгаалахын тулд орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг хүлээж аваад тусгай зөвшөөрлийг нь цуцлаад, энэ газрыг хамгаалалтад аваач ээ гэсэн хүсэлт байна. Орон нутгийн иргэдийн санал, санаачилгыг бүрэн дэмжиж байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Санал хэлж дууслаа. Ингээд 15:00 цаг болсон тул хоолны завсарлага авъя. 16:00 цагаас эргэн танхимдаа цуглана. Нэг цагийн завсарлага.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Юндэнгийн Батчулуун, Бямбын Баярсайхан гэдэг хоёр хүн байвал 5 дугаар микрофон, 6 дугаар микрофон дээр суудлаа эзлээрэй. Бямбын Баярсайхан 6 дугаар микрофон дээр суудлаа эзэлье. Манай зохион байгуулагчид үүдэнд байгаа хүмүүсээ оруулаарай. 15 цаг 45 минут болсон байна. Сонсголын үйл ажиллагааг үргэлжлүүлье.

Оролцогч Ю.Батчулуун: Сайн байцгаана уу? Монголын ард түмэн, Ховдынхондоо баярлалаа. Эх нутгаа хамгаалаад ингэж олуулаа ирсэнд баярлалаа.

Нэгдүгээрт, өнөөдөр эх орон, газар шороогүй бол бид хэн ч биш, юу ч биш гэдэг ухаанаас би тэгж ханддаг.

Хоёрдугаарт, тэр сайхан байгалийн баялаг, ой мод, ус сав газар байсаар атал яагаад заавал “ховор элемент” нэрийн дор Монгол орноо хөгжүүлнэ, эдийн засгаа бэхжүүлнэ гээд мөнгөний араас ингэж улайрч байгаа нь надад таагүй байна. Би иргэн хүний хувьд энэ байр сууриа илэрхийлж байна. Өнөөдөр бид нар эрдэмтэн, доктор, профессор биш. Зүгээр л мөнгөнд худалдагдсан улсуудын үгэнд орж байгалиа сүйтгэхийн оронд, ирээдүй үрсдээ үлдээе. Ирээдүйд улс өөрсдөө тоног төхөөрөмж, технологио хөгжүүлсэн үедээ ашиглаж болно. Харин өнөөдөр түрүүлж аваад мөнгө олох гээд улайраад байгаа нь буруу.

Өнөөдөр бид Оюу толгойг (ОТ) аваад, Эрдэнэтийн дайны 7 дахин том ордтой газар байсан ч өнөөдөр хэдхэн сэндвичин барилгаас өөр юмгүй байна. Тэгэхэд

Эрдэнэтэд бүхэл бүтэн хот сүндэрлэхсэн байна. ОТ-д бол сэндвичин барилгууд л байна, баялгаа ухаж дуусаад, нүхнүүд үлдээгээд явах гэж байна. Та нар байгаа зүйлээ эмх цэгцтэй, тооцоотой, судалгаатайгаар ашиглаач. Заавал байгаагүй зүйлээ ухаж төнхөж, байгалиа сүйтгэх хэрэг байна уу? Хойчдоо ирээдүйтэй улс шүү дээ бид. Зөвхөн өнөөдрийн хэдхэн хүн баяжиж, маргааш нь ухсан нүх л үлдээх гэж байна. Тиймээс энэ төслийг шууд хаамаар байна, тусгай зөвшөөрлийг цуцламаар байна.

Малчид хэдэн жил амьдарсан нутагтаа тийм асуудал байгаагүй гэдгийг хэлж байна. Харин өнөөдөр малын өвчин, ургийн гажиг гараад байгааг хэлж байхад малчдынхаа үгийг хүлээж аваач. “Уран тэдэн хувь байна, ийм байна” гэж ярихын оронд уранаар оролдохгүй, ирээдүйдээ үлдээе гэж хэлье. Ерөөсөө битгий ухаж төнхөөд бай. Хэрвээ ухаж байгаа бол баялгийн өгөөжийг цөмөөрөө адилхан хүртээд, хамтдаа амьдаръя. Эдийн засаг гэж худлаа ярьж, тархийг нь угааж, эх орноо сүйтгэж болохгүй. Эх орноо гэж хэлмээр байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа танд. Одоо УИХ-ын гишүүд сонсголд орж ирж суухыг уриалж байна. Төсвийн хэлэлцүүлэг, давхар нэгдсэн чуулганд хуралдаж байгаа. Гэхдээ энд Халзан бүрэгтэйн ордын сонсгол, цаашдаа газрын ховор элементтэй холбоотой Монгол Улс ямар бодлого баримтлах вэ гэдэг талаар хэлэлцэх учраас гишүүдийг орж ирэхийг урьж байна. Бямбын Баярсайхан 6 номерын микрофон дээр байна уу? Дараа нь Дамдинбаатарын Сарантуяа бэлдээрэй. 6 дугаар микрофон нээлттэй.

Оролцогч Б.Баярсайхан: Би маш товчхон ярья гэж бодож байна. Мянгад сумынхаа уул ус, баялгийг хамгаалахаар олон жил тэмцэж ирсэн. Өнөөдөр биш, эртнээс, 2004, 2005, 2010 оноос эхэлсэн. Тэгээд өнөөдөр ингэж тэмцэж байгаа улсуудаа би өөрөө энд эрүүл мэндийн ажилтай явж байгаад, дэмжье гэж орж ирлээ. Миний амьдрал Мянгадаас эхэлсэн. Тэнд гэр бүлтэй болсон, ажил амьдралаа эхэлсэн, үр хүүхэд төрсөн дандаа сэтгэл зүрх холбоотой байдаг.

Би нэг түүх ярья. Аймгийн дарга байсан Галбадрах гуай, Ховд аймгийн дарга байсан Нямдаваа гуай (2004 оноос 2012 он хүртэл), дараа нь аймгийн дарга байсан Болормаа гуай. Манай аймгийн удирдлагууд энд орж ирээд үг хэлж, сэтгэл санаагаа гаргаж, тэмцэлд оролцож, иргэдээ дэмжиж байгаад нь баярлаж байна. Түүх гэвэл, 2002, 2004 оноос эхлээд тэр хугацаанд бүх лиценз олгогдсон, бүх лиценз солигдсон. Хамгийн сүүлд Болормаа гуай Ерөнхий сайдын зөвлөх байхдаа “Алсын хараа 2050” баримт бичигт Халзан Бүрэгтэйн асуудлыг оруулсан. Тэнд “1. хайгуул хийнэ, 2. судалгаа хийнэ, энэ чиглэлд хөрөнгө оруулалт нэмэгдүүлнэ” гэж тусгасан байсан. Үүнийг би залуу хүний хувьд дэмжиж байна.

Гэхдээ нэг зүйлийг хэлмээр байна. Халзан бүрэгтэйн асуудал чинь хаанахын асуудал юм бэ? Хэрэв “Алсын хараа”-д орчихсон бол энэ чинь Монгол Улсын хөгжлийн бодлогын асуудал байх ёстой. Засгийн газар мэдэж, УИХ баталж, хэрэгжүүлэгч нь Засгийн газар байх ёстой. Аймгийн болон сумдын дарга нар төрийн бүх шатны байгууллагууд хэрэгжүүлэх үүрэгтэй. Өнөөдөр Халзан бүрэгтэйн асуудлыг ярьж байгаа УИХ-ын гишүүд нэг л үг хэлдэг: “Манай аймгаас сонгогдсон...” (минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Цаг дууслаа. Сарантуяа эгч түрүүн үг хэлчихсэн шүү дээ. За нэг минут нэмье. 6 дугаар микрофонд нэг минут.

Оролцогч Б.Баярсайхан: За тэгээд яагаад би энэ улсуудыг дэмжиж ирсэн юм гэхлээр эд нар чинь ерөөсөө эзэнгүй болчихсон юм. Аймаг нь ерөөсөө энэнээс зугтаад

явчихсан юм. Аймгийн дарга нь бүх мэргэжлийн байгууллагууд нь, төрийн байгууллагууд нь, тэгээд энэ хэдэн иргэд нь ингээд ус нутгаа хамгаалах гэж ингэж явж байгаа юм. Аргагүйн эрхэнд сумын 2 дарга нь эд нартайгаа нийлээд ингээд явж байгаа юм. Тэгээд энэ аягүй эмгэнэлтэй байдал энэ үнэхээр засгийн бодлого юм бол шат шатанд байсан төр засгийн дунд шатных нь хаашаа алга болчихсон юм. Тэгээд би одоо энэ аймгийн 2 сумын Иргэдийн хурлын дарга, Засаг дарга хоёрыг, танил 2 Иргэдийн хурлын төлөөлөгчийг нь бас танина. Өрөвддөг хөөрхий амьтад. Эд нар чинь төрийн хүмүүс шүү дээ. Тэгээд л эд нарынхаа талд орохоос өөр арга байхгүй. Тэгээд нэг эвгүй ийм дүр зургийг бий болгоод энэ улсуудыг ингэж тэмцэлд оруулсан, одоо зам нь энэ, тэгээд одоо энийг нэг бол ашиглах юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа. 5 дугаар микрофон дээр Дамдинбаатарын Сарантуяа, дараа нь Түндэвдоржийн Таня 6 дугаар микрофон дээр бэлдэж байгаарай.

Оролцогч Д.Сарантуяа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Яагаад энэ уул уурхайн бодлого алдагдсан бэ, авлига ашиг сонирхол нүүрлэсэн бэ гэдэг асуудал яригдаад байна шүү дээ. За хамгийн гол нь энэ хариуцлагатай уул уурхайн кодэкст 4 юм байгаа юм байна лээ. Иргэдийнхээ итгэлийг олж авна, түүнийг тогтвортой хадгална гэдэг ийм юмыг ерөөсөө манай энэ уул уурхай барьдаг бодлогын ийм баримт бичигт бол энийг завхруулсан. Энэ чинь компани, засаг, иргэний нийгмийн байгууллага, олон талт бүлгийн хяналт оролцоо байж байж, энэ шаардлагуудыг биелүүлдэг байж уул уурхайгаа ухдаг юм байна л даа. Тэгэхэд өнөөдөр Захиргааны ерөнхий хуулийн 26, 27-гоор эд нар ерөөсөө энэ сонсох үйл ажиллагааг хийдэггүй. Ингээд ямар нэгэн аргаар илт давуу байдал олж лицензийг авсан байна. Энэний цаана 96% Канадын компани эзэмшдэг гэж ойлгох юм болбол үнэхээр эмгэнэлтэй байна.

Энэ үндэстэн дамнасан корпорацууд бол Монголын ядуу буурай, хөгжил дорой орны энэ татварын хууль энэ бүх юмнуудыг засдаг юм аа. 2020 оны татварын хуулийн шинэчлэлээр бүх араа шүдийг нь авсан юм байдаг байхгүй юу. Ийм учраас одоо эд нар бол ингээд даам гарчихсан, одоо тэр энэ үндэстэн дамнасанууд бол лиценз аваад бүх хуулийг өөрийн талд илт давуу байдал олгосон юмыг хийсэн юм.

Одоо намрын чуулганаар ч гэсэн энийг засуулах талаар бид нар хөөцөлдөж байгаа. За энд одоо шинжээч нар нэг баахан юм ярилаа л даа. Эд нар бол үнэхээр хангалтгүй байна. Ямар юман дээр нь яг юу шинэчлэх гэж байгаа юм, энэ тухайгаа ч ярихгүй. Хариуцлага тооцдог механизм байна уу? Энэ төсөл дээр нэг баахан шинжээч гээд л мөнгө авах юм байна л даа, тэгээд эд нарт хариуцлага байхгүй. Эд нарын гол хариуцлага бол төрийн албаны хуулийн дагуу мэргэшсэн зэрэг дэв байдаг юм уу? Энэ шинжээч нар энэ одоо хуульд яасан? Яамдын сайд, дарга, энэ төрийн захиргааны энэ ТНБД-аасаа эхлээд тэр газрын дарга нарт ч гэсэн ер нь ийм юм байдаг шүү дээ.

Ер нь тэр мэргэшсэн зэрэг дэвгүй хүмүүс энэ төрд ажиллаад байгаагаас завхрал үүсэж байгаа юм аа. Энэ хөрөнгийн үнэлгээний хуулийн 7.2.12-ыг ерөөсөө хийж өгөхгүй байгаа. Сангийн яам, энэ УУЯ, энэ журам байгаа. Энэ манайх өнөөдөр газрын хөрсөн доорх энэ элементүүдээ яг ямар үнээр, яаж үнэлэх нь тодорхойгүй. Ийм байхад одоо Монгол Улс авлигалдаа идэгдээд л одоо энэ нэг үндэстэн дамнасануудын аманд ороод л байж байхаар л юм байна лээ шүү дээ. За тэгээд уул уурхайн бодлогын баримт бичигт одоо юу оруулдаг вэ гэвэл энэ одоо зарчим шаардлагад байдаггүй. Энэ 190 дүгээр тогтоол, Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 14-ний өдөр хандив тусламж өгсөн, одоо уул уурхайн компаниуд шууд төрөө бүлэглээд л энэ нүүрсний хулгай 40 хэдэн их наядыг тэглүүлж байсан шүү дээ.

3,8 их наяд гэдэг их мөнгө шүү, энэ нүүрсний хулгайчид ингээд мөнгөө тэглүүлчихсэн. Эд нараас авах юм их байгаа шүү дээ. Тэр хүн чинь мөнгөө зээлдүүлэхээр хүүгийн орлого, тэр зардлыг хасъя, цэвэр ашгаа зөв гаргая гэдэг юман дээр л би ажиллаж байгаа юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа. За би Сарантуяа эгчийг бас 4 хүнийг өрөөндөө хүлээж авч уулзсан. Татвартай холбоотой надад ирүүлсэн хүсэлт, зүйлүүдийг би бас нэлээн дэмжиж ажиллаж байгаа. Тийм цаашдаа энэ тал дээр бас энэ татвартай холбоотой хамтарч ажиллана. Шинжээч нарын хувьд төрийн ажлаа хийж байгаа улсуудын хувьд буруу байхгүй ээ. Өнөөдөр бид нар бас энэ хэн хэнийхээ цагийг хэмнэх үүднээс нэлээдгүй өргөн дэлгэр сэдвээр ярьж байгаа. Тэгээд аль болох та бүгдийг чилээхгүй байх үүднээс цаг нэлээн хомс өгсөн. Тэгээд тэр олон дата мэдээллүүдээс багцлаад 10 минутад мэдээлэл хийнэ гэдэг бол тийм амар зүйл биш ээ гэдгийг та бүхэндээ хэлье. Таяа 6 дугаар микрофон, дараа нь Бат-Эрдэнийн Алтангэрэл 5 дугаар микрофон дээр бэлдэж байгаарай.

Оролцогч Т.Таяа: Өнөөдрийн энэ хэлэлцүүлэгт оролцож байгаа бүх одоо ард түмэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэр тусмаа алс хол нутгаас Ховдчууд бол мундаг, одоо эх оронч хүмүүс байдаг аа. За ингээд 6 сард бас энэ Ховдчууд орон нутгийнхаа тэр Халзан бүрэгтэйг хамгаалж тэмцэж байхад нь Улаанбаатар хотоос ээжүүдийн нэгдэлд бид нар бас дэмжиж байсан юм. Тэгээд үнэхээр энэ хэлэлцүүлэгт хэлснээр энэ Халзан бүрэгтэйг бол ерөөсөө ухуулж болохгүй. Ховдчууд болон монголчууд хэзээ ч ухуулж болохгүй. Түрүүчийнхээ ухсан өчнөөн алт, эрдэнэс, орд, янз янзын юмаа үнэтэй үнэгүй зарчихаад энэ төрд шургуулсан хэсэг бүлэг, одоо 30 хэдэн жилийн өмнө, сүүлийн 9 жилд МАН-ын нэг хэсэг бүлэг хулгайч, луйварчингууд яасан ханаж цаддаггүй, хуулийг өөрсдөдөө зориулж одоо олонхын бүлгээрээ баталж, хулгай хийж, ард түмний бүх боломжийг хулгай хийсэн учраас нэр хүндээ монголчуудын дунд алдчихсан хүмүүс байдаг юм аа.

Тийм учраас монголчууд бид нар урьд нь одоо энэ маш олон уул уурхайн баяжмал, янз янзын жонш, орд, алт, эрдэнэсээ ухуулаад өрөнд оруулчихсан. Монголчууд бид нарыг өрөнд оруулчихсан. Одоо та нар тэгж монголчуудаар тоглодоггүй юм аа. Монголчуудын бүх боломжийг хулгай хийсэн хулгайчууд байгаа. Хэсэг бүлэг хулгайчууд, бүүр сүүлийн 9 жил шүү дээ. МАН-ын нэг хэсэг бүлэг хулгайчууд өөрсдөдөө зориулаад ханаж цаддаггүй хулгайчууд ийм төслийг хэрэгжүүлнэ гээд байгаа юм. Худлаа, тэр бол худлаа. Тэгэхээр бүүр Халзан бүрэгтэйг битгий ухуулаарай гэж хэлье. За ураны тухай, бид нар ураныг байнга эсэргүүцэж тэмцдэг. 111,999 хүний гарын үсэгтэйгээр, ард иргэдийн дэмжлэгтэйгээр гарын үсэг зураад хурлаараа хэлэлцээд, ураны гэрээг цуцлаад өгөөч ээ, хууль гаргаад өгөөч ээ гээд 4 сарын 30-нд бичиг Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгаланд өгсөн боловч, одоо хүртэл гөлөг төөрүүлсэн хариу өгч байгаа. Тийм учраас энэ төрд байгаа хүмүүс бол ард түмний төлөө нэг их юм хийж чаддаггүй, одоо юу ч хийхгүй.

Тэгэхээр юу гэх вэ гэвэл энэ хэлэлцүүлгийг зохион байгуулж байгаа хүмүүс та нарын дунд бас тийм нэгэн хүмүүс байгаа болоод ингээд улайраад байгаа байх гэж хардаж байна аа. Тийм учраас монголчууд бид нар хэзээ ч ахиж энэ Монгол Улсаа сүйрүүлэх, Монгол Улсаа ахиж өрөнд оруулахыг хүсэхгүй байна. Дээдсээс заяасан монголчууд бид нар, хөх толботой монголчууд бидэнд ямар сайхан эх орон, ямар сайхан газар шороо үлдээсэн билээ. Гэтэл одоо Монгол Улс юу болчихоод байна вэ? Монгол Улсын тусгаар тогтнол хутганы ирэн дээр байна. Гэтэл яаж байна? Энэ хулгайчууд ханаж цадахгүй, ахиад ухна гээд монголчуудын тархийг эргүүлж байна. За энэ нөхөр Учрал, Тэгшбаяр, Хүрэлсүх...

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа. Таны саналыг сонслоо Таня эгч ээ. Та нас тогтсон, сайхан хүн байна. Өнөөдөр энэ парламент, би түрүүн бас үгэндээ хэлсэн, хүнд хардах эрх байгаа. Хүнд хардах эрх байгаа. Тэгэхдээ хүнийг гүтгэх, гүжирдэх эрх хэнд ч байхгүй шүү. Өнөөдөр бид нар ингээд энд сууж байгаа. Анх удаа сонгогдож орж ирсэн УИХ-ын гишүүд байгаа шүү. Яг хэний юуг хулгайлчихсан болоод хулгайчаараа дуудуулаад суугаад байгааг бол бид нар мэдэхгүй байна. Тийм учраас адилхан бид бас хуулийн байгууллагад хандаад, хариуцлагатай асуудал яривал бас ярина. Өнөөдөр энэ сонсгол олон нийтийн телевизээр шууд дамжигдаж байгаа. Бүх юм баримттай, гэрчтэй. Тэгээд энэ танхимд сууж байгаа Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Б.Уянга, Ж.Золжаргал, С.Замира, Д.Үүрийнтуяа, Б.Бат-Эрдэнэ, миний бие, Л.Соронзонболд, Ө.Шижир, Ч.Лодойсамбуу, Б.Заяабал гишүүн бүгд анх удаагаа сонгогдоод орж ирээд энэ парламентад иргэдийнхээ үгийг сонсоод сууж байгаа.

Энэ сонсголыг зохион байгуулаад зөв зүйтэй шийдвэр гаргачихъя гэдэг талаас нь хандах гэж хичээж байгаа юм. Тэглээ гээд одоо бас бид нар ингээд... Бид нар ч гэсэн эцэг эхтэй, үр хүүхэдтэй, гэр бүлтэй, найз нөхөдтэй хүмүүс шүү дээ. Тэгээд ингээд шууд олон нийтийн телевизээр хулгайчаараа дуудуулна гэдэг чинь бас амар зүйл биш байх аа гэж хэлэх гэсэн юм. Бат-Эрдэнийн Алтангэрэл 5 дээр, 6 дээр Жадамбаагийн Отгонбаяр дараа нь бэлдэж байгаарай.

Оролцогч Б.Алтангэрэл: Сайн байцгаана уу? Би Монголын байгаль орчны мэргэжилтнүүдийн холбоог төлөөлж ирсэн байгаа. Манай холбооны гишүүд одоо уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч байгаа нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх, уул уурхайн хаалт чиглэлээр ажилладаг мэргэжлийн холбоо байгаа юм аа. Бид нар говьд шороонд тоосны тархалт ямар байгаагаас хамаараад л цагаан шороо, одоо Эрдэнэтийн цагаан тоос хаа хүрч байгааг судалж, хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаа хийдэг ийм байгууллага байгаа юм аа. Тэгээд ер нь манай холбооны зүгээс Халзан Бүрэгтэйн төслийг дэмжиж байгаа. Яагаад гэвэл энэ хайгуул, нөгөө талдаа судалгаа, байгаль орчны болон геологи, уул уурхайн асар олон төрлийн хайгуул судалгаануудыг энэ төслүүдийн үр нөлөөгөөр бий болгодог юм.

Монгол Улсад шинээр одоо уул уурхайн үйл ажиллагааны байгууллагууд байгуулагдаж байгаа. Үйл ажиллагаа явж байгаа хүрээнд Монгол Улсын түүхэндээ байгаагүй асар их хэмжээний байгаль орчны дата цугларч байгаа. Одоо агаарын чанар, усны чанар, хөрсний чанар, ургамал, амьтан гэх мэтчилэн асар их дата цуглуулагдаж байгаа. Энэ бол зөвхөн уул уурхайн үйл ажиллагааны дам нөлөөлөл буюу бидэнд ирж байгаа эерэг нөлөөлөл юм аа. Тийм учраас бид нар бол энэ төслийг дэмжиж байгаа. Тэгээд бид нар энэ төслийн хүрээнд хараат бус байдлаар, хөндлөнгөөс ажиглаад, байгаль орчинд учрах нөлөөллийг аль болох бууруулах, олон нийтэд ил тод байлгах чиглэлээр ажиллахад бэлэн байна.

Нэг саналын чанартай 3—4 үйл ажиллагаа байна. Тэр нь болохоор бид нар НҮБ-тай хамтраад, хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөрийг боловсруулаад, аргачлалыг боловсруулаад Монгол Улсад хэрэгжүүлсэн. Энэ арга туршлагаа болохоор Киргизстан болон Төв Азийн орнууд руу бид нар одоо экспортлохоор ингээд ажиллаж байна. Тэгээд энэ аргачлалынхаа дагуу бид нар бас энэ Мянгад сумын иргэдийг бид нартай хамтраад, одоо энэ төсөл хэрэгжүүлэх ААН-үүдтэй хамтраад 3 талт байдлаар ингээд хамтарсан мониторинг хийе ээ. Байгаль орчинд үнэхээр ийм сөрөг нөлөө байгаа юм уу, үгүй юү гэдгийг хамтдаа ойлгоод явъя гэдэг ийм саналтай байна аа.

Дараагийн санал нь болохоор Киргизстан Улсад ураны асар том хаягдлуудын далангууд байдаг. Тэр хаягдлын далангууд дээр хамтарсан мониторинг гэхээсээ гадна тогтмол мониторингийн цэгүүдийг хийчихсэн байдаг. Одоо ураны цацраг идэвхтийн мониторингийн цэгүүд, тэгээд тэр цэгүүдийг болохоор Улаанбаатар хоттой, Ховд аймгийн төвтэй, Мянгад сумын төвтэй гээд харьцуулсан байдлаар мэдээллийн самбарууд хийчихсэн байдаг юм аа. Энийг бас төсөл хэрэгжүүлэгч нар маань Цөмийн энергийн агентлагтай хамтраад хийвэл их зөв, тохиромжтой байж магадгүй гэж бодож байна аа.

За тэгээд ер нь бол ард иргэд уул уурхайн үйл ажиллагааны талаар сөрөг мэдээлэлтэй байгаа нь аргагүй юм. Яагаад гэвэл бид нар уул уурхайгаас орж ирсэн төсөв мөнгийг гуравны нэгийг нь зам руу хийгээд, боловсрол, эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалтаа хийхгүй болохоор буцаад ирж байгаа сөрөг нөлөө нь ийм болж байгаа юм уу гэж ард иргэд асууя. Аливаа асуудлын талаар цэгцтэй, тоймтой шинжлэх ухаанч мэдлэг, хандлагагүй болчихсон байгаа учраас бид нар улсын төсвийн хөрөнгө оруулалтыг зөв зохистой зарцуулах, баялгийг зөв хуваарилах чиглэлээр бас тоймтой ажлуудыг хиймээр байна аа.

Тэгээд хурал даргалагчид дараагийн сонсголыг нь баялгийн хуваарилалтаар хийх хүсэлтэй байгааг дамжуулмаар байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Б.Алтангэрэл оролцогчоос оновчтой зөв саналуудыг хэллээ. Баярлалаа танд. Одоо Жадамбаагийн Отгонбаяр 6 дээр, дараа нь Ганболдын Баяртогтох 5 дээр бэлдэж байгаарай.

Оролцогч Ж.Отгонбаяр: Юуны өмнө Ховд нутгаас 1500 км-ийг зорин ирсэн нутгийн ард иргэд та бүхэн сайн ирцгээв үү? Ямар ч байсан нутгийнхаа төлөө үзэл бодлоо илэрхийлж байгаад нь бүгдэд нь баяр хүргэе ээ. Өглөөнөөс хойш та бүхнийг сонслоо. Та бүхнийг дэмжихгүй гэж үгүй, дэмждэг. Тэгээд энэ зүйл дээр би нэг зүйлийг хэлэх гэсэн юм. Би өөрөө Эдийн засгийн хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа хариуцсан газрын даргаар ажилладаг хүн байгаа юм. Тэгээд ийм хоёр бодитой санал хэлэх гэсэн юм аа, Ховдчууд аа. Орон нутгийнхан нь энд сууж байна, төр нь энд сууж байна, хувийн ААН-үүд сууж байна. Ингээд гурван талдаа ойлголцлоо нэг талдаа гаргах гэж байгаа нь маш зүйтэй байна. Энэ дээр бол баяр хүргэмээр байна. Тэгэхгүй бол энэ чинь аягүй олон хэрүүл маргааны сэдэв болоод явж байсан. Үзэж хараад, сошиалаар бас хараад явж байсан. За түрүүн энд нэг Баянзул гэдэг залуу маш зөв ярьж байна лээ. Нутгийн залуу байсан, хаана байна? Бид нар бол Ховд нутгаа хөгжүүлмээр байна. Энэ ховор элементээр дэлхийд өрсөлдөхүйц машины батарей үйлдвэрлэмээр байна, гар утас үйлдвэрлэмээр байна гэсэн. Энэ зөв өө, хөгжил нь байна шүү дээ.

Өнөөдөр хөтөлж авч ирнэ үү гэхээс хөгжлийг бол бид нар хүлээгээд амжихгүй ээ. Тийм учраас Ховд нутагт байгаа байгалийн өгөгдөл нь зөвхөн Халзан бүрэгтэй ч биш, өөр 4–5 орд байгаа юм байна лээ шүү дээ. За ингээд энэ ар араасаа хэрүүл маргааны сэдэв болох байх. Тэгэхээр юу хэлэх гээд байна гэхлээр: төр нь хувийн хэвшилтэйгээ яаж түншлэх юм бэ, орон нутгийн иргэдтэйгээ ямар ашигтай байх юм бэ? Одоо Өмнөговьд бол нутгийн иргэд нь хожиж байгаа, Улаанбаатарчууд хожоогүй. Өмнөговьд Өмнөговьчууд хожиж байгаа, Өмнөговь аймагт бизнес эрхлэгчид хожиж байгаа. Өмнөговь аймгийн бизнес эрхлэгчид хожиж байгаа учраас дэмждэг. Яг үүн шиг Ховд нутгийн ард иргэд, залуучууд, бизнес эрхлэгчид нийлээд яаж хамтран ажиллах юм бэ гэдгээ ойлголцох хэрэгтэй байх аа. Үгүй ээ, би үгээ хэлж байна шүү дээ, би үгээ хэлж байна шүү дээ. Тийм учраас би уламжлалаа туулах нь хамгийн чухал

гэж бодож байгаа шүү. Нөгөө талдаа хувийн хэвшлийг ингэж шахаж болохгүй ээ. АН үзэл баримтлал, хувь хүний эрх чөлөөг үргэлж хүндэтгэнэ. Тийм учраас энэ дээр маш буруу, зөрүү юм ярьж байгаа зүйлүүд их байна. Энэ олон нийтийн төлөө цацагдаж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Мянгад сумын иргэд ээ, Ховдын иргэд ээ! Та бүгд үг хэлж байхад бусад нь бүгд хүндэтгэлтэй хандаж сонссон. Харилцан бүгд бие биедээ хүндэтгэлтэй хандана. Өнөөдөр бид Монгол Улсынхаа Төрийн ордонд, Их эзэн хааныхаа нэрээр нэрлэсэн танхим дотор энэ хэлэлцүүлэг явагдаж байна. Бидний хүн бүрийн ярьж байгаа зүйл бусдад таалагдах албагүй. Гэхдээ өнөөдөр бид бие биенийхээ үзэл бодлыг сонсдог, ухамсартай иргэд гэдгээ ойлгоцгоогоорой. За, 5 дээр Ганболдын Баяртогтох байна. Дараа нь Пүрэвийн Бурмаа 6 дээр бэлдэж байгаарай.

Оролцогч Г.Баяртогтох: Сайн байцгаана уу? За энд танхимд цугларсан нийт нутгийн ард иргэд болон нийт нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагууд, нийгэмлэгийн төлөөллүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Шууд дамжуулалт гарч байгаа МҮОНРТ-ээр үзэж байгаа Монголын нийт ард иргэддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Энэ танхимд хүрэлцэн ирсэн УИХ-ын гишүүд, энэ танхимд сонгогдож ард иргэдийн төлөөлөл болсон та хэдийнхээ энэ өдрийн амар амгаланг ерөөе. Миний тухайд бол “Өвлөгдөх Хайрхан Аргалант уул” нутгийн нийгэмд үйлчлэх ТББ-ын тэргүүний хувьд оролцож байна. За мэдээж хэрэг саяхан УИХ-ын дарга Д.Амарбаясгалан, ЗГХЭГ-ын дарга С.Бямбацогт ахалсан УИХ-ын гишүүд Ховд аймагт очсон. Ховд аймгийн Мянгад суманд замын нээлт хийгээд, Халзан бүрэгтэй уул уурхайн талаар ярьсан. Энэ асуудал дээр би маш олон хуулийг гаргаж тавьсан.

Монгол Улс өөрөө Үндсэн хуультай. Үндсэн хуульдаа захирагдаж амьдарч байгаа иргэд нь өнөөдөр өөрөө хуулиа дагаж мөрддөг. Хууль бол өнөөдөр хаана очиж, хэнд үйлчилж байгааг бид хэдэд харагдаж байгаа. Ядарсан нэгнийг хуульд далайлгаж айлгаж, ядарсан нэгэн ч байсан, хүчин хийсэн ч байсан, хулгай хийсэн ч байсан хуулийн хариуцлага хүлээдэг.

Компани нь өөрөө хайгуул хийж явах хугацаандаа хууль зөрчсөн маш олон акт дээр өнөөдөр ганц ч шинжээч ярьсангүй. Маш олон хуулийн актуудыг гаргаж тавьж байгаа ганц шалтгаан нь Монгол Улсын иргэд, Монгол Улсын малчдын дуу хоолой болж, нийгэмд үйлчлэх ТББ-ын хүрээнд хэн нэгнийг хардах эрх байхгүй учраас яг энд хуулийг эрхэмлэн дээдэлж, хуулийг дагуулж мөрдүүлэх ёстой УИХ-ын гишүүд ээ. Өнөөдөр иргэд тэмцлээ илэрхийлсэн. Энэ бол ард иргэд үр хүүхдэдээ өвлөж үлдээх гэж байгаа шалтгаан. Үр хүүхэд нь боловсон XXI зуунд биш, XXII зуун руу давшиж орохдоо энэ уул уурхайг ашигтайгаар ухаад явчих боломж байгаа тэр хүртэл нь хадгалъя л гэж байгаа юм. Өнөөдөр яг энд ирсэн шалтгаан бол энэ уул уурхай, өнөөдөр Халзан Бүрэгтэй төсөл явагдаж байх хугацаандаа маш олон хуулийг зөрчиж байгаа.

Энэ актуудаас болж нутгийн ард иргэд болон төрийн хооронд том хагарал үүссэн. Нэг зүйлийг би түрүүн анзаарлаа. Хэвлэлүүд гадаа байна, мөнгөтэй талд үйлчилж байна, мөнгөтэй хүмүүсээс ярилцлага авч байна, уул уурхайн ашигт малтмалыг явуулж байгаа хүмүүсээс ярилцлага авч байна. Үнэн шударгаар үг үзэл бодлоо илэрхийлж байгаа нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагуудаас ярилцлага авахгүй байна. Энд маш хариуцлагатайгаар ирсэн эмэгтэй гишүүд байна шүү дээ.

Одоо Ц.Болормаа гишүүн байна, С.Замира гишүүн байна. Өглөөнөөс хойш суулаа. Яг сонсгол эхлэхээс өмнө орж ирсэн, ард иргэдтэйгээ хамт сонсголыг

үргэлжлүүлээд явж байна. Баруун бүсээс 10 УИХ-ын гишүүн сонгогдсон. Б.Заяабал гишүүн маань сууж байна. Түрүүн Б.Пүрэвдорж гишүүн, З.Мэндсайхан гишүүн харагдаад өнгөрсөн, сууж байгаад гарсан. За тэгэхээр эндээс юу харагдаж байна гэхээр, 160 гаруй мянган иргэдийн санал авч сонгогдсон УИХ-ын гишүүд одоо ард иргэдийнхээ үг, үзэл бодол, дуу хоолой болж суух ёстой юм аа. Тийм учраас одоо энд надад дүгнэлт байна л даа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Надад зүгээр гардуулчих. Тийм, за би аваад уншаад өгчихье. Дараагийн хүн Бурмаа байхгүй байна. Суудал дээрээ суухгүй бол тэгээд байхгүй байна гэж үзнэ шүү. Баяртогтох, наашаа аваад ир наадхаа. За дараа нь Шархүүгийн Молор 5 дугаар микрофон дээр бэлдэж байгаарай.

Оролцогч П.Бурмаа: Намайг П.Бурмаа гэдэг. Ховд аймгийн Буянт сумын уугуул хүн байна. Монгол Улс газрын ховор элемент олборлож байсан туршлага байхгүй, түүх ч байхгүй. Тэгээд Монгол Улсад газрын ховор элемент илэрсэн, хайгуул хийгээд илэрсэн 6 том ордын хамгийн том орд нь Халзан бүрэгтэйн төсөл. Энэ бол байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдээгүй. Цөмийн энергийн газар болоод бусад мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр цацрагийн идэвхт хэмжээ нь 7–8 дахин их гэсэн судалгаа гарсан гээд түрүүн хүмүүс хэлж байх шиг боллоо. Би давхардаад хэлчихлээ. Тэгээд энд газрын ховор элемент яригдаж байна. Дэлхийд Хятад улс хамгийн том тоглогч орон гэдгийг хүмүүс мэдэж байгаа. Энэ олборлох технологи нь өөрөө маш их нарийн төвөгтэй, зардал ихтэй, байгаль орчинд асар их хор нөлөөтэй ийм байдаг юм байна. Энийг хүмүүс яриад л байна л даа. ЗГХЭГ-ын дарга С.Бямбацогт дэлхийд том тоглогч болно гээд байх юм.

Газрын ховор элементээ олборлоод бид нар яаж эдийн засгийн эргэлтэд оруулна гэж яриад байх юм. Бид нар чинь уул уурхайгаа ухаад 35 жилдээ хөгжсөн юм уу? Энэ чинь ухсан нүх болоод дуусаж байгаа биз дээ. Бид нар эргээд өрөнд ороод дуудуулж байгаа биз дээ. Хамгийн наад захын жишээ, ОТ-гоос нэг хүн 40 саяын өртэй байж байна. Тэгээд одоо энэ газрын ховор элементийг олборлоод... одоо би уучлаарай, Бадрах Энержийг ярьчихъя. Одоо уран ухаад, тэр оршихуйгаараа улам хордож байна шүү дээ. Жишээлбэл, тэр Дорноговьд ямар байдал үүсээд байна. Одоо энэ Халзан бүрэгтэйд ч гэсэн маш төвөгтэй асуудлууд гарч байна шүү дээ. Байгаль орчны сөрөг нөлөөлөл нь ард иргэд, малчид бүгд ярьж байна. Би өөрөө газар дээр нь очоод 10 хоног нутагт ажилласан юм. Тэгээд байгаа байдлыг хоёр нүдээрээ харж, чихээрээ сонссон учраас хэлж байна л даа. Энэ ард түмэн үнэхээр уул шиг, өндөр өндөр уул хайрхад шигээ хурц, шийдмэг зантай, зоримог ийм хүмүүс байдаг юм байна лээ. Энэ нь сая хэлж байгаа, ярьж байгаа үг хэлээс нь тод ажиглагдаж байна. Тэгээд энэ говийнхон яаж байна? Налайгаад дүлий дүмбэ болоод, урандаа хордоод, усандаа хүхрийн хүч шахуулаад л хордоод байж байна шүү дээ. Тэгээд энэ Ховдынхон шиг сайхан үг хэлж, үзэл бодлоо илэрхийлээд, тэмцэж байгаа нь ерөөсөө харагдахгүй юм, энэ нутаг орнуудыг харж байхад. Тэгээд сая энэ шинжээчдийн дүгнэлтийг би сонслоо л доо. Энэ ерөөсөө 90 хувь нь танин мэдэхгүй юм яриад байна. Тэртээ тэргүй интернэт дээр газрын ховор элементийн талаар бүх мэдээлэл байж байна шүү дээ. Слайдууд нь, тэгээд энийг ярих ямар шаардлага байгаа юм? Үнэхээр одоо...

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа, ерөнхий санал хэллээ. Шархүүгийн Молор байна уу? За байхгүй байна. Бат-Эрдэнэ овогтой Алтангэрэл байна уу? За байхгүй байна. Баттогтох Энхтуяа? Байхгүй байна. Г.Мөнхбат? Алга байна. Ц.Түмэнцогт 5 дугаар микрофон дээр, Начин овогтой Даваасамбуу байна уу? 6 дугаар дээр дараа нь сууж байгаарай.

Оролцогч Ц.Түмэнцогт: Өдрийн мэнд. Монголын бизнесийн зөвлөлийн Удирдах зөвлөлийн дарга Ц.Түмэнцогт байна. Тэгээд энэ маш чухал хэлэлцүүлгийг зохион байгуулж байгаа УИХ-ын сонсгол зохион байгуулж буй хүмүүст талархал илэрхийлье ээ. Уул уурхай дээр яг ийм байдал үүсчихээд байгаа юм аа. Ер нь бол хуулийн дагуу компани нь лицензээ аваад, эрсдэлээ хүлээгээд, зардлаа гаргаад явдаг. Гэтэл яг орон нутаг дээрээ очоод байгаль орчны үнэлгээ, нөлөөллийн үнэлгээ, ТЭЗҮ энэ бүх юмнаас нь шалтгаалаад дэмжлэг авдаггүй, маш олон жил гацдаг. Тэгэхээр энэ асуудлыг зөвхөн компани нь биш, хариуцсан яам нь, Байгаль орчны яам, Ашигт малтмалын газар үнэхээр ажиллах шаардлагатай байна аа. Ер нь бид нар Монгол Улс уул уурхайгүйгээр явах аргагүй болсон.

Та бүхэн мэдэж байгаа, экспортын орлогын 90 хувь, ДНБ-ий гуравны нэгийг уул уурхай бүрдүүлж байгаа. Тэгэхээр одоо үнэхээр Ховд аймгийн Мянгад сумын иргэд энэ төслийг урт хугацааны төсөл гэж харах шаардлагатай. Түрүүн шинжээчийн мэдээлэл дээр гарч байна. Өвөр Монголын Баян-Овоо орд 1927 онд үйл ажиллагаа явуулж эхэлсэн байдаг, одоо 100 гаруй жил үйл ажиллагаа явуулж байгаа.

Тэгээд өнөөдөр дэлхийд Хятад улс хамгийн том ховор элементийн нийлүүлэгч болсон. Тэгээд Хятадын төрийн тэргүүн Дэн Сяопин гуай тэгж хэлж байсан юм байна лээ: "Ойрх Дорнод газрын тостой бол, Хятад улс газрын ховор элементтэй" гэж. Тэгэхээр үнэхээр технологийн хувьд бүх хөгжлийг энэ элемент тодорхойлж байна. Тийм учраас та бүхэн мэдэж байгаа, Оюу Толгой төсөл 2004 онд хайгуулынхаа зөвшөөрлийг авч байсан, 2023 онд далд уурхай ашиглалтад орсон гэж бодоход үндсэндээ 20 жил болж байж том уул уурхайн төсөл явж байна.

Тэгэхээр Халзан бүрэгтэй ч гэсэн өнөө маргаашгүй эхэлчих төсөл биш ээ. Тийм учраас орчин үед байгаль орчин, нийгэм, засаглалын "ESG" зарчмууд үйлчилж байна. Тэгэхээр энэ зарчмуудад нийцсэн урт хугацааны хамтын ажиллагаа байх ёстой. Түүнээс энэ нэг компани нь зөвхөн ашгаа хайгаад зүтгээд байгаа юм шиг, бусад нь эх орноо хайрлаад хамгаалаад байгаа юм шиг байдлаар явж болохгүй гэж бодож байна. Тэгэхээр бизнесийн зөвлөл, бизнесийн холбоод энэ асуудал дээр хамтарч ажиллаж, байнгын ажиллагаатай ажлын хэсэг, механизм байгуулж ажиллахад бэлэн байгаа шүү. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа. Тэгээд бид нар өнөөдөр олборлолтын талаар ерөөсөө ярьсангүй шүү. Зөвхөн нөөцийн асуудал, хайгуулын асуудлыг л ярьж байгаа гэдгийг бас хэлье. 6 дугаар микрофон дээр Даваасамбуу, дараа нь Төмөр-Очир овогтой Мягмардорж 5 дугаар микрофон дээр бэлдээрэй.

Оролцогч Н.Даваасамбуу: Би уул уурхайн инженер Н.Даваасамбуу гэдэг хүн байна. Миний бие 1980-аад оноос хойш уул уурхайн салбарт мэргэжилтний хувьд ажиллаж, Монгол Улсын 6-7 аймагт, уул уурхайн 10 хэдэн төслийг хэрэгжүүлэхэд гар бие оролцсон ахмад инженер хүн юм. Өнөөдрийн энэ хэлэлцүүлгийг мэргэжлийн зүгээс, хэрэгжүүлэгч байгууллагын, бас хамт ажиллаж байсан хүмүүсийн урилга санаачилгаар ирээд сонсож байна.

Миний анзаарч байгаагаар гүйцэтгэгч байгууллага хэд хэдэн хууль зөрчөөд байгаа гэсэн юм ярьж байна. Энд миний ойлгож байгаагаар ордын маань нарийвчилсан хайгуул бүрэн гүйцэд хийгдэж үр дүн нь гараагүй, нөөц нь тодорхой тогтоогдоогүй мөн тэр доторх элементүүдийн хэмжээ, дамжаа тогтоогдоогүй ийм байхад нь ажлыг нь зогсоочихсон юм байна гэж ингэж ойлгож байгаа. Тэрнээс гадна нөөц нь тогтоогдоод ТЭЗҮ боловсруулагдсаны дараагаар тэр хийгдээгүй байна гэж

яригдаад байгаа байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгддэг ийм эрэмбэ дараатай.

Тэгэхээр энэ орд бол байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдэх тийм цаг хугацаа нь болоогүй юм байна. Тэр байтугай үр дүн нь гараагүй юм байна. Үр дүн нь гараад ирэхээрээ олборлоход олборлож болохоор юм байна гэж гарах юм уу, олборлож болохгүй юм байна гэж гарах юм уу тэр нь одоогоор мэдэгдээгүй л нэг ийм ойлголт, мэдээллийн зөрүүгээс нэлээн асуудалтай болчихсон төсөл явагдаад байгаа юм байна гэж ингэж ойлгож байна.

Тэгээд энд Мянгад сумаас ирсэн иргэдийн дунд л сууж байна л даа. Тэгээд асуухаар тэнд овоолчихсон газар ухчихсан, овоолсон шороо, янз бүрийн юм байдаг юм уу гэхээр зэрэг байхгүй л гэж байна. Би бол тэнд өөрөө очиж үзээгүй юм чинь мэдэхгүй. Тэгээд яадаг юм гэхээр зэрэг нэг ийм өрмийн цооногууд байдаг юм. Труба хийгээд орхичихсон ийм өрмийн цооногууд байдаг юм. Тэрнээс л энэ яриад байгаа эрүүл ахуйн болоод, мал хунарын эмгэг согог үүсдэг байх гэсэн иймэрхүү өнгө аястай юм ярьж байна. Тэгэхээр энэ бол тийм байх учиргүй л дээ. Би их нарийн энэ газрын овор элемент, уран, торийн мэргэжилтэн биш ч гэсэн уул уурхайн жинхэнэ инженер хүний хувьд нэг өрөмдлөг өрөмдөөд тэнд үлдээчихсэн трубанаас ууршаад ч юм уу, тэр нь гарч ирээд хордуулах, эсвэл сөрөг нөлөө үзүүлээд байдаг юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа Мягмардорж байхгүй байна. Цагааны Болормаа байна уу? Байхгүй байна. Цогтын Загарзүсэм байхгүй байна. Нохойжав овогтой Өлзийхишиг байна уу? 5 номер дээр суучих. Т.Мягмардорж байвал дараа нь 6 номер дээр суучихаарай, байхгүй бол Б.Өлзийбат 6 номер дээр суучихаарай. Байна уу?

Оролцогч Н.Өлзийхишиг: Энэ өдрийн мэнд хүргэе. Би Мянгад сумын Гахайт багийн харьяат малчин хүн байгаа юм. Тэгээд энэ уул уурхай гээд өнөөдөр хэлэлцүүлэг. Энэ дээр би өөрөө зориод ирсэн. Яг Халзан бүрэгтэйн 50 хүн дотроо би ороогүй, аймагтайгаа ярьж байгаад би орно, очно гээд ирсэн.

Төр нь нэг юм хэлнэ, уул уурхайн компани нь нэг юм хэлнэ, дахиад иргэд нэг юм хэлнэ ингээд бүх юм нь өөр өөр юм ярьж байгаа шүү дээ. Сая сонсоод сууж байхад бол тэр хоргүй, хор бараг байхгүй гээд л гарч байна. Тэгэхэд чинь аймаар өндөр хортой гээд л яригдаж байсан. Энэ бүх асуудлыг шийдмээр байна. Үнэхээр аль нь үнэн юм, аль нь худлаа юм. Үнэхээр тэгж аймаар тооны зөрөө гаргаж болохгүй шүү дээ. тэгээд 1 дүгээрт энэ байна.

Хоёрдугаарт, миний хэлье гэсэн нэг юм болохоор энэ төр нь асуудлаа шийдэж чадахгүй учраас ард түмний хооронд, хүмүүсийн хооронд аймаар их хэл ам гарч байна. Жишээлэхэд би 4 жил Иргэдийн хурлын төлөөлөгч байсан. Бид нар 10 хүн 1 тэрбум төгрөгийг 100 сая 100 саяар нь авчихсан гээд л хэлэгдсэн. Нэгнийгээ аймаар их хардаж байна, харлуулж байна. Би бол Халзан бүрэгтэйгээс юм авдаг авгай нэртэй. Нөгөө авгай чинь мөнгөний үнэр авчихаж гэдэг. Би Улаанбаатар луу ахыгаа ч юм уу аваад эсвэл өөрөө ч юм уу эмнэлгээр яваад ирэхэд л Халзан бүрэгтэйгээс мөнгө авчихсан асуудалд ороод байдаг. Тийм учраас энэ төр засаг нь үнэхээр юугаа гаргаж чаддаг юм бол? Нарийвчилсан бүх дүнгээ гаргаад ингээд ийм ийм учиртай юм гээд. Үнэндээ манай сумынхан, манай багийнхан бүгдээрээ л эсэргүүцэж байгаа.

Хүн болгон эсэргүүцэж байгаа. Тэгэхэд чинь ирчихээд ингээд шал өөр өөр юм яриад бид нарыг төөрөгдүүлээд дахиад дунд нь 1, 1 хүмүүсийг хэлмэгдүүлээд. Манай сумыг тэгсэн шүү дээ, 4 жил бид нарыг төлөөлөгч хийж байхад зүгээр нэг машин авсан чинь л Халзан бүрэгтэйгээс мөнгө аваад машин авчихаж, нэг байр авсан чинь л

Халзан бүрэгтэйгээс мөнгө аваад байр авчхаж. Ийм л ярианд бид нарыг өнөөдөр хутгаж байна шүү дээ. Тийм учраас наад асуудлаа шийд, үнэхээр үнэн зөвөөр нь шийдэж өгмөөр байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За 6 номер.

Оролцогч Б.Өлзийбат: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Залуусын нэгдэл ТББ-ын үүсгэн байгуулагч Бор Өлзийбат.

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 6.2 дээр иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2-т эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасан. Мөн Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2-т хуулийн биелэлтийг хангах хүрээнд нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар хяналт шалгалт явуулна. Энэ бүх зүйлд гол зүйл хэлэх гэсэн юм. Бид ерөөсөө л энэ төрд тухайн компанийн зорилго, ашиг олох, сайн муу нь бол дараагийн асуудал байх. Иргэдээ дандаа дээрээс хардаг. Анхнаасаа мэдээллийг үнэн зөв өгөөгүйгээс болж л өнөөдрийн асуудал үүссэн. Аливаа зүйлийг болохоор дандаа иргэдийг ерөөсөө л эсэргүүцнэ гэдэг ийм бодол тэр зүрхэнд нь тэр компанийн толгойд л байдаг юм шиг байгаа юм. Юу ч тайлбарлахгүй мөртөө очингуутаа эсэргүүцээд байна гэдэг. Яг иргэд энэний талаар ямар ч мэдээлэлгүй байгаа гэдэг нь энэ сонсголын нэг үр дүн байгаа гэж харж байна.

За тэгээд та бүхэн өнөөдрийн сонсголыг хийх шалтгаан бол 5 сар, 7 сарын 8-ны Байнгын хорооны хамтарсан хуралдаан дээр тов баталсан байна. Даргалагч сонгосон байна. За энэ дээр бол 2 хуулийн заалт онцгой ач холбогдол өгч байгаа юм. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хийгдээд Улсын Их Хурал хууль баталдаг биш хянах процесс руу ороод, хяналт шалгалтын хууль дээр гол зүйл байгаад байгаа юм. Би та бүхэнд уншиж өгье. Хяналт шалгалт явуулж иргэний мэдэх эрхийг хангана гэж байгаа юм. Мөн сонсгол хийх бас нэг хууль нь Нийтийн сонсголын тухай хуулийг барьсан байгаа.

Нийтийн сонсголын тухай хуулийн зорилго бол төрийн байгууллага албан тушаалтан энэ хуульд заасны дагуу нийтийн сонсголыг зохион байгуулж төрийг удирдах хэрэгт иргэдийн оролцоог хангана л гэж байгаа юм. Үндсэндээ бол өнөөдрийн сонсголын гол агуулга, ер нь энэ парламентын хяналтын гол агуулга бол иргэдэд мэдээллийг өгье л гэдэг гол агуулга юм шүү. Тэрнээс энэ нь зөв тэр нь буруу гэдэг бол энэ сонсголын үр дүн биш, сонсголын үр дүн бол олон талт оролцоог бий болгож олон улсад байдаг парламент гаргаж байгаа шийдвэрийн араас эсвэл хууль бус гарсан шийдвэрийн араас явагддаг энэ олон нийтийн оролцоог бий болгох гэж байгаа гол зүйл.

Тийм учраас та бүхэн маань энэ сонсголуудын үр дүн нь өөрөө энэ юм. Өнөөдрийн энэ нээлттэй ярьж байгаа байдал юм шүү. Тэгээд аливаа бүх зүйл өөрчлөгдөж байгаа. Парламент ч гэсэн дагаж өөрчлөгдөж байгаа. Олон улсын парламентын хамгийн гол зүйл бол зоосны 2 тал, нэг талд нь иргэд нөгөө талд нь парламент байгаа. Тийм учраас иргэдийнхээ үгийг сонсох нь чухал.

Тийм учраас гол зүйл хэлчихье. За Улсын Их Хурал ашигт малтмалын сонсгол хийсэн тэгээд Улсын Их хурлын 62 дугаар тогтоол гарсан 2024 онд, үүний биелэлт нь хангалтгүй байгаа. Уучлаарай би нэг минут сунгаад. ... цаг дууссан.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Манай Б.Өлзийбат бас чухал юм ярилаа. Тэгэхдээ цаг бол дууссан дараа нь хоёулаа уулзаж наад мэдээллээ өгч болно. Ингээд өнөөдөр нийт 100 гаруй иргэдийн төлөөлөл сонсголд бүртгүүлж оролцсоноос яг 60 хүн үг хэллээ. Одоо УИХ-ын гишүүд асуулт асууна. Асуулт асуух гишүүд, үг нь тусдаа, асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. С.Замира гишүүнээр тасаллаа. Нийт 10 гишүүн. Б.Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ: За баярлалаа. Ховд аймгаас ирсэн нийт иргэддээ талархал илэрхийлье. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас асуух хэдэн асуулт байна.

Нэгдүгээрт, Халзан бүрэгтэй төсөл одоогоор яг ямар ашигт малтмалын ордоор төрийн санд бүртгэлтэй байгаа юм бэ? Иргэдийн хэлж байгаачлан уран эсвэл газрын ховор элементийн орд юм уу? Уран, газрын ховор элемент 2 чинь хоорондоо үндсэн болон хэрэглээний хувьд ямар ялгаатай байгаа талаарх тайлбарыг иргэдэд өгмөөр байна.

Хоёрдугаарт, Хайгуул судалгааны ажил хийгдэж байгаа гэсэн. Иргэд болохоор уран ухсан учраас мал хордоод, гажигтай мал төрөөд байна гээд яваад байдаг. Гэтэл нөгөө талаас олборлолт хийгдээгүй гэж яриад байдаг. Тэгэхээр өнгөрсөн жилүүдэд Халзан бүрэгтэйн орд дээр олборлолт хийсэн зүйл байгаа юм уу. Албан ёсоор энэ талаар мэдээлэл өгөөч.

Гуравдугаарт, ер нь Монгол Улсад өөр ямар ямар ордуудад газрын ховор элемент илрээд байгаа юм бэ, ямар хайгуулууд хийгдээд ТЭЗҮ-үүд нь батлуулах ажлууд хийгдчихсэн явж байгаа юм бэ гэдгийг асуухыг хүсэж байна. Уул уурхайн төсөл хэрэгжүүлэхдээ иргэдээс санал асуудаг зөвшөөрөл авдаг ямар эрх зүйн орчныг Аж үйлдвэр эрдэс баялгийн яам маань иргэдэд тайлбарлаж өгөх боломжтой байна вэ? Нутгийн иргэдээсээ санал авах юм уу, авахгүй юм уу. Үүнийг тайлбарлаад өгөөч гэдгийг хүсэж байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас дараах асуултыг асууя.

Нэгдүгээрт, Халзан бүрэгтэй орд дээр байгаль орчин бохирдуулсан, хордуулсан, хүн, мал амьтанд сөрөг нөлөө үзүүлсэн үйл ажиллагаа өнгөрсөн хугацаанд явагдсан юм уу? Ийм зүйл болсон эсэх талаар тодорхой хариулт өгнө үү? Энэ асуудлыг баримтжуулж, акт тавих, хариуцлага ногдуулсан баримт бичиг та бүхэнд байна уу?

Дараагийнх нь төсөл хэрэгжүүлэгчийг байгаль орчны нарийвчилсан үнэлгээ батлуулаагүй гэж яриад байгаа юм. Хайгуул судалгааны явцад нарийвчилсан үнэлгээ шаардлагатай юм уу, шаардлагагүй юм уу, эсвэл олборлолт эхлэхэд л хэрэгтэй байдаг юм уу? Би өөрөө Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байсан хүн. Бүгдийг нь мэдэж байгаа. Иргэдэд үнэн зөв бодитой яг энэ мэдээллийг төрийн захиргааны төв байгууллагаас өгөх шаардлагатай асууж байгаа шүү.

Усны агентлаг усны асуудал дээр тодорхой хариулт өгөх хэрэгтэй байна. Сая устай холбоотой маш олон асуудлууд хөндөгдлөө. Үнэхээр Монгол Улсын цэнгэг усны нөөцийн 40% нь байгаа юм уу? Ямар гол ус мөрнүүд энд хамаараад байгаа юм бэ? Ямар хагарал явагдаад байгаа юм. Энийг усны агентлаг Батбаяр дарга маш тодорхой хариулаад өгөөч гэж хүсэж байгаа юм.

Төсөл хэрэгжүүлэгчээс асуух асуулт байна. Танай компани өнгөрсөн хугацаанд яг ямар ямар үйл ажиллагаа явуулж байсан юм бэ? Энийг би мэдмээр байна. Хайгуул юм уу, эсвэл олборлолт юм уу, ашиглалт явуулж байгаа юм уу? Байгаль орчин, хүн, мал, амьтан хордуулсан, хохироосон тийм жишээ байгаа юу? Танай компанид баримттай нотолгоотой зүйлүүд байх ёстой. Танайх Халзан бүрэгтэй дээр ямар ямар үйлдвэр барьж, юу үйлдвэрлэж, хаашаа экспортлох гэж байгаагаа тодорхой тайлбарламаар байна. Үйлдвэр барих гээд байгаа ч юм шиг, барихгүй ч юм шиг экспортлох гээд байгаа ч юм шиг, үгүй ч юм шиг. Зарим нь дотооддоо үйлдвэр байгуулаад, ажлын байр нэмэгдүүлээд, машин техник үйлдвэрлээд эхэлчихвэл бид нар Ховдууд дэмжье ч гэж ярьж байх жишээтэй. Энэ дээр ААН маань хариулт өгчихвөл сайн байна.

Дараагийнх нь танай төслийн ТЭЗҮ болон техник технологийн сонголт бусад судалгааны ажлыг аль улсын ямар компани гүйцэтгэсэн юм бэ? Монгол компани юм уу эсвэл гадаадын аль нэг улсын компани юм уу? Халзан бүрэгтэй дэлхийтэй өрсөлдөх чадавхтай төсөл мөн юм уу? Дэлхийд гол тоглогч болно гээд л С.Бямбацогт сайд хэлсэн гээд иргэд маань яриад л, тийм юм байхгүй гээд хэлээд л байна. Гол тоглогч болох юм уу, болохгүй юм уу, дэлхийд тодорхой хэмжээний өрсөлдөх чадвартай юм уу, биш юм уу гэдгийг би асуух гэж байгаа юм.

Дээрээс нь Ховд аймгийн Засаг даргаар ажиллаж байсан Г.Нямдаваа гуайгаас нэг асуулт асуумаар байна. 2005 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 20/2005 мөн 2005 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр 18/2005 гэдэг ийм дугаартай Ховд аймгийн Мянгад сумын нутаг дэвсгэрийн М46124 кодтой фланшеттэд заасан өргөдлийн Х-13844 дугаарт бүртгэгдсэн гээд координацын тавцанд солбилцлуудтай цэгүүдийг холбосон. Шулуун шугамаар хязгаарлагдсан Халзан бүрэгтэй нэртэй 2068 гектар талбайд ашигт малтмал хайхыг хүсэж гаргасан. Хүсэлтийн дагуу лиценз олгохыг дэмжиж байна гэсэн таны гарын үсэгтэй тамга тэмдэгтэй ийм 2 бичиг байна. Та энд шал өөр юм ярьж байна. Дэмжээд байгаа юм уу, дэмжихгүй байгаа юм уу? Засаг дарга байхдаа дэмжиж байсан юм уу?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Дараа нь тодруулах уу? За эхлээд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, дараа нь Усны газар, дараа нь төсөл хэрэгжүүлэгч, тэгээд дараа нь оролцогч Г.Нямдаваа гэсэн дарааллаар хариулна. Бүгд тэр доор очиж сууна шүү. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам 1 номерын микрофоныг өгье.

Үндэсний геологийн албаны дарга Н.Мөнхбилэг: Энэ өдрийн мэндийг хүргэе. Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Ашигт малтмалын улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд Халзан бүрэгтэйн орд нь газрын ховор элементийн орд ангиллаар бүртгэгдсэн байдаг. Өөр ямар нэгэн өөр төрлийн ашигт малтмал энэ орд дээр бүртгэгдээгүй.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Бусад асуултад нь хариулна уу. За 1 номер үргэлжлээд.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул ашиглалтын газрын дарга С.Ган-Очир: Гишүүний асуултад хариулъя.

Талбайд олборлолт хийсэн үү гэж асуулаа. Хоёулаа ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, гэхдээ одоогоор энэ компани эдгээр талбайд ямар нэгэн олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй, зөвхөн хайгуулын үйл ажиллагаа явагдаж байгаа.

Хайгуулын төлөвлөгөөнд ирүүлснээр цооногийн өрөмдлөг, геофизикийн судалгааны ажил хийж, гео металлургийн дээж авна гэсэн ийм ажлууд төлөвлөсөн байдаг.

Тусгай зөвшөөрөл олголттой холбоотой орон нутгийн Засаг даргаас тухайлбал аймгийн Засаг даргаас санал авдаг зохицуулалт үйлчилж байсан. Яг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульд тусгай зөвшөөрлөөр олгох боломжтой талбайн солбилцлыг Засгийн газраар батлуулдаг. Ингэхдээ орон нутгийн саналыг авч нэгдсэн байдлаар тусгаж батлуулдаг. Мөн төсөл хэрэгжих явцад байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг тухайн орон нутгийн багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэх зохицуулалт үйлчилж байгаа. Энэ дээр Байгаль орчны яам дэлгэрэнгүй хариулт өгөх байх гэж бодож байна.

Газрын ховор элементийн ямар ордууд байгаа вэ гэсэн асуултын хувьд өнөөдрийн байдлаар ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 9 талбайд газрын ховор элементийн орд бүртгэгдсэн байдаг. Халзан бүрэгтэйн орд бол 2 тусгай зөвшөөрөл, 3 тусгай зөвшөөрлийн талбайг үндсэндээ дамнаж оршиж байгаа. Үүнээс гадна Өмнөговь аймгийн нутагт Хотгорын орд, Дундговь аймгийн Өлзийт сумд Хөх дэл, Өмнөговь аймгийн Мандал сумд Мушгиа худаг, Дорноговь аймгийн Хатанбулаг сумд Лугийн гол, Говьсүмбэр, Дундговь, Шивээговь аймгийн нутаг дамнасан Мөнхтийн цагаан дөрвөлжин гэдэг ийм ордууд газрын ховор элементийн нөөц бүртгэгдсэн байдаг.

Усны газрын дарга З.Батбаяр: Та бүгдийн амар амгаланг айлтгая. Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулахад жаахан алсаас эхэлчихье. Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор тулгараад байгаа хамгийн том асуудал, мөнх цасны хайлалтын тухай асуудал байгаа. Өөрөөр хэлбэл, Монгол Алтайн нуруунд байгаа 33 ноён оргилууд, 13 мөнх цастай оргилуудын мөнх цас хайлж 2050 он гэхэд мөнх цастай уулгүй болох гэдэг аюул байгаа. Энэ нь цаашлаад Алтайн нурууны хойд талд эх авч байгаа Ховд голын урсцад аюул учруулна гэдэг зүйлийг бид нар 2050 онд аюул учирч болзошгүй гэдэг ийм прогнозтой байгаа.

Тэгвэл энэ компанийн маань үйл ажиллагааны төлөвлөж байгаа хугацаа нь би зөв ойлгосон бол ойролцоогоор 40 жил гэж бодож байгаа. Хэрвээ 2030 оноос үндсэн хүчин чадлаараа ажиллаад эхэллээ гэж бодоод 30-40 жил гэх юм бол 2070 он буюу саяын бидний ярьж байгаа экологийн сүйрлийн үйл ажиллагааны үед энэ асуудал гарах нь. Тийм болохоор уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой, усны нөөцтэй холбоотой ямар судалгаа байгаа вэ гэдэг асуудлыг 1 дүгээрт шаардаж байгаа.

Хоёрдугаарт, Б.Бат-Эрдэнэ гишүүний асуулт бол ерөөсөө маш тодорхой ойлголтыг өгвөл их сайн байна гэсэн учраас хичээж ярья. Бид нар Ховд гол дээр төлөвлөж байгаа нэг ажил бол Эрдэнэбүрэн дээр баригдах усан сангийн асуудал байгаа. Тэгвэл Эрдэнэбүрэнгийн баригдах усан сан цаад талд нь эрчим хүчийг үйлдвэрлэх үйл ажиллагаатай ганцхан энэ биш, олон лицензийн талбай дээр байж байгаа усны ашиглалт, усны хэрэглээнүүд хэрхэн яаж уялдах вэ гэдэг 2 дахь том асуултын тэмдэг байж байгаа.

3 дугаар асуулт дээр Монголиан нэшнл рийр ийрт корп гэдэг компани маань сүүлийн 2022-2025 онд ус ашигласны дүгнэлт гаргуулаад төлбөрөө төлөөд явж байгаа. Энэ маань маш бага хэмжээний өрмийн ус учраас усны хэмжээ нь багасаад манай сав газрын захиргаанаас дүгнэлт гаргаад ингээд явж байгаа. Гэхдээ 2023 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр манай компанийнхан бүгдээрээ өөрсдөө санаж байгаа. Би өөрөө баталж өгсөн байгаа. Ажил аваад долоо хоногийн дараа 150 литр секунд

газрын доорх усны нөөцийг эрж хайх ажлын даалгаврыг 2023 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр батлуулсан.

Ховд аймгийн Мянгад сумын нутаг Гахай Цагаан булаг гэдэг газарт 116 км квадрат талбай дээр, харамсалтай нь надад байгаа мэдээллээр ямар нэгэн тайлан юм ирээгүй. Энэ батлуулсан ажлын даалгаврын дагуу үйл ажиллагаа явуулаагүй. Сүүлд батлаагүй байж байна. Сая 2025 оны 8 сард 300 литр секундийн нөөцийг олохоор, Цагаан булан гэдэг газар дээр 11км квадрат талбай дээр газрын зурвасын эрэл хайгуул хийе гэсэн ийм хүсэлт ирүүлчихсэн, бид арай батлаагүй байж байна. Бид 2022 онд Усны газраас ус ашиглуулах боломжит нөөцийн дүгнэлтийг гаргаад өгчихсөн байгаа. Уг дүгнэлт дээр 70 литр секундийн усны хэрэгцээтэй, тэр усны хэрэгцээг Ховд голоос татна гэчихсэн байдалтайгаар боломжит нөөцийн дүгнэлтийг гаргачихсан байсан.

Гэтэл ТЭЗҮ дээрээ нэг өөр бичээд, ажлын даалгавар дээр харахаар 300 литр секундийг хүртэл хайж байгаа учраас одоогийн энэ төлөвлөж байгаа талбай дээр 100 литр секундээс илүү нөөц олдоно гэхэд тун итгэл багатай. Ийм учраас ашигт малтмалын нөөцийг тогтоохоосоо илүү усны нөөцийг тогтоох ажлаа эрчимжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Энэ газрын доорх усны судалгааг ер нь давхар хийх тухай асуудлыг ер нь ярих ёстой шүү. Өрөмдлөг ирж хийж байгаа юм бол огтлолцол, тэр усны огтлолцол байгаа юм уу? Хэдэн метрт байгаа юм тэр нь ундны усанд ашиглаж болох юм уу? Тэр шинжилгээг бол ер нь хийх ёстой. Энийг төсөл хэрэгжүүлэгч компани уул нь санаачилгаараа л хийх ёстой байгаа юм л даа. Дараагийнх нь хэн байна? Төсөл хэрэгжүүлэгч 5 номер.

“Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-ийн захирал А.Цолмон: Үйл ажиллагааны одоогийн нөхцөл байдлын хувьд манай компани 2022-2023 онд хайгуулын ажил хийснээс хойш ерөнхийдөө 2024-2025 онуудад Ашигт малтмал, газрын тосны газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас батлагдсан төлөвлөгөөнүүдийнхээ дагуу үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байдалтай байгаа. Өрөмдлөгийн ажил 2023 оноос хойшоо хийгдээгүй. Өрөмдлөгийн ажлын үр дүнгээр бол бид нар геологийн судалгаа хийх нөөцийг тогтоох шаардлагатай байгаа.

Геологийн нөөцийг нь нэмэгдүүлэх, металлургийн шинж чанарыг нь судлах ажил хийгдэж байна. Одоогоор металлургийн дээж авсан. Дээжүүдээ олон улсын итгэмжлэгдсэн лабораторид явуулж судалгаа шинжилгээний ажлыг ахисан түвшинд гаргах, хагас үйлдвэрийн туршилт явуулах гэсэн судалгааны ажлуудыг хийгдээд явж байгаа.

Манай компанийн хувьд олборлолтын ажил огт хийгдээгүй. Нийтдээ талбай дээр 134 цооног, 20 мянга орчим метр, 30 мянга орчим тууш метр өрөмдөгдсөн байдалтай байгаа. Хайгуул судалгааны ажил хийгээд явж байгаа төсөл байгаа.

Байгаль орчны шалгалтаар илэрсэн нөхцөл байдал байдаг уу, байгаль орчинд хор хөнөөл учруулсан нотолгоо байгаа юу гэсэн асуултын хувьд нийтдээ манайх төсөл хэрэгжүүлэх, хайгуул үйл ажиллагаа явуулах хугацаандаа 8 удаагийн төрийн, сумын болон ҮАБЗ-өөс томилогдсон гэх мэт хяналт шалгалтын ажлууд явагдаж байсан. Эдгээр шалгалтын явцад манайх дээр байгаль орчинд ноцтой хор хохирол учруулсан гэсэн нотолгоо баримтууд байхгүй байгаа.

Юу үйлдвэрлэх боломжтой вэ? Бүүр эцсийн бүтээгдэхүүн болтол нь авч явах боломжтой юу гэдэг асуултын хувьд одоогийн ТЭЗҮ-ээр бол бид төслийг олборлолт болон баяжуулалтын хэсгийг Монгол Улсад боломжтой гэсэн байдлаар төсөөлсөн байдаг. Энэ нь 2023 онд хүлээлгэж өгсөн ТЭЗҮ-ээр баяжмалыг боловсруулах ба баяжмалыг бүтээгдэхүүн гэж үзээд борлуулах боломжтой гэсэн ийм төсөөлөл байсан. Гэхдээ бид 2022-2023 онд хийсэн хайгуулын ажлаараа үргэлжлүүлээд цаашдаа гидрометаллургийн боловсруулалт хийж Монгол Улсаас нийлмэл исэл гэсэн бүтээгдэхүүн гарах боломжтой эсэх талаар судалгааны ажлыг үргэлжлүүлээд явж байгаа.

Ерөнхийдөө Халзан бүрэгтэйн орд бол 1980-аад оноос хойш анх геологийн нөөц нь илэрсэн. Анх илэрсэн цагаасаа хойшоо металлурги, баяжуулалт, боловсруулалтын асуудал нь ойлгомжгүй байсан. Тэгээд энэ байдлыг манай төслийн нэгж эцэслэх зорилготой өрөмдлөг судалгааны ажлыг үргэлжлүүлээд явж байгаа. Гидрометаллургийн судалгааны ажил бол хараахан эхлээгүй байна. Лабораторид нь захиадга нь өгөгдчихсөн хариунууд нь эцэслэж гараагүй байдалтай байж байгаа.

Монгол Улс өрсөлдөх боломжтой төсөл эсэх талаар, түрүүнд бас шинжээчдийн дүгнэлтээр ч гэсэн харагдсан. Ерөнхийдөө бол Халзан бүрэгтэйн орд өөрөө агуулга багатай. Гэхдээ Монгол Улсад байгаа хүнд газрын ховрын элемент агуулсан нэг орд учраас өрсөлдөх чадварын хувьд агуулагдаж байгаа элементүүд нь бол өрсөлдөх чадвартай гэж үзэж болохоор байгаа. Гэсэн хэдий ч нөгөө талаасаа хайгуул судалгааны ажил дээр үндэслэж хий гарах тооцооллуудаар тухайн бүс нутагт үйл ажиллагаа явуулах бол...(минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Г.Нямдаваа дарга товчхон хариулна шүү. Тэгээд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам дараа нь хариултад бэлдээд байж байгаарай.

Оролцогч Г.Нямдаваа: Саяын тэр тоог нь бол би сайн санахгүй байна. Тэр үед намайг аймгийн Засаг даргын ажил авсны дараа лицензийн асуудал ямархуу байдалтай байсан бэ гэвэл лицензийн санал авахаар аймгийн Засаг дарга дээр бичиг ирдэг. Тэрнийг би орон нутагт нь сумын Засаг дарга, сумын иргэдийн хуралд явуулдаг, сумын иргэдийн хурлаар хэлэлцээд дэмжихгүй байгаа бол албан ёсны хариугаа ирүүлдэг байдалтай байсан. Тэрнийх нь дагуу би татгалзсан зүйлүүд дээр нь татгалзлаа, дэмжиж байгаа зүйл дээр нь дэмжиж байна гэж өгсөн.

Тэгэхээр тэр үед нь би дэмжиж байгаа гэдгээр нь Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар луу албан тоот явуулчихдаг байсан. Орон нутаг нь жишээлбэл, иргэдийн хурлаараа хэлэлцээд дэмжихгүй гэсэн бичиг ирүүлээ гэхэд л би тэрнийг нь дэмжихгүй гэсэн байдлаар явуулчихаар та хууль бус татгалзсан байна гэсэн хариу ирүүлчихдэг байсан. Тэгээд л шууд өгчихдөг. Бид нар дэмжсэн байсан ч өгчихдөг, дэмжихгүй байсан ч өгчихдөг. Тухайн үед арваад жилд шахам намайг ажлаа өгөх хүртэл яг л тийм хуультай байсан. Ямар нөхцөлд татгалзах эрхтэй байсан гэвэл хуулиараа Улсын тусгай хамгаалалтад байгаа бол татгалзах эрхтэй байсан.

Өөрөөр хэлбэл, орон нутгийн тусгай хамгаалалтад байгаа бол татгалзах эрхтэй бусад тохиолдолд аймгийн Засаг дарга татгалзах эрхгүй гээд шууд олгочихдог байсан. Ашигт малтмалын тухай хуулийн тухайн үеийн заалтаар шууд олгочихдог байсан.

Дараад нь бид нэг хэсэг дандаа дэмжихгүй гэсэн бичиг явуулаад, шууд та хууль бус татгалзсан учраас шууд олголоо лицензийг гэсэн ийм албан тоот над дээр байнга

ирчихдэг байсан. Зарим тохиолдолд орон нутгаас нь санал ирэхгүй байгаа тохиолдолд шууд дэмжих бололцоотой юм гэсэн зүйл хэсэг хэсгээр нь надад оруулчихдаг байсан. Магадгүй тэр дотор оруулж ирж зурагдсан байхыг үгүйсгэх арга байхгүй. Харин би өөрөө Халзан бүрэгтэйн ордыг хүчингүй болгох талаар албан ёсоор Байгаль орчны яаманд, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газарт хэд хэдэн удаа бичиг явуулж байсан. Аймгийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийг газар дээр нь ажиллуулаад дүгнэлт гаргуулаад тэрний дагуу харин хүчингүй болгох тухай албан тоотыг удаа дараа явуулж байсан. Тэр бичиг нь ч гэсэн надад байгаа.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын дарга Г.Энхмөнх: Зөрчилтэй холбоотой асуудлын хувьд 2023 онд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас хайгуулын ажлын үеийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталсан. Улмаар 2023 оны нэгтгэлийг аймгаас байгуулагдсан ажлын хэсэг 90 оноотой дүгнэсэн байгаа. Энэ ажлын хэсгийн дүгнэлтийг харахад сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт, хог хаягдал, мөн энэ хийж байгаа ажилтай холбоотой олон нийтэд мэдээлэл өгөх гэдэг энэ бүх ажлыг ажлын хэсэг 90%-аар дүгнэсэн байж байгаа. Тэгээд 2024-2025 онд бол үйл ажиллагаа явуулаагүй. Яг өнөөдрийн байдлаар манайд ирүүлсэн албан бичиг, мэдээлэл дээр бол байгаль орчин хордсон, энэ бол хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар тогтоогдсон гэдэг юм уу ийм төрлийн мэдээлэл одоогоор ирээгүй байна.

Хоёрдугаар асуултын хувьд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.3 дээр тухайн төсөл нөөц нь тогтоогдоод ТЭЗҮ батлагдсаны дараагаар байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдээд явдаг. Тэгэхлээр тухайн төслийн хувьд бол ТЭЗҮ батлагдсан. ТЭЗҮ дээр үндэслээд байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ ирсэн. Яг харамсалтай нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хувьд шаардлага хангахгүй, судалгаа хангалттай бус байна гэдэг үндэслэлээр буцаасан байж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа. Б.Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би 3 минутдаа багтааж байгаа шүү гэдгээ хэлмээр байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман дээр нэг асуулт байна. Энэ баруун бүс нутгийг хамарсан хэмжээний асуудал яриад байгаа юм. Баруун бүс нутгийг хамарсан хэмжээний том хайгуулын лиценз олгосон юм уу? Баруун бүс нутаг гэдэг чинь 5 аймаг байна. Баян-Өлгий, Ховд, Завхан, Увс, Говь-Алтай гээд ямар хэмжээний газар нутгийг хамарсан лиценз олгочихсон юм бэ? Тийм олон аймгийн газар нутгийг хамрахаар хэмжээний асуудал үүсэхээр түвшнийх юм уу гэдгийг би 1 дүгээрт асуух гэж байгаа юм.

Хоёрдугаарт, иргэд Хар ус нууртай холбоотой асуудал яриад байна. Хар ус нуурын сав газрын захиргаа гэж байгаа шүү дээ. Тусгай хамгаалалтын захиргаанууд ч байгаа. Байгаль орчны яам, тэр захиргаанууд юу хийж байдаг юм бэ? Нэг иргэн би бүгдийг нь цэвэрлэдэг гээд л ярьж байх жишээтэй байна. Ямар учир юм бэ? хариулаад өгөөч.

Гуравдугаарт, Г.Нямдаваа дарга та аягүй хариуцлагагүй мэдэгдэл хийж байна. Өөрөө аймгийн Засаг дарга андуураагүй бол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байсан байх. Тэр үед ерөөсөө хууль ямар байх нь хамаагүй, би ямар гарын үсэг зурах нь хамаагүй байсан л гэж яриад байх юм. Түүний чинь үр дагавар хэрвээ тийм байсан юм бол өнөөдөр бид нар үйл лайг нь эдэлж байна шүү дээ.

Ашигт малтмалын тухай хууль гэж бий. Лиценз олгохдоо тухайн сум аймгийн Засаг даргын дэмжлэг, нутаг дэвсгэрийн төлөвлөгөө, байгаль орчны нөхцөл зэргийг харгалзан үзэхээр заасан байдаг. Иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг сумын Засаг дарга баталгаажуулаад дэмжсэн, дэмжээгүй саналаа өгөөд сумын Засаг даргын дэмжсэн, дэмжээгүйг аймгийн Засаг дарга дэмжсэн, дэмжээгүйгээр саналаа Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яаманд ирүүлдэг. Ашигт малтмал, газрын тосны газарт ирүүлдэг. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд ирүүлдэг. Энэ саналыг үндэслэж байж тухайн лицензийг олгохтой холбоотой асуудал хөндөгддөг байхгүй юу. Нөгөө талдаа Газрын тухай хууль байна. Ашигт малтмалын хайгуул хийхдээ газрын хэмжээг тогтоох, иргэдийн эзэмшиж байгаа газартай давхцал эрсдэлийг давхацсан эсэхийг зохицуулдаг 29 дүгээр зүйл. Бас Засаг даргын бүрэн эрх мэдэл дотор байгаа.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Байгаль орчинд үл нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль энэ бүхэн дээр Засаг даргын бүрэн эрхийг бүгдийг нь заагаад өгчихсөн байгаа. Яагаад? Ийм олон хууль тогтоомжууд байсаар байтал та өөрөө 2005 оны 4 сарын 4-ний өдөр бүхэл бүтэн 2 захирамжаар дэмжиж байна гэсэн бичгээ өгчхөөд 20 жилийн дараа өнөөдөр ийм асуудал өөр нөхцөл байдалтай хөндөөд байж байгаа юм бэ?

Тэгээд дээрээс нь та өнөөгийн Улсын Их Хурлыг чадамжгүй юм шиг эсвэл тухайн үеийн Улсын Их Хурал чадамжгүй байсан юм шиг, хууль тогтоомжийг хэрэгжүүлдэггүй байсан юм шиг, хяналт тавьдаггүй байсан юм шиг, саналыг авдаггүй байсан юм шиг тайлбарлаж болохгүй. Энэ дээрээ та дэлгэрэнгүй тайлбараа өгөөч гэж хүсэж байгаа юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Эхлээд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, дараа нь Г.Нямдаваа дарга хариулна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул ашиглалтын газрын дарга С.Ган-Очир: Гишүүний өгсөн чиглэлийн дагуу мэдээлэл өгье. Баруун бүсийн мэдээлэл бүхэлдээ миний гар дээр маань бэлэн биш байна. Хэрвээ зөвшөөрвөл дараа дахиж баруун бүсийн хэмжээний мэдээллийг өгье. Халзан бүрэгтэй ордын буюу Монголиан нэшнл рийр ийрт корп компанийн тухайд бол 2 тусгай зөвшөөрлийн хувьд 12335 дугаартай тусгай зөвшөөрлийн талбай 91,39 га, 6911 дугаартай тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ бол 175,24 га үндсэндээ нийлээд 170 орчим га л талбай байгаа юм л даа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Наадах чинь тодорхой асуулт асуусан шүү дээ. Халзан бүрэгтэй гээд байгаа энэ ордон 5 аймгийн газар нутгийг бүрэн хамардаг юм уу эс үгүй бол зөвхөн Завхан аймгийн Мянгад сум байдаг юм уу Гахайт багт байдаг юм уу, эс үгүй бол Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс гэсэн 4 аймгийн газар нутгийг хамардаг юм уу гээд асуулт л асуусан шүү дээ.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул ашиглалтын газрын дарга С.Ган-Очир: Халзан бүрэгтэйн ордын тухайд Ховд аймгийн Мянгад сумын нутагт оршдог нэг аймгийн нэг сумын нутаг дэвсгэрт оршдог. Одоогоор ашиглалтын 3 тусгай зөвшөөрлийн талбайд олгогдсон 2 тусгай зөвшөөрлөөс гадна төсөл хэрэгжүүлэгч компанийн 106,6 га талбай мөн энэ ордод хамаардаг.

Усны газрын дарга З.Батбаяр: Сав газрын захиргааны тухайд Ховд гол, Хар ус нуурын сав газрын захиргаа маань 450 км урт урсаж байгаа Ховд голыг Баян-Өлгий аймаг бүхэлдээ гэсэн үг. 4 том нууртайгаа хариуцаж ажилладаг. Энэ үйл ажиллагаа явуулж байгаа компанитай 50-100 метр/куб хоногийн усыг ашиглаж байгаа учраас дүгнэлтүүдээ гаргаад ажиллаж байгаа. Яг очиж хамгаалах ажиллахын тухайд бол чадлынхаа хэрээр ажиллаж байгаа. Мэдээж томилолт, бензиний зардал гэх зэрэг хүндрэлүүд байгаа. Энийг төсөв дээрээ бид ярьж байгаа. Тийм учраас манай сав газрын захиргааны зүгээс дарга нь ирчихсэн сууж байна. Байдаг чадлаараа ажиллаж байгаа хүрэхгүй юмнууд нэлээн олон байгаа. Харилцан иргэдтэйгээ хамтарч ажиллах шаардлага, компанитай бас хамтарч ажиллах шаардлага, харилцан ойлголцож ажиллах шаардлага бол байгаа.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын дарга Г.Энхмөнх: Сав газрын захиргаатай холбоотой асуудал ярилаа. Давхар Хар ус нуурыг хамгаалдаг Улсын тусгай хамгаалалттай газар гээд байж байгаа. Тэгээд тухайн захиргааны хувьд Хар ус нуур орчмын тусгай хамгаалалттай газрыг хамгаалдаг. Тухайлбал байгаль хамгаалагчийн хувьд хариуцан хамгаалах талбай гэж байгаа. Тэгээд хариуцан хамгаалах талбайнхаа хэмжээнд тухайн орчинд гарч байгаа зөрчил дутагдлыг арилгуулах, мөн биологийн олон янз байдалтай холбоотой мониторингийн асуудлыг тогтмол хийгээд явдаг. Тэгэхлээр тухайн хамгаалалтын захиргаа болоод сав газруудын хувьд ажил нь уялдаад явдаг гэсэн үг.

Оролцогч Г.Нямдаваа: Байгаль орчны яам бол санал авдаггүй байсан. Ганцхан Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар л аймгийн Засаг дарга дээрээс албан тоотоор ирүүлж санал авдаг байсан. Ганцхан тийшээ саналаа өгдөг байсан. Тэгээд тэр санал нь ч гэсэн Ховд аймгийн архивд байж байгаа. Миний татгалзаад явуулчихсан орон нутгаас татгалзсан учраас явууллаа гээд явуулчихсан. Тэрнийг нь та хууль бус татгалзсан учраас олголоо гэхихсэн албан тоотууд надад очиж байсан. Албан тоотууд ч гэсэн тэндээ байж байгаа.

Тэгэхдээ татгалзах гуравхан нөхцөлөөр аймгийн Засаг дарга татгалзах эрхтэй байсан гэж байна шүү дээ. Улсын тусгай хамгаалалтад байвал, улсын тусгай хэрэгцээний газар байвал, орон нутгийн тусгай хамгаалалтад байвал гэсэн ийм гуравхан нөхцөлтэй бусад тохиолдолд бол тэр 3-д л байхгүй бол ямар ч нөхцөлөөр аймгийн Засаг дарга татгалзлаа гээд бичиг явуулахад шууд... (минут дуусав.)

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууна.

УИХ-ын гишүүн Ө.Шижир: Төр нэгэнт өөрөө зөвшөөрөөд зөвшөөрлийг нь олгосон бол бүх салбарт хувийн хэвшил хөрөнгө оруулалтаа оруулаад үйл ажиллагаагаа явуулах хэвийн нөхцөл байдлыг нь хангах хэрэгтэй. Бид нарын энэ ярьж байгаа гар утас, харж байгаа энэ дэлгэц, унаж ирсэн машин, ярьж байгаа микрофон, энэ бүгдэд газрын овор элементийн хэсэг бүрдэл орж энэ бүхэн бий болж байгаа юм. Монгол Улс өнөөдөр алт, зэс, нүүрс гээд гуравхан юм зарж амьдарч байна. Айлаар ярих юм бол аль болгон бид 89 тонн нүүрс гаргах вэ, яаж 20 тонн алт олох вэ, яаж жоохон зэсийн баяжмал экспортлох вэ, тэрийгээ яаж ахмадуудын тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдынх нь цалинг өгөх вэ гээд. Ингээд л байж байгаа улс.

Бид илүү сайхан амьдармаар байна. Илүү сайхан орон зайг бий болгомоор байна. Тийм учраас бид нарт дахиад Эрдэнэт хэрэгтэй байна. Бид нар дахиад МАК, Монполимет шиг цементийн үйлдвэр хэрэгтэй байна. Дахиад Бөөрөлжүүт шиг

цахилгаан станц хэрэгтэй байна. Ийм төслүүд олон хэрэгтэй, энэ бүгдэд мөнгө хэрэгтэй.

Гэхдээ төр нэгэнт зөвшөөрлөө олгочихоод хөрөнгөө гаргаад үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн хэвийн үйл ажиллагаа явуулах эрхийг заавал хангаж өгөх ёстой. Энэ бол төрийн үүрэг. Ингэж байж ажлын байр бий болдог, ингэж байж эдийн засаг өсдөг, ингэж байж хүмүүсийн цалин тэтгэвэр нэмэгддэг. Сая төсөл хэрэгжүүлэгч талаас ажил явуулах боломжгүй нөхцөл байдалд байна гэж байна. Хэрвээ энэ төсөл хэлэлцүүлэг явагдаад ингээд ямар нэгэн талдаа шийдэгдлээ гэхэд нэг бол сайн жишээ болж үлдэнэ. Монгол Улсад нэг муу жишээ болж үлдэнэ. Муу жишээ болж үлдэх юм бол үүнээс цааших Монгол Улсад явагдах уул уурхайн том үйлдвэрийн бүтээн байгуулалтын бүх төслүүд энэ жишгийг дагах болно. Тийм учраас иргэдийн оролцоо маш чухал байгаа учраас бас орон нутгаас хүмүүс ирж байгаа гэдэгт маш их талархалтай байна.

2023 оны үед Монгол Улсын Ерөнхий сайд дэлхийн хамгийн нэг номерын тэрбумтан Элон Масктай онлайн хурал хийхэд Тесла компани Старлинг гэхэд нэгхэн сэдэв яригдсан. Газрын ховор элементээр хамтарч ажиллах боломж юу байгаа вэ? Бид нар хөрөнгө оруулъя гэсэн. 2025 оны эхээр та бүхэн санаж байвал АНУ, Хятад улсад тарифын татвар ногдуулахад, зөрөөд Хятад 17 газрын ховор элементээр нь өндөр тариф тогтоогоод хэдхэн хоногийн дараа 2 улс эх орондоо хэлэлцээр хийж байсан. 2 тал уулзах болзох ийм тохиолдол байгаа. Тийм учраас бид нар дэлхийн чиг хандлагаас дэлхийн хөгжлөөс хоцорч болохгүй.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас асуух гээд байгаа юм. Энд байгаа байдлыг харахаар иргэд нь нэг өөр ойлголттой, аж ахуйн нэгж нь өөр ойлголттой, төр нь яах вэ гээд зохицуулах гээд суугаад байна шүү дээ. Тэгэхээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам бас төсөл хэрэгжүүлэгч, нутгийнхаа иргэддээ тухайн орон нутагт амьдарч байгаа энэ холоос зорьж ирсэн нутгийн иргэддээ энэ бүтээгдэхүүн, үйл ажиллагааны талаар хэр мэдээлэл өгсөн юм бэ? Зөв мэдээлэл өгсөн юм уу, эсвэл буруу мэдээлэлтэй яваад байгаа юм уу өгөх гэж оролдлого хийсэн юм уу?

100 хэдхэн жилийн өмнө нүүрс түлэхээр угаартаж үхээд байдаг гээд л зохиолын номууд дээр ч, түүхийн номууд дээр ч байж байдаг шүү дээ. Зөв хэрэглээг бид дадал болгоогүй байсан л асуудал байхгүй юу. Тэгэхээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас би энийг бүүр онцолж асуумаар байна. Яг та хэд нутгийн иргэдэд, нийт иргэддээ газрын ховор элементийнхээ талаар зөв мэдээллийг өгч байгаа юм уу, буруу мэдээлэл өгөөд байгаа юм уу?

Төсөл хэрэгжүүлэгчээс дахиад нэг юм асууя. Та нар яг ер нь юу үйлдвэрлээд ямар үйлдвэр бариад, хааш нь экспортлох гээд байгаа юм, тэрийгээ энэ иргэддээ нэг ойлгомжтой үгээр тайлбарлаад өгөөч. Яг ийм юм үйлдвэрлэнэ, яг ийм үйлдвэр барина, эцсийн үр дүнд ийм бүтээгдэхүүн болно гээд ойлголтуудаа зөв өгөхгүй болохоор ойлголтын зөрүүн дээрээс сүүлдээ хэлэлцүүлэг болоод байна шүү дээ. Тэгэхээр би саяын асуултыг төсөл хэрэгжүүлэгчээс, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас асууя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас энэ дээр илүү тодорхой хариулах хэрэгтэй байна.

Тэгэхгүй бол цаашид бүх төрлийн уул уурхайн төслүүд энэ байдлаар нутгийн иргэдтэйгээ ойлголцохгүй ингээд сунжраад байдаг болчуул яах юм бэ л гэж байгаа юм. Энэ нутгийн иргэдийн ойлголтыг нь зөв өгөх хэрэгтэй шүү дээ.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул ашиглалтын газрын дарга С.Ган-Очир: Гишүүний асуултад хариулъя. Бид орон нутагт тухайн төсөл технологийн талаар сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг. Энд яригдаж байгаа төслийн тухайд бол бид 2017 онд хариуцлагатай уул уурхайн зөвлөгөөнийг Ховд аймагт зохион байгуулсан. Энэ төслийн танилцуулгыг хийлгэж байсан компани ч бас энэ талаар ярих байх. Хамгийн сүүлд бид өнгөрсөн 4 дүгээр сард байна уу даа Ашигт малтмал, газрын тосны газар дээр Ховд аймгийн Мянгад сумын иргэдийн төлөөлөл 20 гаруй хүн ирсэн. Мөн орон нутгийн захиргаа, удирдлагын төлөөлөл оролцсон. Нөгөө талаас Ашигт малтмал, газрын тосны газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Цөмийн энергийн комисс гээд холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулсан уулзалт, танилцуулга, ярилцлага хийсэн. Энэ дээр маш дэлгэрэнгүй мэдээллийг өгсөн. Мөн төсөл хэрэгжүүлэгчийг оролцуулсан.

2022 оноос Ашигт малтмал, газрын тосны газрын төлөөлөгчийн газрыг бүсчилсэн байдлаар ажиллуулж эхэлсэн. Баруун бүсийн төлөөлөгчийн газрыг мөн Ховд аймагт байгуулж, хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөгч болон орон нутгийн удирдлага, төвийн байгууллага, иргэдийн хооронд ийм гүүр болж ажиллах зориулалт, зохицуулалттайгаар ажиллуулж байгаа.

“Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-ийн захирал А.Цолмон: Мэдээлэл өгөх ажлыг манай компани бол өөрийнхөө хэмжээнд аваад явдаг. Уулзалтууд, ганцаарчилсан уулзалтуудыг хийх, иргэд нийтийн хуралд очиж мэдээлэл өгөх мөн Ховд аймгийн бүх сумуудаар явж төслийн танилцуулга хийсэн анхны төсөл болж байгаа байх. Сүүлд аймгийн Засаг даргын санаачилгаар байгуулагдсан олон талт зөвшилцлийн санаачилгыг дэмжиж ажилласан. Энэ дээр нийт 23 гишүүнтэй иргэд, төрийн байгууллага, компани гэсэн 3 талтай ажлын хэсэг ажилладаг. Энэ ажлын хэсгийг Улаанбаатар хотод ирэхдээ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамтай хамтдаа уулзалтыг зохион байгуулж, уулзалтад оролцож байсан.

Ерөнхийдөө мэдээлэл түгээсэн байдал нь бидэнд яг юу хүндрэлтэй байгаад байгаа вэ гэвэл, 2024 онд хайгуулын ажил эхлэхэд байгалийн цацрагтай холбоотой иргэдийн дунд тарсан мэдээлэл, цацрагийн талаар гаргасан төрийн байгууллагын гаргасан ойлгомжгүй дүгнэлт зэргээс үүдэлтэйгээр аж ахуйн нэгжид дангаараа мэдээлэл түгээх байдал хүндрэлтэй болсон. Түүнчлэн хайгуулын ажил талаарх мэдээллийг цаашдаа зөвхөн аж ахуйн нэгж дангаараа хийх боломжгүй нөхцөл байдал үүсчихсэн юм болов уу гэж харагдаад байдаг. Гэхдээ төслийн хэмжээнд ажиллаж байгаа 300, 400 орчим Монгол залуучууд энэ цацрагтай гэж яригдаад байгаа төслийн талбай байнга л ажиллаж байгаа. Нэгэнд нь ч цацрагийн хор аюул илрээгүй л явж байна.

Ямар бүтээгдэхүүн гаргах юм бэ гэдэг дээр одоогийн байгаа ТЭЗҮ-ээр бид баяжмал гаргана гэсэн төсөөлөлтэй байсан. Гэхдээ баяжмалын овор хэмжээ гэх зэргээс хамаараад Монгол Улсад цаашдаа дахин нэг шат ахиулах, боловсруулах боломж байгаа эсэхийг бид лабораторийн түвшинд судалж байна. Энэ лабораторийн туршилтаар гидрометаллургийн үйлдвэр, гидрометаллургийн туршилт хийгдээд ерөнхийдөө Монгол Улсаас анхан шатын боловсруулалт хийгдсэн исэл гарах боломжтой юм уу? Ингэхээрээ овор хэмжээ нь багасаад манай улсын тээврийн татаас байдал буурах ийм боломж харагдаад байгаа юм. Одоогоор бид судалгааны ажлыг хийх гээд лабораторид захиалга өгөөд хүлээж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Баярлалаа. Би төсөл хэрэгжүүлэгчээс энэ далимд хүсэлт байна. Энэ өнөөдрийн хэлэлцүүлэг эхэлсэн

цагаас хойш саяныг хүртэл нэг ийм худалдагдсан, хахууль авлигалтай холбоотой нэг юм явлаа шүү дээ. Эс үгүй бол боов, боорцог тараасан энэ тэр гээд зөндөө юмнууд ярилаа. Тэгэхээр энэ талаар мэдээллийг нууцын хэмжээнд гаргаж өг, шаардлагатай бол би хуулийн байгууллагад шалгуулна. Энийг хэнд хэзээ үнэхээр өгсөн юм байгаа бол? Мэдээллээ тэгэхдээ нууцын хэмжээнд. Энийг би шаардлагатай бол хуулийн байгууллагад өгч шалгуулна. Иймэрхүү зүйлүүд болсон бол болсон, болоогүй бол болоогүйг нь нотлох ёстой.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Болдын Уянга гишүүн асуулт асууна.

УИХ-ын гишүүн Б.Уянга: Өнөөдөр сонсголд оролцож байгаа та бүхний энэ өдрийн мэндийг хүргэе! Ховд аймгийн Мянгад сумын иргэдээс мэдээллээ шууд сонсох боломж олж байгаад талархаад сонсоод байж байлаа. Тэгээд нэг зүйлийг л яг хэнээс асуух вэ? Түрүүнд манай уул уурхайн мэргэшсэн инженер Даваасамбуу гуай хэллээ. Хайгуулын үйл ажиллагаа явж байгаа төсөл байгаад байдаг. Нөгөө талаас харахаар ургийн гажигтай төл малын зургууд л хөврөөд байдаг. Тэгээд хайгуулын үед бол цооногууд л харагдаж байх ёстой. Цооногийн хажууд зүүнхэн нь ухаастай байдаг юм болов уу? Яагаад ялангуяа сүүлийн жилүүдэд 8 удаагийн ийм тохиолдол гарлаа гээд байгаа юм бэ. Тэгээд хайгуулын үйл ажиллагаа явж байгаа газар ийм юм байна гэдэг бол байгалийн фон утга л яриад байгаа юм шиг. Энэ дээр шинжээчдээс хариулт өгөөч. Тэгээд цацрагийн өндөр агуулгатай гээд байх юм.

Төрийн байгууллагуудын мэдээллийг харахаар надад сонирхолтой харагдаж байгаа юм нь Дундговь аймгийн Халзангийн рашаан нэлээд өндөр цацрагийн тунгийн чадал өндөр байгаа нь харагдаад байдаг. Тэгээд энэ мэдээллүүд төрийн байгууллагаас гарч ирээд л, манай Ховдын иргэд, Ховд аймагт байгаа Ашигт малтмал, газрын тосны газрын тэр харьяа байгууллага мэдээллийн мөрөөр газар дээр нь төрийн зохицуулах үйл ажиллагаагаа хийх ёстой. Манай мэргэжлийнхэн ажлаа хийхгүй л байна уу даа л гэж харагдах юм.

Өнгөрсөн 2, 3 хоногт говийн бүсийн 7 гишүүний нэг Н.Наранбаатар гишүүнтэй хамт Дорноговь аймагт ажилласан юм. Миний бие өөрөө Улаанбадрах суманд ажиллалаа. Хөвсгөл суманд, Хатанбулаг суманд, Мандах суманд, Сайхандулаан сумд нөгөө ураны Зөөвч овоо гээд төсөл байгаа. Улаанбадрах сумаас эхлээд Зөөвч овоогийн төсөл дээр очоод яг олборлочихсон байгаа шар нунтгийг нь хараад цацрагийнх нь тоон утгуудыг нь хараад өөрийн биеэр ажиллалаа л даа. Тэгэхэд бол Улаанбадрах сумын иргэдээс яг ийм асуудал яриад байх юм. Ингээд манай Улаанбадрах сум дээр нэг ураны хордлого гэсэн асуудал сошиалаар нэвт явчихсан, Улаанбадрахын мал гэхээр худалдаж авахгүй байна гэсэн асуудал яригдсан.

Үүнтэй адил Ховд аймгийн Мянгад сумынх гэхээр худалдаж авахгүй байгаа ийм тохиолдлууд гарч байна уу? Бид хэт сошиалд хөтлөгдөөд яах вэ, тэгээд би ч гэсэн өөрөө мэдээллээ аваад л явах юм. Зурагт үзэж амжихгүй юм л даа. Энэ дээр эх үүсвэрийг нь сайн нягталж харахгүй бол бид бас малчдадаа тушаа болоод байгаа юм шүү. Энэ байдал битгий давтагдаасай. Тэгэхээр энд ерөөсөө иргэдийг буруутгах юм бол ерөөсөө байхгүй юм билээ. Ерөөсөө л Хөвсгөл, Хатанбулаг, Мандах, Сайхандулаан сумын иргэд Улаанбадрах сумтай хил залгаа оршиж байгаа эдгээр сумдын иргэд уран чинь хортой биз дээ л гээд байгаа юм. Үгүй ээ манайх уран агуулсан шар нунтгийг гаргах юм гэхээр ойлгоод байгаа байхгүй юу. Тэгэхээр нэг тайлбарлаад яваад очоод л нэг ярилцах ёстой юм шиг байгаа юм.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамныхнаас танай энэ мэдээлэл түгээх төрийн зохицуулах үүргээ гүйцэтгэх энэ байдалд Улсын Их Хурлын гишүүдээс ямар дэмжлэг хэрэгтэй байгаа юм бэ? Урсгал зардлыг нэмэгдүүлэх хэрэгтэй байдаг юм уу? Яг яах ёстой юм бол энэ дээр саналуудаа хэлээд нээлттэй тайлбарлаад өгөөч.

Дараагийн нэг зүйл нь өнөөдөр Улсын Их Хурал дээр сонсгол явагдаж байна. Тэгээд яг энэ салбар дээр нэлээн их мэдээлэл гардаг. Манай Ховдынхон бас нэлээн идэвхтэй мэдээллийн араас хөөцөлддөг учраас бүүр мэдээлэл нь явсаар байгаад Улсын Их Хурал дээр сонсгол зохион байгуулагдаж байна. Дараа дараагийн уул уурхайн бусад төслүүд ингээд л нэг, нэгээрээ Улсын Их Хурал дээр ороод ирэх шаардлагагүй. Уг нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамныхан яг өөрийнхөө орон нутаг дахь төлөөлөгчөөрөө дамжуулаад мэдээлэл хүргэх ажлаа хийчих юм бол энэ асуудалгүй байх.

Миний сүүлд асуух гээд байгаа юм нь Ховд аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгчид байна уу? Танайх Ховд аймагтаа яг энэ сонсголыг өөрсдийнхөө хэмжээнд зохион байгуулах боломж байна уу? Энд бас ирж чадаагүй олон Ховд аймгийн иргэд байгаа байх гэж бодож байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Ховд аймгийн удирдлагууд байгаа юм уу? Аймгийн удирдлагууд байхгүй бол наадах чинь хариулах боломжгүй л дээ. Аймгийн Иргэдийн хурлын дарга байна уу, Засаг дарга байна уу?

Шинжээч Д.Лхамсайзмаа: Мал эмнэлэг эрдэм шинжилгээний хүрээлэн эрдэм шинжилгээний ажилтан Д.Лхамсайзмаа гэж хүн байна. Саяын ургийн гажигтай төлийн тал дээр 5 дээжийг илгээсэн байдаг. Ингээд 3 дээжид мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори чиг үүргийнхээ хүрээнд онош тогтоох ийм чиг үүрэгтэй байгууллага байгаа юм. Энэ лаборатори маань шинжлээд дүгнэлтээ гаргасан байдаг. Энэ дүгнэлтийг баталгаажуулах зорилгоор олон улсын Канад улсад байрлах Стантек гээд лавлагаа лабораторид өгсөн байдаг юм. Тэгэхээр энэ шинжилгээний дүн адилхан баталгаажсан хариу нь бол ижил гарсан байсан. Тэгээд энэ шинжилгээний дүнд тэр цацрагийн хэмжээ бол хэвийн байсан. Харин тухайн төлийн эд эрхтэнд цайр, зэс, төмөр, селен гэсэн ийм элементүүдийн дутагдалтай гэж гарсан байсан.

Ер нь энэ ургийн гажиг урд өмнө нь гардаг байсан зүйл, яг шинээр гарч ирээд байгаа зүйл бол биш. Энэ нь хүнд ч ялгаагүй, мал эмнэлэгт ч ялгаагүй гардаг байсан. Ер нь бол судалгаагаар 100 мянган тохиолдолд нэг байвал хэвийн гэж үзнэ гэсэн судалгааны ажлууд бол одоог хүртэл байдаггүй. Ер нь ингээд үзэхээр ургийн гажигт нөлөөлдөг маш олон хүчин зүйлүүд байгаад байдаг. Генийн, мутацийн, хромосомын, насжилтын цус ойртолт жинд гэдэг юм уу. Мөн бидний яриад байгаа энэ цацраг туяа, химийн, малын эмийн зохисгүй хэрэглээ, өвс тэжээлийн дутмагшил, биологийн хүчин зүйл гэхээр нөгөө вирус, бактери, мөөгөнцөр, шимэгч эд нар гээд шалтгаан нь тодорхойгүй ийм олон хүчин зүйлсээс шалтгаалж байж ургийн гажиг үүсдэг гэсэн ийм судалгааны дүн бол байдаг.

Ер нь бол би яг энэ завшааныг тохиолдуулаад хэлэхэд энэ Ховд аймгийн Мянгад суманд тэр тусмаа энэ хөрс ургамалд селен, кобальт, иод, цайр, зэс дутагдалтай гэсэн ийм манай ахмад эрдэмтдийн судалгааны дүн байж байдаг. Тэгээд сүүлийн үед мал хувьд шилжсэнээр малын эрүүл мэндийн суурь үзүүлэлт, энэ халдваргүй хүчний талын судалгааны ажил бол ерөөсөө зогсчихсон байдаг. Тэгэхээр энэ гажгийг үүсгээд байж болзошгүй гэсэн энэ талын судалгааны ажлуудыг бас цааш нь явуулж өгөөсэй. Төр засаг анхааралдаа аваасай. Тэр нутгийн орогнол өвчин буюу эндемик өвчний тандалт судалгаа хорт ургамлын тандалт судалгаа тэр хүрээлэн

байгаа орчны хөрс ус ургамлын макро, микро элементийн хөдлөл зүй, мал, амьтанд яаж нөлөөлөөд байна гэдэг талын судалгаа хийх талаар анхаарч өгөөсэй гэж дашрамд хэлэх байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул ашиглалтын газрын дарга С.Ган-Очир: Гишүүний асуултад хариулъя. Мэдээллийн зөрүүтэй байдал, хүн хүчний хүрэлцээгүй байдал гэх мэт яг бодит байдлыг Б.Уянга гишүүн хэлж байна. Манай дэд сайдаар ажиллаж байсан. Мэдээж шийдүүлэх шаардлагатай 2 асуудал байна.

Тухайлбал, бидний томилолтын зардал бол хаанаа ч хүрэлцдэггүй. Хүний нөөц салбар нэгжүүд гээд ярих юм бол мөн хаанаа ч хүрэлцдэггүй. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хувьд аймаг бүрд салбартай, сум болгонд мэргэжилтэнтэй ийм бүтэцтэй байж байдаг. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар ийм бүтэц байхгүй. Бүсчилсэн байдлаар цөөн тооны 3-4 хүнтэй орон нутгийн нэгжүүдийг ажиллуулж эхлээд удаагүй байна. Мөн чадавхжуулах цаг хугацаа шаардлагатай байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Б.Уянга гишүүн тодруулах уу?

УИХ-ын гишүүн Б.Уянга: Улсын Их Хурал дээр бид 2026 оны төсвийг хэлэлцэж байгаа. Тэгэхээр цааш цаашдаа иргэддээ үнэн бодитой мэдээллийг өгөх нь бид нарын үүрэг. Дахиад нэг ч салбарын мэргэжилтэн бэртэж гэмтэхгүй байгаасай гэж салбарын мэргэжилтний хувьд бодож явдаг. Энэ дээр яг төсөв хэлэлцэж байх үед зарчмын зөрөөтэй санал байдлаар өгмөөр байх юм. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас холбогдох саналыг ирүүлээч гэж хүсэх байна. Мал эмнэлгийнхний хариултыг бол авлаа. Танай танилцуулгын 21 дүгээр слайдыг хараад сууж байлаа.

Тэгээд нутгийн иргэдийн бухимдах аргагүй нэг байдал харагдаад байгаа юм. Мянгад, Баянбулаг сумын хувьд иргэн Лхагвасүрэн гуайн хурга гээд 3 сарын 26-нд хүлээн авсан хэр нь шинжилгээний дүн нь байхгүй. Одоо хэдэн сар юм бэ?. Тэгснээ Гахайт багт байгаа энэ 2 дээж шинжилгээнд яваагүй. Бүгдээрээ 3-4 сарын асуудал юм байна л даа. Тэгэхээр төрийн байгууллагын дутагдаж байгаа зүйл нь яг хэрэгтэй юмандаа төсөв нь байдаггүй. Энэ дээрээ та хэд маань хариуцлагаа ухамсарлаад манай ажлын албаны нэр дээр юм уу эсвэл энд сууж байгаа, баруун бүсээс сонгогдсон гишүүдийнхээ нэр дээр, дүгнэлт гаргах лаборатори дээр ч юм уу, төсөв дээр юу хэрэгтэй байна вэ гэдэг саналаа явуулаач. Тэрийг л хэлэх гэсэн юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За санал хэллээ. Орон нутагт нь нийтийн сонсгол зохион байгуулж болох уу гэсэн асуултын хувьд Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлд зааснаар 2 тохиолдолд зохион байгуулахаар байна. Аймгийн ИХТ-ийн 4/1-ээс дээш санаачилж шаардсан бол, төсөл хэрэгжүүлэгч компанийн эрх нь зөрчигдөж аймгийн иргэдийн хуралд сонсгол зохион байгуулах хүсэлтийг гаргасан бол гэсэн ийм 2 тохиолдолд аймаг, орон нутагт хяналтын сонсголыг зохион байгуулах хууль, эрх зүйн зохицуулалт байгаа юм байна. Одоо Сонгобайн Замира гишүүн асуулт асууна.

УИХ-ын гишүүн С.Замира: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Миний асуух нэлээд хэдэн асуулт Б.Бат-Эрдэнэ гишүүнтэй давхацлаа. Тэгээд нэмж асуух хэдэн асуулт байна. Үүний өмнө би нэг юм хэлмээр байна. Сая шинжээч бас хэллээ л дээ. Бидэнд уур амьсгалын өөрчлөлт, газрын хөрсний өөрчлөлт, усны өөрчлөлт, малчдын тарьж байгаа тариа, шавж хорхойг устгана гээд газар цацаж

байгаа бодисууд энэ бүхэн чинь хортой шүү. Тэрнээс л болоод хорт хавдар ихэссэн байна.

Малын гений өөрчлөлт заримдаа гарч байх шиг байна. Энэ бүгдийн ганцхан ашигт малтмалаас болж байгаа, энэ бүгд хортой байна гэж дүгнэх нь буруу болов уу гээд би бодож байна. Байдал маш хүнд байгаа шүү дээ. Дэлхий даяар дайн дажин, байгалийн гамшиг болж байна. Өнөө маргаашгүй хил ямар нэг асуудлаас болоод хаагдах юм бол бид яаж амьдрах вэ гэдэг асуулт хүн болгоны өмнө тавигдах ёстой. Нэгдүгээрт, нэгэнт төр засаг лиценз өгсөн бол зөвшөөрлөө хамгаалах ёстой.

Хоёрдугаарт ард түмэнд зөв ойлголт өгөх ёстой. Яагаад ард түмний тархийг угаагаад янз бүрийн шинжилгээний дүгнэлт хэлж бухимдуулж байна. Та бүхнийг би зөв гэж бодож байна. Ингээд асуудал тавьж энд ирээд, төр засагтаа бүх юмаа яриад асуудлаа шийдвэрлүүлэх гээд явж байгаа нь зөв гэж бодож байна. Нутгийн ард түмнийг дэмжиж байна.

Одоо гадаа ахмадууд суулт хийж байна. Тэтгэврээ нэмж өгөөч гэнэ ээ, нэмж өгье гэхээр мөнгө байхгүй. Тэгээд боловсролын салбар, эрүүл мэндийн салбар дампуурлын байдалд байна. Нэг ангид 60-70 хүүхэд сурч байна. 2, 3 ээлжээр хичээллэж байна. Энэ бүгд яаж хөгжих ёстой юм. Бид өөрсдийн байгаа боломжоо ашиглаж байж хөгжих ёстой биз дээ. Алийн болгон гадаадаас өр зээл тавих вэ, яагаад бид өр зээл авах ёстой вэ гэж.

Одоогийн парламент өнгөрсөн 76-аас өөр шүү, 126 гишүүн орж ирээд аль болох урьд өмнө гарсан 35 жилд гарсан алдаа засах гээд аль болох эх орноо хөгжүүлэх гээд аль болох хууль хяналтаа бүгдийг нь сайжруулах гээд явж байгаа. Парламентаас хяналтаа тавьж өмнө утааны сонсгол зохион байгуулсан бол өнөөдөр Ховдын ашигт малтмалынхаа маргааны сонсгол гээд явж байна. Хэзээ урьд өмнө ийм сонсгол болж байсан юм бэ? Тийм учраас ард түмэн энийг дүгнэж байх ёстой гэж би бодож байна. Тэгээд нэмж юм асуумаар байна.

Сая яагаад шинжээчдийн дүгнэлт өөр гарсан бэ? Тэрэнд нэг хариу өгөөдхөөч. Нэг хүн очоод энэ чинь хортой шүү гээд ард түмнийг бухимдуулаад хаячихсан байна шүү дээ. Дараа нь очихоор зэрэг нөгөөдөх нь өө энэ чинь хоргүй байна, зүгээр байна гээд ингээд энэнээс эхэлж байгаа байхгүй юу. Төр засаг ажил хийгээд төлөвлөөд, улс эх орноо хөгжүүлэе гээд юм хийгээд байдаг. Тэгсэн чинь дунд, доод шатдаа энийг замхруулаад яваад байдаг. Улс төржүүлээд яваад байдаг. Тэгэхээр бид яаж хөгжих вэ.

Хоёрдугаарт, сая нэг залуу ярьж байна. Хууль хяналтын байгууллагуудыг ашиглаж биднийг дарамталж байна гээд. Тэр чинь үнэн бол энийг шалгах ёстой үнэхээр аж ахуйн нэгж нь тэгж нутгийн ард түмнийг дарамталж байна уу, эсвэл дунд нь хүмүүс ажиллаад байна уу? Уг нь үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж орон нутгийн ард түмэнд хүндэтгэлтэй харьцаж, хэл амаа ололцож, үйл ажиллагаагаа явуулах ёстой.

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамныхан мэдэж байгаа. Тэрэн дээр ашиглалтын лиценз авсан бол орон нутагтай гэрээ хийх ёстой, тэр ямар гэрээ гэх юм бол? Ашиглалтын лиценз авсан гээд би сая сонссон. Орон нутгийн хэчнээн хүнийг ажилтай болгох вэ, орон нутгийг яаж хөгжүүлэх вэ, хэчнээн сургууль барих вэ, хэчнээн ясли цэцэрлэг, эмнэлэг барьж өгөх вэ, сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр эрүүл мэндийн байгууллагыг яаж хангаж өгөх вэ, хэчнээн хүүхдүүдийг гадаад, дотоодод сургаж, өөрсдийн энэ үйлдвэрийн төлөө орон нутгийн

мэргэжилтнийг бэлтгэх тал дээр ямар туслалцаа үзүүлэх вэ гэдгийг аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай гэрээ хийж ард түмэндээ танилцуулах ёстой. Тийм юм хийсэн үү?

Тэгээд бас энэ үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн захирлаас асуумаар байна. Энэ бүтээгдэхүүнийг гаргахад эцсийн бүтээгдэхүүн гаргая гэсэн танай төлөвлөгөө байна уу? Эсвэл түүхийгээр олборлож аваад гадаадад экспортлох гэж байна уу? Эцсийн бүтээгдэхүүн гаргах уу? Ийм нэг асуудал байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас эхлээд хариулах уу? Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Төсөл хэрэгжүүлэгч 2 хариулахад болно. Гишүүн хэнээс асуусан юм? Та оролцогчоос асуусан юм уу? Шинжээч мал эмнэлгийн холбоотой асуултдаа хариулт өг. Тэгээд дараа нь Төсөл хэрэгжүүлэгч хариулаарай 8 номерын микрофоныг өгөөрэй.

Шинжээч Э.Цэрэнчимэг: Эхний ээлжинд цацрагийн чиглэлээр дүн шинжилгээ хийсэн слайдыг гаргахыг хүсэж байна. Энэ боломжтой болов уу? Энэ слайдыг гарахаас өмнө нэг зүйлийг онцолж хэлмээр байна. Энд сууж байгаа шинжээчид бүгд ерөнхий хяналтын сонсголын дэг журмын дагуу ажлын даалгаврын хүрээнд аль нэг талыг илүүд үзэхгүйгээр холбогдох талуудын ирүүлсэн баримт бичиг, дата мэдээллүүд дээр хэн нэгнээс хараат бус байдлаар тоо баримтад дүн шинжилгээ хийж ажиллаж байгаа гэдгийг онцолж хэлмээр байна.

Тэгэхээр цацрагийн дүн шинжилгээ тоо, мэдээлэл дээр хортой хоргүй гэхээс илүүтэйгээр фон буюу дэвсгэр түвшин гэж яригдаад байна. Мөн тэрнээс гадна цацрагийн аюулгүйн норм болоод бусад Монгол Улсын зарим нэг стандартад дурдагдсан стандартын хэмжээний зөвшөөрөгдөх хэмжээнээс их үү, бага уу гэдэг талаар яригдаж байгаа юм. Хортой хоргүй, хордлогод орох тун, үхэлд хүргэх тун гэдэг зүйлүүд бол яг энэ дээр яригдах боломжгүй байгаа юм. Хэрэв хүсвэл дараа нь тооцооллыг нь хийж харуулах боломжтой гэсэн үг.

Тэгэхээр буруу, ташаа мэдээлэл өгсөн, худлаа хоргүй гэсэн гэдэг зүйлийг маш олон иргэдээс сонслоо л доо. Энэ слайд магадгүй маш богино хугацаанд гараад өнгөрчихсөн, дотроо олон датаг агуулчихсан байсан учраас хэт хурдан өнгөрөөд ойлгомжгүй, ойлгогдоогүй өнгөрсөн байхыг үгүйсгэхгүй юм. Би зориуд энэ слайдыг гаргууллаа. Тэгэхээр цацрагийн тогтоогдсон нөхцөл байдал буюу 2012-2025 оны хооронд төрийн байгууллагууд буюу хуучнаар Цөмийн энергийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, тэр дундаа Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын байцаагчдын гаргасан дүгнэлт, мөн олон улсын жишээ нь Австрали Улсад итгэмжлэгдсэн лабораторид хүргүүлсэн дээжийн шинжилгээнүүд, төсөл хэрэгжүүлэгч байгууллагын нөлөөллийн үнэлгээнд хийгдсэн үнэлгээ, судалгааны дүнгүүд, дээр нь сүүлд 2025 оны 8 сарын олон улсын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын дата, мэдээллүүд дээр дүн шинжилгээ хийж ажилласан.

Дүн шинжилгээг хөрсний дээжид агуулагдаж байгаа хэмжээ, гамм цацрагийн тунгийн чадлын хэмжээ, ус болон агаарын стандартад зөвшөөрөгдсөн хэмжээнээс дээшээ юу доошоо юу гэдэг үзүүлэлтүүдийг харуулсан байгаа. Тэгэхээр энэ улаанаар тэмдэглэсэн зүйлүүд бас яг нарийн сайн харагдахгүй байж магадгүй. Ер нь энэ дээр ингэж тэмдэглэсэн.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Цагтаа амжсангүй. За төсөл хэрэгжүүлэгч 5 номер хариулт өгье.

“Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-ийн гүйцэтгэх захирал А.Цолмон: Хамтын гэрээний тухай асуулаа. Манай компани төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс 2022 онд Мянгад сумын удирдлагуудад хамтын гэрээний анхны саналыг хүргүүлж байсан байдаг. Үүнээс хойшоо багуудын хурлаар хэлэлцэгдээд явсан гэж би ойлгодог. Одоогоор хамтын гэрээ аймаг болон сумтай байгуулж чадаагүй байгаа. Гэхдээ хайгуул судалгааны ажлын хүрээнд ийм хэмжээний үйл ажиллагаанууд руу чиглэсэн ажлуудыг хийх боломжтой гэдэг саналаа хүргүүлсэн. Хамгийн сүүлд 2025 оны хайгуулын ажил эхлэх үеэр Мянгад сумын Засаг даргад манай санал хүчинтэй хэвээр байгаа гэдгийг албан ёсоор мэдэгдэж бичгээр хүргүүлсэн байгаа.

Ямар бүтээгдэхүүн гаргах гээд байна вэ гэж байна. Түүхийгээр нь гаргах гээгүй, түүхийгээр нь гаргах боломжгүй. За баяжмал гаргах эхний төсөөлөл байсан. Үүнээс цаашаа дахиад нэг шат ахисан нийлмэл исэл гэдэг бүтээгдэхүүн гаргах зорилттой явж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: С.Замира гишүүн тодруулах уу? Зөрчлийн хуулиар хэдэн хүнд торгуулийн арга хэмжээ авах хүсэлт өгөөд, хэдэн хүнд торгуулийн арга хэмжээ авсан талаар мэдээлэл надад ирсэн байгаа. Би түүнийг танд танилцуулчихъя. Энхбатын Болормаа гишүүн асуулт асууна.

УИХ-ын гишүүн Э.Болормаа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр мэдээлэл өгсөн бүх хүмүүстээ баярлалаа. Ховд аймгаас болон бусад газраас зорин ирж өнөөдрийн хэлэлцүүлэгт орж байгаа бүх иргэддээ баярлалаа гэж хэлье. Юуны өмнө өнөөдрийн иргэдийн хэлж байгаа санал дээр нэг зүйл маш тодорхой харагдаж байгаа болов уу. Энд ямар нэгэн зохион байгуулалттай эсэргүүцэл, шантааж гэсэн зүйл огт байхгүй. Яг нутгийн иргэд нутгаа хамгаалах зорилгоор ирсэн байгаа гэдгийг маш сайн ойлгосон байх гэдэгт найдаж байна.

Надад хэд хэдэн асуулт байна. Иргэдийн тавьсан асуултаас хүргээд өөрөө бас хэд хэдэн асуулт асууя гэж бодож байна. Энэ зөвхөн нэг ордын талаар яриад байгаа гэж битгий хараарай. Бид нар бүх уул уурхайн төслүүдээ УИХ дээр сонсгол хийх юм уу гэх мэтчилэн зарим нь хэлж байна л даа. Энэ зөвхөн Ховд аймгийн Мянгад сумтай холбоотой асуудал огт биш. Монгол Улс газрын ховор элемент дээр ямар бодлоготой байх юм, уул уурхайн өгөөж иргэдэд очиж байна уу, орон нутагтайгаа яаж хамтран ажиллах юм гэх мэтчилэн Монгол Улсын хөгжлийн суурь асуудлууд энд бүгдээрээ хөндөгдөж байгаа.

Тэгэхээр энэ Монгол Улсын бүх иргэдэд хамаатай, бүх төр засгийн байгууллагуудад хамаатай. Энэ салбарын сайд нар нь хаана байна? Яагаад газрын ховор элементийн ганц төсөл нь яригдаж байхад, энд иргэд эсэргүүцэл илэрхийлээд амь насаа тавин үүнийг эсэргүүцнэ гэж байхад салбарын сайд нь тэнд Солонгост энийг хийнэ гээд дураараа форм хэсээд явж байх юм. Эхлээд эх орондоо энэ асуудлаа шийдээд гарцыг нь олоод хамтдаа ярилцаад суух ёстой байтал юугаа хийгээд тэнд Солонгост худлаа амлалт хэлээд явж байгаа юм бэ? Би ерөөсөө энийг ойлгохгүй байна. Энэ асуудлыг иргэд, ААН-ийн хооронд орхиж болохгүй. Төр засаг бодлогоо гаргах ёстой. Төр засаг бодлогоо гаргаагүйгээс болж энд нутгийн иргэд, ААН-д ажиллаж байгаа монгол хүний амь насанд аюул үүсээд байгаа. Энэ аль алиных нь буруу биш. Төр засаг бодлогоо гаргаагүйгээс болж иргэд, ААН хооронд ийм асуудал үүсгээд байгаа юм. Би нэг зүйлийг гайхаж байна.

Сая энэ ААН-ийн хэвлэлийг хариуцдаг хүн нь би Эдийн засаг хөгжлийн яамны газрын дарга гээд өөрийгөө танилцуулаад ороод ирж байх юм. Төрийн албаны босго ийм нам болчихсон юм уу? Иймэрхүү газрын дарга энд ирээд сууж байхад яаж эдийн

засаг хөгжих юм. Улс төржүүлээд АН сайхан, МАН муухай гээд юу яриад байгаа юм бэ? Энд бид Монгол Улсын ирээдүйг ярьж байхад. Энэ ААН та бүхэн өөрсдөөсөө алдаагаа эрэх ёстой.

Өнөөдөр энэ төслийг эсэргүүцсэн хүн болгоныг мангар, тэнэг, мулгуу гэж хэвлэлээр та нар бөмбөгдөх ажлыг зохион байгуулж байгааг би мэдэж байна. Энэ төслийг магтсан хүн болгоныг ийм сайхан ухаантай суут хүн байхгүй мэт ярьж байна. Та нар энэ хэлэлцүүлгүүдэд иймэрхүү байдалтай, хандлагатай оролцсоноос болж өнөөдрийн түвшинд ирсэн байгаа шүү. Энэ ААН энийгээ маш хариуцлагатайгаар анзаарах ёстой.

Одоо хамгийн гол шийдлээ бид ярих ёстой. Энэ төр засгийн байгууллагууд асуудалдаа хариуцлагатай хандмаар байна. Энэ лицензийн асуудлыг ярья. Ашиглалтын лицензтэй энэ байгууллага хайгуул хийгдэж дуусаагүй байтал яагаад ашиглалтын лицензээр хайгуул хийгээд байгаа юм бэ? Энэ дээр өмнөх хуулиараа ингэж зохицуулдаг байсан юм гэдэг хариултыг өгөөд байгаа юм л даа. Гэхдээ энэ хуулийн хийдлээ засах тал дээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам ямар байр суурьтай байдаг юм бэ? Энэ лицензийн талаар би онцгойлон асууя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2011, 2015 онд аль алинд нь ийм зарлиг гарсан байгаа. Цацраг идэвх, ашигт малтмал, таслал, газрын ховор элемент, газрын тосыг ашиглахтай холбогдсон бодлогын асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газарт чиглэл болгосугай гэсэн байна. 2011, 2015 оноос хойших Халзан бүрэгтэй дээр олгосон лицензүүдийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлсэн үү? Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу хэлэлцүүлсэн үү?

Нэмээд иргэдээс ирсэн асуултыг асууя. Лицензтэй талбайд соёлын өвийн судалгаа хийгдсэн үү? Ашиглалтын тусгай зөвшөөрлөө Цөмийн энергийн хуульд заасан нөхцөл журмын дагуу шинэчлэн бүртгүүлсэн үү? Үүнийг Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2023 оны тайлан хүргүүлэх тухай албан тоотод тусгасан байгаа. Дараагийн асуулт нь хаягдал бохир усны талаар юм байгаа юм. За ингээд Усны газраас асууж байна. Хаягдал усны стандартын шаардлагаа хангаж байгаа юу? Энэ дээр судалгаа хийсэн үү?

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Эхлээд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, дараа нь Усны газар, төсөл хэрэгжүүлэгч. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам хариулах асуудал байгаа юу?

Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул ашиглалтын газрын дарга С.Ган-Очир: Гишүүний асуултад хариулъя. Хайгуулын үйл ажиллагаа ер нь төслийн бүх шатад хийгдсээр л байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулж болохгүй гэсэн хууль байхгүй. Сая гишүүн хэллээ. Сайжирсан гэсэн яаж сайжирсан юм бэ гээд. 2011 оноос аль болох нөөц нь бүрэн тогтоогдсон орд дээр ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох зохицуулалт хийсэн. Ордын нөөцийн тайлан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэгдсэний дараа ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогддог зохицуулалт одоо үйлчилж байгаа. Геологи уул уурхайн талаасаа бол хайгуулын үйл ажиллагаа ордыг бүрэн ашиглаж дуусан дуустал үргэлжилсээр л байдаг. Байнга нөөцийнхөө зэрэглэлийг ахиулдаг, нөөцийнхөө үнэн бодит байдлыг бататгадаг ийм хайгуулын ажиллагаа үргэлжилж байдаг гэдгийг хэлмээр байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч гэдэг утгаараа олборлолтын үйл ажиллагаа явуулах эрхтэй. Гэхдээ эхлүүлэхийн өмнө ТЭЗҮ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг бүрэн боловсруулж холбогдох зөвлөлөөр хэлэлцүүлж баталгаажуулсны дараа үйл ажиллагаа явуулах эрх нь үүснэ. Баталгаажна гэсэн үг. ТЭЗҮ-ийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлдэг. ТЭЗҮ-ийг хэлэлцүүлсэн талаарх асуудлыг шинжээч өглөө танилцуулсан. Хэлэлцүүлсэн гэсэн үг. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тухайд бол Энхмөнх дарга бас нэмж хэлэх байх.

Усны газрын дарга 3.Батбаяр: Усны газраас ус ашиглуулах боломжит нөөцийн дүгнэлт гэж гаргадаг. 2022 онд гаргасан байгаа. Энэ дүгнэлтийг компани дахиж гаргана. Яагаад гэвэл 70 литр секундээр тооцож байсан. Одоо та бүхэн 300 литр секундээр байж байгаа учраас дахиж гаргана. 2 дугаарт нь ашиглалт буюу бид нарын ярьдаг усны томоохон хэмжээнд ашиглалт буюу олборлолт үйлдвэрлэл эхэлсэн үед жил болгон ус ашиглуулах дүгнэлт гаргах ба тэнд хэмжээгээ тавиад явна. Ашигласан усаа хаяж эхэлсэн, байгальд нийлүүлж эхэлсэн цагт нь хаягдал усны дүгнэлт гаргаад ингээд усны асуудлыг 3 дүгнэлтээр цаашдаа явна.

Э.Болормаа гишүүний асуусан асуулт бол яг одоо хаягдал усны шаардлага хангаж байгаагүй юу гэдэг асуудал байгаа байх. Одоогийн байдлаар кемпэд хүмүүс амьдарч байгаа учраас тэндээс хаягдал ус гарна. Тэр нь бол 15м³ хоног байна. 2019 оны тушаалаар баталсан хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ гээд заасан байгаа. Энэ жишиг хэмжээ 7 хоногийн өмнө өөрчлөгдсөн байгаа учраас одоо дахиад нэмэгдэх байх.

Хайгуулын өрөмдлөгийн тухайд өрмийн хошууг халахаас сэргийлэх, өрөмдлөгийн шавар, шламыг татаж гаргах, тээвэрлэх, цооногийн ханыг бэхжүүлэх зорилгоор ус ашигладаг. Яг энэ усны чанарын сорьцын шинжилгээг авах боломжгүй байдаг. Яг өрөмдлөг хийж байгаа тохиолдолд. Тэгэхээр одоохондоо бид ийм байдалтайгаар хаягдал усны дүгнэлтээр төлбөр ноогдуулж байгаа. Үйлдвэрлэл эхэлсэн үед ус ашигласан төлбөрөөс дутахгүй хэмжээний хаягдал усны дүгнэлт гарна шүү гэдгийг урьдчилаад хэлчихье.

“Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-ийн гүйцэтгэх захирал А.Цолмон: Манайхаас соёлын өвийн судалгаа хийлгэсэн үү гэсэн асуулт байх шиг байна. Бид 2023 онд одоо ШУА-ийн Түүх ус угсаатны зүйн хүрээлэнгээр Соёлын өвийн судалгааг хийлгэсэн байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Э.Болормаа гишүүн тодруулах уу?

УИХ-ын гишүүн Э.Болормаа: Устай холбоотойгоор би нэг зүйлийг хэлье. Өнөөдрийн хяналтын сонсгол Халзан бүртгэй орд газрын ашиглалт байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах сэдэвт ерөнхий хяналтын сонсгол байгаа. Өнөөдрийн танилцуулгууд дээр ажилласан хүмүүстээ баярлалаа. Гэхдээ маш хангалтгүй мэдээлэл байна. Яг үнэнийг хэлэхэд.

Энэ нарийвчилсан судалгаа гэдэг бол зүгээр наад захын би интернэтэд ороод юм судлахад энэ байтугай мэдээлэл гарч ирж байна л даа. Бид нарыг энэ мэдээллийг мэдэхгүй мангар, тэнэгээр дуудаад байна л даа. Жишээлбэл Харвардын олон улсын тойм сэтгүүл дээр яг энэ газрын ховор элементийн байгаль орчин дахь сөрөг нөлөөллийн талаар 2021 онд ийм мэдээлэл гарсан байна. Би монгол орчуулгаас нь

та нарт нэг л юмыг уншиж үзүүлбэ. Олборлолтын явцад нэг тонн газрын ховор элемент тутам 13кг тоос, 9600-аас 12 мянган шоо метр хаягдал хий, 75 шоо метр бохир ус, 1 тонн цацрагт идэвхт бодисын үлдэгдэл гардаг. Ерөнхийдөө 1 тонн ховор элемент гаргах тутам 2 мянган тонн хорт хаягдал гардаг. Өнөөдөр бид нарын ярьж байгаа асуудал монголчууд бид энэ төлөөсийг төлөөд газрын ховор элемент гаргахад бэлэн байна уу? Бусад улс орнууд магадгүй БНХАУ энэ төлөөсөө төлөөд, технологи байна. Бид энэ төлөөсийг төлөхөд бэлэн байгаа юм уу? Энэ дээр нарийвчилсан судалгаа үнэхээр хангалтгүй байна. Манай мэргэжлийнхэн энэ дээр нэмж заавал судалгаа хийх ёстой. Өнөөдөр энэ хяналтын сонсгол сэдвийнхээ зорилгод хүрч чадахгүй байна. Халзан бүрэгтэйтэй, бүрэгтэйгүй тэнд айфон, приус үйлдвэрлэгдээд л явна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Э.Болормаа гишүүн тодруулах уу? Э.Болормаа гишүүн надад хандаж хэлж байна уу? Нарийвчилсан судалгаанууд байгаа. Хуулиар олгогдсон хуралдааны дэг 10 минут байна. Энд танилцуулах гээд нэлээдгүй хумьж, би өөрөө шүүж харж байгаад танилцуулсан. Энэ шинжээч нараар хийлгэсэн нарийвчилсан судалгааг танд хүргүүлбэ. Үндсэндээ нэг портер хэртэй судалгаа байгаа. Тэрийг бүгдийг нь уншиж танилцуулна гэвэл хэдэн өдөр суух болох байх. Тэрнээс 10 минутад багтах нь их цөөхөн байлаа гэдгийг хэлбэ. Өнөөдрийн хийсэн мэдээллүүдийг бүгдийг нь авч болно. Энийг ерөөсөө нууж хаагаад байх юм ерөөсөө байхгүй. Би Э.Болормаа гишүүнд өөрөө материалаа хүргүүлчихбэ. Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууна.

УИХ-ын гишүүн Ж.Золжаргал: Өнөөдөр бид нар сонсгол хийж байгаа. Тэгэхээр ер нь сонсох гэж гол нь энд ирсэн шүү дээ. Би ч бас химийн технологийн хүн сонсох гэж нэлээн л хичээлээ. Хамгийн гол хариултуудыг авахад хэцүү байна. Маш олон мэдээлэл толгой эргүүлээд байна. Тэгээд 2 талаасаа сонслоо. Иргэдийг сонслоо. Ямар нэгэн байдлаар бид нэг чухал юм явуулах гэхээр бослого гардаг, гадна, дотнын гар хөл гээд л ярьдаг. Үнэхээр сэтгэлээсээ ярьж байгаа хүмүүсийг тэгж болохгүй нь мэдээж. Яг тэндээ аж амьдрал нь, мал ахуй нь, хамаг юм нь, нутаг ус нь ойртсон хүмүүсийн сэтгэлийн үг. Яагаад ингэж байна гэхээр асуудал тодорхой биш байгаад байна. Их олон зүйл тодорхойгүй байна.

Тэгэхээр сонсгол дээр тодорхой тоог сонсох хэрэгтэй. Сонссон тооноосоо хэдийгээр миний үүрэг биш ч гэсэн би дүгнэж хэлбэ гэж бодож байна. Нөгөө талдаа бид нар бодлого яриад байгаа хүмүүсийг бас сонсох хэрэгтэй. Монгол Улсад энэ газрын ховор элемент гэдэг дэлхийд ховор зүйл гайгүй хэмжээгээр байгаад байна. Хэзээ ч бид нар олборлож, ашиглаж байгаагүй. Энэ бол маш чухал. Манай улс Орос улс, Хятад улсын дунд байдаг улс. Манай 2 хөрш харин ч хүлээцтэй, стратегийн хамтрагч, том бодлоготой улсууд тулдаа тун аятайхан ханддаг. Гэхдээ бид нар тусгаар улс учраас бид нарт өөрийн бодлого хэрэгтэй. Гуравдагч улсын оролцоо, хөрөнгө оруулалт хаана байна? Одоо хамгийн гол юм бол иймэрхүү ховор, үнэтэй алт, ховор элемент иймэрхүү зүйлүүд дээр орж ирнэ. Тэгэхээр бид нар ялангуяа гуравдагч улсуудыг оруулж ирэх нь Монголын үндэсний эрх ашиг мөн. Үндэсний эрх ашгаа бодоод тэнд байгаа хүмүүсийг бид нар хөсөр хаяж болохгүй. Тэгэхээр тэнд байгаа хүмүүсийн хүлээлтэд таарсан хариултыг нь өгмөөр байгаа юм. Тэгээд хариулт өгөхийн тулд яах вэ.

Одоо энэ сонсгол ингээд явна дараа нэг ажлын хэсэг гарч таарах байх. Тэгэхээр хариултыг нь тодорхой өгчихмөөр байна. Хандлага бол ийм байгаа юм. За хайгуул хийж байгаа, олборлолт явуулах гээгүй, хайгуул хийж байхад нэг их айхтар хор хохирол учрахгүй, түрдээ тайван байж бай гээд. Ингэхээр энэ хүмүүс чинь тайван байхгүй байна, тайвшруулах гэж оролдовч тайвшрахгүй санаа нь зовоод байна. Одоо

эндээ эвлэрэх хэрэгтэй. Тийм болохоор хайгуул дуусна. Хайгуулыг ашиглах гэж явуулдаг. Ашиглалтын явцад хэчнээн тонн хүдэр гаргаж ирээд баяжуулаад, баяжмалаа зарчихлаа үлдэгдлийг нь овооллоо, тэр нь ямар хэмжээний цацраг идэвхтэй, орчиндоо яаж нөлөөлөх, хэдэн километр радиус татах юм, малд хортой юм уу, хүнд хортой юм уу гээд тодорхой хэлэх хэрэгтэй. Тэр мэдээлэл нь ТЭЗҮ хийсний дараа, нарийн тооцоо гарсны дараа гардаг нь үнэн. Гэхдээ ижил төстэй төслүүд байгаа. Ажлын хэсэг гарч байгаад тэр загвараар нь иргэдийг маш тодорхой мэдээллээр хангамаар байна. Тэр нь хэрвээ хүлээн зөвшөөрөхөөргүй байх юм бол тэгээд зогсоно шүү дээ. Яагаад болдоггүй юм? Хамгийн гол нь энэ нэг маргаан чинь ингэж явсаар байгаад лицензийн ашиг сонирхлын зөрчил үүсгээд, тэр нь Монгол улсын ховор элементийн хөгжлийг булшлах иймэрхүү хортой үр дагаварт хүрч болохгүй.

Би сонсгол дээрээс авсан танилцуугаас хэдэн тоог та бүхэнтэйгээ хуваалцъя гэж бодож байна. Хэдийгээр мэргэжлийн хүмүүс хүний тоон дээр дураараа хэлж болохгүй боловч бид баримжаа авах хэрэгтэй байна.

Нэгдүгээрт нь энд байгалийн цацрагийн түвшнийг нэг хэсэг ярьсан. Байгалиасаа байж байдаг.

Хоёрдугаарт нь газрын ховор элементийн хүдрийг олборлоод баяжуулах явцад цацраг идэвхжилийн асуудлууд байна. Танилцуулгаас авсан тоогоор байгалийн цацраг идэвхжилт Халзан бүрэгтэй орчимд хамгийн өндөр нь 1.67 гэдэг тоо гарчээ. Та бүхэн сайн тэмдэглэж аваарай. Энэ нь Монголын дундаж түвшнээс 8 дахин өндөр гэж байгаа юм. Энэ бол байгалийнх. Тэгсэн чинь Дорнодын Мардай ураны ордтой хэсэгт 4.8 байна. Зөөвч овоо 6.3 байна. Хамгийн өндөр цэгүүдийг нь хэлж байгаа шүү. Дархан хот 3.1% буюу Халзан бүрэгтэйгээс 2 дахин. Тэгэхээр Халзан бүрэгтэй орчимд гарч ирсэн хамгийн өндөр тоо Дарханаас 2 дахин бага, Зөөвч овоогоос 4 дахин бага, Мардайгаас 3 дахин бага байна шүү.

Гуравдугаарт нь олборлолт явах нь ээ. Тэр доор байгаа хүдэр дотор агуулагдаж байгаа ураны хэмжээ 0.01% юм байна. Энэ танилцуулгаас харахад. Мардай хэд вэ гэхээр 0.1%. Өөрөөр хэлбэл 10 дахин өндөр. Зөөвч овоо Арнагийн 0.02% юм байна. Мардайгаас бага тэгэхдээ Халзан бүрэгтэйн агууламжаас 2 дахин. Мардайгийн хамгийн бага агуулгатай эдийн засгийн ач холбогдолтой гэж үздэг нөөц батлахдаа тооцсон захын агуулга нь 0.01 буюу Халзан бүрэгтэйтэй адилхан юм байна.

Өөрөөр хэлбэл Халзан бүрэгтэйн үндсэн баялаг бол ховор элемент мөн. Гэхдээ тэр хүдэр дотор агуулагдаж байгаа уран бол үйлдвэрийн ач холбогдолтой хүрэхүйц хэмжээний уран байна. Тэгээд гаргаж ирээд олборлоод баяжуулчихлаа. Бүтээгдэхүүн буюу ховор элементтэй баяжмал гарна. Баяжмалдаа ихэнх уран нь орчихно. Тэгээд баяжмал доторх нь 0.07% болж байна. 7 дахин өсөж байна гэсэн үг. Тэгэхээр ихэнх уран чинь баяжмалтайгаа явах нь байна. 0.01 хүдрээ олборлочхоод хаягдал гарна шүү дээ. Тэр нь бараг хүдэртэйгээ адилхан. Арай жоохон бага. Баяжмалын хэмжээ нь бага учраас ураных нь агуулга нь хүдэртэйгээ тун ойролцоо хэмжээний хаягдал үүснэ.

Тэгэхээр газрын доор байгаа цацраг идэвхтэй бодисыг гаргаж ирээд тавьчихаар цацраг идэвхтэй юм болно оо доо. Тэрнээс нь хүмүүс айгаад байгаа байх. Тэгэхээр тэр нь 0.01-ээс арай бага буюу 0.09 энэ тэр гэсэн тоо байгаа. Энэ хүний эрүүл мэндэд хэр хортой юм? Энэ малд хэр хортой юм? Энийг яаж саармагжуулдаг юм? Яаж энэ төсөл дээр саармагжуулах гэж байгаа юм? Ер нь зөвшөөрч болох юм уу

үгүй юү? Ийм тоонуудыг мэдмээр байгаа юм. Тэгэхээр энэ цөөн хэдэн тоог хэрвээ одоо өгч болохгүй бол энэ сонсголын дараа ажлын хэсэг гарч байгаад маш тодорхой болгох хэрэгтэй. Ижил төстэй нөгөө Хотгорын ордын баяжмалын үзүүлэлт дээр баяжмал нь 0.07-той, хаягдал нь 0.01 хувьтай байна гэж ярьж байгаа шүү. Тэгэхээр энэ дээр тийм туршилт хийгээгүй гэж байгаа юм. Тэгэхдээ энийг чинь хүмүүс яв цав мэдэх албагүй, юу болох гээд байгааг л мэдэх хэрэгтэй байгаа. Ийм мэдээлэл өгөөд асуултаа асуучихъя.

Асуулт нь Халзан бүрэгтэй хавийн байгалийн цацрагийн цэгүүд байна. Мөн Дархан энэ тэр гээд ярилаа. Тэгэхээр энэ хэд байвал хүн амьдрахад саадгүй гэж үздэг юм бэ? Тийм тоо байна уу? Хэдэн микро зиверт цаг. Хоёдугаарт нь гаргаад ирлээ, баяжуулчихлаа, баяжуулсан хаягдсан чулуугаа овооллоо тэрэн дотор нь хэд байх юм? Ямар хэмжээний цацраг, техникийн үзүүлэлт нь байх юм? Хэд байвал зөвшөөрч болох юм, яаж саармагжуулдаг юм гэсэн асуултууд байна.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Шинжээч нараас Эрдэнэболдын Цэрэнчимэг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Салбарын хяналтын газрын Цөмийн болон цацрагийн хяналтын ахлах мэргэжилтэн.

Шинжээч Э.Цэрэнчимэг: Цацрагийн чиглэлийнхээ асуултад буюу эхний асуултад хариулъя. Аливаа цацрагийг ер нь байгалийн болон зохиомол гэж хоёр ангилж байгаа. Тэгэхээр зохиомол гэдэг нь та бидний мэдэх рентген тоног төхөөрөмжөөс авхуулаад хамгийн ойрын жишээ бол энэ доор байгаа та нарыг оруулахад шалгасан рентгенүүд. Тэгвэл цацрагийн дэвсгэр түвшин буюу фоныг нь хаана ярьдаг вэ гэхээр байгалийн цацраг идэвхтэй изотоп дээр ярьдаг. Зөвхөн ураныг тооцохгүй. Уран, тори, кали, ради, радион гээд дагалдах олон изотопууд байж байна. Тэгэхээр энэ дээр байгалиасаа цацрагийн дэвсгэр түвшин буюу яг фон нь өөрөө байгалиасаа тогтцоосоо ийм өндөр байдаг цэгүүд байна.

Өмнө нь тэр слайд дээр харсан бол олон улсын жишээнүүдийг болон одоо иргэдийн хамгийн их төөрөгдөөд байдаг ураны орхигдсон уурхай Мардайн уурхай буюу өшөө мөн Дорноговийн Зөөвч овоотой харьцуулсан үзүүлэлтүүд байж байгаа юм. За түрүүн онцолж байна. Дарханы алтны уурхайн технологийн дамжлага дахь алтны тунгаагуурын ялгарсан шорооноос илэрсэн тийм цэгүүд.

Яг энэ онцолж нэг ёсондоо Монгол болоод олон улсад илэрсэн цэгүүдтэй харьцуулсан үзүүлэлт байгаа юм. Монгол орны дэвсгэр түвшин 0.02 микро зиверт цаг гэж тооцоологддог. Дэлхийн хэмжээнд улс орон болгон дэвсгэр түвшин нь өөр өөр байдаг. Яагаад гэхээр тэр байгалиасаа тухайн орон нутгийн газар зүйн байрлал болоод газар доор агуулагдах эрдэс бусад газар зүйн байрлал тогтцоосоо хамаараад ялгаатай байдаг. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Т.Аззаяа, 8 дугаар микрофон үргэлжлээд хариулъя.

Шинжээч Т.Аззаяа: Ж.Золжаргал гишүүний асуусан хаягдалтай холбоотой асуултад хариулъя. Энд онцолж хэлэхэд Халзан бүрэгтэй ордын хувьд баяжуулалтын болоод баяжмалыг гүн боловсруулах ямарваа нэгэн нарийвчилсан судалгаа хийгдээгүй байгаа. Тийм учраас би үдээс өмнөх илтгэл дээрээ энэ орд дээр нарийвчилсан судалгааг маш сайн хийх шаардлагатай гэдгийг дахин онцолж хэлж байна. Эхлээд хүдрийг баяжуулах процессын үед хаягдал гарна. Тэр хаягдлыг хаягдлын санд агуулах байгаа.

Тэгэхлээр хаягдлын санд агуулагдаж байгаа хүдэр хүдэрт агуулагдах ураны агуулга хүний эрүүл мэнд, байгаль орчинд хэрхэн нөлөөлөх вэ гэхлээр ер нь Монгол Улсын хувьд бол хаягдлын санд уран, торийг стандартчилчихсан тоо хэмжээ байдаггүй. Олон улсын жишгээр Хятадын Баян-Овоо ч гэдэг юм уу, Америкийн Маунтинг Пасс дээр хийсэн туршлагаас харахад хаягдлын санд агуулагдаж байгаа уран, торийгоос ялгарах цацрагийн радиац хяналтаас чөлөөлөгдөх цацрагийн аюулгүй норм гэж байдаг. Тэр нь уран, тори аль аль нь мянган бекерель/килограмм байдаг.

Хэрвээ тэрнээс өндөр агуулагдах юм бол тухайн хаягдлын санг хаах, бетоноод булах, нөхөн сэргээлт хийх зэрэг арга хэмжээ авдаг. Хэрвээ тэр мянган бекерель/килограммаас доош хэмжээтэй байх юм бол хүний эрүүл мэндэд харьцангуй нөлөөлөх нөлөөлөл байхгүй. Энэ нь зөвшөөрөгдөх хязгаараас доош байгаа учраас байгалийнхаа жамаараа байж байна гэсэн ийм туршлага байдаг.

Монгол Улсын хувьд газрын овор элементийн ордыг олборлох, хүдрийг боловсруулах, баяжмал гаргаж авах, баяжмалыг гүн боловсруулах процесс явагдаагүй байгаа. Тийм учраас өмнө нь маш сайн нарийвчилсан судалгаа хийнэ. Нарийвчилсан судалгаа хийснээр уран, тори хаягдалдаа, баяжмалдаа цаашлаад баяжмалыг боловсруулах, гүн боловсруулалтын үеэр гарах хатуу, шингэн хаягдалд хэрхэн хуваарилж дархалж байгааг нарийвчлан судална.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Ж.Золжаргал гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн Ж.Золжаргал: Миний бодлоор сонсголын бас нэг үр дүн нь гарч ирж байна. Юу гэхээр тодорхойгүй байна. 2 тоо тодорхойгүй байна. Ерөөсөө байгалиасаа цацраг идэвхжил угаасаа өндөр нам байдаг нь ойлгомжтой. Гэхдээ хэдээс илүү байх юм бол хүнд урт удаан хугацаанд амьдрахад муу гэж үздэг юм бэ? Үнэхээр тийм шалгуур байдаггүй гээд сая хэллээ. Тэгэхдээ энийг нягтлах, мэдэх хэрэгтэй. Тэгээд танай нутагт байгаа тэр 1.67 гэдэг тоо тийм аймаар тоо юм уу үгүй юм уу гэдгийг бас мэдчих хэрэгтэй.

Хоёдугаарт нь олборлолт явна, гаргаж ирээд овоолоод тавилаа. Хаягдал нь хэр их хэмжээний цацрагтай байх юм. Энийг ТЭЗҮ хийсэн, нарийвчилсан тооцооны дараа гэх юм бол хэзээ ч дуусахгүй шүү. Энэ бол маш удаан хугацааны нарийн ажлууд лаборатори шинжилгээ хийнэ. Тэгэхдээ баримжаа мэдэх гээд байгаа шүү дээ. Баримжаа мэдэхийн тулд ижил төстэй ажлын технологийн шийдлүүд нь тэр, хэчнээн хэмжээний цацраг идэвхжилд гарч болно, тэрийг бол ингэж саармагжуулна эсвэл энэнээс тэдэн...

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Б.Баярбаатар: Санал уу? За баярлалаа. УИХ-ын гишүүн Загджавын Мэндсайхан асуулт асууна.

УИХ-ын гишүүн З.Мэндсайхан: Та бүхэнд энэ оройн мэнд хүргэе. Юуны өмнө Ховд аймгийн Мянгад сумын иргэдийн өмнө тулгамдаад байгаа асуудлыг хэлэлцүүлэг зохион байгуулж иргэдийн маань дуу хоолойг сонсож байгаа та бүхэндээ, Улсын Их Хурлынхаа Тамгын газарт баярлалаа. Тэгэхээр иргэдийнхээ асуулт болон өөрийнхөө асуултуудыг нэгтгээд асуучихъя гэж бодож байна.

Шинжээчдээс маш тодорхой асуулт байна. Ер нь энэ нээлттэй хэлэлцүүлгийн үндсэн зорилго асууж байгаа асуултыг нь та бүгд мухарлаад өгөөч гэдэг асуулт байгаа юм. Тэгэхээр иргэд маань ирээд ийм л юм яриад байна шүү дээ. Нэгдүгээрт байгалийн

цацраг, Үйлдвэрлэлийн явцад үүсдэг үүсмэл цацраг гэдэг зүйл нэг яриад байна. Би цацрагийг мэргэжлийн хүн биш учраас бас өөрөө судлаад л байна. Тэгэхээр байгалийн цацраг гэдэг түрүүний Ж.Золжаргал гишүүний асуугаад байгаа шиг ямар хувь хэмжээтэй байдаг юм? Халзан бүрэгтэй дээр гараад байгаа цацраг байгалийн цацраг юм уу, хайгуулын ажлаас үүдэж дэгдээд байгаа цацраг юм уу? Энэ нь иргэдэд ба иргэдийн эрүүл мэндэд хортой юм уу? Энэ дээр хариулт өгөөч ээ. Тэгэхгүй зөвшөөрөх түвшнээс тэд байна, эд байна гээд яриад байхаар наадхыг чинь бид нар яг үнэндээ ойлгохгүй байна. Тэгэхээр иргэдэд маань маш тодорхой хэлж өгөөч, мухарлаж өгөөч.

Хоёрдугаарт Мал эмнэлгийн ерөнхий газар, мал эмнэлгийн хүрээлэнгээс ургийн гажигтай гараад байгаа тал дээр иргэд маань судалгаа хийгээд ирсэн байна шүү дээ. Сүүлийн 8 жилийн хугацаанд зөвхөн Ховд аймгийн Мянгад сумд 8 жишээ давтагдлаа. Ургийн гажиг тэгэхээр бусад сумд гарахгүй байна. Бусад сум одоо нуугаад, хаачихлаа гээд та нар янз бүрээр тайлбарлаад байгаа шүү. Тэгвэл энийг та нар яг цацрагаас болж байгаа эвсэл үгүй гэдгийг дүгнэлтээ гаргаж өгөөч.

Цацрагийн түвшин зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна гээд дүгнэлт гаргачхаад энийг бид нар цаашаа судлах боломжгүй байна гээд байна. Энийг хаана судалж болох юм. Энэ дээр маш тодорхой хариулт өгөөч. Энийг мухарламаар байна. Энэ 2 асуултыг мухарлах юм бол бид нар энэ үйл ажиллагаа бид нарын эрүүл ахуй аюулгүй орчинд нөлөөлөхгүй юм уу нөлөөлж байгаа юм уу гэдэг дээр бид нар бас ойлголттой болмоор байна. Хоёрдугаарт энэ уул уурхайн 2 сайдад би тодорхой хүсэлтүүд тавьж байсан. Ц.Туваан сайдад ч тавьж байсан. Г.Дамдинням сайдад тавьсан. Яг иргэдтэй очоод хамт уулзалт хийе, энэ асуудлыг сонсьё, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам нээлттэй мэдээлэл өгөөч гэж. Энэ дээр бол их хариуцлагагүй хандаад байгаа юм.

Тэгэхээр би Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас юу асуух гээд байна гэхээр энэ газрын ховор элемент чинь Цөмийн энергийн тухай хуулиар явах юм уу, Ашигт малтмалын тухай хуулиар явах гээд байгаа юм уу. Одоо ярихаараа дандаа цацраг ярьж байна. Эндээс би ойлгохдоо энэ Цөмийн энергийн тухай хуулиар явах юм байна гэж ойлгож байна. Хэрвээ энэ хуулиар явбал илүү нарийн зохицуулалттай асуудал.

Түрүүн Э.Болормаа гишүүний хэлдэг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хэмжээнд явах ийм асуудал болоод явна. Одоо явж байгаа нь Ашигт малтмалын тухай хуулиар яваад байгаа. Яригдаж байгаа асуудал нь дандаа цөмийн энергийн асуудал яригдаад байна. Уран, тори гэх асуудал яригдаад байна. Энэ дээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам маш тодорхой хариулт өгөөдөх иргэдэд. Мөн аль хууль эрх зүйн орчныг нь тодорхой болгож бид нар тэрийгээ барьж явахаа мэдмээр байна. Энэ чинь тодорхойгүй байгаад байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, байгаль орчны чиглэлийн шинжээчдээс асуух гээд байна. Төслийг хэрэгжүүлээд явахад та нар яг юуг болохгүй гэж үздэг юм? Ямар шалтгаан байгаа юм? Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам жишээлбэл энэ төсөл хэрвээ цаашаа явбал ийм ноцтой шалтгаан байгаа юм гэдгээ өөрсдөө хэлээдэх. Ийм нарийвчилсан үнэлгээ ирэхээр нь бид батлаад байдаг юм аа гээд асуудлаас зугтаад байх юм. Ийм асуудал байна, байгаль, экологийн орчинд ийм нөлөөлөл байна гэж иргэд яриад байдаг. Сумын нарийвчилсан үнэлгээ ирэхээр нь бид нар баталчихсан юм гэж өөрсдөөсөө бултуулмааргүй байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам яг энэн дээр хэрвээ энэ төсөл явах юм бол байгаль орчинд ийм ноцтой хохирол учрах юм гэдгээ дүгнэлтээ өөрсдөө яг

үнэнээр нь хэлээдэх. Ийм юм байна уу? Байгаа бол байгааг нь хэлээд байхгүй бол байхгүйг нь хэлээдэх.

Би иргэдээсээ ирсэн асуултуудыг бас давхар асуугаад явчихмаар байна 2014 онд Цөмийн энергийн газрын комисс газар дээр нь очиж хэмжилт хийгээд чөлөөлөгдөх түвшнээс 8 дахин их гэж дүгнэлт гарсан. Сая шинжээчдийн дүгнэлтээр өчүүхэн бага гэж гарч байна. Энэ яагаад өөрчлөгдөв гэж асуусан байна. Энэ дээр хариултыг нь өгөөч ээ. Энэ дээр Манлайжав гуай та одоо хариултаа өг өө. Та яг газар дээр нь хэмжилт хийсэн хүн нь. Таны дүгнэлтийг үндэслээд би өнөөдрийг хүртэл яриад яваад байгаа. Манай иргэд бас ийм л ойлголттой байгаа. Энэний эргэлзээг та бас нэг талд нь гаргаж өг. Энэ уран хүдрийн ямар давхаргад байгаа юм? Агуулга нь маш бага гээд өөрсдөө тогтоочихсон байна. Тэгэхээр энийг одоо Цөмийн энергийн комиссын судалгааны дүнгээр ашиглаж болох юм уу болохгүй юм уу? Энэ газрын ховор элемент уран хоёр тусдаа ойлголт юм уу? Эсвэл хамт байдаг юм уу? Бид ураныг нь олборлох гээд байгаа юм уу, аль нэгнийх нь агуулга доор нөгөөх нь явах гээд байгаа юм уу? Энийг нь зүгээр тодорхой болгоод хэлээд өг л дөө та бүхэн маань. Энэ бүхэн тодорхойгүй учраас иргэд маань бухимдалтай байна.

Компаниас асуух нь овор хэмжээгээ багасгах гээд боловсруулах юм байна. Тэр хэмжээний хаягдал цацрагийн идэвхжилтэй хог хаях нь. Энэ дээр цацрагийн түвшин ямар байна? Та нар ТЭЗҮ дээрээ судалсан юм байна уу гэж байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас хайгуулын лиценз яагаад хэзээ А лиценз болсон юм? Түрүүн хариулахдаа А лицензтэй компани цаашаа хайгуулаа хийгээд яваад байж болно гэдэг бөөрөнхий хариулт өгч байна. Хэзээ хайгуул хийгээд, ямар хайгуулын үндэслэл, үр дүн дээр үндэслэж лицензийг олгосон юм бэ? Хэдэн сарын хэдний өдрийн хурлаар ямар хайгуул дээр үндэслэсэн юм? Энийг иргэдэд тодорхой хэлж өгөөч гэж хүсэж байна. Шинжээчдээ би бас эргэлзээгүй байлгамаар байна.

Та бүхэн энэ төсөл хэрэгжүүлэгч болон энэ чиглэлээр өмнө нь энэ компанитай холбоотой ямар нэгэн, үгүй бол надтай ч юм уу, сумын иргэдтэй холбоотой ямар нэгэн ажил дүгнэлт гаргаж байсан уу? Энийгээ та бүгд иргэдэд нээлттэй хэлээд өгөхгүй бол иргэдэд маань хардах эрх байна. Энийг одоо хэлж өгөөч. Өмнө нь Нэшнл рийр ийрт хамтарч ажиллаж байсан уу? 2024 онд компани хайгуул хийгээгүй гэж яриад байна. 2024 онд тодорхой хэмжээний хүдрийг хайгуул хийгээд аваад явсан.

Энэ ямар учиртай юм бэ гэж асууж байна. Мянгат сумын иргэдийн хурал тухайн чиглэлийн хяналт хийдэг төрийн бус байгууллагуудаас 2023, 2024 онд удаа дараа санал дүгнэлтийг төрийн захиргааны байгууллага буюу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмалын газарт өгсөн. Эдгээр асуултад хариулт өгнө үү.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам эхлээд хариулна. Дараа нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, төсөл хэрэгжүүлэгч, тэгээд шинжээч хариулна. 1 номер.

Үндэсний геологийн албаны дарга Н.Мөнхбилэг: Гишүүний асуултад хариулъя. УГА-ны дарга Н.Мөнхбилиг геологич мэргэжилтэй. Ашигт малтмалын тухай асуусан учраас ашигт малтмал гэдэг талаас нь би танд бас эхлээд богинохон товчхон тайлбар, дараа нь хуулийн зохицуулалт руу нь оръё. Ашигт малтмал гэдэг нь өөрөө ашиглах боломжтой ашигтай эрдсийн хуримтлал. Хуримтлалын хувьд олон төрлийн эрдэс нэг дор хуримтлагдсан байж болно. Хуримтлагдсан хэмжээ эдийн засгийн үр өгөөж болон ашиглах олборлоход технологид нь тохирсон амархан гэдэг юм уу,

олборлоход боломжтой гэдгээр нь ашигт малтмалаа дотор нь үндсэн ашигт малтмал, дагалдах ашигт малтмал гэж үздэг.

Тэгвэл газрын ховор элементийн хувьд уран, тори нь дагалдаж байгаа болохоос үндсэн ашигт малтмал бол биш. Гэхдээ яг олборлох, баяжуулахын хувьд эдийн засгийн хувьд үр ашигтай юу гэдэг нь одоогоор бүрэн тогтоогдоогүй. Түрүүн хэллээ нарийвчилсан судалгааны түвшиндээ явж байна гэж. Зүйрлэх юм бол Оюу толгойн орд. Бид зэсийн орд гэж ярьдаг гэхдээ Оюу толгой өөрөө зэс, алтны орд буюу дагалдах байдлаар алт байгаа. Алтаа бид дагалдах ашигт малтмалын хэмжээнд нь тооцоод эдийн засгийн өгөөжийг нь хүртээд явж байгаа.

Хуулийн хувьд цацраг идэвхт ашигт малтмалыг Цөмийн энергийн тухай хуулиар зохицуулдаг. Цацраг идэвхт ашигт малтмал гэдэг нь болохоор цацрагийн шинжийг агуулсан. Би хуулийн заалтыг нь яг уншаад өгье. 3.1.4-д Цацраг идэвхт ашигт малтмал гэж ашигт малтмалын тухай хуулийн 4.1.2-т заасан уран болон торигийн бүлгийн цацраг идэвхт изотоп агуулсан эрдэс баялгийн хуримтлалыг хэлнэ гэж байгаа юм. Ашигт малтмалын тухай хууль цацраг идэвхт ашигт малтмалаас бусад ашигт малтмалын харилцааг зохицуулна.

Тэгэхээр одоо энэ нөхцөл байдал нь өнөөдөр үүсээд байгаа эрх зүйн хувьд зөрчил гэж үзээд Аж үйлдвэр эрдэс баялгийн яамнаас бид эрх зүйн хувьд өөрчлөлт оруулах шаардлагатай гээд одоо өргөн барих Ашигт малтмалын тухай хууль болон дагалдах хуулиудад боловсруулалт хийгээд явж байгаа. Та өөрөө түрүүн яг хэллээ. Одоо хэрвээ энэ хууль тодорхойгүй байх юм бол газрын ховор элемент гэдэг ашигт малтмал сонсголын туршид яригдсан энэ цацраг идэвхт шинж чанараасаа болоод гэдэг юм уу тэнд агуулагдаж байгаа уран, тори гэх элементүүдээсээ болоод эдийн засгийн эргэлтэд орохгүй эсвэл тодорхой хуулийн хувьд давхацсан тийм зохицуулалттай болоод зөрчилд орох ийм нөхцөл байдал үүсээд байгаа. Ийм учраас Аж үйлдвэр эрдэс баялгийн яам энэ дээр бас эрх зүйн хувьд цааш цаашдаа эдийн засгийнхаа хөгжлийг тодорхойлохын тулд зохицуулалтуудаа бас өөрчлөх шаардлагатай гэж. Энэ бас ганцхан цацраг идэвхт ашигт малтмалын хувьд ч яригдаж байгаа юм биш. Түгээмэл тархацтай ашигт малтмал гээд бас нэг ойлголт бий. Энэ маань бас л яригддаг асуудал. Хайрга, дайрга, элс олборлох явцад гэх мэтчилэн. Тэгэхээр эрх зүйн хувьд бол зохицуулалт давхацсан, зөрчилдсөн ойлголт яваад байгаа гэж.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын дарга Г.Энхмөнх: Мэндсайхан гишүүний асуултад хариулт өгье өө. Урьдчилсан байдлаар нөлөөллийг бүрэн тогтоогоогүй тохиолдолд бүрэн судалгаа хийгдээгүй үед бид урьдчилсан байдлаар энэ хүрээлэн буй орчинд нөлөөлнө, нөлөөлөх юм байна гэдэг юм уу тийм таамгаа дэвшүүлж, таамгаа батлах замаар тийм ямар ч боломж байхгүй. Ирүүлсэн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хувьд бол тэр тухайн нөлөөлөл нь гадаргын болон гүний ус цэгийн хамаарал нь ямар байгаа юм. Тухайлбал, уурхай үйл ажиллагаа явуулаад эхлэхэд хаягдлын сан ирүүлсэн мэдээлэл дээр 206 га талбай гэж байгаа.

Тэгвэл тухайн хаягдлын сангаас хэдий хэмжээний тархалт үзүүлэх юм тэр нь хүрээлэн буй орчин болоод хүний эрүүл мэндэд ямар нөлөө үзүүлэх юм гэх мэтчилэн асуудал маш тодорхойгүй, ойлгомжгүй. 2 дугаарт нь ургамлын судалгаа нь тодорхойгүй ийм байдлууд ирүүлсэн учраас бид хэд тухайн нарийвчилсан үнэлгээний тайланг буцаагаад дахин нарийвчилсан судалгаа хийе гэдэг ийм л шаардлага тавьсан. Яг энэ судалгаа нь бүрэн хэмжээнд хийгдээд хүрээд ирэх юм бол энэ дээр үндэслээд бид энэ өөрөө технологийн хувьд бол нийцэхгүй юм байна, нөгөө талаасаа

тархалтын хувьд бол хэдий хэмжээний тархалт үзүүлэх юм байна түүн дээрээ үндэслээд нөлөөллийн бүсийг тогтооно. Нөлөөллийн бүсэд байгаа иргэдийн асуудал цаашлаад гадаргын ус, гүний усны нөлөөллийн асуудлыг бол тодорхой болгох ийм зүйл байгаа. Хоёрдугаарх нь төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл болоод орон нутгийн удирдлагаас ирүүлсэн мэдээлэлд тухай бүрд нь хариуг албан бичгээр хүргүүлээд явсан байгаа. Мэдээлэл нь байж байгаа.

“Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-ийн гүйцэтгэх захирал А.Цолмон: Хаягдлын тухай асуулт байсан. Боловсруулах үйлдвэр барихаар Монгол Улсад хаягдлын хэмжээ нэмэгдэх юм биш үү гэсэн асуулт явж байсан. Хаягдал дээр дахиад хэлэхэд манайх судалгаа шинжилгээний ажлаа хийж байна. Лабораторийн хагас үйлдвэрийн туршилт хийгдэх дөнгөж лабораторийн очер дараалалдаа хийгдэж дуусаагүй байгаа учраас шинжилгээний хариуг хэлэхэд төвөгтэй байна. Хотгорын орд шиг яг тэд байсан тэд гэж хэлэхэд бол хэцүү байна. Гэхдээ энэ дээр Золжаргал гишүүний түрүүний санаан дээр сайн жишиг, муу жишиг ч гэх юм уу энэ дээр хариулт бас хэлье гэж бодлоо.

Дэлхий даяар одоо өнөөдөр олборлолт хийгдэж анхан шатын боловсруулалт хийгдэж байгаа хариуцлагатай уул уурхайн жишиг болоод явж байгаа Австралийн Маунт Велд гэж орд байгаа. Маунт Велдийн ордод агуулагдаж байгаа цацраг идэвхт элементүүдээс Халзан бүрэгтэй даруй 4 дахин бага цацраг идэвхт элементтэй агуулгатай байгаа юм. Тэгэхээр тэнд нөхцөл байдлыг удирдаж инженерчилж болж байгаа тохиолдолд манай төслийн хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс хэрэгжүүлэх, удирдах боломжтой гэж хардаг. Анхан шатын шинжилгээний хариунуудаар бол түрүүн шинжээчийн хэлсэн мянган бикрил килограмм буюу хяналтаас чөлөөлөгдөх түвшин гэж яригдаж байгаа тэр мянган бикрил килограммаас доошоо байна гэсэн эхний үр дүнгүүд гарсан. Гэхдээ энийгээ зайлшгүй баталгаажуулах шаардлагатай байгаа.

Шинжээч Э.Цэрэнчимэг: Байгалиасаа оршдог байгалийн цацраг идэвхт изотоп мөн юм уу гэж асуусан. Тэрний хүрээнд хэд хүрвэл хордох юм бэ, хэд хүрвэл хортой гэж үзэх юм бэ гэсэн асуулт зөв үү? Мөн цооногоос ухаж гаргаж ирсэн тэр цооног цацраг идэвхтэй байх юм уу, хэр байх юм бэ гэдэг зүйлийг асуусан. Тэгэхээр энэ дээр би хариулъя. Тийм ээ яг байгалиас оршиж байгаа цацраг идэвхт изотоп юм. Энэ нь уран, тори агуулж байгаа юм аа.

Мэдээж газрын хөрсөн доор байгаа тэр бүтцийг цооногийг ухаад гаргаад ирж байгаа юм чинь мэдээж тодорхой хэмжээний нөлөөлөл байна. Хэрвээ би нэг тооцоолол хийж үзсэн юм л даа. Шинжээчийн үүднээс хортой хоргүй үхэлд хүргэнэ, хүргэхгүй гэдэг асуудал яригдаад байгаа юм. Тэгэхээр яг хамгийн өндөр цэгт хэмжигдсэн 1.67 гэдэг микрозиверт цаг гэдэг тунг олон улсын атомын энергийн агентлаг болон бусад улсуудын репорт, тайлангууд дээр дурдсан хордлогод өртөх тун гэдэг нь 400 мянган микрозивертээс 1 сая хүртэлх байдаг.

Үхэлд хүргэх тун нь 1 сая микрозивертээс 5 сая хүртэлх микрозиверт цаг гэж байдаг. Зарим дээр нь бүүр 20 сая хүртэл гэж тооцсон байдаг. Тэгэхээр яг энэ тунг авч тооцоод хэрвээ үнэхээр хордохоор шийдээд хордье гэж бодоод тухайн яг 1.67 гэдэг цэг дээр ямар ч бодисын солилцоонд орохгүй буюу яг тэр цэг дээр хэвтэх юм уу, суух гэдэг нөлөөллөөр гэсэн үг.

Нэг ёсондоо шууд нөлөөлөлд өртье гэж суугаад яг 1.67 гэсэн цэг дээр суусан тохиолдолд 28-60 жилийн дараа хордлогод өртөх, хордлогын шинж тэмдэг илэрнэ. Нэг ёсондоо энэ олон улсын атомын энергийн агентлаг болон бусад улсуудын тайлангаас харж байгаа шүү. За үхэлд хүргэх тун нь 3.5-5 сая гэж үзэх юм бол. Би

дунджаар авч үзсэн яг энэ утгыг. Ингэх юм бол 69-180 жилийн дараа таныг үхэлд хүргэх тийм боломжтой гэсэн үг.

Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул ашиглалтын газрын дарга С.Ган-Очир: Тусгай зөвшөөрөл олгосон талаарх мэдээллийг товчхон танилцуулъя. Ашигт малтмал, газрын тосны газраас Ган-Очир. Хамгийн анх бол 2000 онд 2797 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлийг иргэн Зул гэдэг хүний нэр дээр олгосон байсан. Тухайн үеийн зохицуулалтаар иргэнд хайгуулын тусгай зөвшөөрөл олгож болдог байсан. Ингээд 2001 онд бол иргэн Зулаас Монтем гэдэг компани руу энэ тусгай зөвшөөрөл шилжсэн байдаг.

2004 онд Монтем компани мөн тухайн үеийн хуулийн зохицуулалтаар өргөдөл гаргаад ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан. 2 ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан эхнийхийг нь 2001 ондоо авсан, дараагийнхыг нь 2004 онд авсан. Ингээд одоогийн “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-ийн компанийн эзэмшиж байгаа 2 тусгай зөвшөөрөл үүссэн байна. За энэ дээр 2010 оноос тус компани өөрийн хөрөнгөөр хайгуулын ажил явуулаад нөөцөө бүртгүүлсэн. Одоо 69 11 талбай дээрээ Б дээр нэмэх нь Ц зэрэглэлээр 191635 тонн ислийн 12 335 тусгай зөвшөөрөл дээрээ 1011448 тонн ислийн нөөц.

Шинжээч Т.Аззаяа: Түрүүн эрхэм гишүүн асуусан. Ер нь орд маань газрын ховор элементийн орд юм уу ураны орд юм уу гэдгийгээ илүү тодруулаад мухарлаад өгөөч ээ гэсний дагуу нэмэлт тодруулалга хийе. Миний илтгэл дээр мөн гарсан байгаа. Тэгэхлээр газрын ховор элементийн орд. Энэ Халзан бүрэгтэй орд маань өөрөө газрын ховрын бие даасан бастнезит, монацит, ксенотим гэсэн эрдсүүдийг агуулдаг. Эдгээр эрдсүүд нь уран торийг тодорхой хэмжээгээр дагалдан агуулдаг. Дээрээс нь геологийнхны тогтоосноор энэ ордод өөр үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий 3 металл илэрсэн. Тийм ч учраас энэ ордыг циркон, необи, ган, газрын ховор элементийн орд гэж тодорхойлсон байгаа. Ураны Зөөвч овоогийн орд буюу ураны ордын хувьд бол үндсэн хүдэр нь Уранинид, Карнотид гэх мэт ураны бие даасан үндсэн эрдэс агуулагдана.

Энэ ураны үндсэн ордод газрын ховрыг одоо үндсэн байдлаар агуулсан эрдэс агуулагдахгүй учраас Зөөвч овоогийн орд бол ураны орд байгаа юм шүү гэдгийг энд илүү тодорхойлж байгаа. Ураны ордод дагалдах элементээр ванади, молибден, селен, тори гэх мэт элементүүд агуулагддаг. Үндсэн яг ашигт элемент нь бол уран байгаа шүү. За ялгаа нь бол ийм бай байгаа. Түрүүн шинжээч нар энэ төсөл хэрэгжүүлэгч компанитай ямар нэгэн ашиг сонирхлын зөрчилтэй юу үүсгэж байгаа юу гэж асуусан байгаа. Хувь хүн, судлаач би болоод манай Хими химийн технологийн хүрээлэн бол энэ төсөл хэрэгжүүлэгч байгууллагатай нэг ч удаа холбогдож үзээгүй, огт мэдэхгүй. Энэ дээр нэг зүйл тодруулахад судлаач бид нарт бол ерөнхийдөө судалгааны судлагдахуун, объект, судалгааны хүдэр дээж гэдэг маань бол өдрийн од шиг олддоггүй эд байгаа юм.

Хэрвээ бид нар одоо энэ бүхэнтэй холбоотой байсан бол аль хэдийн энэ ордын судалгааг бол нарийвчлан хийх боломж байсан байх аа гэж хэлж байна. Тийм учраас ямарваа нэгэн судалгаа хийгдээгүй байгаа.

Шинжээч Д.Лхамсайзмаа: Түрүүн би хариуллаа гэж ойлгосон. Ахиад 3.Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Ургийн гажиг гэдэг бол цоо шинэ, өнөөдөр бид нар сонсож байгаа ийм зүйл биш. Хүн дээр ч, мал дээр ч тийм ээ ер нь бол тохиолддог. Сая химийн болон энэ, цацрагийн судлаачид хэлж байна шүү дээ. Тэр цацраг дээр хамгийн өндөр цэгт нь 28-60 жил хэвтэхэд л хордлогод өртөх ийм

тунгаар нөлөөлнө гэхээр энд бол тэрнээс болоод ургийн гажиг болсон гэж хэлэхэд бол хэцүү л байна л даа.

Ер нь бол өгсөн материал дээр бид нар дүгнэлт хийхэд мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори гэж байдаг. Энэ бол чиг үүргийн хувьд зөвхөн малын өвчнийг оношилдог, онош тогтоодог, ийм чиг үүрэгтэй ХААЯ-ны харьяа байгууллага. Манайх бол тусдаа эрдэм шинжилгээ судалгааны ажил хийдэг Эдийн засаг хөгжлийн яамны харьяанд байдаг байгууллага. Ургийн гажгийн талаар нэг судлаачдын мэдээллийг авч үзэхэд зэс, цайрын агууламж бага байна, эндемик өвчин гарч байна.

Сүүлийн үеийн Мал эмнэлгийн ерөнхий газрын мэдээг харахад онош тодорхойгүй өвчин гэсэн өвчний тоо нэлээн их нэмэгдээд ирдэг. Энэ яаж байна гэхээр онош нь тодорхойгүй, халдваргүй өвчнүүд ихсэж байна гэсэн үг юм. Түрүүн нутгийн хүмүүс буруу ойлгох шиг болсон. Энд тодорхой хариулт өгөхийг хүсэж байна. Рашаан гээд ургамал бол манай шинжлэх ухааны нэршлээрээ бол ортууз буюу окстропис (oxytropis) гээд ургамал байдаг юм. Энэ бол Завхан, Ховд, Буянт голын ай сав дагуу ургадаг. Тодорхой тундаа бол свайнсонан гэдэг алкалоид агуулдаг. Тэр алкалойд тодорхой тундаа эмчилгээний идэвхтэй, дархлаа тэтгэдэг гэх мэт ийм идэвх үзүүлдэг. Тун хэтрээд ирэхээрээ хордуулдаг ийм төрлийн ургамал байгаа юм. Мэдээж мал өөр идэх ургамалгүй бол энэ ургамлыг идэж хорддог. Хордонгуутаа шууд үхэхгүй ашиг шим нь буурна, тэсвэр чанар нь буурдаг ч юм уу өөр өвчинд өртөмтгий иймэрхүү тохиолдлууд гардаг юм шүү. Энэ талын судалгааг бид хийгээгүй биш 2000 оны эхээр Японы эрдэмтэдтэй хамтраад судалгааны ажлыг эхлүүлж байсан.

Хөрөнгө мөнгөний асуудалтай холбоотойгоор зогсоож байсан. Зөвхөн хорт ургамлын төдийгүй өөр бусад үржил селекцийн, эмийн хэрэглээ. Тэгэхээр бид энэ компанийн болон одоо бусад хүмүүсийг бол огт танихгүй. Цаашид хамтраад энэ талын судалгааны ажлыг одоо хийлгэх юм бол бас их таатай хүлээж авах болно шүү. Та бүхэнд ч гэсэн малын эрүүл мэндийн нөгөө суурь үзүүлэлт бий болох ийм ач холбогдолтой юм шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна. Бид бас 21 аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх Халдваргүй өвчний тандан судалгааны хөтөлбөрийг боловсруулчихсан байгаа. Энэ дээр хамтарч ажиллахад таатай байх болно. Баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: 8 номерын микрофоныг бусад шинжээч нар ашиг сонирхолгүй гэдгээ хэлээд.

Шинжээч Э.Цэрэнчимэг: Тус төсөл хэрэгжүүлэгч байгууллагатай ямар нэгэн ашиг сонирхолгүй.

Шинжээч Д.Баярсайхан: Гишүүн болон хэрэгжүүлэгч компанитай ямар нэгэн байдлаар холбоотой асуудал байхгүй.

Шинжээч А.Хаумдас: Зөрчилгүй болно.

Шинжээч М.Пүрэв-Очир: Гишүүн Пүрэв-Очир. Төсөл хэрэгжүүлэгчтэй ямар нэгэн ашиг сонирхлын холбоо байхгүй.

Шинжээч Х.Лхагвабаатар: Ашиг сонирхлын зөрчил байхгүй байгаа.

Шинжээч Н.Наранцэцэг: Төсөл хэрэгжүүлэгчтэй ямар нэгэн байдлаар хамтран ажиллаж байгаагүй, ашиг сонирхлын зөрчил байхгүй болно.

Шинжээч Л.Нямсүрэн: Тухайн төсөл болон, орон нутагтай холбоотой ямар нэгэн холбоо хамаарал байхгүй.

Шинжээч Н.Уртнасан: Тухайн төсөл хэрэгжүүлэгчтэй ашиг сонирхлын зөрчил байхгүй, холбогдож байгаагүй. Анх удаа эдний дээр шинжээчээр орж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: 3.Мэндсайхан гишүүн тодруулах уу? 3.Мэндсайхан гишүүний микрофон.

УИХ-ын гишүүн 3.Мэндсайхан: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас өгч байгаа мэдээллээс харахад ерөнхийдөө хууль эрх зүйн орчин чинь тодорхойгүй байгаа юм байна шүү дээ. Сая шинжээчийн хэлсэн дүгнэлтээр бол энэ бол газрын ховор элемент нь өөрөө давамгайлж байгаа учраас газрын ховор элементийн орд гэж үзнэ. Энийг дагаад уран, тори байгаа гэж байна. Ашигт малтмалын газар болохоор цацрагийн асуудал байгаад байгаа учраас энэ дээр хууль эрх зүйн орчноо өөрчлөх шаардлагатай байна гэхээр ер нь энэ хууль эрх зүйн орчноо тодорхой болгож байж цааш явах нь байна шүү дээ тийм үү? Би тэгж ойлгож байна. Би та бүгдийн амнаас сонссон хариултдаа л хариулт өгч байна.

Ер нь энэ нээлттэй хэлэлцүүлэг бол иргэдийн маань мэдэх гэсэн асуудлыг нэг мөр хариулаад нэг талд нь гаргаад явчихсан бол их сайн байлаа. Гэхдээ харамсалтай нь тэгэх боломжгүй юм байна. Түрүүн Б.Баярбаатар дарга хэлж байна. Маш олон портер ачаа судалгааны материал байна, тэрэнтэй танилцаж болно гэж. Та боломжтой бол би энийг одоо хамаагүй ээ портерыг нь явуулаад авъя. Тэгээд би энэ сумынхандаа, нутгийнхандаа мэдээллийг нь хангаж өгье гэж бодож байна. Тэгэхгүй бол эргэлзээтэй асуудлууд маш их үлдэж байна.

Ер нь ашигт малтмалын тэр А лицензийн асуудал дээр ч гэсэн маш хариуцлагагүй л юм хэлж байна шүү дээ. Ийм байдлаар хайгуул хийгээгүй. Энэ чинь анх удаа л энэ сумд хайгуул хийгээд байгаа. Бид нар бүгд мэдэж байгаа шүү дээ. Сүүлийн 2, 3 жил хайгуул хийгээд ийм асуудал үүсэж байгаа. Тэгэхээр өмнө нь хайгуул хийгдээгүй байж байхад лиценз авчихсан байна. Тэгэхээр эрх зүйн хувьд би энийг нэлээн цааш нь тодруулъя гэж бодож байна. Ямар үндэслэлээр ингэж хэв, хэзээ хийсэн хайгуул дээр. Энэ дээр одоо ямар ч тодорхой хариулт өгөхгүй байна. Тэгэхээр төрийн захиргааны байгууллагууд ийм ойлгомжгүй байгаа чинь энэ иргэдийн бухимдлыг төрүүлж, өнөөдөр энд хүрэх ирэх шалтгаан болоод байгаа юм аа.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам бид нар урьдчилан эрсдэл үүснэ гэж мэдэхгүй байна. Тэгээд нарийвчилж ир ээ гэж буцаалаа. Та нар яагаад цацрагийн асуудал яригдаад иргэд бухимдаж байхад. Тэгвэл яагаад танай яамны сайдад би олон удаа Улсын Их Хурлын индэр дээрээс хэлж байсан юм. Олон улсын байгаль орчны шинжээч, үнэлгээний байгууллагаар энэ дээр дүгнэлт хийлгэж болохгүй юм уу, олон улсын туршлага нь юу байна аа? Ингээд энэ асуудлыг хийе гэхээр зэрэг энийг яасан юм хувийн компани руу нь буцаачихсан юм уу? Чи тийм юм хэлээд байгаа юм уу? ямар учиртай юм. Би буцаачихсан гээд. Чи буцаасан чинь тийм их том гавъяа биш шүү дээ. Чи энэ эрсдэлийг хариуцах гэж сууж байгаа мэргэжилтэн шүү. Төр төлөөлж байгаа хүн шүү дээ. Тэгээд юу яриад байгаа юм.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Асуулт, тодруулсан уу? Санал гэж ойлголоо. Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн асуулт асууна.

УИХ-ын гишүүн Ч.Лодойсамбуу: Бүгдэд нь оройн мэнд хүргэе, бүгдээрээ сайхан намаржиж байна уу, сайн явж ирсэн үү? Өдөржингөө сууж мэдээлэл авах шиг боллоо. Бид нар ч гэсэн нэг дор мэдээллийг анх удаа сонсож байна. Олон л юмнуудыг сонсож мэдэж авч байна. Нэгд асуултууд зөндөө давхардлаа. Олон зүйл нуршиж

нэгнийгээ чилээгээд яах вэ. Эндээс хийж байгаа дүгнэлт манай төр ерөөсөө ажлаа хийхгүй байна. Нэг талдаа зөвшөөрөл өгсөн болоод хаячихдаг, ямар ч мэдээлэл байхгүй. Тэгээд иргэд нь нэг, компани нь нэг талдаа ингээд 2 талдаа гараад маргалдуулаад орхичихдог. Ингэж явсаар явсаар байгаад одоо Улсын Их Хурал бараг эвлэрүүлэн зуучлах гэдэг шиг ийм юм хийгээд сууж байна шүү дээ. Хоорондоо ойлголцчих л доо, гар барьчих л даа гээд байгаа юм уу яагаад байгаа юм бэ? Ийм өрөвдөлтэй. Энэ бол инээдэмтэй биш. 3.Мэндсайхан гишүүнтэй санал нэг байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам өнөөдөр энэ сайд нь улс төржөөд л гадуур яваад байгаа. Энэ чуулгын танхимд явж байсан. Энд орж ирээд сууж байх ёстой шүү дээ. Өнгөрсөн хугацаанд Ховд аймгийн төсөл хэрэгжиж байгаа нутгийн оршин суугчдадаа очоод мэдээлэл өгөөд явж байх ажлыг зохион байгуулж байх ёстой шүү дээ. Тэр газар нутагт нь үнэхээр хортой юм уу, үгүй юм уу гэдэг энд яригдаж байгаа бүх мэдээллийг өгөөд явж байх ёстой, засгийн бодлогоо хэрэгжүүлж байх ёстой. Өнөөдөр шагайх ч үгүй хариуцлага үүрч чаддаггүй. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Засгийн газар ерөөсөө л ажлаа хийхгүй байгаагаас үүдэлтэй ийм асуудлууд бий болж байгаа. Тэрнээс нь болоод яаж байна гэхээр нэг хэсэг нь энэ нутгийн оршин суугчдыг буруутгаад, нөгөө хэсэг нь төсөл хэрэгжүүлэх гэж байгаа төрийн өгчихсөн зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулах гээд чадахгүй хөөгдөж, туугдаад ингээд л байж байгаа. Ийм цаг үед бол бид нар ер нь улс төрчдийг сонсохгүй шүү дээ. Би хэрсүү байя аа гэдэг үгийг маш олон жил хэлж байгаа.

Хэдийгээр тойргийн гишүүн маань ч гэсэн 3.Мэндсайхан гишүүн эдийн засагч мэргэжилтэй хүн. Уяач. Манай Э.Болормаа бас эдийн засагч мэргэжилтэй хүн. Энэ дотор дандаа улс төрчид байгаа. Аргагүй сонгоод гаргачихсан юм чинь тойргийнхоо гишүүнээс мэдээлэл авъя гэхгүй яах юм бэ. Гэтэл тэр тойргийн гишүүн гэдэг чинь өөрөө улс төрч байхгүй юу даа. Ийм үед хэнийг сонсох ёстой юм бэ, хэнд итгэх ёстой юм бэ гэхээр. Бүүр ёстой гэж байгаа шүү. Эрдэмтэдээ л сонсоно. Эрдэмтэдээ итгэхгүй юм бол тэгээд өөр цаашаа алхах газар байхгүй шүү дээ. Дэлхий нийт тийм шүү дээ.

Одоо бид нарын энэ хурлаа хийж байгаа Их Эзэн Чингис хааны нэрээр нэрлэгдсэн энэ танхимд Их Эзэн Чингис хааны амжилтад хүрсэн, дэлхийн талд хүрч дэлхийн талыг эзэлсэн ардчилсан улсыг байгуулж байсан гүрнийг байгуулж байсан амжилтын нууц бол ерөөсөө эрдэмтэдээ итгэсэн л асуудал шүү дээ. Мэддэг хүнээс нь мэддэгийг нь асуудаг, чихээ тавьж сонсдог, тэгээд хамтраад урагшаа алхдаг. Тэр үедээ эрдэмтдээс л асуу, эрдэмтдээ л сонсоосой. Би маргалдах гээгүй ээ. Одоо хэдүүлээ орой хүртэл суучхаад бие бие рүүгээ хашхираад яах вэ дээ. Ямар ч байсан ийм байгаа юм аа гэдэг байр сууриа л хэлж байгаа юм.

Нөгөө талаар Ховд аймгийн Засаг дарга хаана байгаа юм бэ? Яах гэж засаг захиргааны нэгж байгуулж, төсвөөс санхүүжүүлж, ажил хийлгэх гэж томилдог юм бэ? Тэр хүн яагаад олон нийтийнхээ энэ бухимдал, олон нийтийн эргэлзээд байгаадаа мэдээлэл өгдөггүй юм бэ?. Ажлаа хийдэггүй юм бэ? Төсвөөс өчнөөн тэрбумаар нь татаас аваад л байж байдаг энэ захиргааны байгууллагууд нь ер нь яагаад ажлаа хийдэггүй юм бэ?. Төр нь ажлаа хийе гэдэг ийм л дүгнэлттэй байна. Тэрнээс биш энд ингээд нэг хэсэг нь газар хордуулах гээд нөгөө хэсэг нь хордож үхэх гээд байгаа юм ерөөсөө өнөөдрийн байдлаар би лав энэ мэдээлэл дундаас, энэ эрдэмтэн шинжээчид, яамныхан, энэ тойроод сууж байгаа бүх хүмүүсийн дундаас мэдээллийг аваад манай энэ холоос ирсэн нөхдүүд ч гэсэн зарим нь өглөөнийхийг бодвол уур амьсгал нь гайгүй болчихсон бас ойлгосон шинжтэй л сууж байна. Нэг их муудалцаад л нэг нэгнийгээ их гацаах гээд байх тийм зорилго агуулсан хүмүүс бол энэ дунд алга байна шүү дээ. Гол нь мэдээлэл дутагдсан байна.

Төр нь ажлаа хийе, ажлаа хариуцсан хүмүүсээс нь энэ үүргийг нэхье ээ. Тэгэхгүй бол ингээд цаашдаа ер нь Б.Баярбаатар дарга аа, цаашдаа бид бүх асуудал дээр сонсгол зохион байгуулаад л явах юм бол энэ төрийн ажил чинь явахгүй шүү дээ.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Санал хэллээ за Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

УИХ-ын гишүүн М.Бадамсүрэн: Юуны өмнө баруун хязгаараас зорьж ирсэн та бүхэн маань энд ирээд тодорхой үр дүнтэй байгаасай гээд би чин сэтгэлээсээ хүсэж байна. Миний хувьд Дорнод аймгийн Халхгол суманд төрж өссөн. Эх орны одоо тусгаар тогтнолын өлгий болсон сайхан нутаг. Дорнод аймгийн засаг даргаар 9 жил ажилласан.

Би нэг товчхон түүх хэлье. Одоогоос 9 жилийн өмнө УИХ, Засгийн газар шийдвэр гаргаад Дорнодын Халх голын нутгийн 1/3 буюу 500 мянган га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан юм. Энэ дээр би сумынхаа нутгийн зөвлөлийн ард иргэдтэй хамт яг та бүхэн шиг би аймгийн дарга байхдаа хамтдаа ирээд яг энэ танхимд байнгын хороон дээр мэдээлэл тавьж байсан юм. Ямар мэдээлэл тавьсан гэхээр энийг тусгай хэрэгцээнээс гарга аа гэдэг мэдээлэл тавьсан. Тухайн үеийн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга загнаж байсан намайг. Тэгэхээр энд юу харагдаад байна гэхээр ерөөсөө нутгийн ард иргэдээс асуудаггүй, иргэдийн нийтийн хурал, сумын иргэдийн хурал, аймгийн хурлаас санал авахгүйгээр шууд 500 мянган га газар тогтоол гаргаад л байгуулчихсан өнөөдөр тэр нь ямар ч эргэлтэд ороогүй хууль бус учраас ингээд хөдөлгөж чаддаггүй тэгэхдээ сум нь мэддэггүй, улс нь мэддэггүй, ийм байдалтай байгаа байхгүй юу. Би зүгээр жишээ ярьж өгч байгаа юм. Тэгээд яг энэнтэй адилхан энэ уул уурхайн лиценз гэдэг юмыг, хэвлийд доорх баялгийг ашиглах зөвшөөрлийг зүгээр л дураараа өгчхөөд байгаа байхгүй юу. Тийм учраас бухимдал үүсээд байгаа юм. Ер нь энэний өмнө нэг юмыг ойлгох хэрэгтэй.

Монгол Улс 1921 онд 500 хүрэхгүй мянган хүнтэй байсан ардын хувьсгал мандахад. Тэгэхэд Нийслэл хүрээнд бүгд бөөгнөрөөд байсан бол өнөөдөр бид нар энэ өргөн уудам нутагт эзэн болж чадах уу? Энэ Ховдын хязгаар, Дорнодын хязгаар, Өмнөговь, Хөвсгөлийн тайгад хэн энийг авч үлдсэн юм. Малчид авч үлдсэн байхгүй юу. Энэ логикоо ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа юм. Тийм учраас ямар ч цаг үед Монгол Улсыг авч явах юм бол ХАА, тэр дундаа МАА. Энэ нутгийн ард иргэд чинь үе удмаараа тэнд амьдарч байсан учраас энэ баялаг өнөөдөр байгаа байхгүй юу. Тэрийг ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа юм. Өнөөдөр яг ингээд Улаанбаатар хотод сая 500 мянган хүн эндээ ийм өндөр барилгуудтай мөнхөд байсан юм шиг бодоод байгаа юм. Би бол малчин хүний үр удам. Тийм учраас энэ малчдын эрх ашгийг 1 дүгээрт тавих ёстой.

Энэ газрын хэвлийн баялаг гэдэг чинь бол хүний гараар бүтээгдээгүй шүү дээ. Энэ чинь байгаль өөрөө олон 100 сая жилийн туршид бүрэлдэн бий болсон тогтоц байхгүй юу. Тэгээд энийг бид нар ирээдүй үеэсээ зээлж хэрэглэж байгаа юм. Ахмад үе маань энийг хамгаалж авч үлдсэн. Тийм учраас нэгдүгээрт нутгийн ард иргэдийн эрх ашиг. Олон улсад энэ Засгийн газар ашигт малтмалыг одоо олборлохыг л зорьдог. Төсвөө бүрдүүлэхийн тулд. Харин нутгийн ард иргэд энийг эсэргүүцдэг. Бүх улс оронд ийм байгаа. Тэгэхээр энийг яаж хийдэг шийдлийг энэ олон сайд дарга нар, олон жил улс орныг удирдсан хүмүүс бодвол яваад сайн туршлага судалсан байлгүй гэж би найдаж байгаа юм. Гэхдээ үгүй юм шиг байна. Тэгсэн бол өнөөдөр ийм асуудал үүсэхгүй. Би яагаад энэ асуудал дээр орой болтол сууж байгаад санал хэлье гэж бодож байна гэхээр энэ баруун бүсийн гишүүдтэйгээ санал нэг байна.

Баруун бүсийг төлөөлөөд энд Б.Заяабал гишүүн, О.Амгаланбаатар гишүүн, Э.Болормаа гишүүн, З.Мэндсайхан гишүүн сая санал хэлсэн. Эд нар ямар байр суурьтай байна тэрийг бол дэмжинэ. Би зүүн бүсээс сонгочихсон гишүүн хэдий ч бид нийт ард иргэдийн эрх ашгийг хамгаалах үүрэгтэй. Яагаад энэ асуудлыг би сайн ойлгоод байна гэхээр энэ чуулганы танхим дотор байр сууриа илэрхийлдэг хүмүүсийн нэг. Манай Дорнод газрын тостой ба 95 хувь нь Дорнод аймгийн нутгаас олборлодог. Гэхдээ 20 жил улсын төсөвт 4-6 их наяд төгрөг зөвхөн Матад сумын нутгаас төвлөрүүлсэн гэхэд өнөөдөр Матад сумын цэцэрлэгийг 20 жил шинэчилж чадаагүй. Тэгэхээр энэ одоо яагаад байгаа юм бэ. Өрмийг нь аваад тэгээд бараг хусам ч байхгүй, бүгдийг нь татаж авдаг. Уул уурхайгүй аймгаас сонгогдсон, нийслэлээс сонгогдсон зарим гишүүд энийг ойлгодоггүй. Тэгэхээр Монгол Улс нэгдмэл улс гэдэг ганцхан үг хэлдэг. Энэ нийт ард түмний баялаг үнэн. Гэхдээ тэнд насаараа нутаглаж ирсэн иргэд адилхан хөгжихийг хүсэж байгаа шүү дээ. Яагаад компанийнхан том том жийп авч унаж, баян тансаг амьдраад гадаа дотоод зугаалаад, яагаад нутгийн ард иргэд нь хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлж чадахгүй байна.

Тэгээд би нэг асуулт асууя гэж бодож байна. Түрүүн Э.Болормаа гишүүн асуусан. Энэ Ерөнхийлөгчийн зарлигтай байхгүй юу энийг хуульд оруулъя гэхэд дэмжээгүй. Энэ уул уурхайг дэмждэг бүлэг их байгаа. Энэ ерөөсөө их хүнд. За цаг бага байгаа. Тэгэхээр Ерөнхийлөгчийн зарлигаар бол энэ газрын тос, газрын ховор элемент, уран гэдэг энэ 3 стратегийн ач холбогдолтой ашигт малтмалыг лиценз олгох шилжүүлэх ажлыг зөвхөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газраар шийдэх ёстой. Нэг албан тушаалтан гарын үсэг зураад өгчхөөд байгаа шүү дээ наадхыг чинь. Энийг болиулъя л гээд, нутгийн ард иргэд та нар энэ дээрээ гол анхаараарай, энийг шалгуулаарай өргөдөл гомдол гаргаарай.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За санал хэллээ. О.Амгаланбаатар гишүүн.

УИХ-ын гишүүн О.Амгаланбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. За түрүүн Г.Нямдаваа Засаг дарга тэнд бас хөөрхий улалзаад сууж байна. Миний хувьд энэ Засаг даргын зовлонг мэдэхийн хувьд хэлье. Түрүүн Г.Нямдаваа дарга дутуу ярьчихсан учраас гүйцээгээд хэлчихье. Одоогийн хуулиар аймгийн иргэдийн хурал сумын иргэдийн хурлаас санал авч лиценз олгож байгаа юм. Санал авна гэдэг чинь хөөрхий Г.Нямдаваа эсвэл энэ Мянгад сумын чинь Засаг дарга, Иргэдийн хурал нь татгалзаад явуулж байгаа. Гэтэл Уул уурхайн яамнаас энийг үл харгалзан лиценз олгочхож байгаа юм. Тэгэхээр бүх сумын дарга, аймгийн дарга нарын зовлон чинь энэ байдаг. Та 60 очоод л сумынхаа Засаг даргыг тэр одоогоос 10 жилийн өмнө, 20 жилийн өмнө байсан тэр Засаг дарга нараа улалзуулаад л багийн даргаа улалзуулаад л чи лиценз өгчихсөн байна, чи муу нутаг зарсан гээд л ингээд л улалзуулдаг. Нөгөө нөхөр чинь татгалзаад явуулчихсан байдаг, аймгийн дарга нар нь мөн ийм байдаг.

Ер нь бол лиценз өгье гэж гарын үсэг зурсан сум, аймгийн Засаг дарга нар бараг байдаггүй шүү. Хурал бараг байдаггүй юм. Яагаад гэхээр малчидтайгаа, иргэдтэйгээ өдөр болгон ингэж харилцаж байдаг учраас. Тэгэхээр одоо өнөөдрийн хүчин төгөлдөр хуулиар сум, аймгийн саналыг аваад санал нь ямар байхаас үл харгалзан, татгалзсан байсан ч хамаагүй Уул уурхайн яамнаас лицензийг нь олгочхож байгаа юм манайхан.

Тэгэхээр та нар нэг зүйл ойлгоорой. Энэ өмнө нь танай сумын Засаг даргаар ажиллаж байсан тэр хүмүүст буруу байхгүй. Багийн даргаар ажиллаж байсан хүмүүст тэр буруу байхгүй. Аймгийн даргаар ажиллаж байсан хүмүүст бараг буруу байхгүй.

Уул уурхайн яам энэ хайгуулын лицензийг олгочихсон гэсэн үг. Харин ашиглалтынх болохын өмнө багийн нийтийн хурал гэж хуралддаг юм. Тэр багийн хурал чинь хуралдаад тэнд харин зөвшөөрсөн байх ёстой байдаг юм. Тэрийгээ та нар харин нягталсан нь дээр байх. А лиценз болоход хуралдсан багийн дарга. Аймгийн дарга бол хайгуулын лиценз дээр иргэдийн хурлын саналыг нэг уламжлах үүрэг гүйцэтгээд тэрнээс хойш аймгийн даргад ямар ч үүрэг байдаггүй юм шүү гэдгийг би энэ дээр эхлээд хэлчихье. Тэгэхээр энийг бас ялгаж салгаж ойлгохгүй бол.

Бас Г.Нямдаваа дарга түрүүн бас дутуу яриад дутуу ойлгуулчхаж байгаа учраас энийг хэлье. Тэгэхээр одоо энэ Уул уурхайн яам, энэ хариуцсан төрийн байгууллага нь ажлаа хийх ёстой. Нэгэнт та нар, танай өмнөх үе нь хамаа байхгүй энэ лицензийг олгосон бол энэ дээрээ та нар хариуцлага хүлээх ёстой. Өнөөдөр та нар аль аль талд нь үүсэж байгаа энэ нөхцөл байдлыг аль хэзээнээс хойш газар дээр нь зохицуулах боломжтой байсан улсууд. Та нар яг өнөөдөр энэ лиценз олгож байгаа чинь та нар төр-ард иргэдийн өмнөөс хариуцлага хүлээж байх ёстой хүмүүс уг нь. Гэтэл өнөөдөр ийм нөхцөл байдал руу оруулж байгаа нь та нарын асуудал. Тийм учраас энийгээ та нар өөрсдөө нэгдүгээрт зохицуулах ёстой гэдгийг хэлье.

За тэгээд компанийн нөхдүүдэд бас нэг зүйлийг хэлэхэд дахиад Уул уурхайн яамных эсвэл аймгийн удирдлагууд нь мэдээж энэ лицензтэй компани чинь нэг байгаль орчны үнэлгээ хийлгээд ирж байна. Тэгэхээр нэгэнт би захиалсан юм чинь тэр үнэлгээ бол надад тааруулаад гэдэг юм уу, энэ компанид тааруулаад болно гэсэн үнэлгээ хүрээд ирдэг. Тэгэхээр энэ хүмүүсийн барьсан юмнууд нь юу байна гэхээр үнэхээр тэр Хар ус нуур, Дөргөн нуур цаашлаад Хар нуур гэдэг юм уу цаашлаад бүр Хяргас нуур энэ одоо нөхцөл байдал эвгүйднэ, энээс болоод Их нууруудын хотгор чинь будаа болох гэж байна гэдэг зүйл яриад байна шүү дээ. Тэгвэл үнэхээр тэр байгаль орчны үнэлгээгээ та нар энэ аймгийнхаа төсөв дээр, сумын аймагт сонгогдсон төлөөлөгч нар байгаа. Тэгээд танай сумаас УИХ-ын гишүүн байж байна. Магадгүй улсын төсөв дээр ч мөнгө суулгадаг юм уу эсвэл аймгийн төсөв дээрээ хангалттай хэмжээний мөнгө суулгаж байгаад та нар олон улсын хөндлөнгийн байгаль орчны үнэлгээг хийлгэх хэрэгтэй. Үнэхээр энэ хөндлөнгийн байгаль орчны үнэлгээ нь асуудалгүй гээд гараад ирэх юм бол бүгдээрээ ширээний ард сууж байгаад ярилцах хэрэгтэй. Түүнээс биш энэ компанийн зарласан үнэлгээгээр ороод ирэхээр яг үнэндээ хэлэхэд компанидаа үйлчлэх юм бол дараа нь магадгүй та нарын энэ иргэдийн айгаад байгаа 10 жилийн дараа нөгөө Хар ус нуур, Дөргөн нуур, тэр Их нууруудын хотгор будаа болчих юм бол мянга уйлахад хоцорсон байна.

Тэгэхээр энэ байгаль орчны үнэлгээгээ маш сайн хийх хэрэгтэй. Тэгээд зарим нь сая энд нэг залууг хэлж байна. Тэр худалдагдсан эрдэмтэд гэж, бүгдийг тэгж харлуулж болохгүй. Яг үнэхээр ажлаа шударга хийж байгаа, яг үнэхээр энэ зөв дүгнэлт гаргадаг хүмүүс зөндөө байгаа.

Тэгэхээр энэ юмыг хэдүүлээ бодитой харах хэрэгтэй. За энийг одоо аймгийн удирдлагууд мэдээж тэр Уул уурхайн сайд нь энд сууж байх ёстой хаана байгаа юм, тэр Кадастрын дарга нь мэдээж байгаа байлгүй, /байгаа юу тэр нь хаана байгаа юм/ за дахиад тэр аймгийн удирдлагууд нь энд сууж байх ёстой хаана байгаа юм тэгэхээр ийм ийм зүйл дээр ач холбогдол өгөх ёстой байдаг.

Дараагийн зүйл нь би энэ компанийн нөхдүүдэд юм уу та нар нийлж байгаад нэг зүйлийг хийх хэрэгтэй. За минутаа авчихъя. Энэ газрын ховор гэдэг үнэхээр чухал уу чухал. Тийм учраас та хэдийн хувьд за минутаа авчихъя.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: О.Амгаланбаатар гишүүний минутыг сунгая.

УИХ-ын гишүүн О.Амгаланбаатар: Ийм учраас та хэд энэ 60 хүнээсээ авхуулаад цаана нь дэлхийд хамгийн том ордтой, боловсруулж байгаа энүүхэн энэ урд талд Бугат хот байна шүү дээ Хятадад. Тэгвэл та нар Хятад, Орост байгаа яг адилхан түвшний газрууд нь очоод уурхайг нь үзүүлээд ингээд нэгэнт та нар энэ том төслийг хөдөлгөх гэж байгаа бол энэ хүмүүстээ яг ямархуу хортой байна гэдгийг нь газар дээр нь очоод нүдээр нь үзүүлбэл уг нь сайн байна. Хэрвээ ингээд энэ хүн хүмүүсийн болгоомжлоод байгаа тэр болгоомжийг мэдээж 10, 20 жил ашиглачихсан тэр ордыг очоод нүдээр үзүүлбэл, би хэвлэлээс л харж байна, танайх чинь тэр Худалдаа хөгжлийн банкных ч билүү их баян компани юм гэсэн, тэгэхээр нэг онгоц хөлслөөд энэ хүмүүсийг үзүүлбэл. Юмыг нүдээр хараад, гараар барих өөр байдаг. Иймэрхүү зүйлүүдийг та нар Орос, Хятад хоёр хоёулаа байж байгаа учраас энд очоод үзүүлчихвэл их сайн байх. Тэгвэл энэ хүмүүс чинь газар дээр нь үнэхээр ийм юм байна гэнэ шүү дээ. Магадгүй очоод үзсэн чинь үнэхээр будаа болгочихсон бол энийг явуулж болохгүй шүү дээ. Харин очсон чинь аятайхан байвал арай өөр гэдгээ, үзэж болно шүү дээ та хэд.

За тэгэхээр та хэдийн хувьд бол нэгдүгээрт хөндлөнгийн, тэр шинжээчийн дүгнэлтийг гэдэг юм уу, хөндлөнгийн байгаль орчны үнэлгээг заавал хийлгэх хэрэгтэй. Тэгэхээр энэ маань эргээд тав арван жилийн дараа ямар ч болох юм билээ.

УИХ-ын гишүүн О.Амгаланбаатар: Хүн ярьж байхад та нар жоохон бүдүүлэг байна. Би та нарын ярианд нэг ч саад болоогүй шүү дээ. Тэгэхээр бие биедээ соёлтой байя. Би буруу юм ярьсангүй, гарц гаргалгааг нь л хэлж өгч байна. Нэгэнт ийм байгаа бол та бид бас очоод үзчих гэдгийг нь хэлж байна.

УИХ-ын гишүүн О.Амгаланбаатар: Би ямар ч мэдээлэлгүй байна. Зөв, буруу юу гэдгийг чинь шинжээч хэлэх ёстой, байгаль орчны үнэлгээ гарах ёстой. Түүнээс биш хар таамгаар мэдэхгүй сэдвээ би мэддэг юм шиг ярьж болохгүй шүү дээ.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Санал хэллээ. За Б.Заяабал гишүүн.

УИХ-ын гишүүн Б.Заяабал: Та бүгдэд оройн мэнд хүргэе. Өнөөдөр энэ ерөнхий сонсголд оролцохоор Ховд аймгийн Мянгад сумаас алс тэртээх баруун бүс нутгаас анай малчин түмэн маань намрынхаа ид ажилтай энэ үед ажлаа хойш тавиад нутаг орныхоо төлөө, Монгол Улсад анхлан эхлүүлэх гээд зөв буруу нь мэдэгдэхгүй эхлэх гэж байгаа ийм ховор элементийн ордыг ашиглахтай холбоотой асуудлын талаар олон нийтэд, зөвхөн Ховдын ард түмэн өөрийнхөө сумын ард түмэнд биш олон нийтэд, Монгол орон даяараа, Монгол Улсынхаа төрд ажиллаж байгаа албан тушаалтнууд, төрийн бодлого бариад явж байгаа хүмүүс, Монголынхоо нийт ард түмэнд бүгдэд нь ийм зөв ойлголт өгөхөөр ингээд явж байгаад би бас талархууштай байна гэдгийгээ юуны өмнө бас илэрхийлж хэлье.

Өнөөдрийн энэ арга хэмжээнд манай төрийнхөн нэлээдгүй оролцож байна. Манай мэргэжлийн шинжээчид байна. Бусад бүх төрийн байгууллагын хүмүүс хүрэлцэн ирсэн байна. Энд бас их сайшаалтай байна гэдгээ илэрхийлж хэлье. Тэгээд

бүгдээрээ өнөөдөр ямар үр дүнд хүрч байна вэ гэдгийг би бас дүгнэсэн маягаар ганц хоёр асуултыг асууя гэж бодож байна.

Миний асуухаар бэлдэж байсан, сонирхож байсан асуултууд маань ерөнхийдөө зарим гол асуултууд маань асуултад гарчихлаа.

Тэгэхлээр нэгдүгээрт нь бол энэ ерөнхий сонсголын зорилго нь юу вэ гэдгээс эхлээд би ярья гэж бодож байна. Ерөнхий сонсголын зорилго бол энэ төрийн бодлого үйл ажиллагааны хэрэгжилт нь ямар шатандаа байгаа юм, тэрийг олон нийтэд ил тод гаргах, нөгөө талаасаа төрийн бодлогод хуулийн хэрэгжилтэд ард нийтийн оролцоо ямар байх юм тэдний оролцоо, бодлыг яаж төрийн бодлогод тусгах юм бэ гэсэн ийм агуулгатай сонсгол болж байгаа.

Энэ сонсголын үр дүнд УИХ-ын холбогдох шийдвэрүүд гарч таарна. Энэ сонсгол дээр, энэ бодлогын шийдвэр дээр өнөөдрийн ярилцаж байгаа ялангуяа энэ манай ард иргэдийн төлөөллийн ирж байгаа саналууд бол тусгагдах ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа. За ажиглаад, сонсоод суугаад байхад хэд хэдэн асуудлууд байгаа юм. Нэгдүгээрт нь энэ байгаль орчны ерөнхий судалгаа хийгдсэн боловч нарийвчилсан судалгаа гэдэг нь ерөөсөө хийгдээгүй байна гэдэг ийм асуудал яригдаж байгаа. Энэ нь байгаль орчинд ямар хор уршигтай, мал амьтны хүний амьдралд ямар нөлөө үзүүлэх юм, тэнд яг тэр бүс нутагт амьдарч байгаа иргэд нь энд санаа бодлоо тусгаж чадсан юм уу, зөвшөөрсөн юм уу гэдэг энэ зүйлүүд нь бүгдээрээ нарийн тодорхой тусгагдаж байж уг нь энэ лицензийн зөвшөөрөл нь анх олгогдсон баймаар юм гэдэг ийм бодолтой байгаа. Тэр 2001 онд энэ лиценз нь олгогдчихсон. Тэгсэн мөртөө тэрнээс хойш ингээд лицензийнхэн А лиценз авчихсан мөртөө дахиад өнөөдрийг хүртэл хайгуул хийгээд яваад байдаг гэдэг нь бас эргэлзээ төрүүлж байна. Сая манай З.Мэндсайхан гишүүн энэ дээр ярьж байсан энэ бол эргэлзээтэй байна, энийг эргэж харна гэж. Би бас энэ дээр З.Мэндсайхан гишүүнийхээ манлайлал доор энэ дээр бас онцгой анхаарч ажиллана гэж бодож байна.

Хоёрдугаар асуудал нь энэ ховор элементийн асуудал байна. Монгол Улсад энэ ховор элементийн бодлого бол тодорхойгүй байна гэдэг нь өнөөдрийн энэ хэлэлцүүлгээс бас ажиглагдаж байна. Цөмийн энергийн тухай хуульд ганцхан заалт л байгаа. Цөмийн цацраг гэж юу вэ гэдэг дээр газрын ховор элемент гээд ганцхан өгүүлбэр л байна. Би бүүр хайгаад олоогүй. Тэгэхлээр энэ газрын ховор элементийнхээ ашиглахтай холбоотой асуудлыг төрийн бодлогыг тусад нь гаргаж тодорхой болгох гэж байж энэ бодлогынхоо үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй бол. Энэ чинь ашиглуулж байгаа орон нутгийн иргэдийн асуудлаас гадна энэ хөрөнгө оруулагчид ч хүртэл тодорхойгүй байгаа юм биш үү гэдэг ийм нөхцөл байдал үүсэж байна. Тэгэхлээр энэ ховор элементийнхээ бодлогыг Монголын төр өөрөө тодорхой болгож байж энэ ордууд руугаа ашиглах хэрэгтэй.

Өнөөдөр Ховд аймгийн Мянгад сумын энэ тэмцэл бол газрын ховор гэдэг энэ элементийг ашиглах, ашиглаж эхлэхээс өмнө бүх зүйлийг зөв зүйтэй болгож байж эхлүүлэх зөв үндсийг тавилаа гэж ингэж ойлгож байна. Тийм учраас энэ холбогдох яам, төрийн байгууллагынхан маань энэ ховор элементийнхээ бодлогыг тодорхой оруулж ирэх хэрэгтэй. Өнөөдөр бас энэ зарим оролцогчид хэлж байна. Бодлого нь тодорхойгүй байна, энд ажиллах мэргэжилтэн ч гэж тодорхойгүй, мэргэжилтнээ ч бэлтгээгүй байна гэдэг ийм зүйл ярьж байна. Энэ бол бас зөв л асуудлыг ярьж байна шүү дээ.

Тэгэхлээр энийг хамгаалах гэж манай төрийн яам, Засгийн газрын талынхан бол суугаад хэрэггүй, энэ бодлогоо зөв болгох чиглэлээр бодлого боловсруулагч

талтайгаа УИХ-тайгаа бас ойлголцож хамтарч ажиллах зайлшгүй шаардлага байна гэдгийг хэлж байна. За гуравдугаарт миний дүгнэж байгаа зүйл бол энэ баруун бүсийн экосистемийн асуудал яригдаж байна. Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал гээд сая энэ Усны газрын дарга З.Батбаяр дарга тодорхой ярилаа. 2050 он гэхэд баруун бүс.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Нэг минут сунгачихъя.

УИХ-ын гишүүн Б.Заяабал: Мөнх цасаас эх авч урсдаг энэ голууд чинь байхгүй болох нь, мөнх цас чинь байхгүй болох нь гэдэг ийм асуудлууд яригдаж байна. Тэгэхээр энэ дээр манай зарим оролцогчид маань бас хэлж байсан. Энэ зөвхөн энэ газрын ховор элементийн лицензийн асуудал биш, дагаад 24 лиценз гэдэг асуудал яригдаж байгаа. Энэ зөвхөн Ховдын Мянгад сумын хувьд ярьж байгаа 24 лиценз нь. Ер нь баруун аймаг энэ дэлхийн дулаарал уур амьсгалын өөрчлөлтөд ороод байгаа юм бол энэ баруун 5 аймагт чинь байгаа лицензүүдийгээ яах юм бэ, ашиглуулах юм уу гэдэг асуудал. Өнөөдөр Увс аймгийн яг гол дагуу олгочихсон баахан лицензүүд байгаа. Бас дахиад л иргэдийн тэмцэлтэй тулж байгаа. Яахын аргагүй ард иргэдийн амьжиргаа, хүн малын ундны усны асуудал гараад байна шүү дээ. Тэгээд ард иргэдийгээ амьжиргаагүй болгож байж төр нь мөнгө олдог ийм төрийн бодлого байж болохгүй. Энэ дээр зайлшгүй тодорхой бодлого явах ёстой гэдгийг энд хэлье.

За нэгдүгээрт нь тэр лиценз нь зөв олгочихсон юм уу гэдэг дээр бас дахиад нэг тодорхой хариулт өгөөдөх. Би яг тодорхой буруу олгочихсон, зөв олгочихсон гэдэг дээр яг тодорхой хариултыг бас сонсож чадсангүй. Энэ дээр яг тодорхой хариултыг надад хэлж өгөөч. За яагаад нарийвчилсан үнэлгээг сая байгаль орчны одоо чиглэлээр шинжээч ажилласан. Ямар бичиг баримт дээр тулгуурлаж саяын энэ дүгнэлтүүдээ гаргасан бэ? Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ нь тодорхой болоогүй байхад яг ийм дүгнэлт яагаад гаргасан юм бэ гэдэг асуулт бас асууя. За дараагийн асуулт нь энэ усны асуудал байна. Тэр бүс нутагт амьдарч байгаа иргэдийн энэ гар худгийн асуудал энэ ер нь цацраг гэдэгт байгаа юм уу? Одоо баруун аймгийнхан эрүүл мэндийнх нь үнэлгээний судалгаа аваад үзэхэд манай баруун бүсийнхэн хорт хавдраар өвчлөгч нь илүү байдаг.

Тэгэхээр одоо байгаад байгаа энэ газрын доор байгаа, ашиглаад байгаа, ашиглаж эхлээгүй байгаа энэ газар нутагт гаргачихсан худгаас ус ууж байгаа. Энэ усанд нь хүнд элементийн асуудлууд ер нь ямархуу юм байдаг юм бэ? Энэ нь эргээд баруун бүсийнхээ хүн амын эрүүл мэндэд хэр зэрэг нөлөөлж байгаа юм бэ гэдэг дээр бас тодорхой хариулт өгөөч гэдгийг бас хэлье. За эцэст нь энэ газар нутгийнхаа төлөө тэмцэж байгаа иргэдийн асуултууд байна. Увс аймаг дээр ч гэсэн бас ийм асуудал үүсэж байгаа. Яах аргагүй амьжиргаагаа алдахгүйн төлөө хүн ард иргэд одоо тэмцэхээс өөр арга байхгүй. Ингээд тэмцсэн иргэдийг нь цагдаа, шүүх, хяналтын байгууллагуудад өгдөг, цагдаагаас байнга дуудаж, бас ингээд байцаадаг, дарамталдаг.

Ингээд ард иргэдийнхээ амьжиргааныхаа төлөө тэмцсэнээсээ болоод хууль хяналтын байгууллага руу байнга дуудагддаг. Сэтгэл санааны хувьд ч гэсэн хүндрэлтэй ийм байдал үүсээд байна гэдэг ийм асуудал яригдаад байгаа юм. Энэ ер нь хэр үндэстэй юм бэ, энд хариулт өгөөч гэсэн ийм асуултуудыг асууя, за баярлалаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас эхлээд хариулаад дараа нь Усны газар тэгээд шинжээч.

Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул ашиглалтын газрын дарга С.Ган-Очир: Гишүүн ээ, түрүүн он цагийн дарааллаар нь бол хэлчихсэн. Тэгэхдээ яг яагаад ийм зохицуулалтууд байсан юм бэ, нөөцтэй байсан уу, байгаагүй юу гэдэг дээр тайлбар хэлье. Тусгай зөвшөөрөл 2000 оноос олгогдож эхэлсэн байгаа. 2006 оны хуулиас Эрдэс баялгийн зөвлөлөөр батлагдсан нөөцтэй талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгодог зохицуулалт хэрэгжиж эхэлсэн. Түүнээс өмнө өөрийн эзэмшиж байгаа хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай дээрээ ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргах эрх нээлттэй байсан. Энэ эрхийнхээ дагуу Монтем компани өөрийн эзэмшлийн хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай дээрээ 2 хэсэг ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан байдаг. Тэгэхээр таны хэлээд байгаа нөөцтэй байсан уу, үгүй юу гэдэг эргэлзээ зөв гэсэн үг.

Одоо энэ компани одоогийн эзэмшиж байгаа компани дээр шилжсэнээсээ хойш би энэ компьютер унтарчхаад яг он цагийг нь харж чадахгүй байна, 2010 оноос хайгуулаа хийсэн байдаг байх, Эрдэс баялгийн зөвлөлөөр нөөцөө хэлэлцүүлж батлуулаад 2015 онд бүртгүүлсэн. Өөрөөр хэлбэл Эрдэс баялгийн зөвлөлд бүртгэлтэй, нөөцтэй, тэр нөөцийг нь бид яриад байж байна гэсэн үг, 1 сая 200 мянган тонн гээд. 2015 онд Ерөнхийлөгчийн зарлиг гарсан талаар бас ярьж байна.

Энэ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэх тухай асуудал байсан. Эдний ашиглалтын тусгай зөвшөөрөл бол энэнээс аль хэдийн өмнө, даруй 10 жилийн өмнө олгогдоод явчихсан байсан гэсэн үг. Шилжилтийг нь он цагаа харж байж ярихгүй бол. Монтем компаниас одоогийн энэ компанид шилжсэн байгаа. Ямар ч байсан зарлиг гарахаас өмнө эдний ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдчихсон байсан. Би он цагийг андуурсан байж магадгүй энэ компьютер унтарчихсан байгаа учраас харах боломжгүй байгаад байна.

Усны газрын дарга 3.Батбаяр: Уучлаарай хуралдаан даргалагчаасаа нэг зөвшөөрөл хүсээд 20-хон секундэд багтаагаад оролцогчдоо хандаад юм хэлчихье. Бас жоохон ах зах хүний хувьд Монгол төрийн албан хаагч нар Монгол төрийн сүлдний өмнө, Эзэн Чингис хааны өмнө, Их хурлын эрхэм гишүүдийн өмнө биеэ авч явах тийм ёс зүйн юмтай байдаг юм. Тийм учраас та бүгдийгээ бас энэ сайхан танхимд энэ төрийн сүлдний өмнө байж байгаагаа бас нэг анхаарчхаач юу ярихаасаа үл хамаараад гээд нэг зүйлийг хэлчихмээр байна.

За хоёрдугаарт нь устай холбоотой асуудал дээр Ховд аймагт нийт 246 гол, 889 булаг шанд, 177 нуур, 38 рашаан, 1529 худаг байна. За яг гишүүний асуултад хариулаад би энд бүр уншаад өгчихье. Ховд аймгийн Мянгад сумын усны чанарыг бохирдлын индексээр үнэлээд үзье. Ингээд үзэх юм бол “Мянгад шим ус” төрийн орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрын эх үүсвэрийн гүний худаг 2012 онд ашиглалтад орсон, химийн бүрэлдэхүүн дээрээ гидрокарбонатын ангийн кальцийн бүлгийн 1 дүгээр төрлийн чанарын хувьд цэнгэг, эрсдэлжилт 208 мг литр зөөлөн, за хатуулгийн хэмжээ 2,05 мг эквивалент бохирдолгүй ус байна.

Шинэчилсэн үзүүлэлтээс радоны хэмжээ стандартад заасан хэмжээнээс их, фторын ион ялимгүй бага байна. За Мянгад Засаг даргын Тамгын газрын 1 дүгээр худаг дээр 2003 онд ашиглалтад орсон бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн кальцийн бүлгийн 1 дүгээр төрлийн чанарын хувьд цэнгэг, зөөлөн, хатуулгыг 2,19 түрүүчийнхтэй ойролцоо гэсэн үг. Бохирдолгүй ус байна.

Шинжилсэн физик, хими, бичил элементүүд болон бичил амь судлалын үзүүлэлтүүд нь стандартад заасан хэмжээнд байгаа боловч фторын ионы агууламж стандартаас бага, цацрагийн аюулгүй үзүүлэлтүүдээс радон стандартаас их байна.

Засаг даргын Тамгын газрын 2 дугаар худаг 2021 онд ашиглалтад орсон. Цэнгэг зөөлөн усанд орж байна, бохирдолгүй ус байна, за бидний асуугаад байгаа стандартын хэмжээнд байгаа боловч фтор ионийн агууламж стандартаас бага, цацрагийн аюулгүй үзүүлэлтүүдээс радион стандартаас их байна гэсэн ийм дүнг яг Мянгад сумын төвд байгаа худгуудаас хэлж болж байна.

За гишүүний асуусан асуулт дээр маш тодорхой нэг хариултыг хэлээдэхье. 2050 он гэхэд хэрвээ бид нар мөнх цасны хайлалтаас сэргийлэх замаар хайлж байгаа цасны усыг хуримтлуулах, хур борооны усыг хуримтлуулах хөв цөөрмийн ажлаа хийхгүй бол юун уул уурхайн үйл ажиллагаа явуулах байтугай нөгөө мал аж ахуй маань, нөгөө амьдралаа тэр хэвээр нь үргэлжлүүлэх боломжгүй болох экологийн сүйрлийн аюул хаалга тогшоод байна гэдгийг л хэлээд байгаа учраас уул уурхайн компаниуд болоод бүх хүн анхааралтай ажиллах хэрэгтэй байна.

Шинжээч Н.Наранцэцэг: Байгаль орчны дүгнэлтийг ямар материал ашиглаж гаргасан бэ гэж хэлж байна. Нарийвчилсан үнэлгээ байхгүй гэж тайлбарласан байна. Би үдээс өмнийн илтгэл дээр хэлсэнчлэн 2022 оны төлөв байдлын тайлан, 2022, 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан, 2024 оны төлөв байдлын тайлангууд дээрх хөрс, ус, агаарын, цацрагийн шинжилгээний хариуны үр дүнгүүдийн нэгтгэлийн нийлбэрийг танилцуулсан. Энэ хяналтын цэг болоод малчдын өвөлжөө хаваржааны байршлууд дээр хэмжсэн цэгүүдийн үр дүнг харьцуулсан судалгааг л танилцуулсан. Энэ дүнгээр юу хэлэх гэсэн юм бэ гэхээр өнөөдөр тэр талбай дээр энэ зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан бохирдол үүсээгүй байна гэдгийг тайлбарласан.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За Б.Заяабал гишүүн тодруулъя.

УИХ-ын гишүүн Б.Заяабал: За баярлалаа. Би дахиад тодруулаад нэг ганц 2 юм асуугаадахъя. Саяын тэр ховор элементийн бодлого дээр ерөөсөө хариулахгүй байна л даа. Өмнө нь бас З.Мэндсайхан гишүүн бас Г.Манлайжав даргаас асуусан, Г.Манлайжав дарга хариулахгүй л байгаад байна л даа. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөдхөөч. Энэ ховор элемент чинь цацраг идэвхт юм уу, юу юм бэ? Би бол цаашдаа бие даасан төрийн бодлого гаргаад явах ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа гишүүн. Тэгээд энэ дээр одоо бие даасан ийм бодлого гаргахгүй юм уу? Цөмийн энергийн тухай хууль дээр ганцхан өгүүлбэрээр ингээд бүхэл бүтэн ийм хүн амын малд бас ийм нөлөөтэй ийм том ордын асуудал яригдаад яваад байх юм уу гэдэг дээр тодорхой хариулт өгчихмөөр байна.

Хоёрдугаарт Ерөнхийлөгчийн зарлиг бас саяхан гарсан. Энэ дээр ерөөсөө уул уурхайн олгогдсон лицензүүдийг эргэж харъя гэсэн. Энэ дээр Усны газрын даргын саяын хэлсэн асуудлаар энэ баруун бүсэд олгогдсон лицензүүд дээр бас онцгой анхаарч та бүхэн судлаарай. Зөвхөн энэ ховор элементийн асуудал биш бусад лицензүүдийг бас давхар үзэх шаардлагатай байна.

Цөмийн энергийн комиссын Ажлын албаны дарга Г.Манлайжав: Та бүхэнд энэ оройн мэндийг хүргэе. Цөмийн энергийн тухай хуулийг анх 2009 онд батлахдаа газрын ховор элементтэй холбоотой эрдэсийн хуримтлал бүхий талбайн ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг авъя гэсэн бодлого бол байсан юм байна лээ. Энэ асуудлаа бас тэр үеийн Эрдэс баялаг, эрчим хүчний яаманд удаа дараа тавьж байсан. Тухайн үед бол газрын ховор элементийн эрдсийн хуримтлалтай талбайн тусгай зөвшөөрлийг Цөмийн энергийн тухай хуулиар танайд олгохгүй, энийг бол Ашигт малтмалын тухай хуулиараа явнаа гэж тэр үед Ашигт малтмалын газар гэж

байсан, хариуцаж явна гэсэн ийм үндэслэлүүдээр бол олгоогүй. 2009 онд бол манай Цөмийн энергийн тухай хууль анх батлагдаад энэ хуулийг дагаад Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль гэж гарсан.

Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль дээр хуулийн тодорхой хугацаанд бол Ашигт малтмалын газраас зөвхөн урантай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг 160-аад ААН-ийн тусгай зөвшөөрлүүд шилжиж ирээд тэгээд шинэчлэн олгогдсон байгаа юм. Одоо бол Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэг бас гараад бид нар ажиллаж байна. Цөмийн комиссын дарга, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын тушаалаар ажлын хэсэг гараад ажиллаж байна. За энэнд бол бид нар газрын ховор элементтэй холбоотой асуудлыг хаана оруулах вэ, Ашигт малтмалын хуулиар зохицуулах уу, Цөмийн энергийн тухай хуулиар зохицуулах уу гэдэг асуудлыг Улсын Их Хурал дээр шийдэх байх аа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа. Даваагийн Цогтбаатар гишүүн.

УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар: Өнөө өглөө энэ хурлыг болно гэж сонсоод би орж ирээд бас нэлээн ажиглаж суулаа. Тэгээд хаа байсан Ховд аймгийн Мянгад сумаас нутгийнхаа төлөө энд ирээд бүх л өдөржингөө сууж байгаа нутгийн иргэд та бүхэнд энэ оройн мэндийг хүргэе. Та бүхэнд бас талархал илэрхийлье. Би яагаад энэ сонсголд ач холбогдол өгөөд суугаад байгаа вэ гэхээр манай Баянхонгор аймгийн говь бас яг ийм асуудалтай. Манай Шинэжинст, Баянлиг дээр бас нэг алтны ордууд яригддаг нүүрсний ордууд яригддаг. Тэгээд би чинь өөрөө улс төрч болоод бас удаагүй нэг жил гаран л болж байна. Тэгээд өмнө нь бид нарыг ингээд хөдөө орон нутгаар явж байхад тийм зовлон сонсогддоггүй байсан юм. Тэгээд улс төрч болчихсон хойноо очсон чинь яг нутгийн залуу бүр эрэгтэйчүүд нь одоо энэ газрын гүний ус ширгээд байгаа нь тэр юм уу одоо энэ байгаль дээр байгаа ус өөрөө булаг шанд ширгээд алга болоод байна, бид нар одоо малтайгаа хаачих юм бэ гээд.

Миний одоо яг энэ чин сэтгэл зүрхэндээ байдаг нэг үзэл бол Монголыг тэр хөдөө байгаа малчид л авч явж байгаа болохоос энэ хотод сууж байгаа бид хэд авч яваагүй байхгүй юу. Яг уламжлалт нүүдлийн мал аж ахуйтай хаа байсан одоо тэр хэдэн оноос хойш юм уу өнөөдрийг хүртэл яг монгол нүүдэлчид л авч явж байгаа болохоос энэ түгжирчихсэн Улаанбаатар энэ тэр чинь бол дэлхийд нэг их гайхуулаад байх тийм онцлог бол биш. Тэгэхээр малчид бол энийг авч явж байгаа гэдгийг хэлээд та бүхэнд талархал илэрхийлж байгаа юм. За тэгээд давхардаж байсан асуултуудаа орхичхоод байгаа юм.

Тэгээд Г.Манлайжав гуайгаас нэг асуулт байна. Та бол эдийн засгийн үр ашиггүй гээд биччихсэн юм шиг байгаа юм. Та одоо яг ингэж дүгнэсэн юм уу эсвэл та ингэж дүгнэдэг хүн нь үү мэргэжлийн хүмүүс хийдэг үү? тэнд хүн амьдарч болох юм уу болохгүй юм уу? яг тийм нэг мэргэжлийн хариулт өгөөдхөөч. Тэнд одоо цацрагаас нь болоод муу юм юу тохиолдоод байгаа юм бэ гэдэг талаар.

За тэгээд би өөрөө банкны салбарт 20 жил ажиллаж байгаа. Зээл олгох шийдвэр бол за эсвэл үгүй гэдэг ийм тодорхой юм гардаг. Одоо энд өнөөдөр хэлэлцүүлэгдэж байгаа асуудлыг харахаар энэ лицензийг бид нар ашиглах ч юм шиг ашиглахгүй ч юм шиг өдөржингөө л маргаад байгаа юм 2 тал болчихсон. Тэгэхээр би одоо нөгөө нэг тас түс байх үүднээс хуралдаан даргалагчаас бас асуух гээд байгаа асуулт төсөл хэрэгжүүлэгчээс бас асуух гээд байгаа нэг нэг асуулт байгаа юм. Төсөл хэрэгжүүлэгчээс бол улс төрч нар бол яах вэ орон нутагт очихоороо та нарын талд энийг хэрэгжүүлэхгүй байд гэж ярьдаг байх. Хотод ирээд энэ ордон дотор суухаараа

бол энэ төсөл явах ёстой, эдийн засаг янз бүрийн л юм ярьж байгаа. Тэгэхээр одоо яг энэ энэ байдлаас үүдээд та нарт ямар хор хохирол учраад байгаа юм бэ гэдгийг бас нэг хэлээд өгөөч. За тэгээд энэ өдөржингөө суусан хүмүүс танаас бас асуух гэж байж магадгүй. Одоо яг энэ ямар үр дүнд хүрэх юм бэ. Одоо энэ ч дүгнэлт ч юм уу, шийдвэр ч юм уу гарах уу, энийг одоо ухах юм уу, ухахгүй юм уу, яг нэг талд нь шийдэж чадах уу гэсэн ийм 2 асуулт байгаа.

За тэгээд Ховд аймгийн Мянгад сумын Цагаанбулан багаас ирсэн н.Болорчимэг гэдэг хүн надад энэ асуултыг өгсөн. Хууль эрх зүйн болон нарийвчилсан ТЭЗҮ гараагүй учраас А лицензийг цуцлуулъя гэж. Энийг одоо энэ Засгийн газарт хэлэх ёстой юм уу, Улсын Их Хуралд хэлэх ёстой юм уу, энийг дамжуулж асуулгаж байгаа ийм 3 асуултад хариулт авъя. Энэ лицензээ цуцлуулъя гэж байна шүү дээ тэнд сууж байгаа Болорчимэг гэдэг эмэгтэй.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: Эхний асуултыг Г.Манлайжав дарга, 6 номерын микрофон.

Цөмийн энергийн комиссын Ажлын албаны дарга Г.Манлайжав: За гишүүний асуултад хариулъя. Тэр эдийн засгийн үр өгөөжийн асуудлыг бас ярьж байх шиг байна. За Цөмийн энергийн комисс бол ҮАБЗ-ийг мэдээллээр хангах чиг үүрэгтэй байдаг. Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдад 2003 оны 1 сард бол мэдээллийг өгсөн. Тэндээ бас тодорхой нөхцөл байдал, байгаль орчны асуудлууд, цацрагийн асуудал, эдийн засагтай холбоотой асуудлуудыг тусгаж энэ талаар мэдээлэл өгөөрэй гэсэн учраас тэр үед бүх мэдээллүүдийг судалж үзсэн. Бид нар өөрсдийнхөө хүрээнд тэр тусмаа хамгийн шинэ шинэлэг мэдээллүүдийг олон газруудаас манай энэ бол ганцхан миний бас өгч байгаа зүйл биш, Цөмийн энергийн комиссын ажлын алба энэ дээр ажиллаж бид нар дүнгүүдээ үзсэн.

Байгаль орчинтой холбоотой асуудлуудыг хаанаас ч гэсэн үзэж болох байх, эдийн засагтай холбоотой асуудлууд дээр бас төслийн үр дүнгүүд дээр нэлээд хүндрэлтэй. Ганцхан манай дээр манай төслөөс ч биш дэлхийн бусад төслүүд дээр бол ийм зүйлүүд нэлээд их байсан. Манай Халзан бүрэгтэйн ордын хувьд дээр бас өмнө хийж байсан геологийн ажил дээр оролцож байсан улсууд, за бас өмнө нь Германд ч бас 2009 онд бас нэг судалгаа хийлгэж байсан юм байна лээ. Тэрэн дээр гаргасан тооцоонуудыг үзэхэд нэлээд хүндрэлтэй байна, эрсдэлтэй байна гэсэн дүгнэлтүүд гарсныг Монгол Улсын Ерөнхий сайдад өгсөн. Тэгэхдээ би бол өмнө нь хийгдэж байсан судалгаагаар гэж би бол өгүүлбэртээ бичээд энэ үр ашиггүй гэж бас үзэхээр байна гэж. Тэгээд энэ мэдээллүүд бол бас сошиалаар нэлээд гарчихсан байгаа учраас бараг энд байгаа улсууд бүгдээрээ үзсэн байх гэж бодож байна. За баярлалаа.

Төсөл хэрэгжүүлэгч, “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-ийн гүйцэтгэх захирал А.Цолмон: За хэр хэмжээний хор хохирол учраад байгаа вэ гэсэн за яахав би зүгээр мөнгөн дүнгээр гэж ярих юм бол яахав 2024 онд бид нарт 2,6 тэрбум төгрөгийн хохирол учирсан байдаг. За энэ жилийн хувьд бас иргэдийн үл ойлголцолтой холбоотой 1 тэрбум орчим төгрөгийн хохирол учирсан явж байгаа. Мөнгөн дүнгээсээ гадна бас нэг цаг хугацааны хувьд жоохон алдагдалтай яваад байгаа. 2 жилийн хайгуулын улирал хойшилсноороо төслийн ерөнхий хуваарь бол 2,5-аас бараг 3 жил шахуу ухарчихсан байдалтай явж байгаа.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За би сонсгол даргалагчийн хувьд уг нь дэгээр бол асуулт асуух эрхгүй л юм байна. Тэгээд одоо хариулъя нэрнээсээ их ойлгомжтой сонсгол. Өнөөдөр энэ үүсээд байгаа нөхцөл

байдалтай холбоотойгоор сонсголыг миний бие ахалж байгаа. Шийдвэр байнгын хороон дээр гарна. УИХ-ын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. За Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн, Загджавын Мэндсайхан гишүүнээр тасаллаа. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүний микрофоныг өгье.

УИХ-ын гишүүн М.Бадамсүрэн: Бүх юмны эх үндэс бол айл өрхөөс эхтэй. Улс орны тулгуур багана бол айл өрх. Энэ ардчилсан Монгол Улсын анхан шатын нэгж бол баг, сум, аймаг. Тэгээд харамсалтай нь энэ жоохон урвуу болчихоод байгаа юм. Тийм учраас энэ одоо ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон ард иргэд дээрээ тулгуурласан, тэдний санал бодол дээр тулгуурласан зарчмыг л бид нар хэрэгжүүлж ажиллаагүйгээс ийм асуудал үүсээд байгаа юм. Тэгээд ерөөсөө ингээд лиценз авчихсан юм чинь эсвэл олгочихсон юм чинь ингээд хүч түрээд ямар нэгэн аргаар үйл ажиллагаа явуулна гэдэг л нэг ийм л юм яваад байгаа юм л даа. Тэгээд их даам байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр юу гэж хэлээд байна вэ гэхээр би хэн нэгнийг буруутгах гэхээсээ илүүтэй зарчмын асуудал яриад байгаа юм. Одоо та бүхэн санаж байгаа бол хэвлэлээр Ашигт малтмал, газрын тосны газрын дарга байсан Жаргалсайхан гэдэг хүн Ухаа худгийг хууль бусаар өгсөн. Одоо хувьдаа энэ Сүхбаатар аймагт Төмөртэй ордыг өгсөн гээд сонссон уу, Үүрийнтуяа гээд Ашигт малтмал, газрын тосны газрын дарга байсан хүн ураны 3 лицензийг авлигын журмаар өгсөн байж болзошгүй гэж Францын шүүх тогтоолоо гээд сонссон уу? Энэ юу харагдаад байна гэхээр энэ нэг хувь албан тушаалтанд ингээд олгодог тэгээд энийг нь Засгийн газар мэдэхгүй, бид нар олгоогүй гэдэг. Тэгэхээр би бол ямар санал дэвшүүлээд байна гэхээр энийг лицензийг олгох, шилжүүлэх энэ үйл ажиллагааг Засгийн газар өөрөө мэдэлдээ авч өөрөө хариуцлагаа хүлээх ёстой. Тэгээд 1 асуудал үүсгээд нэг албан тушаалтан руу чихдэг. Тэгээд тэр 2 албан тушаалтан нь ямар хариуцлага хүлээсэн.

Нэр дурдаад байгаа энийг засаж байж цаашдаа Монгол Улсад хариуцлага тогтоно. Ингэхгүй бол ингээд өнгөрнө, тэгээд тийм учраас энэ одоо би хэлсэн 9 жил аймгийн Засаг даргаар ажилласан гээд. Ингээд анх энэ хууль чинь орон нутгийн хурал аймгийн хурлаас санал авдаг байсан юм. Энэ лиценз олгохдоо. Одоо байхгүй шүү дээ. Авахаа больчихсон, шууд олгоно. За тэгэхдээ би гарцыг нь хэлж өгөх гээд байна. Сумд ямар эрх байгаа гэхээр сумын иргэдийн хурал энийг эдэлбэр газар буюу энд кемп байгуулах, энд байшин барилга барих тэр сууцаа байрлуулах энэ газрын зөвшөөрлийг сумын иргэдийн хурлын зөвшөөрлөөр Засаг дарга өгдөг юм шүү. Хэвлий доорх баялгийг нь олгох зөвшөөрлийг Ашигт малтмалын газар өгсөн байж болно. Өгчихсөн байна тийм үү, дээр нь үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг сум өгнө шүү, агаар дээр үйл ажиллагаа явуулахгүй тэгэхээр. Энэ боломж нь өөрөө сумд байгаа гэдгийг би зөвлөж хэлэх гээд байгаа юм.

Тэр сумынхаа Иргэдийн төлөөлөгчдийн хуралд одоо энэ саналаа та бүхэн бас тавих хэрэгтэй. Ер нь энэ Монгол Улсын хуулиуд энэ хэвтээ ардчилал буюу орон нутгийн эрх ашиг иргэдийн оролцоог хангасан заалтуудыг бид нар ашиглаж чадвал байгаа шүү. Би одоо жишээлбэл Дорнодод тэр “Магнай трейд” гэдэг компани газрын тосны хайгуул хийнэ гээд хууль бусаар үйл ажиллагаа явуулахад нь энийг нь зогсоогоод тэгээд энэнээс болж одоо олон жил шүүхээр явсаар байгаад хамгийн сүүлд нь өөр аймгийн шүүх рүү шилжүүлж байгаад 2,5 тэрбум төгрөгийг надад өр ноогдуулсан ийм шийдвэр гарчхаад байгаа. Тэгэхээр энэ дээр би юу гэж хэлэх гээд байна гэхээр бүх юм хуулийн дагуу та бүхэн яваарай, нутгийн ард иргэд ээ.

Нэгдүгээрт сумын хуралд энэ боломж нь байгаа, хоёрдугаарт нь сумын хуралд ус ашиглах зөвшөөрлийг олгодог. Сумын Засаг дарга хог хаягдал ашиглах зөвшөөрлийг олгодог агаар дээр үйл ажиллагаа явуулдаггүй шүү, боломж нь байгаа шүү. Энд хэлэхээсээ гадна, энэ Төрийн ордонд хэлэхээс гадна тэр сумдаа энийг хэлнэ.

Хоёрдугаарт энэ дээр байгаа, энэ танилцуулга дээр 2015 онд 2017 онд 2 удаа ашиглалтын зөвшөөрөл олгосон гээд би таамгаар яриагүй шүү. Энэ танилцуулгыг нь хараад ярьж байгаа юм. Энийг хаанаас бэлдэж өгсөн юм бэ?, бодвол одоо энэ эрх бүхий байгууллага бэлдэж өгсөн байлгүй дээ тэ шинжээчид. Тэгэхээр Ерөнхийлөгчийн зарлиг 2011, 2015 онд гарчхаад байхад тэрийг баримтлахгүй яагаад энэ лицензийг тэгвэл шинээр олгосон юм бэ. Энд хариулахгүй байгаа байхгүй юу., тэгэхээр та бүхэн энэний араас явах хэрэгтэй. Тэгэхээр би яахав хэтэрхий олон юм ярихаасаа илүүтэй яг практик дээр энэ зовлонг туулаад явсан хүний хувьд энэ 2 зүйл дээр анхаараарай. Эцэст нь энэ газрын хэвлийн баялгийг ашиглах өгөөж нь ард түмэндээ, тэр дундаа нутгийн ард иргэддээ очдог байх ёстой шүү, очдоггүй учраас өнөөдөр хэн ч итгэхгүй, итгэхгүй биз дээ, энэ чинь, би итгэхгүй байна шүү дээ.

Дорнод бол газрын тос олборлоод 20 жил боллоо. Тэгээд тэнд нь юу ч ноогддоггүй. Юу гэхээр манай сайд дарга нар энд нийт ард түмний баялаг гэдэг үнэн. Гэхдээ олон улсад тэр нутгийн ард иргэдэд нь одоо нөлөөлөл.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За Загджавын Мэндсайхан гишүүн.

УИХ-ын гишүүн З.Мэндсайхан: Юуны өмнө өнөөдөр холоос ирсэн иргэдийг маань мэдээллээр хангаж өгсөн хараат бус шинжээч нартаа талархлаа. Бас тодорхой мэдээллийг иргэд маань авсан байх. За Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарсан тэгээд Засгийн газарт чиглэл өгсөн байгаа. Энэ уул уурхайтай холбоотой лицензүүдийг ер нь нэг шалга гэдэг. Тэгээд энэний цаана юу байгаа юм гэхээр Засгийн газар бол тооллого явуулна гээд иргэдэд бас буруу мэдээлэл хэвлэлээр дамжаад хүрчих шиг болсон. Энэ лиценз шалгах гээд байгаа энэ цаад агуулга нь бол жишээлбэл одоо Төгрөг нуурын орд гээд нэг асуудал үүсэнгүүт үүний цаана 250 сая долларын гэмт хэргийн шинжтэй үйлдэл байна гэдэг асуудал босож ирж байгаа тийм ээ, та бүхэн энийг сонссон байх. Тэгэхээр энэ бол Монгол Улсын нэг л лиценз.

Тэгэхээр лиценз болгоны ард сая миний эргэлзээд асуугаад байгаа яагаад ашиглалтын лиценз болчхов гээд энэ түүхүүдийг эргэж харах гээд байгаа юм. Энэ лиценз яаж яваад, хэнд очсон юм бэ? Очихдоо ямар замаар очсон юм бэ? Энэ бүгдийг тогтоох гээд байгаа юм Засгийн газар. Тэгэхээр энэ дээр бас одоо бүсээс сонгочихсон гишүүд болон байнгын хорооныхоо гишүүдтэй бид нар хамтарч Засгийн газрын энэ шалгалтад онцгой анхаарал тавьж ажиллана. Энэ дээр одоо зөвхөн одоо Халзан бүрэгтэй гэлтгүй бүс нутгийн хэмжээнд олгогдсон лицензүүдийг бид нар анхаарна. Ер нь ямар нэгэн асуудал үүсэхээр нэг лиценз гарч ирдэг. Тэрний ард асар том асуудал хураагдчихсан, нуугдчихсан явж байдаг. Тэгэхээр энэ асуудлыг Ерөнхийлөгчийн чиглэл болгосны дагуу Засгийн газар цэгцлэх гээд байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар онцгой анхаарч ажиллана.

За хурал даргалагчаас би юу хүсэх гээд байна гэхээр өнөөдрийн ерөнхий сонсгол гээд болоод өнгөрч байна. За өнөөдөр бол мэдээж маш олон мэдээлэл тодорхой боллоо тийм ээ. Гэхдээ ямар ч шийдэл гарахгүй байна. Түрүүн Д.Цогтбаатар гишүүн хэлээд байна. Цуцална, цуцлахгүй, явуулна, явуулахгүй энэ шийдвэр л бид нар хүсээд байгаа тийм биз дээ? Тэгэхээр энэ шийдвэрийг байнгын

хороон дээрээ энэ сонсголын үр дүн тодорхой гаргаж өгөөч. Үнэхээр явуулах ёстой бол. Би ямар бодолтой байдаг вэ гэхээр төр нэгэнт ямар нэгэн зөвшөөрөл олгочихсон бол энэ хариуцлагаа өөрөө хүлээх ёстой, үүний цаана алдаа завхрал байгаа бол хүлээх ёстой, энийгээ залруулах ёстой.

Энэ мэдээллийг төр өөрөө хангаж өгөхгүй байна гэдэг асуудлыг би тавьж тэр уул уурхайн сайд, тэр үе үеийн сайд нар луу хандаж байсан. Байгаль орчны сайд нар луу хандаж байсан миний байр суурь хэвээрээ байгаа. Тийм учраас энэ байнга энэ сонсголын үр дүнд энэ нутгийн иргэдэд тэр холоос зорьж ирсэн иргэдэд маань тодорхой шийдвэрийг нь гаргаж өгөөрэй гэж хүсэх байна. Маш тодорхой шийдвэр.

УИХ-ын гишүүн, сонсгол даргалагч Б.Баярбаатар: За баярлалаа. Манай сонсгол Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд бүх зүйл тодорхой байгаа. З.Мэндсайхан гишүүн өөрөө байнгын хорооны гишүүн, танай байнгын хороогоор хэлэлцэгдэнэ тэгэхээр шийдвэр таны гарт байна гэж бас та ойлгоорой. За гишүүд санал хэлж дууслаа.

За өнөөдрийн хэлэлцэх асуудал ингээд энд хүрээд өндөрлөлөө.

Өнөөдөр өглөөнөөс хойш тэсвэртэй сууж үзэл бодлоо илэрхийлж, мөн сонсголд бас дэгээ сахиж оролцсон Ховд аймгийн иргэд, Мянгад сумын төлөөлөл иргэд та бүхэндээ тусгайлан талархал илэрхийлье. Дээр нь өнөөдөр төрийн байгууллагууд, орон нутгийн удирдлагууд, төсөл хэрэгжүүлэгч компанийн төлөөлөл, хараат бус шинжээч нар, УИХ-ын гишүүд гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр сонсгол болж өндөрлөх цэгтээ хүрч байна. Эндээс эргээд харахад өнөөдөр бид нар сонсголыг анх санаачлаад Төрийн ордонд хийж хэрэгжүүлэх товыг тогтоод явж байгаа үедээ бид хэд хэдэн зүйлийг онцгой анхаарсан.

Нэгдүгээрт, энэ газрын ховор элементийн талаарх мэдлэг мэдээллийн асуудал, хоёрдугаарт бид энэ байгаль орчин, хүн малын эрүүл мэндийн асуудал, гуравдугаарт бид нар улс эх орны геополитик эдийн засгийн асуудал гэсэн ийм гурван зүйл дээр төвлөрч энэ сонсголын суурь зарчим өнөөдөр ингэж өгөгдөж мэдээллүүд ч гэсэн энэ дээр үндэслэгдэж хийсэн. Эндээс үзэхэд энэ сонсголоос дүгнэлт гарна, дүгнэлтийг байнгын хороо хэлэлцэнэ. Цаашлаад УИХ-ын 126 гишүүнд бүгдэд нь хууль санаачлах эрх байж байгаа.

Тодорхой хууль, эрх зүйн орчны асуудлаар УИХ-ын гишүүн бүрэн эрхийнхээ хүрээнд хуулиа санаачлаад, асуудалдаа бодитой хандаад явах эрх зүйн орчин бол байж байгаа. Хамгийн эхний жишээ гэвэл бид өнөөдөр өнгөрсөн цаг хугацаанд алт, зэс, нүүрс, хүдэр, мөнгө, цайр гээд олон зүйлүүдийг олборлоод явж ирсэн.

Газрын ховор элементийг өнөөдөр бид нар хайгуулын шатандаа хэлэлцээд өнөөдрийн нөхцөл байдал аж ахуйн нэгж, иргэдийн хоорондын үл ойлголцлоос болж төр тодорхой түвшинд оролцож, энэ асуудлыг зохицуулах шаардлага, үүргийг хүлээж байна. Гэтэл эндээс бид нарт хамгийн түрүүнд харагдсан зүйл юу вэ гэхээр бид нар өнөөдөр газрын ховор элемент дээр төр ямар ч бодлого алга байна гэдэг нь харагдаж байгаа юм. Яагаад гэвэл энэ төр буруутай биш.

Бас өнгөрсөн хугацаанд бид нар энэ газрын ховор элементийн талаар хайгуул, ашиглалт гээд лиценз олгосон хэлбэр төдий асуудалд хандаад явж байсан бол одоо цаашлаад үнэхээр энийг бид нар олборлох нь зөв юм уу, уран юм уу, газрын ховор элемент юм уу хүний эрүүл мэндэд ямар хортой гээд нарийвчилсан судалгаанууд

хийгээд ингээд явах гэхээр эрх зүйн орчин тодорхой бус, дээр нь бодлого тодорхой бус байгаагаас болж өнөөдөр төр засаг нь үйл ажиллагаа хийхгүй байгаа юм шиг, ард иргэд нь бас тэрэнд нь дургүйцээд эсэргүүцээд байгаа юм шиг ийм нөхцөл байдал үүссэнийг өнөөдрийн энэ сонсгол харууллаа гэдгийг бас та бүхэнд хэлье.


Тэгээд дахин та бүхэндээ өнөөдөр энэ сонсголд оролцож, санаа бодлоо уралдуулан, үзэл бодлоо илэрхийлсэнд талархал илэрхийлье.

Өнөөдөр 126 гишүүнтэй парламент хууль тогтоох бүрэн эрхийнхээ хүрээнд энэ бодлогыг тодорхой болгож, цаашлаад энэ үл ойлголцлыг ойлголцлын түвшинд хүргэх хэмжээнд асуудлуудыг нарийн чиг үүрэгтэйгээр зохицуулах үүргийг хүлээж байна гэдгийг парламент өндөр түвшиндээ хүлээж авлаа.

За ингээд өнөөдрийн сонсгол хаасныг мэдэгдье. Баярлалаа та бүхэндээ.

Тэмдэглэлтэй танилцсан:

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
СОНСГОЛ ДАРГАЛАГЧ



Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР